

[Type here]



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-123

1. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-123
--	-------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 13-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, О.Саранчулуун, А.Ундраа, С.Цэнгүүн;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Б.Баярбаатар, Х.Булгантуяа,
Т.Мөнхсайхан, М.Нарантуяа-Нара, Г.Хосбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: О.Алтангэрэл, Н.Алтанхуяа, Д.Батлут, Ж.Баярмаа,
С.Ганбаатар, Л.Гантөмөр, П.Мөнхтулга, Ч.Номин, П.Сайнзориг, Ж.Чинбүрэн,
Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Х.Баттулга, Б.Батцэцэг, С.Лүндэг, Н.Наранбаатар,
Л.Оюун-Эрдэнэ, Б.Тулга, Б.Энхбаяр;

Хоцорсон: Н.Алтаншагай-43 минут, Х.Баасанжаргал-1 цаг 02 минут,
М.Бадамсүрэн-4 цаг 53 минут, Э.Бат-Амгалан-4 цаг 23 минут, Б.Батбаатар-15
минут, Э.Болормаа-08 минут, Д.Бум-Очир-4 цаг 47 минут, Д.Ганбат-21 минут,
Д.Ганмаа-13 минут, Ц.Даваасүрэн-28 минут, Т.Доржханд-47 минут,
Б.Дэлгэрсайхан-1 цаг 21 минут, Б.Жавхлан-6 цаг 18 минут, Х.Жангабыл-56
минут, Д.Жаргалсайхан-1 цаг 48 минут, Ж.Золжаргал-14 минут, Г.Лувсанжамц-
17 минут, М.Мандхай-15 минут, З.Мэндсайхан-3 цаг 14 минут, Б.Пунсалмаа-1
цаг 37 минут, Р.Сэддорж-02 минут, Ц.Туваан-22 минут, Б.Түвшин-16 минут,
Г.Тэмүүлэн-4 цаг 57 минут, Ч.Ундрэм-2 цаг 31 минут, Д.Цогтбаатар-1 цаг 20
минут, Л.Энх-Амгалан-3 цаг 00 минут, Ж.Энхбаяр-14 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 10 цаг 10 минутаас 10 цаг 11
минутад хуралдааныг удирдав.

**Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн
чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар
2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд
Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд
бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол
Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их

Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуяг, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Тусгай хамгаалалттай нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг, Барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Золбаяр, мөн яамны Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Борхүү, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Чандмань, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнх-Эрдэнэ, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн З.Райымбек, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Нийслэлийн Засаг даргын Нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Хоёрдугаар орлогч А.Амартүвшин, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, академич А.Бакей, Шинжлэх ухааны академийн академич Д.Дагвадорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

дарга Б.Цэнгэл, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн Үр дүнд суурилсан төлөвлөлтийн зөвлөх Г.Цэрэнжаргал нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын зөвлөх Б.Нандингэрэл, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн албаны зөвлөх Л.Батмөнх, референт Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар танилцуулав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг танилцуулав.

Танилцуулга болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Б.Пүрэвдорж, С.Эрдэнэболд, Л.Мөнхбаясгалан, Х.Тэмүүжин, Ц.Мөнхтуяа, П.Батчимэг, Ө.Шижир, О.Номинчимэг, О.Цогтгэрэл, С.Одонтуяа, А.Ариунзаяа, Л.Энхнасан, Да.Цогтбаатар, С.Зулпхар, Д.Энхтуяа, Г.Очирбат, С.Эрдэнэбат, Д.Энхтүвшин, М.Ганхүлэг, Ц.Баатархүү, Ж.Галбадрах, Ц.Сандаг-Очир, Б.Бейсен, М.Энхцэцэг, Д.Пүрэвдаваа, Э.Болормаа, Д.Ганмаа, М.Мандхай, Б.Түвшин, Г.Лувсанжамц, Ц.Туваан, Р.Сэддорж, О.Амгаланбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуяг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Боловсролын сайд П.Наранбаяр, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, академич А.Бакей, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, С.Замира, Г.Очирбат, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, Г.Ганбаатар, М.Мандхай нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:09/

Уг асуудлыг 17 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 59 минут үргэлжилж, 126 гишүүнээс 97 гишүүн хүрэлцэн ирж, 77.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

**2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 10 минут**

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Пүрэвдорж: Их Хурлын гишүүдийн болон Монгол Улсынхаа иргэдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Нийт 67 гишүүн ирж, 53.2 хувиар ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнгөрсөн хугацаанд 2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн болон Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулиудыг баталлаа.

Энд бүх зүйлд дэмжиж ажилласан Их Хурлын гишүүддээ талархлаа. Тэгээд өчигдөр Жадамбын Бат-Эрдэнийг Монгол Улсын Их Хурлын дэд даргаар томилох тогтоолыг бид бүхэн баталсан. Мөн түүнчлэн Улсын Их Хурлын даргын албан үүргийг гүйцэтгэх тогтоолыг бас бид бүхэн баталсан. Энэ хууль, энэ тогтоолыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-ын дагуу Улсын Их Хурлын Хурлын дарга энийг ёсчилж гарын үсэг зурсан. Тийм учраас Жадамбын Бат-Эрдэнэ таныг чуулганы хуралдааны даргын суудалд урьж дараагийн асуудлуудыг хэлэлцэж өгнө үү гэж урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүдийнхээ энэ, Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэнэ.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Засгийн газраар 2025 оны 10 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн төсөл байгаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл”. Тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын

Учрал танилцуулна. Тэгвэл хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатар танилцуулна.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар таныг индэрт урьж байна.

Г.Занданшатар: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7-д заасны дагуу Хөгжлийн бодлого, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн Монгол Улсын Засгийн газраас 2026-2030 онд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулан танилцуулж байна. Энэхүү шинэ итгэл, эрс шинэтгэл хөгжлийн таван жилийн үндсэн чиглэлийг Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, мөн ШУА тооцоо судалгаа, шинжлэх ухаан дээр үндэслэж, гуравдугаарт ард түмнийхээ санал бодол, хүсэл эрмэлзэлд нийцүүлэн ийм 3 тулгуур хүчин зүйл дээр үндэслэж боловсрууллаа.

Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэдэг. ШУА-ийн Бага, Их чуулган, эрдэмтэн судлаачид, төсөв захирагчид, бизнес эрхлэгчдээр шүүн хэлэлцүүлж нийт 644 санал, санаачилга гарсныг нэг бүрчлэн судлан үзэж, 7 хэмжиж, 1 огтлох зарчимд нийцүүлэн боловсруулсан ийм хөгжлийн төлөвлөгөө юм. Зүг чиг зөв бол хүрэх газар дөт гэдэг үгтэй. Хөгжилд хүрэх газрын зургаасаа гажихгүй бол хүчирхэг Монголыг цогцлоох үйл хэрэг бүтэмжтэй байх нь эргэлзээгүй. Ингээд олон тооцоо судалгаа, эрдэмтэн судлаачдын дүгнэлтээс зүйлийг би эхэнд нь онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, тусгаар тогтнол, хамаарал туйлын эмзэг байна. Үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдлын хүчин зүйл нэн эмзэг байгааг нууц биш нууц болоод бүх хэлэлцүүлгээр тод ярьсан. Манай гадаад худалдааны 70 гаруй хувь, экспортын 90 гаруй хувь нь 1 улсаас цөөн тооны нэр төрлийн бүтээгдэхүүнүүдээс хамааралтай, эрчим хүчний 24 хувь, түлш шатахууны хувьд 100 хувь импортоос хамааралтай. Монгол Улсын гадаад өр, ДНБ-ий 160 хувьд хүрсэн. Айлаар зүйрлэвэл 1 сая төгрөгийн орлого олдог, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, бүтээдэг 1 сая 600 мянган төгрөгийн өртэй гэсэн үг. Эдийн засгийн төржилтийн индексээр 145 орноос 139-д эрэмбэлэгдэж байна. Үндсэндээ эдийн засаг төрөлжөөгүй дан ганц 1 салбараас хамааралтай гэсэн утгатай. Тоо худлаа хэлдэггүйгээс гадна тоо юу хэлэх вэ гэдэг бас их онц чухал. Эдгээр тоон үзүүлэлтүүд бол Монгол Улсын эдийн засгийн тусгаар тогтнол хэврэг, эмзэг, хамаарал ихтэй байгааг илтгэж байгаа юм.

Ийм учраас эдийн засгаа төрөлжүүлж хамаарлаа бууруулах явдал бол хөгжлийн үндсэн чиглэлийн үндсэн зорилго бас өгөгдөж байгаа даалгавар юм. Тиймээс шинэ итгэл, эрс шинэтгэл хий хоосон уриа биш бодит ажил, шийдэх асуудлын бүрэн багц, бүрэн зураглал байх учиртай гэж төлөвлөлөө. Ирэх 5 жилд юунд, хаана, хэрхэн, яаж, ямар үр дүнд хүрэхийг заан тодорхойлсон замын зураг юм. Ирэх 5 жилд эдийн засгаа бүтцээр нь өөрчилж, өсөлтөө тогтвортой хадгалж, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлж өөрөөр хэлбэл эдийн засгийн төрөлжилтөө нэмэгдүүлэх явдал энэ төлөвлөгөөний үндсэн 1 зорилго бөгөөд өсөлтийг өрх бүрд, айл бүрийн хаалгаар оруулах явдал энэ иж бүрэн

төлөвлөгөөний гол зорилго байх ёстой. Шинэ итгэл, эрс шинэтгэлийн гол зорилгоо болгосон Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөл нь хүний хөгжил, нийгмийн хөгжил ба үндэст үндэсний нэгдмэл үнэт зүйл, эдийн засаг ба дэд бүтцийн хөгжил, байгаль орчин, ногоон эдийн засаг, засаглал, дижитал шилжилт, бүсийн хөгжил, үндэсний өрсөлдөх чадвар, шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэж байгаа.

Үндэсний хэмжээнд зорих 10 салбар, 10 салбарын хэмжээнд зорих 35, төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд зорих 85, хөтөлбөрийн хэмжээнд зорих нийт 200 үр дүнг тус тус тодорхойлсон. Эдгээр үр дүнгүүдийг хэмжих шалгуур үзүүлэлтийг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын 17 зорилтын Монгол Улсад хамаарах 16 зорилгын шалгуур үзүүлэлттэй уялдуулж тодорхойлсон нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын өмнө манай улсын үүрэг, амлалтыг биелүүлэх, нөгөө талаас уг бичиг баримтыг боловсруулсан боловсруулалтын чанарыг сайжруулахад чухал алхам боллоо.

Дээрх бодлогын 8 чиглэлийн хүрээнд үндэсний 10 үр дүнг дараах байдлаар тодорхой тусгасан.

Нэгдүгээрт, боловсрол, эрүүл мэндийн салбарт хийх шинэчлэлийн хүрээнд чанартай хүртээмжтэй, үйлчилгээг иргэн бүрд тэгш хүргэх. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийг бэлтгэх, хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.813 оноонд хүргэнэ 1 бүхлээс. Хүний хөгжил Засгийн газрын хамгийн том мега төсөл байх ёстой. Хүнээ хөгжүүлж байж хүчирхэг Монголыг цогцлоож чадна гэсэн ийм зорилт юм.

Хоёрдугаарт, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, ажлын байранд осол, гэмтэл, хөдөлмөрлөх эрхийн зөрчил маргааныг бууруулах замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлнэ. Ингэж чинээлэг дундаж давхарга бол тогтвортой нийгмийн үндэс, хөгжлийн тулгуур багана гэсэн зорилтоор чинээлэг дундаж давхраа дэмжих татвар, зээл, нийгэм эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. Бид халамжийн тогтолцоонд шинэчлэл хийж хамгийн сайн халамж бол хөдөлмөр эрхлэлт байх зарчмыг удирдлага болгохоор тусгалаа.

Гуравдугаарт, энэ иргэдийн оролцоо, соён гэгээрэл, хамтын хариуцлагыг нэмэгдүүлж, тэгш боломжийг ханган, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн үндэсний соёлын дархлааг бэхжүүлж, эв нэгдлийг бататган, үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн үзүүлэлтийг 55 хувьд хүргэж, эх оронч Монгол бахархлыг түгээн дэлгэрүүлнэ. Ер нь ард түмэнтэйгээ хамгийн ойр байж, тэдний үг санал, үзэл бодлыг сонсож, үр дүнтэйгээр шийдвэрлэж, иргэдийнхээ төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн. Энэ үндэсний үнэт зүйл бол Монголын үзэл санаа, Монгол мөрөөдөл байх учиртай. Монголын мөрөөдөл гэдэг эцсийн эцэст ард түмний мөрөөдөл. Ард түмэндээ нягт тулгуурлаж байж хэрэгжүүлэх учиртай, ард түмнийхээ сайн сайхны төлөө Монгол хүний төлөөх нэгдмэл цогц ойлголтыг бий болгоё гэж байгаа юм Монгол мөрөөдөл гэдэг. Ард түмэн нь улсынхаа эзэн байх, хуулиар улсыг засах явдлыг цэгцтэй нэгдлийг баримтлан ард түмнээ голлох байр сууринд тавьж ардчиллыг өргөжүүлэн хөгжүүлэх нь энэ цэгцрэх хөдөлгөөнийг өрнүүлэх нь бидний нийтлэг зорилт юм. Бид цаг ямагт ард түмнийхээ дуу хоолойг

сонсож, ард түмний итгэл найдлагад хариу өгч, ард түмний эрх тэгш оролцоо, эрх тэгш хөгжих боломж, эрхийг хамгаалан, нийгмийн эрх тэгш, шударга ёсыг сахин хамгаалж боловсрох сургуультай, орлого олох хөдөлмөртэй, эмчлэх эмнэлэгтэй, асруулах газартай, амьдрах орон байртай байлгах чиглэлээр байнга шинэ ахиц дэвшил гаргаж, өргөн олон ард түмний язгуур эрх ашгийг сайтар хэрэгжүүлж, сайтар хамгаалж, сайтар хөгжүүлэн, хөгжлийн үр шимийг нийт ард иргэддээ илүү ихээр, илүү шударга, тэгш хүртээж, нийгэм эдийн засгийн тасралтгүй хөгжлийн суурин дээр хамтдаа чинээлэг дундаж давхаргаа улам бүүр хөгжүүлж тогтвортой урагшлах ёстой юм.

Дөрөвдүгээрт, энэ эрүүл аюулгүй, амьд амьдрах орчинд хүртээмжтэй орон сууц, чанартай нийгмийн хамгааллын үйлчилгээгээр амьдралын чанарыг дээшлүүлж, гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг бэхжүүлж, хүний эрхийн баталгааг ханган хүүхдийн хөгжил хамгааллыг шинэ шатад гаргаж, нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг 20 хувиар өсгөхөөр ийм учраас төлөвлөлөө Монгол хүнийг хөгжлийн бодлогынхоо цөмд нь иргэдийнхээ эрхийг шийдлийнхээ голд нь тавьж асуудалд ханддаг, ард иргэдийнхээ төлөө улс гэрээ боддог ийм төр засагтай байх эрхэм зорилгоо болгож ажиллах учиртайг энд засаглалын шинэчлэлийн хүрээнд тусгалаа.

Тавдугаарт боловсруулах салбарын боловсруулалтын түвшнийг дээшлүүлэн бүтээмж төрөлжилтийг нэмэгдүүлснээр эдийн засгийн тогтвортой өсөлтийг 6 хувиас дээш түвшинд тогтвортой хадгалж, үйлдвэрлэгч Монгол байх үүд хаалгыг нээж хөгжүүлнэ. Үндэсний баялгийн сангийн иргэдэд хүртэх өгөөжийг нэмэгдүүлж, дундаж давхаргыг нэмэгдүүлсэн баялагтаа эзэн Монгол зорилтыг тууштай хэрэгжүүлэхээр тусгалаа.

Зургаадугаарт, анхдагч эко системийн тэнцвэрийг хангаж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, байгалийн нөөц баялгийн нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг дэмжин, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл хэрэглээнээс үүсэх бохирдол, хаягдлыг бууруулж, орчны чанар стандартыг сайжруулж, байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтийг 59 оноонд хүргэхээр төлөвлөлөө. Ногоон орон сууц, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ил тод байдлыг хангана.

Долоодугаарт, авлигыг бууруулж, иргэдийн шүүхэд итгэх итгэл, шударга ёсны тогтолцоог бэхжүүлж, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлж, батлан хамгаалах үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулж, цахимаар нэн тэргүүнд зарчмыг хэрэгжүүлж, иргэн төвтэй үйлчилгээг бүрдүүлж, зөв засаглалын үзүүлэлтээр эхний 90 орны 1 болох зорилтыг тавилаа. Иргэддээ ээлтэй, бас ил тод, нээлттэй засаг болсноор авлигын индексээр арагшаа ухарсан алдаа гажуудлыг засаж, төрийн үйлчилгээг түгжрэлгүй түргэн шуурхай болгох юм. Авлигын эсрэг шүгэл үлээгчийн хамгаалалтыг сайжруулж, ил тод байдлыг бэхжүүлж, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Наймдугаарт, бүс орон нутгийн хөгжлийн ялгааг багасгаж, эдийн засгийн хувьд төрөлжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тэнцвэржүүлж, төвлөрлийг сааруулах замаар орон нутгийн хөгжлийн үзүүлэлтийг 20 хувиар нэмэгдүүлнэ. Аймаг, сумд ажил орон сууц хосолсон хот, тосгоныг хөгжүүлж, ногоон хорооллыг бий болгоно.

Есдүгээрт, бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалан татварын болон гаалийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, Монгол Улс өрсөлдөх чадварын үзүүлэлтээр дэлхийн эхний 50 орны 1 болно. Иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулж, төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг тууштай хэрэгжүүлнэ.

Аравт, Монгол Улсын хөгжилд оруулах шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмрийг дээшлүүлж, төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгааны үр дүн, оюуны өмч, шинэ технологийг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх боломжийг нээж, дэлхийн мэдлэгийн индексийг 52.4 оноонд хүргэнэ. Хиймэл оюуныг төрийн үйлчилгээнд нэвтрүүлсэн цахимаар эн тэргүүнд урайн доор цахим шилжилтийг эрхэмлэгч Засгийн газар байхаар төлөвлөлөө. Ингээд энэ тавьж байгаа, тавьсан зорилт, хүрэх үр дүнд тодорхой, тодорхой хэмжүүртэй дэлхийн стандарт, НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтыг хэмждэг онооны үзүүлэлтүүдээр энэ 10 үзүүлэлтийг бид тодорхойлж томъёолж танилцуулж байна.

2030 он гэхэд экспортыг 22 тэрбум ам.долларт хүргэнэ. Эдийн засгийн өсөлтийг 6 хувиас дээш хадгална. 1 хүнд оногдох ДНБ-ийг жилийн дүнгээрээ 10.7 мянган ам.долларт хүргэнэ. Инфляцыг 5 хувьд хүргэн бууруулна, төсвийн сахилгыг чанд хатуу мөрдөнө, хөрөнгө оруулалтын урсгалаа хувийн хэвшилдээ чиглүүлнэ, орон нутгийн эдийн засгаа дэмжиж төвлөрлийг сааруулна. Мөн хүний хөгжлийн индексийг 8 хувиар сайжруулж, дундаж давхаргаа 20 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн өгөөжийг иргэн бүрд хүргэж, Монгол Улс өрсөлдөх чадвараараа дэлхийн эхний 50 орны 1 болох зорилтыг тавилаа.

Ирэх таван жилийн хөгжлийн төлөвлөгөөг ханган хэрэгжүүлэхэд Монгол Улсын 2026-2030 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг мөн боловсруулж хамт өргөн мэдүүллээ. Энэ хөтөлбөрт 30 тэрбумаас дээш өртөгтэй ТЭЗҮ зураг, төсөл нь хийгдсэн урт болон дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан томоохон төслүүдийг эрэмбэлж, энэ хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгалаа. Өөрөөр хэлбэл энэ зорилгоо хөрөнгө оруулалтаар баталгаажуулсан ийм бодит хөтөлбөр юм. Монгол Улсаас Монгол Улсын 2026-2030 онд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 66.6 их наяд төгрөгийн үнэлгээтэй 87 төсөл тусгагдсан. Үүнээс 39 төсөл нь буюу 44.8 хувь нь улсын төсвийн дэмжлэгээр, 25 төсөл нь буюу 28.7 хувь нь гадаадын зээл, тусламжаар, 14 төсөл буюу 16.1 нь шууд хөрөнгө оруулалтаар 8 төсөл төр, хувийн хэвшлийн түншлэл, холимог эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тооцлоо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Чинээлэг дундаж нийгмийг иж бүрэн цогцлоож, баян хүчирхэг, ардчилсан, соёл иргэншилтэй, эв нэгдэлтэй, шинэ цагийн Монгол Улсыг байгуулах зорилтоо хэрэгжүүлэн Монгол Улсынхаа сэргэн мандалтыг илэрхийлсэн Монголын мөрөөдлийг бий болгон түүнийгээ бодитой хэрэгжүүлнэ гэдэг улсаа хүчирхэг баян болгож, үндэсний мандуулан бадрааж, ард иргэд бүрээ зол жаргалтай амьдруулах явдал бөгөөд өнөөгийн Монгол Улсын иргэний мөрөөдлийг гүн гүнзгий илтгэж, бас

үе үеийнхний маань цуцашгүй тэмүүлж урагшлуулж ирсэн гайхамшигт өв уламжлалаа шинэчлэлээр баяжуулан хөгжүүлэх зорилт хөтөлбөр юм.

Монголын онцлогтой ардчиллын үйл хэргийг урагшлуулж, Монгол үндэстний сэргэн мандлын Монголын мөрөөдлийг биелүүлэхээр тасралтгүй тэмцэх ёстой. Хөгжлийн алсын хараагаа улам тодосгож хүрэх зорилтын чигээ нарийвчлан тодорхойлсон “Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг эрхэм гишүүд та бүхнээсээ хичээнгүйлэн хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа. Мөнх хөх тэнгэрийн дор Монгол Улс мандан бадрах болтугай.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг танилцуулна.

М.Энхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хийлээ.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг шинэ итгэл, эрс шинэчлэлд зорин, хүний хөгжил, нийгмийн хөгжил ба үндэсний нэгдмэл үнэт зүйл, эдийн засаг ба дэд бүтцийн хөгжил, байгаль орчинд ногоон эдийн засаг, засаглал, дижитал шилжилт, бүсийн хөгжил, үндэсний өрсөлдөх чадвар, шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун гэсэн бодлогын 8 чиглэлээр бүрдэхээр боловсруулж, энэ хүрээнд үндэсний 10, салбарын 35, төсвийн ерөнхийлөн захирагчийн 85, хөтөлбөрийн 200 үр дүн, нийт 330 үр дүнг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлттэй уялдуулан тодорхойлжээ.

Дээрх бодлогын 8 чиглэлийн хүрээнд үндэсний 10 үр дүнг дараах байдлаар тодорхойлон тусгасан байна. Үүнд:

1.Чанартай, хүртээмжтэй боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг иргэн бүрд тэгш хүргэж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийг бэлтгэн хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг сайжруулах.

2.Хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулах замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын эзлэх хувийг нэмэгдүүлэх.

3.Эх хэл, түүх, соёл, өв соёлоо дээдэлсэн үндэсний соёлын дархлааг бэхжүүлэн эв нэгдлийг бататган үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн үзүүлэлтүүдийг сайжруулах.

4.Эрүүл, аюулгүй амьдрах орчин, хүртээмжтэй орон сууц, чанартай нийгмийн хамгааллын үйлчилгээгээр амьдралын чанарыг дээшлүүлж, гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг бэхжүүлж, хүүхдийн хөгжил, хамгааллыг шинэ шатанд гаргаж, нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтүүдийг сайжруулах.

5.Боловсруулах салбарын боловсруулалтын түвшнийг дээшлүүлж, бүтээмж төрөлжилтийг нэмэгдүүлснээр эдийн засгийн тогтвортой хөгжлийг хадгалах. Анхдагч эко системийн тэнцвэрийг хангаж, уур амьсгалын өөрчлөлтийг сайжруулж, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг дэмжин байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлж байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтийг сайжруулах.

7.Авлигыг бууруулж, шударга ёсны тогтолцоог бэхжүүлж, ил тод байдал хариуцлагыг нэмэгдүүлж, цахим засаглалыг дэмжиж, иргэн төвтэй үйлчилгээг бүрдүүлж, төв засаглалын үзүүлэлтүүдийг сайжруулах.

8.Бүс орон нутгийн хөгжлийн ялгааг багасгаж, эдийн засгийн хувьд төрөлжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тэнцвэржүүлэх замаар орон нутгийн хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах.

9.Бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, татварын болон гаалийн шинэчлэлтийг гүнзгийрүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтийг сайжруулах.

10.Монгол Улсын хөгжилд оруулах шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмрийг дээшлүүлж, төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, дэлхийн мэдлэгийн индексийг сайжруулна гэж ээ. Тогтоолын төслийг D-Parliament цахим сайтад байршуулж, иргэн олон нийтийн санал авч байна. Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга ТӨК-удын хэдэн хувийг хэзээ, яаж хувьчлах талаар, мөн уул уурхайн салбарын тогтвортой байдлыг хангахын тулд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хэрхэн хамгаалах талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд инфляцыг хянаж, салбар хоорондын дундын зохицуулалтыг хийхэд ямар бодлогын арга хэмжээ төлөвлөсөн талаар, мөн Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой ямар бүтцийн өөрчлөлт хийх бодлогын арга хэмжээг авах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг ирэх 5 жилд эрчим хүчний салбарын хэдэн хувийг либералчилж, чөлөөт өрсөлдөөнтэй болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь өмнөх бодлогын баримт бичгүүдээс ахиц дэвшил авчрах ямар бодлого боловсруулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үр дүнг дүгнэсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал нүүрс, химийн үйлдвэрлэлийг яагаад орхигдуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх бодлого, үүнд чиглэсэн хөдөлмөрийн талаар асуулт асууж хариулт авлаа. Хөтөлбөрүүдийн талаар асуулт асууж хариулт авлаа. Мөн Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг эрчим хүчний салбарын зах зээлийг либералчлах, чөлөөт өрсөлдөөнийг бий болгох талаар ирэх 5 жилд ямар үр дүнд хүрсэн байх талаар энэхүү бодлогын баримт бичигт нарийвчлан тусгах шаардлагатай талаар Монгол

улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн нь хэт ерөнхий байгаа байдал нь эрчим хүчний салбарыг либералчлах, чөлөөт өрсөлдөөн бий болгох, саад болж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үр дүнг хэрхэн үнэлсэн талаар, мөн монгол улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байгаа талаар, ирэх таван жилийн үндсэн чиглэлдээ энэ дагуу гарсан санал, дүгнэлт зөвлөмжийг тусгах талаар тус тус санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад 50 хувийн саналаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны хуралдааныг даргалсан Улсын Их Хурлын гишүүн Ц.Лодойсамбуу.

Ж.Бат-Эрдэнэ: Энхцэцэг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийн нэрсийг уншиж танилцуулъя. Гомбожавын Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд, Ням-Осорын Учрал Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын шадар сайд, Хассуурийн Ганхуяг Монгол Улсын Шадар сайд, Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Батмөнхийн Батцэцэг гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Баттөмөрийн Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Батын Батбаатар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Чинбатын Ундррам Спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Энхтайваны Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Энхбаярын Батшугар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Жигжидсүрэнгийн Чинбүрэн Эрүүл мэндийн сайд, Лхагважавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яам Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батмөнхийн Насантогтох Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн

дарга, Бямбасүрэнгийн Даваацэрэн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөрхуягийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Чулуунцэцэгийн Золбаяр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Түмэндалайн Даваадалай Нийслэлийн Засаг даргын Нэгдүгээр орлогч, Амгаланбаярын Амартүвшин Нийслэлийн Засаг даргын Хоёрдугаар орлогч Агипарын Бакей Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч, академич, Сүхрагчаагийн Нямзагд Шинжлэх ухааны академийн академич, Дамдиннямын Дагвадорж Шинжлэх ухааны академийн академич, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулах газрын дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Батаагийн Батцэцэг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Булгаагийн Ганбат Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх, Ганхуягийн Цэрэнжаргал НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн үр дүнд суурилсан төлөвлөлтийн зөвлөх, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Батболдын Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Гүнтэвсүрэнгийн Бямбасүрэн Гадаад харилцааны бодлогын газрын захирал, Аюурзанын Энх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Чулуунбарын Гандирваа Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Түвдэндоржийн Балжинням, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохистой ашиглалтын газрын дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалтын нутгийн бодлогын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны газрын дарга, Юрагийн Отгонбилэг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга, Ганбадраагийн Батбаяр Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Чадраабалын Сугармаа Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга, Жамъянгийн Отгонбат Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Оюуны Одбаяр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Цэнджавын Борхүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга, Баярмаагийн Туяа Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар

дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжлийн нийгмийн бодлогын хэлтсийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батжаргалын Төгөлдөр Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжил, төсөл хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Зияханы Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн хүмүүс ажлын хэсэгт ирсэн байна.

Ингээд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Асуулт асуухаар 39 гишүүн нэрээ өгсөн байна. 39 хүн гишүүний нэрсийг тасаллаа. Ирцээрээ орсон байх. Мөнхсоёл гишүүний микрофоныг нээе. Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Өглөөний мэнд бүгдийнх нь энэ өдрийн амрыг айлтгая. Тэгээд шууд 1 дүгээр асуулт эдийн засаг дахь төрийн оролцооны талаар асуумаар байна. Өчигдөрхөн би шинэхэн гарсан судалгааны үр дүн сонссон. Олон үзүүлэлт, олон асуудлуудыг ярьж болно. Хоёрхон үзүүлэлтийг дурдъя. 1 дүгээрт нь олон улсад хэмжигддэг хэмжигдэхүүн, татварын орлого ба ДНБ-ий харьцаа, олон улсын түвшинд энэ нь 15-20 хувь байдаг бол Монгол Улсын түвшинд энэ нь 34.2 хувьтай байна.

2 дугаар үзүүлэлт болохоор Засгийн газрын зарлагыг ДНБ-д харьцуулсан харьцаа. Олон улсын түвшинд энэ нь 25-30 хувьтай байдаг бол Монгол Улсад энэ нь 37.9 хувьтай байна. Энэ 2-ыг харахад л Монголд эдийн засаг дахь төрийн оролцоо өндөр байна. Энийг бизнесийнхэн, аж ахуйн нэгжийнхэн ч гэсэн маш их шүүмжилж ярьдаг. Энэ дээр ямар бодлого хэрэгжүүлэх гэж байна? Тодорхой хариулт авъя.

2 дугаар асуулт болохоор энэ ерөнхийд нь харахад энэ хүрэх зорилго хэмжигдэхүйц байдлаасаа харьцангуй сайн ийм төлөвлөгөө гарсан байна. Гэхдээ яг агуулга, ажлын цар хүрээний хувьд бас тодорхойгүй зүйлүүд их байна. Үүнтэй холбогдуулаад асуухад олон жил ярьсан нөгөө эдийн засгийг солонгоруулах, сая Ерөнхий сайд бас хэллээ шүү дээ хэвтэх эмнэлгийн тоо гэгчихсэн. Бид нарын бодлоор сүүлийн үед ялангуяа шүүмжлэгдэж байгаа Эрүүл мэндийн даатгалын сан, урьдчилан сэргийлэх чухал байна. Хүмүүсийн эрүүл мэндийн хувьд. Хоёрдугаарт нь болохоор илүү өвдсөн хойно нь хамгаалахаасаа илүү өвдөхөөс нь сэргийлэх ийм бодлогууд чухал байна гээд ярьсан.

Түүнчлэн гэр бүлийг дэмжих бодлого, нөгөө эрчим хүчний либералчлал энэ тэртэй холбоотой яг тодорхой реформын шинжтэй ажлууд байна уу, хэрхэн яаж хүрэх шийдлүүд нь байна вэ, ямар стратеги байна вэ гэдгийг асууя. Төсвийн ерөнхийлөн захирагчдын хувьд бид нар тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралт 1-ээр хүрэх үр дүн, зорилго, зорилтод хүрэх түвшнийг тодорхойлдог шүү дээ. Гэтэл энэ таван жилийн төлөвлөгөөнд тусгачихсан байгаа нь үүнээс цааш

тухайн тухайн жилийн төсвийн төсөлд орж ирэхгүй гэсэн үг үү энэ нь? Уг нь богино хугацаандаа энийг төлөвлөөд явбал чухал юм болов уу гэсэн ийм санал байгаа юм. Ийм тодорхой асуултууд асуучихъя. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд, Занданшатар Ерөнхий сайд хариулъя

Г.Занданшатар: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Чухал асуулт байна. Ер нь эдийн засаг дахь төрийн оролцоог interventionism буюу тэгээд энэ төрөөс оролцож байгаа монопол, Монополын эсрэг хууль, төрийн татаас, татварын ачаалал гээд олон үзүүлэлтүүдээр хэмждэг. Тэр дотроо татварын ачаалал бол таны хэлснээр 2026, одоо 33.4 хувьтай байгаа нь үнэн. 2026 онд 31.5 хувь болохоор саяын батлагдсан төсвөөр 1.9 функтээр бууруулж тооцож байгаа нь цаашдаа татварын ачаалал хэр хэмжээгээр буурна, тэр хэмжээгээр төрийн оролцоо тэр хэмжээгээр буурна гэсэн ийм чиглэлтэй байна. Олон жилийн дунджаар манай улсын нийт орлогод эзлэх татварын болон татварын бус орлогын харьцаа 90.10-тай байгаа. Сүүлийн 2, 3 жилд татварын орлого өссөн нь цэвэр уул уурхайн өсөлттэй холбоотой. Цэвэр уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой, бас экспортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин нэмэгдсэнээр татварын орлого өсөж, татварын орлого 92 орчим хувь руу дөхсөн. Ингээд энэ хэмжээгээр төсөв тэлсэн. Төсөв тэлээд данхайх тусам төрийн оролцоо бас томорсон. Одоо бол бид мөчлөг дагасан сөрсөн бодлого явуулж, төсвөө хумих чиглэл баримталж байгаа. Дэлхийн бусад орнуудын жишээнээс харвал хөгжингүй орнууд буюу илүү либерал эдийн засагтай АНУ, Герман зэрэг улсуудын татварын бус орлого маш бага байдаг. Манайх социал демократ чигтээ гэдэг юм уу, Швед, Скандинавдын орнуудынх чинь саяын татварын ачаалал 50 хүртэл хувь ч бий. Япон, Солонгос зэрэг улсуудын татварын бус орлого ч гэсэн маш бага байгаа. Учир нь тухайн орнуудын татварын бааз суурь илүү тогтвортой байгаа юм. Эдийн засаг нь төрөлжсөн байгаа юм. Ганц уул уурхайгаас хамааралтай, үнээс нь хамааралтай, дээш тийшээ савладаг эдийн засаг бий болчихоод байна л даа.

Харин байгалийн баялагтай орнууд, жишээлбэл Норвег, Казахстан зэрэг орнуудын хувьд татварын бус орлого харьцангуй өндөр 10-30 хувь байдаг нь ноогдол ашгаар дамжуулж орлого бүрддэгтэй холбоотой, бусад орлогоор бүрдэхтэй холбоотой. Ерөөсөө л төрийн оролцооны хамгийн том элемент уул уурхайн эдийн засаг. Уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засаг болчихоод сая бид энийгээ төрөлжүүлъя, солонгоруулъя, таны хэлж байгаа энэ бодлого чинь татварын бодлого, мөнгө зээлийн бодлогоор дэмжихгүй бол манайх импортын татвар ч тэр хэт бага, дотоодын үйлдвэрлэл өрсөлдөх чадваргүй, төрөлжих боломжгүй, бусад улстай өрсөлдөх чадвартай болгож үндэсний үйлдвэрлэлээ бойжуулж хөгжүүлэх шаардлагатай байгаа. Ийм учраас татварын бус орлогоо нэмэгдүүлъя гэвэл ногдол ашиг, навигацийн орлого, хүү, торгуулийн орлогуудыг л нэмэгдүүлэх замаар өсөж болно. Ер нь уул уурхайн салбарын орлогын төсвийн орлогын 26.7 хувийг бүрдүүлж байгаа саяын 33.4-ийн. Уул уурхай үнийн циклээсээ хамаараад татварын ачаалал зарим жилүүдэд өсөх, зарим жилүүдэд буурах .../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Мөнхсоёл гишүүн тодруулъя.

Б.Мөнхсоёл: Товчхон зүгээр базаад хэлчихье дээ. Одоо иргэд чинь, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх чиглэлд бас их зорьж ажиллана гээд сая өөрөө танилцуулгадаа хэлчихсэн. Энийг би маш чухал гэж боддог хувь хүн байгаа юм. Ноднин л чуулган анх эхлэхэд л хэлж байсан үг. Хоёрдугаарт нь хүмүүс үгэнд хууртахаа байсан. Гоё гоё үг, гоё гоё ийм зураг, график, үйлдэл яг бодит гүйцэтгэл маш чухал байгаа. Тэр дээр сайн анхаарч ажиллаарай гээд Засгийн газрын бүх сайд нартаа анхааруулж хэлье л гэж бодож байна даа.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд Занданшатар сайд 1 минут.

Г.Занданшатар: Мөнхсоёл гишүүний хэлж байгаа зүйлтэй санал нэг байна. Үг, үйлдэл байх ёстой. Ер нь тэгээд түрүүнийхийг гүйцээж хариулж амжсангүй. Ер нь товчхондоо хэлэхэд бид аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг хамгийн том саад хоригуудыг арилгах замаар бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ гэж зорьсон. Одоо бид өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцэж танилцсан. Удахгүй Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Энэ бол бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшлээ илүү эрх чөлөөтэй дарамт шахалтаас ангид байлгахад чиглэгдсэн Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Баялаг бүтээгчдийг дэмжих багц хуулийг өргөн барихаар ажиллаж байна. Аж ахуй нэгжүүдэд тулгардаг нэг бэрхшээл бол зөвшөөрлийн хүнд суртал, дарамтын бизнест нь халддаг энэ бүх эрх чөлөөг нь хаасан, боомилсон хуулиудыг өөрчилж, 100 гаруй хуулийн төсөл дээр энэ дагаж өөрчлөлт орсон ийм цогц хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үгээ хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ таван жилийн үндсэн төлөвлөгөө чинь, үндсэн чиглэл батлах тухай энэ тогтоол чинь мэргэжлийн Байнгын хороон дээр уначихсан юм байна. Бүүр мэргэжлийн Байнгын хороон дээр унана гэдэг чинь энэ Их Хурал давахгүй гэсэн үг л дээ. Тэгээд энэ юунаас шалтгаалж байна вэ гэх дээр яг Учрал сайд орсон байж таарлаа. Бусад нь байхгүй байсан байж таарна. Тэгээд яг мэргэжлийн асуулт асуухад тэр сайд нар нь огт хариулаагүй л гэсэн үг л дээ. Тэгээд өнөөдөр ингээд харж байхад чинь танай Занданшатар дарга танай энэ сайд нар чинь бас таныг хүндэтгэхгүй энд суухгүй байна шүү дээ. 6, 7-хон сайд л сууж байна. Доржханд сайд чинь бүүр засгаас гарах юм сан гэхчхэн явж байна лээ. Тэр ч яах вэ. Тэгээд энэ баахан 40 хэдэн хүний ажлын хэсгийн хүмүүсийн нэрийг хэллээ. Сайд нар чинь ажлаа мэддэггүй юм уу, цөөхөн салбартай шүү дээ та нар. Би бүгдийг нь цээжилчихнэ, тэгээд бодлогоо толгойдоо хийчихнэ, тэгээд ингээд хариулаад л явчихна. Гэтэл та нарын ингээд байж байгаа царай нь иймэрхүү л байна.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд, 1 жилийн хугацаанд Хөгжлийн банкин дээр манай Нарантуяа гишүүн, захирал сүрхий ажилласан. Зардлуудыг багасгасан, бага хүүтэй бонд босгосон, тэрийгээ сольсон. Тэрний үр дүнд зардал багасаж байгаа. Саяхан халчих нь байна лээ. Тэрийг нь Хөгжлийн банкиг бодлогоор дэмждэггүй, зээл олгох тэр эрхийг нь гаргаж өгдөггүй. Энэ юунаас шалтгаалж байна вэ гэхээр Засгийн газрын хамтын шийдвэр гарсан тэр асуудлаар өнөөдөр Алтанхуяг даргыг буруутгаад шүүх дээр явж байгаа учраас энэ Засгийн газар нь ямарваа нэгэн шийдвэр гаргаж өгдөггүй, зээл гаргадаггүй. Тэнд 100 гаруй хүн сууж

байгаа. Бүгдээрээ цалин аваад л тэгээд л байж байх санаатай. Ерөөсөө хумсаа нуусан муур шиг тийм хүмүүс л байдаг юм байна гэж байна лээ.

Тэгээд энэ хүрээндээ та бас тэр нөгөө Гантиг вилла дээр очоод тэр Капитал банкны Эрүүл мэндийн даатгалын сангийн асуудлаар баахан байр хурааж авна гээд явсан байх. Одоо тэр газар чинь тэгээд л гацаанд орчихсон аль байрыг нь хурааж авах юм, алийг нь хурааж авах юм, ямар байрыг нь хурааж авах юм мэдэхгүй тэр аж ахуйн нэгж чинь бас гацаанд орчихсон юмаа төлөвлөж чадахгүй хэцүү байна гэж байна лээ шүү дээ. Над дээр ирж гомдлоо ярьсан. Энэ дээр ямар арга хэмжээ авах юм? Тэр хүмүүс чинь бас тодорхой ажлуудаа хийх ёстой.

Хоёрдугаарт нь Зэс хайлуулах цогцолбор гээд компанийг байгуулсан. Ардчилсан намаас бас энэ менежер энэ тэр томилогдоод л очоод ажилласан. Тэр Эрдэнэтийн зэсийн тендерийн мафийнхан бүгдээрээ зогсоогоод ажлыг нь ерөөсөө хийлгэдэггүй. Санхүүжилтийг нь өгдөггүй. Тэгээд одоо ингээд тэд нар яах гэж байна гэхээр хамгийн муу технологиор Эрдэнэт үйлдвэрийнхэн нь тэр зэс хайлуулах үйлдвэрийг шахаж байгаа. Тэр нь лоббитой байгаа. Сайн технологийг одоо оруулж ирэхийг зөвшөөрдөггүй.

Тийм учраас энэ дээрээ та нар яг нөгөө Засгийн газраараа яг хариуцлагатай байж байгаад хамгийн сайн технологи, зардал багатай, илүү сайн технологитой тэр үйлдвэрүүдийг авчрах талаар та нар бүгдээрээ хариуцлагатай байгаарай. Хэн нэгэн дарга нар шийдэх юм бол тэгээд дараа нь шийдчихээд хаячихаад алга болчихно. Монгол хохироод л үлдэнэ. Тийм учраас энэ дээрээ та нар бүгдээрээ бод л доо Засгийн газраараа хамтдаа бүр ажиллаж байж шийдвэр гаргаарай л гэж. Тэр чинь 1 тэрбум долларын үйлдвэр шүү дээ. Тийм учраас Засгийн газраар хамтдаа бүүр цаана нь гарч байгаа зөв үйлдвэрийг авчраарай л гэж би та нарт зөвлөмөөр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя. Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн бас санаа зовж сайхан үгийг боож хэлсэнд хариуг нь хэлье. Баруун тийшээ харвал Доржханд сайд хажууд чинь сууж байна. Тэндээс тодруулж асуугаарай. Тийм, зүүн тийшээ харвал бүх сайд нар сууж байна нүдээ том нээгээд хараарай гэж хүсээд, Пүрэвдорж гишүүн ээ юу чинь, ер нь манай энэ хэт улс төржсөн томилгоонууд засгийн ажлыг явуулахад саад болдог. Тийм учраас энэ Хөгжлийн банкны тухай хуулиар олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох ёстой албан тушаалууд дээр жишээлбэл улс төрийн шинж чанартай томилгоонууд хийгдсэн зарим ажилд гацаа саад учруулдаг.

Тийм учраас тэр Гантиг Вил, Хөгжлийн банкны хөрөнгө хураах ажлуудыг эрчимжүүлэх зорилгоор өөрчлөлтүүд хийгдэж байгаа. Энэ талаар Цэнгэл дарга хариулна. Гантиг Вилла болон Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сангийн хөрөнгүүдийг төвлөрүүлэх ажил эрчимтэй хийгдэж байгаа. Тодорхой үр дүнгүүд гарч байгаа. Энэ талаар Цэнгэл дарга хариулна. Зэс хайлуулах үйлдвэрийг Бямбацогт сайд хариулна. Өөр ямар асуулт асуулаа Пүрэвдорж гишүүнээ? Ерөнхийдөө Доржханд сайд сая эдийн засгийн асуудлууд дээр хариулна.

Ж.Бат-Эрдэнэ: Микрофон, 4 номерын микрофон. Индрийн 4 номер.

Б.Цэнгэл: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Ерөнхий сайдын 75 дугаар захирамжаар энэ асуудлыг хариуцах ажлын хэсгийг томилон ажиллуулж байгаа. Ажлын хэсэг 5 удаа хуралдсан, газар дээр очиж ажилласан. Эхний ээлжид ер нь Хөгжлийн банк, Чингис банк, Капитал банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк гэсэн банкнууд дээр байгаа төртэй холбоотой 1.4 их наядын асуудал байж байгаа. Өр төлбөрийн асуудал. Эхний ээлжид бид нар Хөгжлийн банкны активыг сайжруулах чиглэлээр өр төлбөрийг барагдуулахаар ажлын хэсэг ажиллаж байгаа. Энэ 11 сардаа багтаагаад Засгийн газраар бид нар танилцуулж тогтоол гаргуулахаар ажиллаж байгаа. Энэ дээр бид Хөтөлтэй холбоотой 460-аад тэрбум төгрөгийн асуудал, Шинэ Яармаг хороолол, таны ярьж байгаа Гантиг вилла, мөн 3, 4 аж ахуйн нэгжүүдтэй холбоотой асуудлыг Засгийн газраар шийдвэр гаргахаар ажиллаж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Зэс хайлуулах үйлдвэрийн төсөл их олон жил яригдсан юм байна лээ. Эрдэнэт үйлдвэр сүүлийн жилүүдэд харин эрчимтэйхэн ТЭЗҮ хийгээд, ТЭЗҮ хийгээд дуусаж байгаа. Одоо Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн зөвлөлөөр, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр батлагдчихсан. Ойрын үед олон улсын нээлттэй сонгон шалгаруулалт зарлана. Энэ үйлдвэрт хөрөнгө оруулах энэ үйлдвэрийн технологи, менежментийг хамтарч хариуцах ийм олон улсын юунд нээлттэй. Тэгэхээр энд ямар ч компани оролцох бололцоотой. Энэ дээр энд ямар хардлага сэрдлэг, дээрээс нь юу гэдэг юм хямд үнэтэй муу технологи ороод ирчих бий гэж хардах шаардлагагүй. Ер нь Эрдэнэт үйлдвэр харьцангуй ил тод болсон. Гэрээний хулгай, тэр шахааны хулгай, овоолгын хулгай гээд бүх юмыг цэгцэлж байгаа. Энэ зэс хайлуулах үйлдвэр ч гэсэн ил тод нээлттэй олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар хамгийн сайн компани орж ирнэ ээ гэдгийг бас албан ёсоор хэлчихье.

Ж.Бат-Эрдэнэ: Доржханд сайд.

Т.Доржханд: Баярлалаа. Эдийн засгийн төрөлжилтийн асуудал дээр тайлбарууд бас байгаа юм. Тэрний өмнө бас тайлбар хийхэд энэ Пүрэвдорж гишүүн бид 2 өмнөх 4 жил маш их сайн гар нийлж ажилласан юм уг нь. Тэгээд ингээд ХҮН намын даргын өмнөөс мэдэгдэл хийдэг болчихсон байна. Тэгмээргүй байна. Би бид 2 огт тийм зүйл яриагүй. ХҮН нам бол өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үнэхээр манлайлж хийсний хувьд ачаагаа үүрье. Монгол Улс ингээд 2 талдаа хуваагдаад ажил хийдэггүй хий эргэдэг байдлыг зогсооё гээд ингээд маш их итгэл үнэмшилтэйгээр Засгийн газарт ажиллаж байгаа шүү. Өнөөдрийг хүртэл улс төрийн ямар ч мэдэгдэл хийгээгүй шүү бид нар. Аль нэгэн нам нь муу, сайн гэж огт хийгээгүй. Харин энэ намууд төлөвшөөд, бүрэн бүтэн болоод улсынхаа ачааг үүрээд яваасай гэдэг энэ тал дээр хатуу байдаг. Тийм болохлоор бид нар ачаагаа үүрээд явна. Ардчилсан нам хэрвээ ХҮН намыг гаргамаар байгаа бол түүнийгээ хэлээрэй. Бид нар муулуулсан ч сайлуулсан ч гэсэн үр дүн гаргахын төлөө зүтгэж явна гэдгээ ХҮН намын дарга.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль 11 жилийн өмнө батлагдаад 6 жилийн өмнө шинэчилсэн найруулга нь батлагдсанаас хойш 2 дахь удаагийн улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Их Хурлаар хэлэлцэгдэх гэж байгаа юм. Тэгээд өмнөх таван жилийн үндсэн чиглэлийн төлөвлөлтийн хэрэгжилт хангалтгүй байгаа талаар Байнгын хороон дээр тавьсан илтгэл, танилцуулгын үеэр бас ийм дүгнэлт гарсан байна. Тэгэхээр ер нь үндсэн шалтгаан нь хэмжиж чадахгүй байгаа, хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж буюу асуудлыг шийдвэрлэж чадахгүй гэсэн тийм зүй тогтол харагдаж байгаа юм байна. Тэгэхээр ингээд дараах саналуудыг хэлмээр байна.

Нэгдүгээрт нь болохоор энэ үндсэн чиглэлийн хүрээнд зорилго, үр дүн, шалгуур үзүүлэлт, арга хэмжээ, төсөв гэсэн ийм гинжин холбоосыг бүх салбарт нэг загвараар мөрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна Ерөнхий сайд аа. Өөрөөр хэлбэл хэм хэмжээ.

Хоёрдугаарт, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үр дүнг 4 жилийн эцэст Улсын Их Хурлын түвшинд 1 удаа дүгнэх биш явцыг жил бүр, сар бүрээр нь, цахим байдлаар хяналтын систем бүрдүүлээд ингээд хардаг бол зөв байна гэж үзэж байна. Сүүлийн үеийн судалгаагаар хиймэл оюуны буюу бүтээмэл оюуны үр өгөөж төрийн энэ ашигт үйлийн коэффициентыг нэмэгдүүлэхэд 70 хүртэлх хувиар боломж авчирч байгаа, хэмнэлт авчирч байгаа, үр дүн авчирч байгаа гэсэн зүйл байгаа. Тэр утгаараа энэ цахим, цахим дотроо энэ хиймэл оюун ашигласан хэлбэр рүү бас оруулмаар байна.

Жилийн зорилт төсвийн хөтөлбөрүүдийн хүрээнд жилийн хөгжлийн төлөвлөгөө дарамтгүй дундаж төсөв, гүйцэтгэлийн гэрээг үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлттэй холбож программ төсөвлөлтийн зарчимд шилжихийг бас санал болгож байна. Аймаг тус бүр орон нутгийн нэгж, үндсэн чиглэлтэй 3-5 үндсэн шалгуур үзүүлэлтээр Ерөнхий сайдтай тодорхой гэрээ байгуулан ажиллаад хэрэгжилтийн үр дүнгээр нь санхүүжилтийн татаас, урамшууллын хэмжээг тогтоож олгох нь зүйтэй гэдэг саналыг бас хэлмээр байна.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, үр дүнд хөндлөнгийн үнэлгээг хараат бус бие даасан байгууллагаар хийлгээд Улсын Их Хурал дээр сонсож болно гэсэн саналыг бас хэлэх гэж байгаа. Энэ талаар шаардлагатай гэж үзвэл холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах боломж байна гэж харж байгаа юм. Мөн бас үндсэн чиглэлийн салбар бүрийн багцыг төлөвлөх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ загвар программ хангамж бүхий техникийн хатуу зөөлөн дэд бүтцийг бүрдүүлээд үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн явцыг ил тод байлгахыг бас энэ Эдийн засаг, хөгжлийн яам бас хийвэл үр дүнтэй гэж харж байгаа Учрал сайдаа. Үндсэн чиглэлийн гол индикаторын тодорхойлолт тооцооллын арга, өгөгдлийн форматыг холбогдох сайдуудын хамтарсан тушаалаар батлаад бүх байгууллага мөрдөж ажиллах нь бас бүтээмжийг нэмэгдүүлэх юм байна гэж харж байгаа. Зүгээр жишээ татахад бид нар ингээд утаатай холбоотой асуудлыг сүүлийн 10 гаран жил ярьсан байгууллага нь 8 удаа субъектээ сольсон. Заримдаа Эрүүл мэндийн яам, заримдаа хот, заримдаа Уур амьсгал, байгаль орчны яам, заримдаа Эрчим хүчний яам, заримдаа Ерөнхийлөгчийн Тамгын газар гээд явчихсан.

Тэгэхээр аливаа асуудал дээр тогтвортой хариуцлага хүлээх эзэн байхгүй. Салбар хоорондын дундын ойлголцол муутай, тэгсэн хэр нь тусдаа 1 Засгийн газар мөртөө дотроо гарч байгаа шийдвэрүүд нь уялдаа холбоо багатай, эргээд тэр нь хэмжих нэгжгүйгээс болоод ямар ч гэгээлэг хөгжлийн төлөвлөгөө хөтөлбөр байсан хэмжиж чадахгүй дээр болоод унаад байгаа юм. Тийм учраас бас Монгол Улсын Ерөнхий сайд та бас шатрын спортын хүн энэ улс орны хөгжил дэвшил дээр төлөвлөлт гэдэг юмыг хэмжих нэгжтэй нь шинжлэх ухаанч байдлаар ингэж хангахад энэ таван жилийн хөтөлбөртөө их тусгаасай гэсэн саналыг хэлмээр байна. Санал хэлж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулах уу? Занданшатар Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Яг ийм шалтгааны улмаас Үндсэн хуульд, Үндсэн хуулийн 25.1.7-д хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэсэн заалтыг оруулсан. 2019 он хүртэл үндсэндээ өнгөрсөн 20, 30 жилийн хамгийн алдаа бол яг таны ярьж байгаа нэгдсэн бодлого, төлөвлөлтгүй 174 хөгжлийн бодлого баримт бичиг хоорондоо уялдаа холбоогүй, хэрэгждэггүй, уриа лоозонгийн шинж чанартай хэмжиж болохгүй. Ийм учраас үндсэн хуульчлах замаар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд 2021 оны 1 дүгээр сарын 26-нд билүү 19 онд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулиар баталгаажуулаад, Хөгжлийн төлөвлөлт гэдэг бол хөгжлийн бодлогын хэмжигдэхүйц зорилго, зорилтуудыг үе шаттайгаар тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр тодорхойлсон хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг хүртэл тодорхойлоод шинжлэх ухааны үндэстэй байхаар заагаад. Урт хугацааны хөгжлийн бодлого, дунд хугацааны хөгжлийн баримт бичиг буюу энэ таван жилийн үндсэн чиглэл, таван жилийн үндсэн чиглэл дээрээ үндэслээд аймгийн засаг, аймаг, орон нутгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хөгжлийн зорилтот хөтөлбөр, энэнээсээ үндэслээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр энэ таван жилийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гарах ёстой. Нарийвчилсан төлөвлөгөө нь. Ингээд бүх салбаруудын тоо уялдаа холбоотой нэгдсэн бодлоготой болж байгаа юм. Бүх салбарууд төдийгүй бүх аймаг, сум хүртэл энэ дотор нэгдэж гарах ёстой ийм хууль баталсан байхгүй юу. Одоо энэ Улсын Их Хурлын хууль, та хуулиа үзэх юм бол. Ингээд энэ хуулийн дагуу улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг батална. Одоо хамт батлах гэж байна. Энэний дагуу улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө батална. Жилийн төлөвлөгөөгөө яг энэ хэмжигдэхүйц нэгжээр батална. Жилийн төлөвлөгөөндөө үндэслэж улсын төсөв батлах ингээд энэ бодлого бүгд уялдах ёстой юм.

Харамсалтай нь энэ хэлэлцүүлгийн явц дээр нөгөө улсын жилийн төлөвлөгөө нь энэ таван жилийн үндсэн чиглэлтэйгээ уялдаж батлагдах ёстой байтал мөрөөдлийн жагсаалт болоод тэлээд баталчихсан тохиолдол өнгөрсөн хэрэг дээр гарсан. Ийм учраас төсөв цэгцтэй болоход маш хүндрэл учруулсан. Ийм учраас энийг хаа хаанаа анхаарч энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн байх зарчмыг Улсын Их Хурал, Засгийн газар бүх салбарын түвшинд анхаарч ажиллах шаардлагатай. Тэгж байж энэ бодитой баримт бичиг болж байгаа юм. Хуультай, хуульчлаад энэ таны хэлж байгаа бүх юмыг уул нь заачихсан юм. Хууль маань хэрэгжихгүй яваад байгааг л бид хэрэгжүүлэх гээд байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад Эдийн засаг, хөгжлийн яамыг бий болгосон шүү дээ. Миний бие энэ Бямбацогт бид хэд санаачилж байгаад Эдийн засаг, хөгжлийн яамтай болсон. Эдийн засаг, хөгжлийн яам энийгээ базаж байх ёстой байхгүй юу. Эрдэнэболд тодруулах уу? Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Сая Ерөнхий сайдын хариулт дээрээс үндэслээд тодруулга авах гээд байгаа нь таныг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллаж байхад бас бичиг өгч хандаж байсан асуудал бол энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай холбоотой асуудал 2010 онд батлагдсан. Тэгээд үзэл баримтлалын дотор яг хугацаа заасан хэд хэдэн асуудал байдаг л даа. Эрчим хүчний хараат бус байдлаа 2020 он гэхэд шийднэ ээ, шатахууны асуудлаа 20 он гэхэд шийднэ ээ гээд. Энэнээс нь хойшид ингээд 5 жил өнгөрчихсөн яваад байгаа. Одоо 15 жил. Тэгээд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бас цаг үеийн шинж чанартай үндсэн 6 бүлгээс зайлшгүй өөрчлөх шаардлагатай зүйлүүд байгаад байгаа. Тэгэхээр Монгол Улсын 2050 хүртэл Алсын хараа гэж ярьж байгаа, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал ингээд энэ нөгөө хоттой нийлээд, орон нутагтай нийлээд яг бодлогын тулгуур 11 бичиг баримт хэрэгжиж байна л даа. Яг одоогийн байдлаар. Тэгэхээр энэ таван жилийн төлөвлөгөөгөө та үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай яаж уялдуулсан бэ? Энэ талаар тодруулчихгүй юу.

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүний тодруулгад хариулт өгье. Та хэрвээ анзаарсан бол би хэлсэн үгийнхээ эхэнд эдийн засгийн аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын гол бүрэлдэхүүн, 5 бүрэлдэхүүн хэсгийн нь болох эдийн засгийн аюулгүй байдлын талаар онцолж дурдсан. Энэ бодлогын баримт бичиг маань үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр үндэслэж, тэр хэсэг дээр онцгой анхаарч эдийн засгийн төрөлжилт, хамаарлыг бууруулах ийм чиглэлийн талаар тодорхой ярьсан.

Бодлогын уялдааны үнэлгээ гэдэг асуудал бол Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн 4.1.24-д заагдсан байгаа. Тэрийг та тодруулж харвал энэ дээр бүх зүйлүүд энд үнэлгээ нь хийгдчихсэн байгаа. Ер нь бидний хамгийн гол анхаарах ёстой зүйл хуулиа хэрэгжүүлэх л асуудал байгаад байгаа юм. Бид Үндсэн хуульд зориуд ингэж оруулсан байхгүй юу. Яг л ийм замбараагүй болчихсон учраас Үндсэн хуульд бид санаачилж энийг оруулсан. Одоо энийгээ хэрэгжүүлэх гэж байгаа юм. Хэрэгжилтийг нь хангалтгүй хаячихсан юм байна лээ. Хэчнээн сайн хууль батлаад тэрийг хэрэгжүүлэхгүй буруу хэрэг.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан.

Л.Мөнхбаясгалан: Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал Монгол Улсын Үндсэн хуульд заагдсан байдаг нэг нь үзэл баримтлалтай төслийг энэ 2026-2030 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөнөөс хассан байна. Энэ хасъя гэж хасаагүй болов уу л гэж бодож байна. Яагаад гэвэл энэ бол 333 нуур, 1 нуур, 1 сум усны хуримтлал төсөл юм байгаа юм. Бид энийг заавал энэ хөгжлийн төлөвлөгөө дотор хийх ёстой. Яагаад гэвэл 2050 он гэхэд Монгол Улсын мөнх цас, мөсөн гол үндсэндээ хайлж дуусна гэж эрдэмтэд тогтоосон байгаа.

Хамгийн түрүүнд Отгонтэнгэр хайрхан, Сутай хайрхны мөнх цас, мөсөн гол урсаж байхгүй болох юм. Ингэхээр яах вэ гэхээр Ховд гол тасрах аюултай. Ховд гол тасрах юм бол Их нууруудын хотгор тэр чигээрээ усгүй болно оо. Энэ бол Монгол Улсын эко системийн сүйрэл эндээс эхэлж байгаа юм.

Тэгэхээр бид нар энийг урьдчилан сэргийлэх ёстой. Урьдчилан сэргийлэхийн тулд энэ 333 нуур, 1 нуур, 1 сум гэдэг энэ төслийг манай эрдэмтэд холбогдох байгууллагынхан гаргаж ирсэн. Энэ бол зураг, төсөвтэй. Зураг, төсвийг нь би та нарт ингээд харуулъя л даа. Зураг, төсөвгүй гэж бодоод хассан байх магадлалтай. Энэ зураг, төсөвтэй. Амжилттай хэрэгжиж байгаа бас жишээ баримттай Ховдод хэрэгжиж байна. Нэг нь Багануурт. Ингээд бид нар үгүй бас хажуугаар нь бид нар мөнх цэвдэг нь үгүй болж байна. Мөнх цэвдэг үгүй болж хайлж урсах юм бол бэлчээрийн цөлжилт ихэснэ. Бэлчээр үгүй болох юм бол Монгол Улсын оршин тогтнохуйн үндэс болсон бэлчээрийн мал аж ахуй, малчин 2 үгүй болох юм.

Тэгэхээр бид энэ дээр анхаарах хэрэгтэй. Яаж анхаарах вэ гэхээр энэ хөтөлбөрийг дэмжих ёстой. Энэ хөтөлбөр тэгэхдээ Ерөнхий сайд аа төсвөөс мөнгө авахгүй байхгүй юу. Байгаль орчны яамны Усны газар, холбогдох байгууллагууд, мэргэжилтнүүд нь Азийн хөгжлийн банкнаас 56 сая доллар авахаар болоод 5 сая доллар нь буцалтгүй тусламжаар орж ирэхээр болсон. Ил нуур, цөөрөм нь болохоор хангайн бүсэд хийгдэнэ. Газрын гадарга доор ус хуримтлуулах нуур нь болохоор говийн бүсэд хийгдэх учиртай юм. Маар гээд дэлхий дээр 1800-хан байдаг газрын доорх усны хуримтлал Багануур дүүрэгт бид амжилттай хийчихсэн байгаа.

Тэгэхээр энэ хөтөлбөрийг оруулж өгөх ёстой. Ерөнхий сайд сая хэлсэн үгэндээ 90 оноос хойш төгрөгийн ханш 44 дахин унасан үнэгүйдсэн. Энэ юунаас болсон бэ гэхээр үндэсний үйлдвэрлэлгүйгээс болсон гэсэн. Үнэн. Үндэсний үйлдвэрлэл хөгжихөд аливаа үйлдвэрлэл хөгжихөд ус хэрэгтэй. Ер нь ус бол амьдралын эх булаг, оршин тогтнохуйн үндэс шүү дээ. Тэгэхээр бид энэ үзэл баримтлалдаа энэ баримтын бодлогын бичигтэй энэ 333 нуур, 1 нуур, 1 сумыг оруулж өгөөч ээ. Азийн хөгжлийн банк ямар тохиолдолд бидэнд мөнгө өгөх вэ гэхээр бид нарын энэ хөгжлийн төлөвлөгөөнд оруулсан тохиолдолд. Дээрээс нь Засгийн газар хүсэлтээ тавьсан тохиолдолд энэ орох ёстой. Тэгээд ч 26 он Монгол Улсын дэлхийд цөлжилтийн эсрэг манай улсын манлайлал доор COP17 хурал зохион байгуулагдах ёстой.

Тийм учраас бид нар энэ төслийг энэ хөтөлбөртөө заавал оруулах ёстой. Тэгээд би хассан үндэслэлийг нь сонсмоор байна. Ямар учраас энэ төслийг хашсан юм бэ?

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Мөнхбаясгалан гишүүнээ энэ 1 сум, 1 нуур төсөл бол илүү арга хэмжээ рүү чиглэсэн төсөл гэж үзээд сум, орон нутаг болгоны хэрэгцээ, шаардлага, хүн, малын тоо толгой, тэгээд түүндээ нийцүүлсэн нарийвчилсан байршлыг сонгох шаардлагатай. Ингэж сонгосны үр дүнд үе шаттайгаар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж авах нь зүйтэй гэж үзээд энэ улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаагүй. Яагаад гэхээр энэ төслийг Эдийн засаг,

хөгжлийн яаманд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлэхдээ яг аль аймаг, сумд усны нөөц хангамж муу байгаа, алинд нь сайн байгаа гэдгийг нарийвчилсан байршлаар ирүүлээгүй. Хуулиараа нөгөө нарийвчилсан байршил хаана хэрэгжих вэ нөгөө ТЭЗҮ чинь тэрүүгээрээ тодорхой байх ёстой. Оюу толгой энэ тэрээс говийн усны төсөл энэ тэр дээр мөнгө санхүүжүүлээд ТЭЗҮ энэ тэр хийгдээд явж байгаа нөгөө говийн усны төслүүд хэрэгжинэ. Тэгтэл говийн усны төсөлтэйгөө уялдаж хэрэгжих шаардлагатай байгаа юм.

Яагаад гэхээр хиймэл нуур, цөөрөм үүсгэхээс авхуулаад энэ чинь. Тэгтэл Хангайн бүсэд жишээлбэл голтой, нууртай сумууд байна шүү дээ тийм ээ тэр чинь ингэж ялгаж яахгүй бүгдийг нь 330 сум гээд ингээд хавтгайруулчхаж болохгүй үе шаттай хэрэгжүүлэх ёстой. Ийм учраас нарийвчилсан ТЭЗҮ, нарийвчилсан байршил энэ бүхнийг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаад явах нь зүйтэй. Ийм ч учраас ирэх жилийн СОР 26-д бид бас усны төслийг нэгдүгээрт оруулъя. Ус, хөрс гэсэн агуулгаар оруулъя. Тэн дээр мөнгө босгоё. Энэ ТЭЗҮ энэ тэрийг нь хийж байгаад олон улсын хэмжээнд энэ цөлжилттэй тэмцэх ажлын хүрээнд говийг усжуулах цогц хөтөлбөр болгож оруулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Батбаатарт даалгавар өгөөд СОР-ыг мөнгө босгох энэ чинь бас хөрөнгө оруулалт, зардал гарахаасаа гадна манай хувьд нөгөө шар шуурга, цөлжилттэй тэмцэх цогц ажлын хүрээнд нэлээн бас хөрөнгө оруулалт энэ тэр босгоод явж байгаа. Тэр талаараа Батбаатар сайд мэдээлэл өгнө.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар сайд хариулах уу? Батбаатар сайдын.

Б.Батбаатар: Усны 333 гэсэн хөв цөөрөм энэ төсөл энэ үндсэн чиглэлд тусаагүй. Сая шалтгааныг нь хэлчихлээ. Тэгээд энэ 6.3.1.2 гэж байгаа. Тэр дээр усны нөөцийн зохистой ашиглалтыг дэмжих гээд үүн дээрээ үр дүнгээ яаж үүсгэх вэ гэхээр усны нөөцийг хамгаалж, нөхөн сэргээх, хэмнэлтийн үр ашигтай хэрэглээг нэвтрүүлнэ гээд байж байгаа. Энэ хүрээнд бас тусаж байгаа гэж ойлгож болно. Ус бол амин чухал, туйлын чухал асуудал. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хувьд ус болон хүлэмжийн хийн чиглэлээр нэлээн ажлуудыг урагшлуулж байгаа. Сая бас төсөв бид нар батлахдаа усны чиглэлд тодорхой хэмжээний тавигдаагүй байсан мөнгөн дүнг Их Хурлын гишүүд, говийн гишүүд хамтарч санаачилж тавигдсанд бас талархал илэрхийлье. Тэгээд усан дээр.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд болоод энэ Тамгын газрынхан цаашид анхаарахгүй бол сая би ажлын хэсгийн 72 нэр уншлаа. 72. Ер нь сайд нар яамдынхаа газрын дарга, тэгээд агентлагийн дарга нартай байхад ер нь болдог шүү дээ. Тэгээд энэ олон 72 хүн цуглуулчхаад ингээд суугаад байдаг. Цаашдаа анхаарахгүй бол, анхаарах нь зүйтэй байх гэж бодож байна.

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин. Тодруулах уу? Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Ерөнхий сайдаа энэ энэ зураг, төсөл нь байна шүү дээ 180 цэгт хийчихсэн юм. Огт хийгээгүй биш байхгүй юу даа. Тэгэхээр бид нар Азийн хөгжлийн банк өнөөдөр мөнгө өгнө өө гэгчихсэн байгаа дээр бид нар аваад 180 цэгээсээ цаашаа 333 болтлоо зураг, төсөл дээр ч гэсэн ажлаа хийгээд явах ёстой байхгүй юу. Засгийн газраас энэ эко төслийн нэгдүгээрт, манай говийн усны

төслийг нэгдүгээрт эрэмбэлж өгсөн байна лээ. Энэ дээр маш их талархалтай хандаж байгаа. Сая бас Онги-Цагаан бургастайн төслийг хөдөлгөх мөнгийг төлөвлөж өгсөн. Тийм учраас бид нар 180 ийм зураг байгаа. Би 3-хан зураг л авчирсан. Тэгэхээр Ерөнхий сайд бид нар энийг оруулаад тэр мөнгийг аваад цаашаа 333 болтол хийгээд явах нь зөв байх. Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналаар оруулж ирье гэж бодож байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Манай яаман дээр энэ 1 нуур төслийн мэдээлэл Байгаль орчны яамнаас 1 нүүр материал ирсэн. Тэр санхүүжилт тодорхойгүй, ТЭЗҮ, зураг байхгүй гээд Байгаль орчны яам ийм материал ирүүлсэн. Тийм. Тэгэхээр хэрвээ тэр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр зураг, төсөв нь бэлэн болоод ингээд бэлтгэл ажил хангагдаж байна гэж үзвэл энэ 30 тэрбумаас дээш өртөгтэй төсөл, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр гээд хавсралт дээр нэмээд явахад болохгүй зүйл байхгүй. Тэгээд манай салбарын яам өөрсдөө бас тэгээд ажиллах хэрэгтэй. Ажлын хэсэг дээр, Их Хурал дээр мэдээж ажлын хэсэг гарах байх. Тэгээд бэлэн байдлын үнэлгээг нь хийнэ. Тэгээд нэмээд явахад бас болохгүй зүйл байхгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултаа асууя.

Х.Тэмүүжин: 4 сэдэв дээр асуулт асуух гэж байгаа юм. Гэхдээ тэрний өмнө хэлэхэд бид Улсын Их Хурал дээр ер нь Үндсэн хуулийнхаа дэг журмыг нэлээн сайн сахиж баримталж байхгүй бол болохгүй нь ээ гэдгийг хэлэх гэж байгаа юм. Улсын Их Хурлын гишүүд Засгийн газраас, Ерөнхий сайдаас асуулт асууж, тайлбар авч, Улсын Их Хурлын өмнө Ерөнхий сайд ажлаа хариуцан тайлагнаж, сайдууд Ерөнхий сайдынхаа өмнө ажлаа хариуцан тайлагнаж байгаа. Улсын Их Хурлын асуулт асууж байгаа гишүүн өөрөө зөвшөөрөхгүй бол сайдуудын үгийг заавал сонсох албагүй. Ийм зарчим Үндсэн хуулийн дэг журмаар байгаа.

Гэтэл яам, тамгын газрууд болон ингээд бүүр доогуур прокурор түвшний түшмэлүүдийг авчраад Улсын Их Хурал дээр мэдээлэл өгүүлэх, буцаад хариуцлага тооцох юм уу? Улсын Их Хурлын хяналт ажиллахад төвөгтэй. Тийм учраас энэ агуулгаараа ер нь Ерөнхий сайд Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлбараа хийгээд шаардлагатай гэж үзэж байгаа бол сайдуудын үгийг, тэгэхдээ асуулт асууж байгаа гишүүнээс нь асууж байж сайдыг сонсоно, сонсохгүй гэдэг хэлбэрээр явж байхгүй бол үндсэндээ энэ парламентын энэ хэлэлцүүлэг өөрөө их сонин дүр зураг руу улам бүүр ороод байна. Үндсэн хууль дээр маш тодорхой байгаа шүү. Улсын Их Хурлын гишүүд чуулганд үг хэлдэг бусад нь мэдээлэл өгдөг. Ерөнхийлөгч хүртэл мэдээлэл өгдөг, үг хэлдэггүй Үндсэн хуулийн өөрийнх нь текст шүү дээ.

Би эргэж харсан намынхаа дотоод хэрүүл дээр нэлээн их цаг аваад одоо л нэг урагшаа хараад төлөвлөлт хийх, ирээдүй рүүгээ харах уураг тархиа ажиллуулах боломж хаа хаанаа гарч байх шиг байна гэж харж байгаа. Энэ өнөөдөр ч гэсэн энэ асуудал орж ирээд би Ерөнхий сайдаас 4 асуудал асуух гэж байгаа юм.

Нэгдүгээрт, энэ баримт бичиг дотор гарчиг болон хийх арга зам, үнэлэх хэмжүүр маш их зөрчилдсөн, хоорондоо уялдахгүй үг, үсгүүд зөндөө байна. Гэдэс

дотортой холбоотой асуудал цаашдаа хэлэлцэх эсэх дээр ярих байх. Хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа. Би 4 асуудал эхнийх нь хүний эрхийг хамгаалах чиглэл дээр. Ер нь бид хэд иргэний үндсэн эрх, эрх чөлөөтэй холбоотой тэр дундаа Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг нэгмөр хэрэгждэг, баталгаатай иргэд нь эдэлдэг тогтолцоо руу шилжихийн тулд энэ Үндсэн хуулийн цэцийг Үндсэн хуулийн шүүх болгож иргэний үндсэн эрхийн маргааныг шийддэг болох тэр чиглэл рүү зоригтой алхам хийхгүй бол сүүлийн бараг 26 жил энэ тухай ярьсан боловч Улсын Их Хурал дээр зоригтой шийдэл гаргасангүй, Засгийн газар манлайлал хэрэгжүүлсэнгүй. Ер нь хойшоо суусаар байгаа. Тэгээд энэ тал дээр энэ өнгө ирэх 5 жил дээр ер нь төлөвлөсөн бодсон юм байна уу үгүй юү? Үндсэн хуульд заасан эрхээ эдэлж чадахгүй байна гэдэг чинь Үндсэн хууль цаасан дээрээ хоосон үлдэж байна л гэсэн үг шүү дээ. Энэ чиглэлийн 1 алхмыг хийх бодол санаа байна уу үгүй юу гэж?

Хоёрт нь Мөнхсоёл гишүүнээс авхуулаад гишүүд ярьж байх шиг байна. Эдийн засгийн үзүүлэлт, эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой асуудал дээр энэ хувийн хэвшил, бизнес эрхлэгчдээ дэмждэг тогтолцоо руу орохгүй бол төр өмнүүр нь бизнесийг нь булааж хийдэг, зах зээл дээр томоороо данхайгаад жижиг аж ахуйн нэгжүүдээ тээрэмддэг энэ үйл явдал ерөөсөө зогсохгүй нь. Тэгээд энэ талаар бизнесийн эрх чөлөөтэй, эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой хууль өргөн барина гэж байх шиг байна. Үнэхээр зоригтой бас ийм газар хөдлөлтийн дайны цочроо өгөхөөр шийдвэр гаргахгүй бол болохгүй нь.

Гуравд нь сая Засгийн газар Улсын Их Хурал дээр процессын шударга ёс хангагдаагүй, процессын алдаа гарсан учраас гээд Засгийн газар Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр буцааж эрх мэдэл нь сэргэж тогтож байна. Яг энэнтэй адилхан Засгийн газрыг хамгаалаад процессын шударга ярихаас гадна ер нь энэ төрийн байгууллага хууль сахиулах үйл ажиллагаа явуулж байгаа.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээгээд 1 минут Тэмүүжин гишүүнд.

Х.Тэмүүжин: Төрийн байгууллагууд хууль сахиулах байгууллагуудын энэ процессын шударга ёсыг хангах, процессжихтой холбоотой асуудлуудыг төрийн хяналт шалгалтууд процессжихтой холбоотой асуудлуудыг ямар нэгэн байдлаар иргэдийг шийтгэх, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хязгаарлахтай холбоотой хэн нэгэн албан тушаалтны дур зоргоор биш, маш тодорхой илэрхийлэгдсэн процесс, шалгуур хангасан дүрэм, журамтай байх тухай асуудал дээр зоригтой алхам хийхгүй бол үнэхээр даргын үзэмжээр бизнес, хүний эрх өөрөө үгүйсгэгдээд байна аа. Энэ тал дээр бас дорвитойхон алхам хийгээсэй гэж хүсэж байна.

Дөрөв дэх нь үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхтай холбоотойгоор энэ үндэсний квартал бий болгох онцгой байдал, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, энэ орон нутгийн хамгаалалт гэх мэтчилэн дээр дэмжлэг үзүүлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэхгүй бол энэ иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах, чадавхыг бүрэн нөөцөөр нь энэ үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхтай үйл ажиллагаатай холбож зохио.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя. Гэхдээ сая энэ Тэмүүжин гишүүний хэлж байгаа саналыг бид нар бас бодох ёстой шүү. Ер нь Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг бид нар томилж байгаа. Ерөнхий сайд өөрөө сайд нараа дагуулж

орж ирж байгаа. Тийм болохоор Улсын Их Хурлын өмнө Ерөнхий сайд л ер нь хариуцлага хүлээх ёстой гэж харж байгаа шүү дээ. Тэр утгаараа Ерөнхий сайд хариулах, шаардлагатай бол сайд нар хариулаад л явах ёстой юм даа уг нь. Ерөнхий сайд Занданшатар сайд хариулъя.

Г.Занданшатар: Нэгдүгээрт, Үндсэн хуулийг би тайлбарлах эрхгүй. Үндсэн хуулийн 41.1-д Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг, хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна гэж заасан байдаг. Өмнөх уламжлал бүх юмны дагуу энэ аливаа хуулийн төсөл болон бодлогын баримт бичгийг боловсруулахад оролцсон ажлын хэсэг, ард түмний төлөөлөгч болсон гишүүдийн энэ үг, саналыг сонсож, цаашид боловсруулах явцад тусалж, дэмжиж ирсэн нь ажил хэргийн бодит шийдэл. Сангийн яамны хариуцсан улсууд нь орж ирж байж төсөв сая батлахад хүртэл энэ тоо баримт дээрээ сууна шүү дээ. Дэлхийн бүх улсын парламентын жишиг ийм. Зүгээр яах вэ Английн парламентын зүгээр ингээд мэтгэлцээний цаг шиг 2 хүн гараад ярьдаг Ерөнхий сайд сөрөг хүчинтэйгээ мэтгэлцдэг тэр цагийг, тэр хэлбэрийг хуулийн төсөл болон энэ бодлогын баримт бичиг боловсруулах ажил хэрэгч хандах энэ зарчимтай нийцүүлж хольж хутгаж болохгүй. Ийм учраас Үндсэн хуулийг бид хэрэгжүүлж ирсэн уламжлалт практик, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу явж байгаа юм. Дэгийн тухай хууль дээр ажлын хэсгээс асууж, хариулна гэж байгаа. Тэгээд энэ тухай хууль дээр сайд нар оролцож асуудлаа танилцуулдаг. Энэ л чиглэлээрээ явж байна гэж бид бодож байна.

Үндсэн хуулийн цэцийн хүний суурь эрхийг хамгаалалтыг хянадаг байх агуулгын Үндсэн хуулийн цэцийн болон холбогдох судалгааг бүрэн хийж дууссаны дараа Улсын Их Хуралд оруулж ирэхээр төлөвлөж байна. Тэгэхдээ энэ асуудлыг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт дээр бид яриад Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуулийн шүүхийн статусаар хүний үндсэн эрхийн маргааныг хянадаг байх асуудлыг хэлэлцэж энэ шүүх засаглалтай зөрчилдөх болон Үндсэн хуулийн үндсэн суурь концепцуудтай зөрчилдөх гэсэн олон агуулгаар хэлэлцэж байгаад энэ асуудал ороогүй. Тэгэхдээ энэ бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Яг Үндсэн хуулийн зарчим бол Үндсэн хуулийн эрх мэдлийн 3 салаа мөчир болох хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн харилцан хяналт уялдааг хатуу заагаад өгчихсөн.

Тийм учраас Засгийн газар бас шүүх эрх мэдэл болон Үндсэн хуулийн цэцийн эрх мэдэл рүү шууд санаачлан халдаад байх асуудлыг 3 талт хэлбэрээр ярилцаж хэлэлцэж байж шийдэх ёстой асуудал байх. Таван жилийн үндсэн чиглэлд шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшин 2023 оны байдлаар 48.4 хувьтай байна. Цаашдаа шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байдлыг хангаж, шүүхийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх замаар 2030 он гэхэд шүүхэд итгэх иргэдийн итгэлийг 49.2 хувьд хүргэхээр заасан. Энэ нь шүүн таслах ажиллагааны хараат бус байдал, мөн хууль дээдлэх зарчимтай уялдаж хэрэгжих ёстой байх. Үндсэн хуулийн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн. Тодруулах уу?

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ирэх таван жилийн үндсэн чиглэлийг оруулж ирэхдээ бодлогын тэргүүлэх 8 чиглэлийг тусгасан байна. Үндсэн тэргүүлэх энэ 8 чиглэл дотроо хүний хөгжил, тэр дундаа боловсрол, эрүүл

мэндийн шинэчлэл, хөдөлмөрийн бүтээмж, Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийн асуудлыг оруулж ирсэн сайшаалтай санагдаж байна. Тэгээд маш тодорхой 4 асуулт асууна. Бүрэн тодорхой хариулж өгөөрэй гэдгийг хүсье.

Нэгдүгээрт нь боловсролд зориулдаг улсын төсвийн санхүүжилтийг тодорхой босготой болгох зайлшгүй шаардлага байгаа нь багш, ажилчдын тэмцэл, шаардлагаас маш тодорхой харагдаж байна. Тийм учраас энэ ирэх 5 жилд боловсролд зарцуулдаг улсын төсвийн санхүүжилтийг ДНБ-ий 6, төсвийн зардлын 20 хувиас багагүй хэмжээнд оруулах боломж байна уу? Манай улсын Засгийн газар олон улсын өмнө үүрэг хүлээж, Инчоны тунхаглалд гарын үсэг зурсан ийм юу байгаа шүү дээ 2015 онд. Өнөөдөр 10 жил өнгөрчхөөд байхад энэ нь хэрэгжээгүй байна. 30 онд энэ Инчоны гэрээг дүгнэнэ. Тэгэхээр энэ дээр манай Засгийн газар зайлшгүй энэ асуудал дээр онцгой ач холбогдол өгөх хэрэгтэй байгаа шүү гэдгийг бас анхааруулж хэлье. Бас асууя.

Хоёрдугаарт, боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн үр дүнд 2022 оноос гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжилт рүү шилжсэн. Өөрөөр хэлбэл, цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн боловсролын сургуулийн 1 сурагчид ноогдох хувьсах зардлын хэмжээгээр илэрхийлэгддэг. Өнөөдөр 1 сурагчид оногдох хувьсах зардал маань 400-хан доллар байгаа. Тэгэхээр энийг бас 1000 доллартой тэнцүүлэх ийм арга хэмжээг авах уу энэ таван жилийн төлөвлөгөөндөө?

Гуравдугаарт, боловсролын салбар боловсон хүчний хомсдолд орсныг бүгдээрээ мэдэж байгаа. Энэ яагаад боловсон хүчний хомсдолд ороод байгаа нь үнэхээр тодорхой байна шүү дээ. Багшийн цалин хөлс, нийгмийн баталгаа. Тэгээд ирэх 5 жилд багш, ажилчдын үндсэн цалинг хэдэн төгрөгт хүргэхээр төлөвлөж байгаа вэ? Мөн багш, ажилчдад өөр ямар нийгмийн баталгаагаар хангах ийм төлөвлөгөө байгаа вэ гэдгийг бас асуумаар байна. Энэ таван жилийн төлөвлөгөө дотор.

Дөрөвдүгээрт ирэх хичээлийн жилээс ЕБС-ийн сургалтын хөтөлбөр шинэчлэгдэнэ. Үндсэндээ дунд, ахлах ангийн сурагчид маш олон хичээл үзэж, судалж байдаг ч байдаг нийгмийн шүүмжлэлд өртдөг. Ингээд дунд ангийн сурагчид 7 хоногт 18 хичээл заавал судална гээд үзэж байгаа. Тэгэхээр энэ үүнийг бодитой бууруулах ямар шинэчлэлийг төлөвлөж байгаа вэ гэдгийг бас асууя. 4 асуулт асууж байгаа шүү би. Боловсролын сайд, Учрал сайд, Сангийн юу Ерөнхий сайд.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулах уу? Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Хүний хөгжил хамгийн том мега төсөл байна гэсэн. Боловсролд зарцуулдаг 1 төгрөг ирээдүйн 28 төгрөгтэй тэнцдэг энэ манай хөгжлийн хамгийн гол тулгуур салбар бол боловсролын салбар мөн. Одоогийн байдлаар боловсролын салбарт зарцуулж байгаа зардал ДНБ-ий 5.2 хувь, төсвийн зарлагын 16.4 хувийг эзэлдэг. Бусад улстай ингээд олон улсад хүлээн зөвшөөрөөд бид нар тунхаглалд нэгдчихдэг. Харьцуулах нэг зүйлд Монгол Улс бол хүүхэд, залуучуудын орон. Сая 145 мянган хүүхэд сургуульд суралцаж байна. 3-ны 1 нь сумд, ер нь 60 хувь нь Улаанбаатарт суралцаж байна. Тэгтэл багш нарын 3-ны 1 нь Улаанбаатарт ажиллаж байна гэх

мэтчилэн энэ суралцахуйн хувьсгал хийх шаардлага, ЮНЕСКО-гийн сая баталсан боловсролын салбарт хийх өөрчлөлт, шинэчлэлт энэ 21 дүгээр зуун, технологийн эрин үед суралцахуйн хувьсгал, teaching гэдэг хандлагаас learning буюу суралцахуй руу. Заахаа суралцахуй руу шилжсэн том хувьсгал хийж байгаа юм.

Ийм учраас багш эрдэм мэдлэгийг, өөрийнхөө эрдэм мэдлэгийн далайгаас хүүхдүүддээ зөөдөг биш хүүхдүүд эрдэм мэдлэгийн далай руу багш хөтөлж, хөтөч болж тэндээс хүүхдүүд цар хэмжээгээрээ хүртдэг. Энэ шинэ суралцахуйн хувьсгал бол боловсролын салбарын зардлыг үр ашигтай болгох энэ багш нарын цалин хөлсийг нэмэгдүүлэх том өөрчлөлт шинэчлэлт болно. Бид хөтөлбөрт суралцахуйн хувьсгал хийхээр төлөвлөж байна. Манай 26 онд 5.3 их наядын зардал төсөвлөснөөс ер нь бид 93353 мянган багш, ажилчид орон тоо байгаа. Энэний бараг тэн хагас нь ажилчид, боловсролын салбарын ажилтан, ажиллагсад тэн хагас нь багш нар байгаа. Багш нарын хүрэлцээ муу байгаа. Таны хэлж байгаа зөв. 7000 багшийн орон тоо дутуу энэ тэр гэсэн тооцоо судалгаанууд байна.

Ийм учраас энэ цогц реформыг хийх замаар боловсролын салбарын үр ашгийг сайжруулах замаар бид ойрын хугацаанд 27, 8 оноос багш нарын цалинг 3.5 саяд хүргэх талаар бас ажиллаж байгаа. Тэр талаар таны санаачилсан бас хуулийн төсөл дээр бас багш нарын нийгмийн асуудлыг шийдэх тодорхой санаачилгуудыг бас бид дэмжиж энэ хуулийн төсөлтэй хамтарч ажиллая гэж байгаа. Энэ асуудал ч гэсэн энэ хөтөлбөрт туссан байгаа.

Тийм учраас ер нь энэ боловсролын салбар дээр цогц реформ хийхтэй уялдаж, багш нарын цалин хөлсийг үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм. Яг үндсэндээ манайх шиг ингэж олон хүүхэдтэй харьцангуй Ази, дэлхийн хэмжээнд манайх хүн амын 3-ны 1 нь хүүхэд тийм улс байгаа. Яагаад гэвэл алтан гахайгаас хойш төрөлтийн хэмжээ нэмэгдсээр байгаад дэлхийн түвшнээсээ манай боловсролын салбарын ачаалал хэчнээн сургууль шинээр барих шаардлагатай болж байна. Тэрийг дагаад багшийн орон тоо, хэрэгцээ яаж нэмэгдэж байна. Энэ нэг талаасаа төсвийн ачааллыг нэмэгдүүлж байгаа юм боловч ирээдүйдээ маш сайн төрөлт нэмэг.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр сайд хариулах уу? Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр Инчоны тунхаглал 2015 онд гарснаас хойших энэ хугацаанд бид энэ төсвийн зарцуулах хэмжээг энэ рүү ойртуулах ийм шаардлага бий. Ингэж байж энэ боловсролд хуримтлагдсан олон жилийн асуудлуудыг бас шийдвэрлэх боломжтой болно гэж харж байгаа. Энэ тал дээр би тантай санал нэг байна. Өнөөдөр суралцагчид оногдож байгаа 1 дүгээр ангиас 12 дугаар анги хүртэл ялгаатай байгаа хувьсах зардлын хэмжээ нь дундажлаад үзэх юм бол 2.3 сая. Үнэхээрийн хувьсах зардлаар дамжуулж энэ салбарын хөрөнгө оруулалтыг нэмэх юм бол олон асуудлыг шийдэх боломжтой. Боловсон хүчний дутлын тухайд бас энэ багш нарын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах замаар багш мэргэжлийг зорьж ирэх ийм залуусыг нэмэгдүүлэх ийм бодлого барьж байгаа.

Тэгснээрээ энэ таван жилийн төлөвлөгөөнд мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан цэцэрлэгийн хувь хэмжээг 95 хувьд, стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан цэцэрлэгийг.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя. Тэмүүжин гишүүн түрүүнийхээ асуулт дээр тодруулчихъя.

Х.Тэмүүжин: Ерөнхий сайд аа ер нь энэ 30 жил тогтсон нэг алдааг бид засах хэрэгтэй байна. Таны яриан дотор ч гэсэн сая гарч ирж байна. Minister of justice гэж яриад байгаа Хууль зүйн яам, Хууль зүйн сайд чинь шударга ёсны тогтолцоо ажиллах хууль зүйн бодлогыг Улсын Их Хурал руу боловсруулж, судалж оруулж ирэх үүрэгтэй тийм яам. Зөвхөн Дотоод хэргийн яамаар нь ерөөсөө бид харж болохгүй. Бид 30 жил Дотоод хэргийн яамны чиг үүргээр тэр яамыг ажиллуулаад үндсэндээ энэ хүний эрхийг хамгаалах, шударга ёсыг бэхжүүлэх, хууль зүйн тогтолцоог илүү ухаалаг байлгах тэр чиглэлийнх нь оюун ухааныг Засгийн газрын түвшинд ажиллуулах дандаа саад тээг болж байсан. Тийм учраас энэ харах өнцгөө бас солиод үзээрэй гэж бодож байна. Яагаад би нөгөө сайдуудыг бас асууж Улсын Их Хурал дээр заавал асуух ёсгүй вэ гэвэл иргэний эрхийг хангах гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог байх уу, үгүй юү гэхэд танай Хууль зүйн сайд чинь байна гэж хэлсэн. Гэхдээ тэр сайд чинь одоо байхгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Мөнхтуяа гишүүн асуултдаа тодруулга авъя.

Ц.Мөнхтуяа: Ерөнхий сайд суралцахуй хувьсгал хийнэ гэж ярьж байна. Тэгээд энэ Боловсролын ерөнхий хуулийг маань бас дэмжиж бас ач холбогдол өгч ярьж байгаад баярлалаа гэж хэлмээр байна. Хамгийн чухал юм одоо бид нар ингээд өмнө нь яриад л байна яриад л байна тунхаг төдий юм гаргачхаад таван жилийн дараа бид нар дахиад л багшийн цалин, багшийн хомсдол энэ хувьсах зардлын дутмагшил яриад суумааргүй байна. Тийм учраас яг бодитой тодорхой тоотой юм сонсмоор байна. Зүгээр тэгнэ ээ ингэнэ ээ гээд ирээдүй цаг дээр бид нар сүүлийн 30 жил яриад ирсэн. Би дараа 5 жилд бас яг ингээд сууж байх вий гэж санаа зовсондоо бас энийг бүүр дахин хэлмээр байна. Тэгээд Наранбаяр сайд асуултад дутуу хариулсан хүүхдийн дунд ангийн хүүхдүүд 17-18 хичээл судалж байгаа шүү дээ 7 хоногт. Энийг багасах тал дээр ямар бодлого барьж ажиллах вэ гэдгийг бас тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ түрүүнд харин цаг дуусаад хариулж амжсангүй уучлаарай. Тэгэхээр энэ хөтөлбөрийн шинэчлэл бол СӨБ дээр яваад дууссан. Ингээд хэрэгжээд явж байна. Энэ бол 5 настныг сургуульд бэлтгэх энэ чиглэл рүү л илүү түлхүү анхаарсан ийм хөтөлбөр болсон. Өнөөдөр багц боловсролын сургуулийн хөтөлбөрийн шинэчлэл явагдаж байна. Энэ дээр хичээлийн тоог цөөлж байгаа. 10 хүрэхгүй ийм хичээлийн тоотой болж байгаа. Тэгээд энэ жилийн ирэх оноос эхлээд бид энэ дунд сургууль буюу суурь боловсролынхоо 1-9 дүгээр анги, ахлах боловсролынхоо хичээлүүдийн хөтөлбөрийг, судлагдахуунуудын энэ хөтөлбөрийг шинэчлэх ажлыг эхлүүлнэ. Энэ дээр өнөөдөр яг ингээд 18-19 төрлийн хичээл үзэж байгааг интеграцчлах. Гэхдээ байгалийн ухааны үндэс суурийг сайн тавих ийм зорилгоор хөтөлбөрийг явуулна. Ингэснээр хүүхдийн ачааллыг бууруулах. Гэхдээ олж авах мэдлэг нь дэлхийн түвшнээс дут.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн маш чухал баримт бичгийг, бодлогын баримт бичгийг Улсын Их Хурлаар өнөөдөр хэлэлцэж байна. Тэгээд улс орны дунд хугацааны буюу ирэх таван жилийн хөгжлийг тодорхойлох энэ чухал бодлогын баримт бичгийг Улсын Их Хурлаар батлуулахаас сар хүрэхгүй хугацааны өмнө Засгийн газраас Их Хуралд ингэж өргөн мэдүүлж хэлэлцүүлж байгаад шүүмжлэлтэй хандмаар байна. Учир нь энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хугацаа дуусгавар болохоос 4 сарын өмнө хэрэгжилтийн үнэлгээг Улсын Их Хуралд танилцуулна гээд заачихсан байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурал тус үнэлгээнд үндэслэн Засгийн газарт дараагийн таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахтай холбоотой чиглэл өгнө өө гээд. Тэгэхээр энэ Улсын Их Хурал энэ онд дуусгавар болж байгаа Монгол Улсыг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан гэж бодвол байдаг байх. Энийгээ эхлээд энэ тайлангаа эхлээд хэлэлцсэний дараа одоогийнхоо оруулж ирж байгаа энэ үндсэн чиглэлийг хэлэлцчихвэл яасан юм бол? Ер нь хэлэлцвэл, хэлэлцэх ёстой юм биш үү гэсэн асуулт байна. Үндсэн чиглэлийн бодлогын баримт бичгээс миний ингээд гол анхаарч байгаа нэг зүйл бол энэ дундаж давхаргыг нэмэгдүүлэх гэсэн асуудал байгаа юм. Эдийн засгийн байнгын хороон дээр би бас нэлээн ярьсан. Тэгээд Учрал сайд хариулахдаа ер нь 20 хувиар нэмэгдүүлнэ. 2030 онд 20 хувиар нэмэгдүүлнэ.

Ер нь дундаж давхаргын түвшин гэдэг энэ ажиллах хүчний оролцоог одоогоор дүгнэх, хэмжих ийм аргачлал байхгүй байгаа гэсэн ийм харамсалтай хариултыг би авч байсан. Тэгэхээр энэ дундаж давхарга гэдэг өнөөдрийн Монголын нийгэмд ер нь байна уу үгүй юү гэдэг дээр маш их эргэлзэж байна. Дундаж давхаргаасаа бид ядуу амьдрал руу шилжүүлээд л ядуугаасаа нэн ядуу руу шилжлээ гээд сүүлийн олон жил ярилаа даа. Тэгэхээр энэ дундаж давхаргыг 20 хувиар нэмэгдүүлнэ, дундаж цалинг нэмэгдүүлнэ гэснээс ажиллах хүчний оролцооны түвшин үндсэн чиглэлийн төсөлд 2024 онд 61.3 хувь гэж энэ тусгасан байгаа юм. Энэнтэй би санал нийлэхгүй байгаа юм.

Яагаад гэхээр энэ хөдөлмөрийн зах зээл, өнөөгийн нөхцөл байдал гээд 2024 оны судалгаан дээр Гэр бүл, нийгмийн хамгааллаас гаргасан 57.6 гээд дүгнэчихсэн байгаа юм л даа 2023 онд. Тэгтэл энд 61.3 гэсэн. Ингээд бодохоор энэ 2010 онд 61.6 хувьтай байсан энэ графикаар үзүүлчихсэн энэ хувь өнөөдөр бүүр ингээд 1 жилийн дотор л шууд 3.7 хувиар өссөн гэдэгтэй санал нийлэхгүй байна Ерөнхий сайдаа. 1992 оноос хойш яг үнэнийг хэлэхэд өнөөг хүртэл ерөөсөө тасралтгүй буурч байгаа шүү дээ ажиллах хүчний оролцоо. Тэгэхээр энэ дээр энэ Засгийн газар ямар дүгнэлт хийж энэ үндсэн чиглэлд тодорхой ямар бодлого тусгуулсан бэ? Дундаж давхаргын эзлэх хувь буурч байгаатай санал нэг байна уу?

Өнөөдөр ахмадын тэтгэвэр, халамжийн тухай маш их ярьж байна. Тэгэхээр энэ ахмад настнуудын халамж, тэтгэврээр амьдрах биш дахин ажил, хөдөлмөр эрхлэх энэ хууль зүйн орчныг шинээр бий болгох тал дээр Засгийн газрын бодлого ямархуу байна вэ? Өнөөдөр 55 ба түүнээс дээш настай ахмад ажиллах хүчний

тоо, дэлхий дээр гэхэд 150 сая хүрчихсэн. Дэлхийн хөгжилтэй орнууд одоо.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 1 минут сунгая Батчимэг гишүүнд.

П.Батчимэг: Тэгэхээр өнөөдөр дэлхийн улс орнууд ялангуяа энэ хөгжилтэй Азийн орнууд, Сингапур, Малайз, энэ Япон, Солонгос гэх зэрэг орнуудад үнэхээр энэ тэтгэврийн насны ахмадуудаа дахин хөдөлмөр эрхлүүлэх энэ чиглэл дээр бүр төрийн бодлого болгож ингэж явж байгаа маш сайн жишээнүүд байдаг. Үйлчилгээний газрууд, зочид буудал, эмнэлэг, сургууль, энэ гоё газруудад ерөөсөө ахмад настнуудаа тэтгэвэрт гарсан 55-аас дээш насны иргэдээ 65 хүртэлх насны иргэдээ ажиллуулдаг. Ажил, орлоготой байлгадаг, амьдралынх нь чанарыг дээшлүүлдэг ийм жишиг байгаа юм. Тэгэхээр манай улсын хэмжээнд бид халамжийн тухай ярьж ийм өдөр хоног өнгөрөөсөн ийм асуудлаар ахмадуудаа хуурч сууж байхаар энэ ахмад настны дахин хөдөлмөр эрхлэх асуудлыг үндсэн чиглэлдээ оруулж өгөх ийм.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Санал уу? Өлзийхүүгийн Шижир. Ерөнхий сайд хариулъя. Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Пүрэвийн Батчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ яагаад оройтож өргөн барьж байгаа юм бэ түрүүн Тэмүүжин гишүүн ч бас яриад байсан энэ улс төржиж явсаар байгаад ингээд сүүлд өргөн барьж байгаа юм шиг тийм ойлголт байхгүй. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх үндсэн чиглэлийн баримт бичгийн хугацаа дуусгавар болохоос 2 сарын өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ ээ гээдхуульд өөрчлөлт оруулаад заачихсан. Бид хуулийн дагуу л өргөн мэдүүлж байгаа. Тэгээд төсвийн хуулийг 9 сарын 1-нд өргөн мэдүүлдэг болоод сая баталчихсан та. Ингээд энэ хоёрын хооронд ийм зөрүү, зөрчил гарч байгаа нь бодит үнэн. Энэ хуулиа л бид, та биелүүлэх ёстой гээд түрүүн яриа биз. Засгийн газар хууль биелүүлэх үүрэгтэй. Хугацаа нь 12 дугаар сарын 31-нээр дуусах ёстой байсан. 2 сар гэдэг бол 11 дүгээр сарын 1-нээр гээд бид өргөн мэдүүлээд өнөөдөр хэлэлцүүлж байна.

Дундаж давхаргын хувьд манайх дундаж давхаргыг тодорхойлох аргачлалаа одоо хүртэл батлаагүй юм билээ. Тийм учраас тооцоолол байхгүй байгаа. Олон улсын зарим аргачлалаар үзэхээр 48.1 хувь гэж гарч байгаа. Бид нар Тогтвортой хөгжлийн зорилтын НҮБ-ын баталсан Эс Ти Жи 17 буюу Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг тооцдог аргачлалаар хүний хөгжлийн өсөлтийг удаашруулж байгаа энэ амьдралын чанар, ажилгүйдэл, дундаж орлого бага байгаа, инфляц, үнийн өсөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдэд тооцож байгаа. Ер нь дундаж давхарга маш эмзэг. Үнэ 10 хувиар өсгөхөд, үнийн өсөлт 10 хувиар өсөхөд 423 мянган хүн ядуурлын эгнээнд шилжинэ ээ гэсэн ийм судалгаа байдаг учраас манай дундаж давхарга багш, эмч нараас авхуулаад ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс бүгд орох боловч энэ маань эмзэг хэвээрээ байгаа. Ийм учраас дундаж давхаргын бодитой байдлыг нэмэгдүүлэх, дундаж давхаргын эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлэх зорилтыг тусгасан дундаж давхаргыг тодорхойлох аргачлалыг боловсруулж тооцдог болохоор заасан.

Дундаж давхаргын хэмжээг нэмэгдүүлэхэд үндсэн чиглэлийн төслийн 2 дугаар хавсралтын зохистой ажлын байр бүтээгч ажил олгогч эздийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны чанарыг сайжруулах, бүтээмж гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоонд шилжих, гарааны бизнес, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх гээд ийм тодорхой заалтууд суусан. Наслалтын хувьд таны хэлж байгаа шиг Монгол хүний дундаж наслалт нэмэгдэж байгаа 8.6-аас, 2000 оноос хойш 8.6-гаар нас нэмэгдсэн. Дундаж наслалт 2024 оны байдлаар 71.8 болсон. Эрэгтэй хүний дундаж наслалт 67.9, эмэгтэй хүний дундаж наслалт 77.1 нас хүрч насжилт нэмэгдэж байгаа нь их сайн үзүүлэлт.

Нөгөө талаараа 2000 оны үед 23 онд 385 мянган ахмад настны тэтгэвэр авдаг байсан бол 403 болоод нэмэгдээд байгаа юм. Тэгэхээр нөгөө халамжийн хэмжээ бас яагаад нэмэгдээд манай энэ хүн амын цонх энэ эрсдэлттэй болоод байна гэхээр хүүхдийн тоо маань сургууль, цэцэрлэг барих ёстой нэмэгдээд 1 сая 145 мянган суралцагчдын тоо нэмэгдсэн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Та тодруулчихсан. Алив Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Батчимэг гишүүн маш чухал асуудал хөндөж байгаа юм. Бид өмнөх 21-25 оны үндсэн чиглэлийнхээ биелэлтийг тайланг нь хэлэлцээд дүгнэж байж тэн дээрээсээ тулгуурлаад 26-30 оныхоо дараагийнх нь залгаас нь хийгдэх ёстой. Энэ дээр Засгийн газар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хуралд 21-25 оныхоо үндсэн чиглэлийн биелэлтийн гүйцэтгэлийг хүргүүлсэн. Улсын Их Хурал дээр хэлэлцээд Засгийн газарт тодорхой чиглэл өгөх ийм дэгтэй байсан. Энэ процесс явагдаагүй юм байна лээ. Энэ процесс. Бидний, Засгийн газрын дүгнэснээр үндсэндээ 21-25 оны үндсэн чиглэлийн биелэлт маань 54 орчим хувьтай гарсан. 95 шалгуур үзүүлэлттэй байсан. 95 шалгуур үзүүлэлтээс тодорхой хэсэг нь 85-аас дээш, тодорхой хэсэг нь 85-аас доош биелэлт, хувийн биелэлттэй гээд дунджаар 53 хувьтай гарсан. Үүн дээрээ тулгуурлаад энэ 26-30 оны үндсэн чиглэлийг бид Засгийн газар Улсын Их Хуралд оруулж ирж байгаа юм. Энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу энэ.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Өлзийхүүгийн Шижир гишүүн.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Бид чинь хаврын чуулганаар 2026 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө батлах гээд бас баримт бичиг баталчихсан 4 сарын сүүлээр билүү дээ. Тэгээд түүний 3.1.5 дээр би тухайн үед асууж байсан юм. Нүүрс хими, кокс химийн үйлдвэр барьж ашиглалтад оруулна гээд. Тэгээд тухайн үед барьж ашиглалтад оруулна, барина л гээд байсан. Тэгээд одоо энэ өргөн барьж байгаа таван жилийн үндсэн чиглэл дээр энэ төсөл чинь алга болчихож. Хэрэгжүүлэхээ больчихсон юм уу аль эсвэл алдаад биччихэв үү? Нөгөө 250-аас 300 тэрбум доллар гэдэг шиг. Энэ тал дээр асуух гэсэн юм.

Хоёрдугаарт, төр ер нь хөрөнгийн менежментээ яаж хийх юм? Би Бямбацогт сайдтай бас хувийн байдлаар нэлээн санал солилцож байсан. Өнөөдөр төрд чинь орон нутгийн өмч болон төрийн өмч гээд нийтдээ 120 их наяд төгрөгийн хөрөнгө байгаад байна. Үүний 60 их наяд нь ТӨК-уд дээр байна. Гэтэл ганцхан “Эрдэнэт”, “Эрдэнэс Тавантолгой” гээд ашигтай ажиллаж байгаа үйлдвэрүүдийнхээ ард

халхавч болоод нуугдчихдаг тэгээд бусад үйлдвэрүүд нь ингээд үр ашиггүй байдаг. Үүнд маш их хөрөнгийг үр дүнгүй зарцуулдаг. Тэгээд бодит үйл ажлын тайлан байхгүй. Тэгэхээр төр энэ хөрөнгийн менежментээ яаж хийх гэж байгаа юм бэ? Тэгэхгүй ДНБ-ий чинь 74 хувийг төр үйлдвэрлээд байна. Энэ үндсэн чиглэл батлагдаад хэрэгжих байх. Хэрэгжээд явсны дараа 2030 онд ДНБ-ий хэдэн хувийг чинь төр үйлдвэрлэсэн байх юм, төр ямар хөрөнгийн менежмент хийчихсэн байх юм гэдэг ийм юунууд дээр ингээд тодорхой хариулт өгөөч. Тэгэхгүй бол яг энэ цааснууд дээр бичдэг, боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлнэ, малчдын орлогыг нэмэгдүүлнэ, аж үйлдвэрийг бий болгоно гэдэг өгүүлбэр би буруу санаагүй бол сүүлийн 10 жил яг энэ өгүүлбэрээрээ л явж байгаа. Дандаа ингэж бичдэг, дандаа ийм гоё үг тавьдаг. Тэгээд эд нар дээр тодорхой хариул.

Гурав дахь нь дүүжин тээврийн талаар зохицуулалт асуух гэсэн юм. Дүүжин тээврийн тухай хуулийн заалт байхгүй. Дүүжин тээврийг нийтийн тээвэр үзнэ гэж хууль хуулийн заалт байхгүй. Тэгсэн мөртөө энэ төслийн 53 дээр явж байгаа. Тэгээд одоогоор яах юм дүүжин тээврийн чинь хуулийн зохицуулалт байхгүй юм бол ажил нь эхэлчихсэн. Хамгийн өндөр цэг нь 46 метр юм байна. Тэгээд агаарын тээвэр гэж үзэх юм уу, нийтийн тээвэр гэж үзэх юм уу, авто замынх юм уу, авто замын газар хариуцах юм уу, ашиглалтыг нь яах юм? Тэр дээр 46 метр дээр гацаад ямар нэгэн осол, аваар үүслээ гэхэд манай ОБЕГ-т 46 метрийн өндөрт гарах авран хамгаалах тийм тоног төхөөрөмж байна уу? Энэ чинь өчигдөр 48 хувьтай явж байна гээд тэгж байна лээ шүү дээ. Тэгээд хуулийн зохицуулалт байхгүй мөртөө ажил нь эхэлчихсэн. Тэгэхээр тодорхойлолт байхгүй гэсэн үг. Нийтийн тээвэр юм гэсэн. Тэгээд агаараар яваад байгаа юм. Тэгээд агаарын тээвэр юм уу, нийтийн тээвэр юм уу энэ хуулийн зохицуулалтыг нь хэзээ хийж өгөх юм бэ гэсэн ийм 3 асуулт, тэгээд тодруулчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Шижир гишүүний асуултад хариулъя. Энэ чухал асуулт байна. Үнэхээр манайхан яриад байдаг хэрэгждэггүй. Тийм учраас бид дандаа бодит ажил хэрэг болгох шаардлага тэр нь төсөлтэй, ТЭЗҮ-тэй, санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдсэн байх шаардлага тавьж байгаа. Энэ таван жилийн үндсэн чиглэлд Багануурын үйлдвэр, технологийн паркийг түшиглэсэн нүүрс, химийн үйлдвэр байгуулахаар төсөвлөсөн. Багануурын үйлдвэр, технологийн паркийн төслийг, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай төслийн жагсаалтад оруулсан байгаа. Багануурын үйлдвэр, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөөг баталчихсан. Эхний шатад нүүрс пирализ 2 дахь үе шат нь нүүрс-химийн цогцолбор байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас ирүүлсэн саналын дагуу нүүрс, пирализын үйлдвэр гэх нэрээр санхүүжилтийн эх үүсвэр шийдэх шаардлагатай төслүүдийн жагсаалтын 15-д тусгасан байгаа. Пирализ, химийн үйлдвэр байгуулж, 850 мянган тонн хагас кокс, 725 сая м3 нийлэг хий үйлдвэрлэнэ. Цаашид устөрөгч, нафта дизель түлш, нийлэг байгалийн хий, метанол зэрэг төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой химийн үйлдвэр хөгжих бололцоотой дагаж бий болно.

Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийг Францдаа ингээд 20 онд Нийслэлийн Засаг дарга гарын үсэг зурчихсан юм байна лээ. Ингээд 2 талын гэрээгээр батлагдаад ингээд явчихсан энэ төсөл учраас үргэлжилнэ гэж л тооцсон. Амлалтын дүн нь 251.6 тэрбум төгрөг, ажлын гүйцэтгэл

33 хувьтай явна гэж мэдэгдсэн. Зээлийн хугацаа нь 40 жил, үнэ төлбөрөөс чөлөөлөх хугацаа нь 12 жил, зээлийн хүү нь 0.076 хувийн хүүтэй, 2025 онд батлагдсан 67.3 тэрбум төгрөгийн ажил явагдаж байгаа, 25 онд 67 аравны, 26 онд 50.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэл хийгдэнэ. 25 оны ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа гэсэн ийм мэдээлэл манай Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлсэн байгаа Нийслэлээс.

ДНБ-ий 72.4 хувийг хувийн хэвшил 2024 оны байдлаар үйлдвэрлэж байна. “Эрдэнэт”, “Тавантолгой” ч гэдэг юм уу улсын үйлдвэрийн газруудын уул уурхайн компаниудын эзлэх хувийн жин өндөр байгаа нь үнэн. 2030 онд бид энэ таван жилийн үндсэн чиглэлээр хувийн хэвшлийн оролцоог 84 хувь болгож нэмэгдүүлэхээр үндсэн чиглэлд тусгасан. 24 оны байдлаар ДНБ ер нь 27.5 хувийг ТӨК үйлдвэрлэж байгаа саяын хэлсэн. Энэ бол Статистикийн хорооны мэдээлэл.

Кабин 42 метр байна гэсэн ийм дүүжин тээврийн бөгөөд хууль шинэчлэх ажлыг Эдийн засаг, хөгжлийн яаман дээр, Зам, тээврийн яаман дээр ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа юм байна лээ 26 оны 8 сар гэхэд төсөл хэрэгжиж дуусна. Эхний үе шат 48 хувьтай явж байна гэсэн мэдээллийг ирүүлсэн байна.

Ж.Бат-Эрдэнэ: Дэлгэрсайхан гишүүн хариулах уу. Энэ дүүжин Тээврийн стандарт хуульдаа Тээврийн тухай хуульдаа тусаад орж ирэх ёстой шүү дээ. Тэрийг л асуугаад байх шиг байна. Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Шижир гишүүний асуултад хариулъя. Ер нь таны хэлж байгаатай санал нэг байгаа. Дүүжин тээвэр, мөн дамжуулах бас тээвэр гээд ингээд олон төрлийн тээврийн асуудал сүүлийн үед нэмэгдэж орж ирж байгаа Монгол Улсад шинээр орж ирж байгаа ийм зүйл, төрөл тээврийн хэрэгсэл байгаа. Тэгэхлээр энэ дээр бид хуулийн төсөл боловсруулж байгаа удахгүй ингээд Засгийн газраас Их Хуралд өргөн барина. Энэ дээр бас гишүүдийн зүгээс санал авч байгаа. Ганц дүүжин тээвэр биш мөн хил дамнасан дамжуулах ремень дамжуулахтай тээвэр гэж ярьдаг бас ийм олон төрлийн тээвэр ирээдүйд бас ингээд шинээр гарч ирж байгаа учраас энэ хуулийг удахгүй ингээд өргөн барина гэдгийг хэлье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Осол аваар болсон тохиолдолд яах юм бэ гэсэн Онцгой байдлынхан хариулах уу? Энэ стандартаа маш яаралтай Дэлгэрсайхан сайд оруулж ирэх хэрэгтэй байна даа. Онцгой байдлынхан байна уу хэн хариулах юм? Яг одоо бид нар бэлэн байна уу үгүй юү энэ ашиглалттай холбоотой асуудал дээр. Хариулах хүн алга.

Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Тэгээд яах вэ бид нар чинь хуулийн зохицуулалтгүй мөртөө ажил нь эхэлчхээд байна шүү дээ. Тэгээд одоо хууль нь араас нь явж байгаа юм байна гэж ойлгож байгаа юм. Ингээд 48 хувьтай гээд өчигдөр Нямбаатар дарга мэдээлэл хийгээд байгаа юм. Тэгэхээр нь нийтийн тээвэр чинь автобус, такси гээд ингээд хуульчилчихсан. Дүүжин тээвэр чинь хууль чинь хуульд байхгүй. Тэгэхээр агаарын тээвэр гэж үзэх юм уу, нийтийн тээвэр гэх юм уу, ашиглалтыг нь хаанах хариуцах юм, Нийслэлийн авто замын газар хариуцах юм уу? 46 метрийн өндөрт гацвал яах юм, тэрэнд нь тэнд байгаа иргэдийг авран хамгаалах шат, авран хамгаалах

техник, хэрэгсэл байгаа юм уу л гэж асуугаад байгаа байхгүй юу. Тэгээд байгаа бол байгаа, байхгүй бол байхгүй гээд хэлээд өгөөч ээ л гэж.

Ж.Бат-Эрдэнэ: Тэр байхгүй ээ байхгүй Тээврийн сайд оруулж ирэх байх удахгүй. Одсүрэнгийн. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын гишүүн болоод энд 1 жил гаруй хугацаанд ингээд сууж байхад надад юм их тодорхой боллоо гэж харж байна. Энэ бол манай Монгол Улс маань баялгийн хараалд нэрвэгджээ. Энэ бол баялгийн хараал гэж олон улсын нэр томъёо байдаг. 2008, 2009 оноос эхлээд уул уурхайн томоохон төслүүд хөдөлгөж, энэнтэй зэрэгцээд баялгийн энэ тойрсон хуваарилалтууд эхэлсэн. Тэгээд уул уурхайгаас олсон мөнгөө сонгуулиар сонгогчдын саналыг худалдан авахад ашиглаж, сонгогчдын ирээдүй болон тэдгээрийн үр хүүхдүүдийн ирээдүйг бэлэн мөнгөөр ингэж худалдаж авдаг болсон. Хавтгайрсан энэ халамжаас үүдсэн үүдээд ажлын байр, ажиллах хүчний оролцоо багассан байна, ажлын байр нэмэгдэхгүй байна, уул уурхайгаас олж байгаа энэ орлогоо бид нар олон тулгуурт эдийн засгийн бодлоготой болох байтугай дундаж давхаргаа тэлэхэд чиглэсэн үр дүнтэй бодлого хэрэгжүүлэхэд зарцуулаагүй л байна гэж харагдаж байгаа юм. Тэгээд бид нар ийм чөтгөрийн тойрогт орчихсон байна.

Ер нь баялгийн хараал хүрчихсэн улс орнуудын ингээд symptom-ууд байдаг л даа. Энэ зөвхөн манай Монгол Улс биш тэр бусад Нидерланд нь байна уу, Чили нь байна уу, Африкийн улсууд нь байна уу бүгдээрээ л адилхан с symptom-ууд гардаг. Тэгээд энэ дээр төсвөөс гадуурх ийм төслийн, төсвийн хяналтаас ийм гадуур баялаг байна их хэмжээний. Энэ бол үндсэндээ улс төр, эдийн засгийн бүлэглэлүүдийн тэмцлийн талбар болсон байна гэж би харж байгаа. Иргэдийн эрх ашиг, сайн сайхнаас илүүтэйгээр энэ эдийн засгийн бүлэглэлүүдийн эрх ашгийг дээгүүр тавьсан бодлого гаргадаг болсон байна. Системийн авлига гаарч тэр хэрээрээ нийгмийн шударга ёс ерөөсөө алдагдсан байна. Засаглалын институтууд ч гэсэн бие даасан хараат бус байх байдлууд суларсан байна гэж харж байна. Тэгээд энэ бүхнийг бид нар засаж залруулах шаардлагатай. Мэдээж засаглалаа бид нар сайжруулах шаардлагатай.

Гэхдээ засаглалаа сайжруулна гээд бид нар зүгээр хуулийн нэр томъёо дээр ажиллах асуудал ерөөсөө биш байна. Symptom-той нь биш, учир шалтгаантай нь, уг угшилтай нь тэмцэх юм бол энэ миний хувьд юу гэж харж байна гэхээр бид нар энэ ТӨК-удаасаа л эхлэх ёстой гэж харж байна. Төсвөөс гадуурх энэ мөнгөний том хэсэг байна шүү дээ. Тэгээд ТӨК чинь өөрөө эдийн засагт маш их том гажуудал гаргаж байна. Төрийн оролцоо, эдийн засаг дахь оролцоо хэт байна, зах зээлийн зарчмыг гажуудуулж байна, хувийн хэвшлийн орон зайг бүр боомилж байна, авлига цэцэглэх энэ гол үүр уурхай ч гэсэн энэ төрийн өмчийн компаниуд дээр байна гэж харж байгаа юм. Тэгэхээр 2026 онд Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө гэж хаврын чуулганаар Улсын Их Хурлаар баталсан. Тэр жилийн төлөвлөгөөнд ТӨК-ийн засаглалын реформ гээд уг нь их чухал юмнууд туссан байсан юм. ТӨК-удын реформыг эрчимжүүлж зардлыг 15 хувиар бууруулна, ТӨК-удын бүтээмжийг 30 хувиар сайжруулна. Тэгээд харамсалтай нь энэ 2026 онд сая батлагдсан төсөв дээр яг энэ үнийн дүнгээрээ яаж тооцоолол хийгдэж туссан юм бэ гэхээр үнэхээр тэр бол байхгүй байгаад байгаа юм.

Өнөөдөр ингээд таван жилийн төлөвлөгөө орж ирж байна. Ингээд харахаар дахиад л Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ТӨК-ийн засаглалыг сайжруулна, орон нутгийн өмч, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ, мэдээллийн харилцааны бүртгэл мэдээлэл, ил тод байдлыг бүрэн хангана л гэсэн ийм 3 зорилт байгаа юм. Тэгээд энэ төрийн өмчийн энэ компанид эдийн засгийн оролцоог нь багасгах энэ олон гажуудлын үүр уурхай болоод байгаа энэ асуудлаа гажуудуулахад ийм л зүйлийг хийнэ гэж харж байна уу? Уг нь нээлттэй, ил тод байлгаад IPO буюу юу гэдэг юм олон нийтийн хяналтад хамгийн сайн хийх асуудал бол олон нийтэд нээлттэй болгох л асуудал шүү дээ. IPO хийдэг юм уу хэдэн хувиар нь энэ асуудал ер нь ирэх 5 жил хийгдэнэ гэж үзэж байгаа юу, ямартай ч бидэнд өгсөн энэ таван жилийн төлөвлөгөө дээр алга байна. Тэгэхээр энэтэй холбоотой ТӨК-уд компаниудыг хувьчлах байдаг юм уу? Олон нийтэд нээлттэй болгох асуудлаар ямар төлөвлөгөө үйл ажиллагааг бодож

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Номинчимэг гишүүнд бас талархал илэрхийлье. Энэ баялгийн хулгайтай тэмцэж байгаа, бүлэглэлтэй хийж байгаа ажлыг бас ингээд ойлгож, дэмжиж, бас энэ цаад учир шалтгаантай нь хамт устах ёстой гэж байгаатай санал нэг байна. Тэгэхдээ энэ баялгийн хараал гэдэг нэр томъёо ер нь ядуурлыг нэмэгдүүлж байдаг, ядуурлыг нэмэгдүүлж байгаа байгалийн баялгаас олсон орлогыг эдийн засгийн өсөлт ардчилалд сөргөөр нөлөөлөөд тэгээд эдийн засгийн өсөлт бага байлгадаг ийм үзэгдлийг баялгийн хараал гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл энэ савлагаанд нь яг өртөж байгаа энэ баялгийн үнэ буурахаар эдийн засагт нөлөөлдөг, өгөөжийг нь ард иргэд биш цөөнх бүлэг хүртэж байдаг энэ асуудлыг баялгийн хараал гэж ойлгодог.

Түрүүн Батчимэг ч гэсэн асууж байсан. Яагаад ингээд ажил эрхлэлт багадаад, нэмэгдээд байна гэхээр ерөөсөө уул уурхайн салбар бусад салбараа унагаагаад энийг Голланд өвчин гэж байгаа юм. Дашизм гэдэг уул уурхайн бусад салбараа унагаагаад тэгээд бусад салбарын ажилгүйдэл, үйлдвэрлэлийн өсөлт унаад энэнээс болоод уул уурхайн салбар капитал инсенто буюу хөрөнгө оруулалт их шаарддаг ажлын байр бага шаарддаг хөдөө аж ахуй, аялал жуулчлал энэ салбар бол labor инсенто буюу ажлын байр бий болгож байдаг. Энийг бас баялгийн хараал гэж нэрлэдэг. Тэгээд баялгийн хараал, Голланд өвчин хоёр хоёр өөр ойлголт гэдгийг хар.

Тийм учраас энэ хоёр хоёулаа зэрэг нэрвэгдээд байгаа учраас Монголын эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтийг өнөөдрийн таван жилийн үндсэн чиглэл засаглалыг сайжруулах, төрийн оролцоог багасгах, хяналттай болгох жишээлбэл бид олон нийтийн хяналтын тухай хуулийг санаачилж байна. Төрийн өмчийн компаниуд дээр олон нийтийн хяналтыг бий болгох асуудлуудыг Жишээлбэл “Эрдэнэс Тавантолгой”-г олон нийтийн хяналтад оруулах, эхний ээлжид нээлттэй компани болгож бүртгээд, ард иргэдийн хяналтыг ТУЗ-д нь оруулах ийм цогц шинэчлэлүүдийг хамт хийж байгаа учир шалтгаантай нь болон нийт ард иргэдийнхээ итгэлийг олж байгаа энэ зарчим, хэрэгжүүлэлтээр. Хэчнээн сайн хууль гаргаад хувийн хэвшилд ч очлоо гэсэн энэ Голланд өвчний суурийг бид эмчилж чадахгүй байж болно.

Ийм учраас энийг цогцоор нь шийдэх шинэчлэл, чиглэл энэ таван жилийн үндсэн чиглэлийн гол зорилго байгаа юм гэдгийг би бас онцолж хэлмээр байна. Тийм учраас төрийн оролцоог бууруулах, засаглалыг сайжруулах, цахимжуулах олон асуудал явж байгаа. Ганцхан жишээ дурдахад Эрдэнэт үйлдвэр дээр жишээлэхэд бид хиймэл оюун ухаанаар тендер шалгаруулдаг болсноор Эрдэнэтийн шахаа гэдэг юм үндсэндээ байхгүй болж байгаа юм. Тийм эхлэлийг тавьж байгаа юм. Хиймэл оюун ухаан, Тендерийн үнэлгээний хороо 2 зэрэг ажиллаж байна. Бие биедээ хяналт тавьж байна. Цаашдаа энэ Эрдэнэс Эм Жи Эл бүх шатад технологийн дэвшлийг ашигласан энэ шинэчлэлийг хэрэгжүүлнэ. Бүх зүйл хувьчилснаар бас сайхан болчихдог юм биш. Тийм учраас энэ зэрэг зэрэг явж байгаа энэ технологийн дэвшил ашигласан орчин үеийн шинэчлэлийг хийж бид эдийн засгаа сэргээнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Ер нь энэ ТӨК орон нутгийн өмчийн энэ асуудлыг бид нар яг энэ парламентын үед шийдэх ёстой гэж үзэж байгаа. Тэгээд зарим компани нь ашигтай ажилладаг боловч түрүүн бас гишүүдийн үгэнд гарч байна ашиггүй ажиллаж байгаа, эсвэл ашгийг нь албаар бууруулдаг. Тэгээд бүгдээрээ л бараг энэ улс төрд явж байгаа хүмүүс бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ төрийн өмчийн компаниуд дээр явж байгаа. Тэгж байгаад үнэгүйдүүлж байгаад хувьчилдаг ч гэдэг юм уу ийм муухай аргууд их явсан.

Тэгэхээр энийгээ нэгдүгээрт ил тод бүгдийг нь байлгах хэрэгтэй байна. Тэгээд олборлох салбарын ил тод байдлын тухай бид нар чинь ийм санаачилгад нэгдчихсэн. Одоо энэ төрийн болон орон нутгийн өмчийн компанийн засаглалын тухай билүү өмнөх намрын чуулганаар орж байсан, 2 сард энэ оны 2 сард энэ хуулийг Улсын Их Хурал дээр хэлэлцэх эсэхийг нь шийдээд ажлын хэсэг уг нь байгуулсан. Ажлын хэсгийн ахлагч нь даанч ингээд сайд болоод явчихлаа. Эзэнгүйдсэн. Тэгэхээр хэрвээ боломжтой бол энэ хуулийг бас ахлаад энэ ажлыг бас урагшлуулах ийм хүсэлтэй байгаагаа энд илэрхийлье.

Ж.Бат-Эрдэнэ: Одонгийн Цогтгэрэл.

О.Цогтгэрэл: 26-30 оны үндсэн чиглэл буюу Монгол Улс 2 дахь таван жилийнхээ төлөвлөгөөг төлөвлөлтийг ярьж байна л даа уг нь. Зүй ёсоороо эхний таван жилийнхээ тэр хэрэгжилт, үр дүн, алдаа оноогоо уг нь дүгнэхээд 2 дахь шинэ төлөвлөлтөө ярьдаггүй нөгөөдөх өмнөх маань хаачив, гүйцэтгэл үр дүн маань хаачив, тэрийгээ эхэлж энэ чинь ярьдаг наад захын дэг ёс байхгүй юу. Өмнөхдөө дүгнэлт хийхээд дараагийн зүйлээ. Тэгээд ч ер нь энэ төлөвлөлтийн арга зүйг харахад 2050 гээд 30 жилийн төлөвлөгөө, таван жилийн төлөвлөгөө, 4 жилийн мөрийн хөтөлбөр, 1 жилийн үйл ажиллагаа, явсаар байгаад төсөв дээр очдог. Яг үнэндээ энэ бүх зүйлүүд чинь бүгдээрээ хэлбэрийн, тунхгийн шинжтэй болоод явсаар явсаар байгаад төсөв тэгээд үнэндээ тэр сая өчигдөр батлагдаж байгаа төсөв, батлагдаж байгаа үйл явцаа бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Юу нь өм цөм энд тэндээс нэмж хасаад ямар ч тэр цалин, орлого нэмж байгаа энэ зүйлс чинь бодлогын өөрчлөлт, бүтцийн шинэчлэл ямар ч зүйлд тулгуурлаагүй зүгээр л амиа аргацаагаад л төсөв баталсан болоод л ингээд гарч байгаа шүү дээ. Юу нь энэ Алсын хараа, мөрийн хөтөлбөр.

Яг үнэндээ энэ Засгийн газар чинь уг нь шинээр байгуулагдаж байгаа Засгийн газар. Тэр мөрийн хөтөлбөр энэ тэр гэдэг зүйлээ дахин нэг авч үзээд оновчлоод уг нь явмаар юм. Гэтэл өмнөх Засгийн газрын энэ “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэж байсан, 14 мега төсөл гэж байсан тэр мөрийн хөтөлбөр нь хэвээрээ байгаа юм уу, байхгүй байгаа юм уу бүү мэд. Тэрийг биелүүлэх гээд байгаа юм уу яг яах гээд байгаа юм. Тэгэхээр эндээс харахлаар зарчмын хувьд энэ төлөвлөлтийн арга зүй маань ер нь болж байгаа юм уу? Бид нар ингээд та нар ч гэсэн өөрснөө хэлбэрдэж байгаа Засгийн газар зүгээр л батлуулсан болоод ингээд гарчихъя юу өмнөх гүйцэтгэл угаасаа энэ худлаа юм чинь энийг хэн ч барьдаггүй юм чинь, яах вэ дээ ингээд хэлбэрдээд гарчихъя гэдэг ийм л үйл явц л болоод байгаа юм шиг харагдаад байна л даа.

Тэгэхлээр ер нь зүгээр онолынхоо үед түвшинд яагаад энэ бид нар төлөвлөлт дээр ер нь ингэж хандаад байгаа юм? Явсаар явсаар байгаад төсөв болдог төсөв чинь өөрөө жилдээ 2, 3 тодотгодог. Тэрийг дагаад тэр төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл олон олон зүйлүүд нь бараг тэрнээсээ олон өөрчлөгддөг. Энэ ер нь төлөвлөлтийн чадвар гэдэг юм бид нарт байхгүй байгаад байгаа юм уу, аль эсвэл, аль эсвэл төлөвлөлтөөсөө, тэр шинжлэх ухаанаасаа улс төр нь өмнөө гарчихлаараа ийм юм болоод зүгээр эхний ээлжид үүндээ дүгнэлт хийж, бараг үүнийхээ учрыг олохгүй бол ингэж элдэв янзын 7 бичиг цаас хэрэг гаргаж байхын хэрэг ер нь байгаа юм уу ер нь? Энийг барьдаггүй, хэмждэггүй, ярьдаггүй, дүгнэдэггүй. Тэгчхээд зүгээр явсаар явсаар эцсийн дүндээ урвуу бодлого гэдэг шиг яг 1 жилийн Алсын хараатай, 1 жилийн л үйл ажиллагааны төлөвлөгөө буюу төсөв дээр очоод л бүх зүйлийг л эцэст нь.

Тэгэхээр би нарийн ширийн гоё сайхан зүйлүүдийг ярихаас өөр дээр ер нь энэ төлөвлөлт одоо яг хэрэгтэй байгаа юм уу? Ингэж хэлбэрддэг ээ ингэж баахан цаг, цаас үрж ингэж юм хийдэг ээ зүгээр энэ яг энэ байдлаараа зүгээр больсон нь л дээр. Энэ чинь ямар ч ийм тунхгийн, ач холбогдлын зэрэг нөгөө priority элдэв дээдийн юм гэдэг энэ зүйлүүд чинь энд ерөөсөө алга. Баахан бүх зүйлийг гоё болгоно гээд л биччихдэг. Уг нь бүх зүйлийг энэ чинь аливаа нөөц чинь, цаг хугацаа, мөнгө санхүү бүх зүйл чинь хэмжээ хязгаартай байх л даа. Тэгээд бүх зүйлийг гоё болгоно гэж биччихээр чинь яаж төлөвлөлт бас байх вэ дээ. Яг анхаарах зүйл нь юу юм Засгийн газрын түвшинд улс орны түвшинд? Салбар яамнуудын гол, гол гол бараг ядаж 1, 1 зүйлийг биччихсэн ч бараг 20 яамтай газар 20 тун бодлогын ард гарчихна л даа. Тэгэхээр бүх зүйлийг гоё болгоно гээд биччихдэг. Эцсийн дүндээ та нар энэ төлөвлөлт дээр тэгээд ач холбогдол өгч байгаа, хэмжиж байгаа, дамжиж байгаа, энийг дүгнэлт хийж байгаа, өнгөрсөн 5 жилд нь яг юу болчихсон юм? Энэ бүхэн чинь үнэхээр яг ингэсэн дор энэ энэ төлөвлөлтийг хийхгүй байсан нь л дээр л ийм л зүйл харагдаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Цогтгэрэл гишүүн бас маш чухал асуудал хөндөж байна. Өнгөрсөн 30 жил, 30 хэдэн жил бид нар үндсэндээ төлөвлөлтгүй явж ирсэн. 1990 он хүртэл 5, 5 жилээр төлөвлөөд түүнийгээ биелүүлэх гээд бүгд зүтгэдэг, улсаараа хичээдэг байсан. Гадаадын улс орнууд бас 5, 10 жилээрээ, 30 жилээрээ төлөвлөдөг ийм байдаг. Бид нарт ямар ч төлөвлөгөө байхгүй. Ялсан нам болгон өөрсдийнхөө дураараа мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлнэ гээд дайрчихдаг. Ерөнхий сайд хүн болсон хүн болгон би өөрийнхөө бодлого хэрэгжүүлнэ ээ гэдэг өмнөхөө

дандаа үгүйсгэдэг ийм чөтгөрийн тойрогт орсон, ингэж явж ирсэн. Үүнээс салах гэж бас олон жил оролдож байгаа. 19 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. “Монгол Улсын төрийн бодлого нь хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж үг орсон, оруулсан бид нар. Ингэж байж үүн дээрээ тулгуурлаж Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг Улсын Их Хурлаар баталсан. Тэгээд төлөвлөлт байхгүй болохоор нөгөө хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй.

Тийм учраас төлөвлөлт байхгүй болохоор төлөвлөлтгүй тэгээд л жил жилдээ Ерөнхий сайд болгон өөрийн бодлогоо хэрэгжүүлдэг. Улсын Их Хурал төсөв батлахдаа тэгээд л тухайн үедээ лоббидож байгаад л хэр дуртай, хэн овсгоотой нь ахиу төсөв батлуулдаг ийм замбараагүй явж ирсэн. Энэ жишгийг л халах гэж бид нар Монгол Улсын бодлого төрийн бодлоготой больё оо, төрийн бодлого төлөвлөлттэй байя. Энэ нь урт, дунд, богино хугацаандаа харилцан уялдаатай байя гэдэг үүднээс 30 жилийн урт хугацааны бодлого, 10 жилийн 8 үндсэн зорилт, хөтөлбөр, таван жилийн үндсэн чиглэл, үүнд тулгуурласан 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үүнийгээ хэрэгжүүлэх гэж жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд төсөв ийм харилцан уялдаатай байх ийм хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай харилцан уялдаатай төрийн бодлогын бичиг баримтууд уялдаатай байх энэ асуудлаа хуульчилж өгсөн юм. Хуульчилж өгсөн. Одоо энийгээ ингээд хэрэгжүүлээд явмаар байгаа юм.

Таны саяын ярьж байгаа 21-25 оныхоо таван жилийн анхны төлөвлөгөөгөө бид нар хэрэгжүүлсэн. Хэрэгжилтийг нь хянаад үзсэн. 95 шалгуур үзүүлэлтээр зорилтуудаа ингээд тавьсан зорилтоо хэмжиж үзэхэд 54 хувийн биелэлттэй байсан. Энийгээ бид нар Улсын Их Хуралд бас танилцуулсан, хүргүүлсэн. Улсын Их Хуралд хүргүүлж танилцуулсан юмаа Улсын Их Хурал дээр хэлэлцээд Улсын Их Хурлаас Засгийн газарт энэ нь зөв байна, энэ нь буруу байна дараагийн 2 дахь таван жилийн төлөвлөгөө дээр та нар энэ асуудлуудаа ингэж тусгаарай гээд чиглэл өгөх ёстой байсан боловч энэ процесс хийгдсэнгүй. Хуулийн дагуу Монгол Улсын Засгийн газар хуульд заасан хугацааныхаа хүрээнд дотор багтаагаад энэ дараагийн 26-30 он буюу таван жилийн үндсэн чиглэл оруулж ирж байгаа юм.

Энэ нөгөө шинэ яваад байгаа учраас хэрэгтэй ч юм шиг, хэрэггүй ч юм шиг тэгээд Их Хурлын гишүүд маань бас сайн ойлголт бас багатай байгаа учраас энд ач холбогдол өгдөггүй. Үүнээсээ болоод зөв ч юм шиг, буруу ч юм шиг, шаардлагатай ч юм шиг, шаардлагагүй ч юм шиг ийм болчихоод байгаа юм л даа. Тийм болохоор маш чухал бодлогын бичиг баримт шүү. Үүн дээр тулгуурлаж 28 оны улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр гарна.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ яриад байгаа төсөв, төлөвлөгөө, төлөвлөлттэй холбоотой асуудал энэ Учрал сайд та хариулаадхаач. Танай яаман дээр чинь бүх асуудлуудыг базаж байх ёстой шүү дээ уг нь. Учрал сайд.

Н.Учрал: 21-24 оны хэрэгжилт хийсэн аудитын үнэлгээ 67 хувьтай байсан. Манайх бол өөрсдөө үнэлгээ хийсэн энэ бол 52.8 хувьтай гарсан. Тэгээд Их Хуралд тайланг нь хүргүүлсэн. Энэ юунаас болдог байсан бэ гэхээр шалгуур үзүүлэлтүүд, индикаторуудыг тавиагүй. Энэ quality ер нь ийм чанарын арга хэрэглээд яваад ирчихсэн хэмжиж болохгүй. Тэгэхээр энэ удаагийн гол зорилт хэмжиж болдог байдлаар хийж байгаа юм л даа. Тэгэхээр заавал тайланг

процессыг нь үнэлэхгүй гэсэн үг. Тэгэхээр бид ирэх жил огт процесс үнэлэхгүй. Жилийн төлөвлөгөөг ч гэсэн. Зөвхөн үр дүн хэмжинэ. Тэгэхээр энэ таван жилийн чиглэлд ч гэсэн салбарын үр дүн, үндэсний үр дүн төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн 30 тэрбумаас дээш 200 хөтөлбөр гэж байгаа юм. Тэгэхээр хэмжиж болох бололцоотой болж байгаа учраас дахиж ийм процесс үнэлэгдсэн тайлан тавиад байхгүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Тэгээд энэ төлөвлөлтийн ач холбогдол, арга зүй талаас нь тэр эрдэмтдийн багаас бас төлөөлөөд нэг нь хариулж өгөөч. Би бас Ерөнхий зарчмын асуултыг нь л асуугаад байна л даа. Үнэхээр төлөвлөж чадахгүй байгаа юм уу, аль эсвэл өөр шалтгаан байна уу? Яг ийм энэ төлөвлөлтөд та нар сэтгэл хангалуун байгаа юу? Энд бас эхний ээлжид хариулт авмаар байна.

Хоёрдугаарт нь жоохон тодорхойдуу асуулт нь ер нь эдийн засгийн өсөлт гэж өнгөрсөн хугацаанд болоод ирээдүйд цаг дээр явж байгаа энэ зүйлээс харахад төлөвлөлтөд энэ эдийн засгийн өсөлтөд уул уурхайг хасвал үлдэж байгаа эдийн засгийн өсөлт гэдэг юм яг ямар тоо байгаа юм бол? Энийг салбарын сайд болоод энэ ажил хариуцсан хүмүүс нь нэгдүгээрт нь. Хоёрдугаарт нь энэ технологийн өсөлт, технологийн хөгжил, дэвшил гэдэг зүйл дижиталчлал, элдэв зүйлүүд маань манай эдийн засгийн өсөлтөд та нар ямар үр нөлөөтэй гэж үзэж байгаа юм? Энэний тооцоолол, тооцоонууд нь яг юу байна? Уул уурхайг хасвал ямар байна, энэ технологийн хөгжил дэвшлийг бид яаж.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон. Төлөвлөж чадаж байгаа юм уу чадахгүй зүгээр эвдээд байна уу гэдэг дээр бүүр тодорхой хариулт өгөөч. 4 номер.

А.Бакей: Баярлалаа. Тэгэхлээр энэ таван жилийн үндсэн чиглэлийн төслийг боловсруулах явцад ШУА холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл оролцож бас боловсруулах шат дээрээ ажилласан. Миний хувьд бас судлаач хүний хувьд энэ асуултад хариулъя. Ер нь үндсэн чиглэл бол Монгол Улсын хөгжлийн урт хугацааны болоод богино хугацааны хөгжлийн бодлогыг хооронд нь холбох маш чухал төрийн хөгжлийн бодлогын баримт бичиг гэж үзэж байгаа. Энэ баримт бичгийн онцлог нь баахан мөрөөдлийн жагсаалтыг өөртөө агуулах биш хамгийн гол нь хэмжиж болохуйц чиглүүлэгч шинжтэй ийм баримт бичиг гэж боловсруулах шатдаа бид нар бас сайн ярьсан. Тийм ч учраас.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон индрийг дахиад сунгая.

А.Бакей: Учраас энэ удаад энэ үндсэн чиглэл нь үр дүнд суурилсан, судалгаанд суурилсан, оролцоонд суурилсан ийм онцлогтой арга зүйн хувьд ахиц дэвшил гарсан төлөвлөлт болсон гэж үзэж байгаа. Мэдээж энэ дээр сайжруулах зүйл байгаа. Энийг их дараачийн шатны хэлэлцүүлэх явцдаа бас эрхэм гишүүд маань өөрсдийнхөө саналаа гаргаад сайжруулаад явах байх гэж найдаж байна. Жишээ нь өнөөдөр хөдөө аж ахуйд хамгийн тулгамдсан асуудал бэлчээрийн доройтол, бэлчээрийн ачаалал нэмэгдсэнтэй холбоотой асуудал байна. Энэ дээр хэмжихүйц зорилт дэвшүүлсэн. Жишээлбэл, бэлчээрийн ачааллыг бууруулна. Энэ бол 100 га бэлчээрийн талбайд ноогдох малын тоо хонин толгойд шилжүүлснээр 114 байгааг 30 онд 95-д хүргэнэ гэж байгаа. Тэгвэл Хөдөө аж ахуйн сайд энэ

зорилтыг хэрэгжүүлэхийн тулд малынхаа тоо, тоо толгойг эдийн засгийн эргэлтэд ор.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд тодруулъя.

Г.Занданшатар: Тэгээд. Цогтгэрэл гишүүн ээ ер нь энэ эмх замбараагүй төлөвлөлтгүй, бодлогын 174 баримт бичигтэй хэрэгжилтгүй яг таны хэлснээр яваад байсан учраас Үндсэн хуульд нэмэлт өөрчилж Үндсэн хуульчилж байж тэгээд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд 21 онд өөрчлөлт оруулаад энэ бүх процессыг зааж өгсөн юм. Харамсалтай нь энийгээ зөв зүйтэй хэрэгжүүлж чадаагүй юм байна лээ. Энэ чинь шинэ тулгар байна, улам сайжруулж байна. Жишээлбэл хаа хаанаа хариуцлагатай байх хэрэгтэй. 9 дүгээр сарын 11-ний өдөр өнгөрсөн таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ, тайланг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тэгээд заавар, зөвлөмжөө сарын дотор өгөх ёстой байсан байх. Одоо ингээд илүү үр дүнд чиглэсэн тодорхой хэмжиж болохуйц, хэмжигдэхүйц энэ шаардлагад нийцүүлээд бодитой хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөв мөнгө, санхүүжилтийн эх үүсвэртэй нь уясан төлөвлөгөө оруулж байгаа. Энэ Азийн хөгжлийн загвар гэж ерөөсөө таны ч ярьдагчлан Япон.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууя.

С.Одонтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр нэлээд бас нарийн уншиж танилцлаа. Тэгэхээр бид чинь хэддүгээр зуунд амьдраад байгаа вэ гэдгийг л асуумаар байна. XXI дүгээр зууны хамгийн гол хөгжил авч ирж байгаа зүйл чинь цахим эдийн засгийн шилжилтийн эрин үе. Тэгэхээр өнөөдөр Монгол Улс бол ингээд хөгжихгүй байна, хоцрогдож байна, хэтэрхий хуучин сэтгэлгээгээр байна гэдэг чинь энэ цахим эдийн засаг руу зоригтой орж чадахгүй байгаагийнх л байгаа шүү дээ. Би тэгээд энэ дээр цахим эдийн засаг гэдэг үг зүгээр хайгаад олдсонгүй, уучлаарай байна уу, үгүй юү. Бид нар өчигдөр төсвөө баталсан. Тэр төсвөөр бид энэ хуучин ядуу сэтгэлгээгээр явах юм бол дахиад л хөгжихгүй. Харин өчигдрийн баталсан төсвөөр, шинэ сэтгэлгээгээр энэ цахим эдийн засагт яаралтай шилжих юм бид бол амжилтад хүрэх боломжтой. Энэ 35 дугаар хуудсан дээр байна л даа “цахим Монгол” гээд. Тэгэхээр энэ “цахим Монгол” дээр амжилтууд гарч байгааг би дэмжиж байна. Жишээлэхэд E-Mongolia, тэгээд л цахим индексжүүлэлт энэ тэр гээд. Энэ бол цахим эдийн засаг биш цахим үйлчилгээ байхгүй юу. Цахим үйлчилгээ буюу цахимжуулалт энэ юугаараа ялгаатай юм бэ гэхээр өмнө хийж байсан ажлыг арай хурдан хийж байгаа л хэлбэр шүү дээ. Хүмүүст арай хурдан хүргэж байгаа хэлбэр. Цахим эдийн засаг гэдэг нь өөрөө энэ уламжлалт аргаасаа татгалзаад цоо шинэ өндөр түвшний үр өгөөжтэй эдийн засгийн энэ аргуудыг хэрэглэхийг л бид нар хэлээд байгаа юм.

Тэгэхээр мэдээж яах вэ тодорхой энэ уламжлалт аргуудаа бид нар хэрэглэнэ л дээ. Гэхдээ би зүгээр хэдэн жишээ хэлье. Alibaba байна ч жижиглэн худалдааны дэлгүүргүй хэр нь өнөөдөр дэлхийн хамгийн том сүлжээ болчихсон Netflix байна. 1 ч кино театргүй хэр нь өнөөдөр дэлхийн хамгийн том кино театр, Uber байна. Манайд яах вэ энэ Uber бас үнэхээр том цахим эдийн засгийн том хэлбэр мөн, маш том зүйлүүд эргэлдэж байна. Тэнд өөрийн гэсэн уламжлалт такси байхгүй хэр нь эдийн засгийн том эргэлтүүд хийж байгаа. Тэгэхээр би бол энэ цахим эдийн засаг гэдэг гэр чиглэлээр би өмнөх Засгийн газрын гишүүдэд бас

засгийн хурал дээр их олон удаа л бас хэлж байсан. Энэ цахим эдийн засаг руугаа бид нар шилжихгүй юм уу зоригтой гээд.

Би зүгээр 1, 2 тоо хэлье л дээ энэ Бээжин хот өнөөдөр цахим эдийн засгийн загвар болно гээд. Өнөөдөр цахим эдийн засаг нь Бээжин хотынхоо ДНБ-ий 45 хувьд хүрчихсэн байна. Нийт Хятад улсын эдийн засгийн цахим эдийн засгийн эзлэх хувь нь ДНБ-ийхээ 44.5 хувьд хүрчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь өөрөө авлигыг бууруулдаг тэгээд 10 хүн тутамд 5G станцуудыг ингээд олноор нь барьж байна. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр бид нар энэ цөөхүүлээ ийм нэг салбараас хамааралтай хүмүүс энэ цахим эдийн засаг руу бид зоригтой шилжиж чадах юм бол энэ эдийн засагт том боломж байна гэдгийг хэлэх гээд байна.

Тэгэхээр би тэр цахимжуулалт, энэ цахим индекс, цахим үйлчилгээ энэ чинь тусдаа асуудал шүү. Цахим эдийн засаг гэдэг чинь том эдийн засгийн том цар хүрээ, эргэлтийг авчрахгүй юм уу л гээд байгаа юм. Тэгэхээр цахим эдийн засагт шилжихийн тулд бид 5 үндсэн бодлогыг цогцоор нь авч хэрэгжүүлэх ёстой. Нэгдүгээрт тэлэлтийн бодлого, хоёр дахь нь холболтын бодлого, гурав дахь нь үйлдвэр, худалдааны бодлого, хөрөнгө оруулалтын бодлого, хууль, эрх зүйн бодлого гэсэн энэ 5 бодлогыг цогцоор нь хэрэгжүүлэхгүйгээр бид амжилтад хүрэхгүй юм гэдгийг би бас олон удаа хэлж байгаа. Тэгэхээр энэ асуудал руугаа яагаад ороогүй юм бэ? Эсвэл орсноо эндээ тодорхойлж чадаагүй юм болов уу яасан юм бол? Учрал сайд энэ дээр бас хариулт өгөх үү л гэж л хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Батшугар сайд хариулъя.

Э.Батшугар: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Тантай санал нэг байна. Цахим эрин үе ирчихсэн байна. Тэгээд дэлхийн хамгийн том компаниуд үнэхээр өмнө нь уул уурхайн, нефть, газ олборлодог компаниуд байсан. Одоо яг цахим компаниуд болчихсон байгаа. Тэгэхээр Монгол Улсын өнөөдрийн нөхцөл байдал яг үнэндээ яг цахим талдаа, эдийн засаг талдаа тийм том дэмжлэг байгаагүй. Харин өмнөх парламент та бас санаж байгаа байх Мэдээлэл, технологийг дэмжих тухай хууль батлагдсан. Үүний үр дүнд виртуал бүс гэсэн тийм бүс байгуулагдаж байгаа. 21 оны 1 сарын 1-ээс. Виртуал бүсийг амилуулах 2 журам нь сая Засгийн газраар 9 сард батлагдчихсан. Энэ тодорхой хэмжээний цахим эдийн засгийг тэлнэ гэж харж байгаа юм. Үүнд мэдээлэл өгөх компаниуд бүртгэгдсэнээр орлогын албан татвараас чөлөөлөгдөнө, НӨАТ-аас чөлөөлөгдөнө, дээрээс нь НДШ-ийн буцаан олголт хийнэ, экспортод бүтээгдэхүүн гаргавал тэгвэл судалгаа шинжилгээ гэж ярьдаг Ар Эн Ди-гийнх нь зардлынх нь 70 хувийг нь буцаан олгоно. Хиймэл оюундаа тулгуурласан бүтээгдэхүүн гаргавал 40 хувь нь буцаж олгоно гэх мэтчилэн дэмжлэгүүд орчихсон байгаа юм. Олон улсын жишгийг харахад энэ виртуал цөөн бий болсноор цахим эдийн засаг нь нэлээн томоор тэлдэг юм байна лээ.

Жишээлбэл, Молдова улс 2017 онд яг энэ виртуал zone-той адилхан тийм zone хууль батлагдсан. Тухайн үед цахим эдийн засаг нь 212 сая доллар байсан 22 онд таван жилийн дараа гэхэд 677 сая доллар болчихсон. Гүрж улс мөн адилхан. 2011 онд цахим эдийн засгаа дэмжих тийм хууль батлагдсан. Яг манай Монголын виртуал zone-той адилхан. Үүнд тухайн үед цахим эдийн засаг нь 32 сая доллар байсан. Таван жилийн дараа гэхэд 240 сая доллар болсон. Тэгэхээр

Монгол Улс яг өнөөгийн байдлаар нийт дотоодын бүтээгдэхүүн болон GDP-ийн цахим эдийн засаг 2 хувийг эзэлж байгаа. Үүн дээр дийлэнх нь оператор компаниуд байгаа. Мобиком, Юнител, Скайтел гэх мэтчилэн эд нарыгаа цэвэрлээд хасвал 0.12 хувийг нь эзэлж байгаа юм. Энэ 30 он гэхэд энэ виртуал zone бүрэн хэрэгжиж эхлээд тэгэхэд ямар ч байсан байдлаар 4 дахин өснө гэж тийм тооцоолол гарсан. Гэхдээ энэнээс илүү өсөх бололцоотой.

Яагаад гэвэл хиймэл оюуныг ч гэсэн Засгийн газар нэлээн дэмжээд тэгээд ирэх жилд Жи Пи Юу-ийн кластер байгуулагдана. Энэ кластертаа бид нар дан түр хэрэглэхгүй. Харин эсрэгээр бас эрдэм шинжилгээний судалгааны байгууллагууд болон манай start app гарааны бизнесүүд ч гэсэн Жи Пи Юу-аа Монголдоо ашиглах бололцоог нээнэ. Одоогийн байдлаар гаднын серверүүдийг үнэтэйгээр түрээсэлдэг. Харин эсрэгээрээ манай дата центртээ үүнийгээ бүрэн ашиглуулаад хиймэл оюун тулгуурласан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн бусад цахим эдийн засгаа тэлэх шинэ бүтээ.../минут дуусав.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулах уу Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр харин тийм би бас ойлголоо. Тэгэхдээ ДНБ-ий 0.12 гэдэг чинь дэндүү бага шүү дээ. Бараг байхгүйтэй адилхан байхгүй юу. Гэтэл өнөөдөр энэ Хятадын цахим эдийн засгийн аж үйлдвэрийн хөгжлийн тайлан гээд би харж байна л даа 23 оных нь шүү дээ хуучирсан тоо. Тэгэхдээ энд Хятадын цахим эдийн засгийн цар хүрээ 50 их наяд юанийг давж ДНБ-ийхээ 41.5 хувь хүрдэг.

Гэтэл манайх 0.12 гэдэг чинь бага байхгүй юу. Би байхгүй гэж огт хэлээгүй мэдээж байгаа. Тэгэхдээ хэтэрхий удаан байна, муу байна. Энэ гол үндсэн чиглэлдээ энийгээ сайн тусгахгүй байна. Зүгээр цахимжуулалт гэдэг дээрээ ингээд яриад байдаг, хариулаад байдаг. Гэтэл яг цахим эдийн засаг гэдэг юм руугаа орохгүй байна гээд. Тэгээд худалдааны бодлого гээд л Их Хурлаар зөндөө л дамжаад л ярьсан. Тэр бодлого хэзээ орж ирэх юм бол оо Занданшатар дарга та мэдэж байна уу? Худалдааны бодлого ер нь энэ Засгийн газар?

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар сайд хариулъя.

Г.Занданшатар: Одонтуяа гишүүнтэй санал нэг байна. Цахим эдийн засаг эдийн засгийн шинэ төрөл болсон бөгөөд энэ мобайл device-сууд дээр тулгуурлаж байгаа. Тэгэхээр энэ хиймэл оюун ухаантай холбоотой ер нь. Энийг “мэдлэгийн эдийн засаг” гэж томъёолсон байгаа. Орчин үеийн технологийн дэвшлээр хөтөлсөн эдийн засгийг мэдлэгийн эдийн засгийн шинэ хэлбэр гэж үздэг болчихсон.

Тийм учраас энэ хөтөлбөрт яг “цахим эдийн засаг” гэж томъёолоогүй боловч “мэдлэгийн эдийн засаг” руу шилжих шинжлэх ухаан, технологийг дэмжих гэсэн агуулгаар “мэдлэгийн эдийн засаг” гэж томъёолсон байгаа. Хиймэл оюун ухааны зах зээлд өрсөлдөх чадварыг Засгийн газрын хиймэл оюуны бэлэн байдлын индексийг 42.36 байгааг 30 онд 65-д хүргэнэ. Дижитал шилжилт ба мэдлэгийн эдийн засаг 2 бол 1 зоосны 2 талын юм гэсэн агуулгаар тэгж туссан байгаа. Үнэхээр би ч бас ч хэлж байсан манай нүүрсний экспорт 15 тэрбум доллар. Тэгэхэд Air rod-ын жижигхэн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Тийм учраас ганцхан жишээ дурдахад бид бас Цогтгэрэл гишүүн ч гэсэн түрүүн асуугаад байсан 5 жил яг шаардлагатай юу үгүй юү гэж. Бид бүс нутгийн интеграцид нэгдэх шаардлагатай. БНХАУ гэхэд XV дугаар таван жилийн төлөвлөгөөгөө ирэх 3 сард батална. Тэнд энэ цахим оюун, хиймэл оюун ухаан, цахим эдийн засгийн шинэ төрлийг хөгжүүлэх гэх мэтчилэн ингээд Зүүн хойд Азийн бүс нутагт нэвтэрч байгаа технологийн дэвшлийг яаж засаглалд, үйлчилгээнд, төрийн үйлчилгээнд эдийн засгийн шинэ хэлбэрээр хөгжүүлэх ийм цогц бодлогууд тусаж байгаа юм байна лээ. Тэгээд энэнтэй энэ эдийн засаг, шинэ эдийн засаг бий бий болгох асуудал асар уудам газар нутагтай, хүн ам цөөтэй Монгол Улсын үед хиймэл оюун ухаан, робот технологи, аж үйлдвэрийн IV дүгээр, технологийн IV дүгээр хувьсгалын эрин үед энэ цахим эдийн засгийг хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг мэдлэгийн эдийн засаг гэдэг агуулгаар томъёолсон гэж ойлгож байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: “Монгол Улсыг 26-30 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” энэ тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаах нь зүйтэй гэдэг саналыг Эдийн засгийн байнгын хороо гаргажээ. Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжих эсэхээр санал хураана. Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжсэн тохиолдолд хууль санаачлагчид буцаагдана. Хэлэлцэх эсэх дээр нь унаж байгаа учраас 1 жилийн хугацаанд оруулж ирэх үү, үгүй юү, бусад энгийн хууль тогтоомжтой адил Дэгийн хууль үйлчлэх үү үгүй юү гэдгийг нөгөө талдаа бас харах ёстой байх.

Дэмжээгүй саналыг дэмжээгүй тохиолдолд хэлэлцээд явна буюу энэ асуудал босож ирнэ ээ гэсэн үг. Энэ тохиолдолд яах вэ гэхлээр Улсын Их Хурлын чуулганы танхимд байгаа гишүүд улаан кнопоо дарах нь. Манай Хуягаагийн зарчмаар улаан, ногоон лааз гэдэг улаан лаазыг өргөх нь байна. Эсвэл ирцэд орсон хүмүүс гарч, кноpdoo хүрэхгүй байх энэ боломж нь ч гэсэн байгаа. Ингэснээр чуулганы хуралдаандаа оролцож байгаа гишүүдийн олонх нь Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжээгүй учраас хууль цаашлаад хэлэлцээд явагдана гэсэн үг. Тэгээд би энийг яагаад хэлээд байна вэ гэхлээр энэ зүгээр л манай Их Хурал дээр явагддаг процесс. Угаасаа л бид бүгдээрээ үүнийг мэднэ.

Гэтэл Цэц биднийг юу гэсэн бэ гэхлээр энэ чинь ардчилсан бусад улс оронд байдаггүй асуудал юм. Улсын Их Хурлын гишүүд ирцдээ орчхоод саналаа өгөхгүй байгаа чинь Үндсэн хуулийн 27.7, 23.1-ийг зөрчсөн шүү гэдэг ийм сонин дүгнэлтийг гаргачихсан байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын хуралдааныг даргалагч Бат-Эрдэнэ дарга та бас хууль маань тан дээр өөрөөр үйлчлэх вий. Санал хураалгахдаа гишүүдийнхээ ирцийг бас анхаарах уу, үгүй юү, эс үгүй бол түүгээрээ явах уу гэдгийгээ харна биз. Ер нь Улсын Их Хурлын дотоод асуудал энэ дэгтэй холбоотой маш буруу ийм дүгнэлтийг бас гаргасан байгаа гэдгийг хэзээ нэгэн цагт түүх гэрчилж энэ дүгнэлтийг авч үзэх хүмүүс гарах байх гэж бодож байна.

1 минут үлдсэн байна. Би Ерөнхий сайдаас гуравхан тодорхой асуултыг асууя та минь хариулаад өгөөрэй. Тулгамдаж байгаа асуудалтай холбоотой.

Тэтгэврийг Тэтгэврийн санг 8.6 хувиар нэмэгдүүлэх төсөв бид нар баталчихлаа. Тэтгэврийн тухай хуулийн 27.1 тухайн өнгөрсөн жилийн инфляцын дундаж түвшнээр бид нар нэмэгдүүлнэ ээ гээд. 27.2 Засгийн газар хэрхэн яаж нэмэгдүүлэх вэ гэдэг аргачлалыг батална гээд. Тэгээд одоо ахмадууд яг харж байгаа бага дээр нь ахиухан нэмэх боломжтой юу, бүгдийг нь адил, тэгш хувиар нэмэх гээд байна уу, аргачлалаа Засгийн газар яаж батлах вэ гэдэг дээр та хариулт хэлж өгөөч. Бүгдийг нь адил, тэгш хувиар нэмэгдүүлнэ ээ гэдэг маань өөрөө тухайн үедээ хүмүүс ажил, хөдөлмөр эрхэлж байхдаа өндөр цалингаасаа өндөр шимтгэл төлж байсан үнэн, зөв. Гэхдээ тэр хэр хэрээрээ өндөр тэтгэвэр тогтоолгочихсон учраас зохистой харьцааг нь хадгалахын тулд тусгайлсан аргачлал авч явдаг юм. Тийм учраас яг энэ 27.2-ыг та ашиглаж Засгийн газар ямар шийдвэр гаргах вэ? Энэ дээрээ хариулт өгчихвөл сайн байна. Ахмадууд бас жагсах нь жагсаад, бичих нь бичээд, бухимдах нь бухимдаад харж байгаа хүмүүс их байна.

Хоёр дахь нь цалин хөлсний нэгдмэл бодлого алдагдчихлаа. Эмч, багшаас гадна бусад төрийн албан хаагчид маань яах вэ? Төсвийн тодотгол орж ирэх үү? Эдгээрийгээ эс үгүй бол шалз хаях уу гэдэг дээр та Ерөнхий сайдын хувьд хариулаад өгөөч.

Гурав дахь асуулт нь төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэмжтэй холбоотой 50 хувийн эх үүсвэрийг тавьсан. 50 хувилна гэдэг маань түрүүлж гарсанд нь 100 хувь өгнө гэсэн үг үү. Эсвэл 50, 50 хувиар 50 хувийг нь 50 хувийг нь ирэх жил өгнө гэсэн үг үү?

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд Занданшатар. Ерөнхий сайд хариульъя.

Г.Занданшатар: Нэгдүгээрт, Үндсэн хуулийн цэцийг шүүгээд хэрэггүй ээ гэж дахин зөвлөө. Яагаад гэхээр энгийн санал хураалтаас тусдаа Үндсэн хуульчлаад заагаад, эс үйлдлээр биш үйлдлээр заавал Засгийн газрын тогтвортой байдлын асуудлыг шийддэг зарчмыг дэлхийн парламентуудын практикт нийцүүлээд бүүр яг картаар хаалгаар гардаг Английн парламентын жишиг дэлхийн бүх парламентуудын жишиг энэ эмзэг асуудлыг ингэж үнэтэй нийцүүлж Үндсэн хуульчилсан зарчим бусад санал хураалттай адилгүй гэдгийг ойлголт өгөх ёстой юм байгаа юм. 100 дахь удаагаа хэлж байна.

Хоёрдугаарт нь тэтгэврийг нэмэгдүүлэх зарчмыг бид нар мөнгөн дүнгээр нэмэгдүүлэх ёстой гэсэн зарчим баримталж байгаа. Жишээлбэл, 100 мянган төгрөгөөр бүх тэтгэврийг нэмэгдүүлэхтэй адилхан. Сая багш нарын цалингийн ч гэсэн хамгийн гол асуудал залуу багш нарын цалин сая 484 мянган төгрөг байгаа нь хамгийн гол асуудал 1-4 жил ажилласан байсан. Тийм учраас бид нар тогтмол мөнгөн дүнгээр нэмэгдүүлсэн. Хувиар нэмэгдүүлсэн биш. Тэгээд бусад салбарууд тэрэнтэй барьцаад. Ер нь та ч гэсэн Нийгмийн хамгааллын яаманд ажиллаж байхдаа энэ цалингийн гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоо энэ цалингийн реформ хийх ёстой болсон гэдгийг ойлгосон баймаар гэж бодож байна.

Тийм учраас цалингийн цогц шинэчлэл бид төрийн албан хаагчдын төрийн албаны реформтойгоо нийцүүлж хийх гүйцэтгэлд суурилсан цалингийн шинэчлэлийг, бодлогыг хэрэгжүүлж энэ хүрээндээ цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална. Ер нь өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээ бол дундаж цалингийн 33.8 хувьтай байгаа нь нийгмийн хамгааллыг хангалттай

хэмжээнд үзүүлж чадахгүй байгаагийн жишээ. Тийм учраас Үндсэн чиглэлийн төслийн 2 дугаар асуултын 2.2.1.2-т тэтгэврийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг тогтмол өсгөхөөр заасан. Тэтгэврийн тогтолцоог 3 тулгуурт болгохоор одоо зорилт дэвшүүлсэн. Олон эх үүсвэрийг бий болгох замаар 2030 онд тэтгэврийн хэмжээг ажилчдын дундаж цалингийн 35 хувьд хүргэхээр хүргэж, нийгмийн баталгааг нь хангахаар зорьсон.

Ер нь тэтгэврийг нэмэгдүүлэх шийдвэрээ үндэслэлтэй гаргана. Бид 8.7-13.3 нэгжээр цалингийн адил түвшний улсуудаас ялгаатай байгааг нэмэгдүүлж, 49-50.5 хувьд хүргэхээр тооцож байна. Тийм учраас ерөнхий зарчим бол суурь, доод тэтгэврээ түлхүү өндөр, арай өндөр хувиар нэмэгдүүлнэ л гэсэн үг. Яагаад гэвэл хувиар нэмэгдүүлээд байх тусам тэтгэврийн зөрүү ихсээд зарим 4 сая 500 мянган төгрөгийн цалин авдаг эрт тэтгэвэрт гарсан цэргийн алба юу төрийн тусгай албан хаагч ч байна. Тэгтэл 686 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа ахмад настнуудын тэтгэврийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхэд жишээлбэл илүү нөгөө хувийн хувьд илүү .../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатар ахмадууддаа хандаж ижил, тэгш хувиар нэмэгдүүлэхгүй мөнгөн дүнгээр нэмэгдүүлнэ, бага дээр нь ахиу нэмэгдэж, энэ нь ийм өөрчлөлтийг үзүүлнэ ээ гэдгийг хэллээ. Би энэ саналыг дэмжиж байна баярлалаа. Энэ нь яг зүйтэй. Хоорондын зөрүүг нь улам алсруулахгүй байх арга хэмжээ авах нь зүйтэй.

Хоёр дахь асуулт маань төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог 36 сар хүртэл тэтгэмжтэй холбоотой эх үүсвэр тэтгэврийн 50 хувийг тавьсан нь Төсвийн хууль, Төрийн албаны тухай хуулийг зөрчсөн хэдий ч 50 хувийн эх үүсвэрийг нь л баталлаа. Үүнийг хэрхэн яаж олгох вэ гэдэг тал дээр Засгийн газар бас аргачлалаа бас одоо батална гэж Сангийн яам хариулж байсан. Үүн дээр та бас хариуцлагатайгаар хариулаад өгнө үү. Түрүүлж тэтгэвэртээ гарч байгаа хүмүүсийн 36 хүртэл сарын тэтгэмжийг 100 хувь өгөх юм уу, эс үгүй бол бүгдийг нь 50 хувь 26 онд 50 хувь, 27 онд 50 хувь өгөх юм уу гэдгийг бас тодорхой болгож өгөхийг хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Тэр аргачлалыг тодруулж өгье Ерөнхий сайд Занданшатар.

Г.Занданшатар: Ер нь бид энэ ахмад настны талаар төрөөс баримтлах бодлогыг бас эргэж харах шаардлагатай юм. Ер нь тэтгэврийн насыг ч гэсэн та бол Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдал, алдагдлыг сайн мэдэж байгаа. Тэтгэврийн насыг нэмэгдүүлж байгаа. Үүнтэй ч уялдуулаад ер нь бас эмч, багш нарын хувьд ч байдаг юм уу чадалтай, чадвартай багш нар үргэлжлүүлээд ажиллах, заавал тэтгэвэрт гарах гэж төсөвлөөд шахах биш үргэлжлээд ажиллаж болно. Тэтгэврийн тэтгэвэрт гарах хувь, хэмжээгээр тооцож тэгсэн болохоос биш өгөхгүй хассан зүйл огт байхгүй. Өөрөөр хэлбэл, одоогийн дундаж статистик тооцоогоор бас жилийн дараа гардаг. 1, 2 жил ажиллаж хамт олонтойгоо байчхаад гардаг. Цаашдаа тэтгэврийн дундаж нас ч гэсэн 6, 6 сараар нэмэгдэж байгаа тэтгэврийн насаа ч нэмэгдүүлэх ийм шаардлага бас гарна. Монгол хүний дундаж наслалт нэмэгдэж, 71.9-д хүрч байгаа. Эмэгтэйчүүдийн дундаж наслалт 77-д хүрч байна, 75-д хүрч байна.

Г.Занданшатар: Занданшатар гишүүн, сайд өшөө тодруулах уу? Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Ерөнхий сайд аа, багш, эмч нарыг тэтгэвэртээ гарах насаа гэдэг юм уу, тэтгэвэртээ гарах эрхээ 1 жилээр хойшлуулж ажил хөдөлмөр эрхлээч ээ гэдгийг хүсэх гэж байгаа юм байна гэж би таны хариултаа сонслоо. Тэгэхээр түрүүлж тэтгэвэртээ гарч байгаа хүмүүсийн төрийн албан хаагчдыг яриад байна шүү дээ хуулиар олгогдох ёстой 36 сарын тэтгэмжийг. Түрүүлж тэтгэвэртээ гарч байгаа үргэлжлүүлэн ажиллахаас татгалзаж байгаа эдгээр төрийн албан хаагчдын тэтгэмжийг 100 хувь өгөх үү, үгүй юү гэдгийг л асуугаад байгаа юм. Яагаад гэхлээр 50 хувийг нь өгөх гээд байгаа юм уу, эс үгүй бол 100 хувийг өгөх гээд байгаа юм уу гэдэг ийм асуултын тэмдэг байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үүн дээрээ 1 жил жишээлбэл 50 хувийг нь өгөөд, 1 жил 50 хувийг нь хойшлууллаа гэхэд энэ 1 жилийн хугацаанд ямар нэгэн эрсдэл үүсвэл яах бэ, нас барчихвал яах бэ, ар гэрт нь өгөх үү гэдэг асуултыг төрийн албан хаагчид асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үүн дээр л тодорхой хариултыг өгөөч. Тэрнээс биш үргэлжлүүлэн ажиллаач тэтгэвэрт гарах насаа хойшлуулаач гэж гуйхыг чинь би ойлгоод байгаа юм. Гагцхүү одоо яг ямар аргачлал байх юм бэ?

Ж.Бат-Эрдэнэ: Энэ ахмадуудын маань хувьд чухал асуудал болчихоод байгаа шүү дээ. Ерөнхий сайд хариулах уу? Занданшатар Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Маш тодорхой хариулъя дахин. Тэтгэвэрт гарах тэтгэвэрт гарах хүсэлтээ илэрхийлсэн төрийн албан хаагчид, ахмадуудын тэтгэмжийг 100 хувь өгнө өө. Одоо энэ Сангийн яамны гүйцэтгэлийн статистик дүн гэж байна. Яг ийм яг ийм үр дүнгээр ингээд хэрэгжээд яваад ирж ирсэн тийм бодит байдал дээр үндэслэж байж энэ тооцооллыг хийж байгаа. Тийм учраас тэтгэвэрт гарахыг хүсэлт гаргасан бүх иргэд төрийн албан хаагчид 100 хувь тэтгэмж авна. 50 хувилж биш 100 хувь авна гэдгийг дахин тодруулж хэлье. Хуультай шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Лутаагийн Энхнасан. Энхнасан гишүүн.

Л.Энхнасан: Өдрийн мэндийг хүргэе. Эдийн засаг, тогтвортой хөгжил, өсөлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх нэг том салбар бол аялал жуулчлалын салбар байгаа. Энэ үүднээс ч бас бүсчилсэн хөгжлийн бодлого дээр баруун бүсэд, зүүн бүс, хойд бүсэд байгалийн аялал жуулчлал, түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлж гэсэн зорилт тавьж ажиллаж байгаа. Энэ хүрээнд жуулчдын тоог нэмэгдүүлэх үүднээс энэ аялал жуулчлалын дэд бүтэц их чухал байгаа. Тэгэхлээр би Дэлгэрсайхан сайдаас асуумаар байна. Ирэх жил ер нь олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх үү, Иргэний нисэхийн паркийн шинэчлэлийг төлөвлөж байгаа юу, ямар улсуудтай олон улсын нислэг нэмэгдүүлэх гэж байна, мөн аялал жуулчлалын компаниудыг яаж дэмжих гэж байна? Ялангуяа сая төсвийн тодотголоор аялал жуулчлалын компаниудад татаас олгох энэ 8 тэрбум байсан. Тэрийг бууруулчихсан байгаа. Мөн өнөөдөр залуучууд Netflix-ээр Phycial Asia гээд нэвтрүүлгүүдийг бүгдээрээ үзэж бас манай залуучууд маань Монголыг гадаадад сурталчилж байна. Гэтэл Солонгосоос жишээлбэл хүмүүс ирье ээ гэхэд нислэгийн тоо хүрэлцээтэй байна уу энэ асуултыг асууя.

Хоёрдугаарт, хүний хөгжлийн том индекс нь бас боловсрол, эрүүл мэнд, орлого гэж байгаа юм. Тэрний нэг нь эрүүл мэндэд дундаж наслалт байгаа. Мэдээж дундаж наслалт нэмэгдэж байгаа. Гэвч яг эрэгтэй хүмүүс эмэгтэй хүмүүсээс 10 жилээр бага насалж байна. Ялангуяа эрэгтэйчүүд бол осол гэмтэл, гэнэтийн нас баралтаар маш их нас барж байна. Залуучууд амиа маш их хорлож байна. Тэгээд энэ нийгмийн эрүүл мэнд болон сэтгэцийн сэтгэл зүйн эрүүл мэнд дээр яг ямар ажил хийгдэх гэж байгаа юм бэ? Энийг яагаад анхаарахгүй байна аа? Ийм 2 асуулт байна. Дараа нь тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулах уу? Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Ер нь бид бас аялал жуулчлалыг татах зорилгоор манай иргэний агаарын тээвэр ер нь энд өнгөрсөн жил болоод энэ жил нэлээн нислэгүүдийг нэмж гаргаж байгаа. Жишээлбэл, өвлийн аялал жуулчлал гээд зориулаад Вьетнам, Тайланд, Тайландын Бангкок, Букет руу, мөн Сингапурыг шинээр нээсэн энэ жилээс. Зуны аялал жуулчлал буюу гаднаас ирэх аялал жуулчлалыг бид нар, бид энэ Шанхай, Сингапур, Хөх хот, Эрээний чиглэлийг бас шинээр нээж байгаа. Ер нь нийтдээ 14 чиглэлд нислэг хийж байгаа.

Тэгээд бид агаарын тээврийн баримталж байгаа гол зорилго бол ер нь транзит аялал жуулчлалыг бас татах энэ асуудал дээр нэлээн анхаарал тавьж ажиллаж байгаа. Анх 3800 зорчигч явдаг байсан бол энэ жилийн байдлаар одоогийн яг өнөөдрийн тоо баримтаар 41 мянган транзит зорчигчид явж байна. Энэ бас манайд нэлээдгүй бас мөнгө үлдээж байгаа. Бид цаашдаа бас энийг 100 мянгад хүргэх ийм зорилготой ажиллаж байгаа. Энэ аялал жуулчлалыг бас дэмжих зорилгоор энэ гол аялал жуулчлал хийдэг дотоодын нислэгүүдээ бас бид алдагдалтай ч гэсэн явуулж байгаа. Ялангуяа Өмнөговь, Хөвсгөл, тэгээд Ховд, Баян-Өлгий гээд нэлээдгүй зундаа нэлээн нэмж байгаа. Орон нутагт өдөрт бас 2 нислэг үйлдэж байгаа.

Сая та Сөүлийг асууж байх шиг байна. Энэ Сөүл зундаа өдөрт 9 агаарын тээврийн компани 10-аас дээш нислэг хийж байгаа МИАТ өдөртөө 5 удаа нисэж байгаа. Дотоодын 3 компани тэгээд гаднын 7 компани нийлээд Сөүл рүү зуны нислэгт өдөрт 10-аас дээш удаа нислэг хийж байгаа. Бусад газруудад 1-2 удаа нисэж байгаа гэдгийг бас хэлье. Тэгээд өөр нэмж тодруулах юм байвал хариулахад бэлэн байна. Бид аль болохоор л аялал жуулчлалыг нэмэгдүүлэх дээр онцгой анхаарч ажиллаж байгаа. Мөн энэтэй холбогдуулаад бас энэ юу “Чингис хаан” нисэх онгоцны буудал дээр бас транзит зочид буудал барих ийм тендер зарласан төр, хувийн хэвшлийн түншлэлээр. Тэрнээс төр зочид буудал барихгүй. Тийм учраас транзит жуулчид, транзит зорчигчид нэмэгдэж байгаатай холбогдуулаад энийг бас зайлшгүй хийх ёстой гэж үзэж байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Аялал жуулчлалын талаар Ундррам сайд. Ундррам сайдын микрофон.

Ч.Ундррам: 26 оны улсын төсөвт аялал жуулчлалын салбарыг дэмжихэд чиглэсэн хөнгөлөлттэй, нэн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасыг суулгасан байгаа. Тэгээд өнөөдөр батлагдсан дүнгээр бид нар 150 орчим тэрбум төгрөгийн нэн хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкнудаар дамжуулж аялал жуулчлалын

компаниудад өгөхөөр болсон байгаа. Энэний журам нь 3, 4 удаа аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, салбарт ажиллаж байгаа компаниудаар хэлэлцүүлэгдээд Монголбанканд хүргэгдчихсэн байгаа. Тэгээд энэ дээр бид нар энэ 150 орчим тэрбум төгрөгт квот олгосон байгаа. Дотор нь орон нутагт зочид буудал, resort барьж байгуулах, өргөтгөх, зэрэглэл ахиулах, ариун цэврийн байгууламж байгуулах, мөн зам дагуух үйлчилгээний ариун цэврийн байгууламж бүхий ийм газруудыг барьж байгуулах.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ундррам гишүүн.

Ч.Ундррам: Мөн Мерчендайз буюу сувенир үйлдвэрлэх гэх мэтчилэн орон нутаг хоорондын зам, тээврийн компаниуд гээд бид нар квот олгоод ирэх жилээс арилжааны банкнуудаар дамжуулж өгнө. Үүнээс гадна бид нар энэ нислэгтэй холбоотой зөвхөн Улаанбаатараар дамжиж аялал жуулчлал хийхээр хязгаарлагдахгүйгээр шууд орон нутаг руу олон улсаас нисэх ийм нислэгүүдийг бид нар дэмжиж байгаа. Жишээлэх юм бол өнгөрсөн энэ жил БНСУ-аас шууд Хөвсгөл рүү 2 удаа нислэг хийсэн байгаа. Тэгэхээр ирэх жил 20 орчим нислэгийг шууд Хөвсгөл рүү хийхээр төлөвлөсөн байна лээ. Мөн хувийн хэвшлийн нисэх компани Ховдоос Шинжаан руу нислэг удахгүй эхэлж байгаа. Тэгэхээр баруун, зүүн, хойд, өмнөд бүс рүү шууд олон улсын нислэг хийх ийм байдлаар аялал жуулчлал .../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тодруулах юм байна шүү дээ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Энхнасан гишүүн тодруулъя.

Л.Энхнасан: Би яг тэр орон нутгийн нисэх буудлуудын шинэчлэлийг асуух гэж байсан. Ер нь өөр ямар аймгуудаар нисэх буудлыг шинэчлэх гэж байгаа вэ? Ялангуяа Дорнод зүүн бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэе гэж байгаа. Дорнодын нисэх буудлыг олон жил олон улсын ийм жишиг нисэх буудал болъё гэж ярьж байсан. Энэ ажил юу болсон бэ? Мөн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ гээд маш олон жил ярьж байгаа гэхэд хилээс орж ирж байгаа жуулчдын энэ гааль, процесс нь маш удаан байдаг. Энэ дээр бас ямар ажил төлөвлөж байна?

Ж.Бат-Эрдэнэ: Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Энэ орон нутгийн нисэх онгоцны буудалтай холбогдуулаад бид бас энэ таван жилийн төлөвлөгөөндөө 4 орон нутгийн онгоцны буудлыг 4 Си ангиллын нислэгийн буудал болгох гэж байгаа. Энд жишээлбэл Өмнөговийн Гурвансайхан мөн Ховд, Баян-Өлгий, Хөвсгөлийн онгоцны буудлыг 4 Си ангиллын буудал болгоно. Эхнийхийг нь бид бас Өмнөговь аймгийн удирдлагуудтай яриад бас энийг аймаг орон нутагтай хамтарч хийхээр ярьж байгаа. Жишээлбэл, олон компаниудтай, ялангуяа гаднын олон компаниудтай бид нар ярилцаж судалгаа хийж байна. Чехийн нисэх буудал барьдаг орон нутгийн нисэх буудал барьдаг компани мөн Франц, Итали гээд олон компаниудтай манай иргэний.../минут дуусав.

Ж.Бат-Эрдэнэ: Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Шинээр сонгогдсон Бат-Эрдэнэ гишүүнд, даргад амжилт хүсье. Тэгээд Улсын Их Хурлын дэд дарга болонгуутаа та худлаа ярьж эхэлж болохгүй. Та ажлын хэсгийн гишүүн гээд энд 78 хүн дуудсан. Засгийн газрын байгаа сайд нар нь 6, 7 сайд байна. Эрүүл мэндийн сайд нь ч байхгүй, Төрийн нарийн бичгийн дарга нь ч байхгүй энд 20 гаруй хүн сууж байна. Улсын Их Хуралдаа бас тодорхой хэмжээнд хүндэтгэлтэй хандуулах ёс ажлыг та наанаасаа хийж хэрэгжүүлэх ёстой байх. Тэгээд энэ Засгийн газар чинь үйл ажиллагааныхаа төлөвлөгөө, таван жилийн төлөвлөгөөгөө батлуулна гээд байдаг 6, 7-хон сайд нар сууж байгааг бас анхаараасай гэж бодож байгаа юм. Мөн өмнө нь бас хэлж байсан юм. Энэ Улсын Их Хурлаас томилогдоод явдаг МАН-ын томилгоонууд байдаг. Очоод ажлаа хийдэггүй. Би бодит жишээг нь хэлье. Баянхонгор аймаг, Өвөрхангай аймагт Засаг дарга нар нь Төрийн албаны зөвлөл шаардлага хангаагүй нөхдүүдийг томилдог. Томилгоонуудынх нь энэ хууль бус гэдэг шийдвэр нь гардаг. Энэнтэй холбоотой Төрийн албаны зөвлөлөөс мэдээлэл авмаар байна гээд Булгантуяа дэд даргыг наана чинь сууж байхад хэлсэн. Одоо болтол хариу байхгүй. Одоо болтол хариу байхгүй. Та дэд даргын ажил хийж байгаа дээр нь Улсын Их Хурлаас томилогдож байгаа албан тушаалтнуудтайгаа ажил хийлгэдэг талаас нь хариуцлагын тогтолцоо яримаар байна.

Тэгээд татвараар цуглуулсан хэдэн төгрөгөөрөө бид нар бөөн юм болж болж улсын төсвийг баталж өгдөг. Тэгтэл анхан шатан дээр хүүхдүүдийн хоолны махных нь мөнгөнөөс хүртэл хэдэн нөхдүүд тэнд хэдэн махны хүмүүстэй нийлж байгаад хулгай хийдэг, авлигажчихсан ийм тогтолцоо бүүр гарч ирээд тогтчихсон байгаа. Энийг Ерөнхий сайд маш сайн анхааралдаа авч ажиллаасай гэж бодож байгаа. АПУ-гийн эзэн гэх юм уу, Эм Си Эс-ийн эзэн гэх юм уу эдгээр төр, хувийн хэвшилд ажиллаад өдий болтол зүтгээд баялаг бүтээчихсэн хүмүүсээсээ баян тансаг амьдарч байгаа хүмүүс Монгол Ардын намын цагаан байраар дүүрэн байгаа. Тэгээд энэ хулгайч нартайгаа тэмцэхгүй болохоор чинь багш нар цалингаа нэмүүлье, эмч нар цалингаа нэмүүлье, ахмадууд тэтгэврээ нэмүүлье гэж талбай дээр гарч ирэх чинь зүй ёсны асуудал. Харин ч бусад иргэд гарч ирээгүйд нь Засгийн газарт баярлах ёстой болов уу. Тэгээд энэ Авлигатай тэмцэх газар бол захиалгаар улс төрийн зодооны хэрэгсэл болоод ажлаа хийхгүй байгаад байгаа учраас Монгол Улс авлигаараа энэ олон улсын индексээрээ улам хойшлоод байгаа энэ дээр Ерөнхий сайдыг бүүр онцгой анхаарч ажиллаасай гэж бодож байгаа. Энэ төлөвлөгөө дээр ч гэсэн бичигдчихсэн байна. Танилцуулга тараасан юман дээр ч гэсэн бичигдчихсэн байна. Одоо бид нарт үр дүн хэрэгтэй байна. Энэ тал дээр таны одоо байр суурийг бас тодруулмаар байна.

Тэгээд та 2 хоногийн өмнө намын даргад нэр дэвших дэвшилтээсээ татгалзаж байгаагаа илэрхийлсэн. Намынхаа хулгайчуудтай эвлэрчихсэн болоод нэрээ татчихсан уу гэж танаас асуух гэсэн юм? Ер нь хөгжилтэй холбоотой асуудал ярих юм бол бид нар төсвийг ярина. Төсөвтэй холбоотой асуудал ярих юм бол зарчмын 2, 3 асуудал байгаа юм.

Нэгдүгээрт, бид нар урсгал зардлаа ерөөсөө цаашдаа өсгөхгүйгээр үйл ажиллагаагаа явуулж сурах хэрэгтэй гэдэг энэ зарчмыг Засгийн газар тогтмол баримталж ажилламаар байна.

Хоёрдугаарт, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хариуцлагын асуудлыг бас сайжруулмаар байгаа юм. Жишээлэхэд энэ 10 аймгийн дулааны станцын асуудал дээр Солонгосын тал санхүүжүүлээд Солонгосын компани гүйцэтгээд явж байхад Солонгосын компани нь дампуурчихсан Монгол хүү төлөөд явж байгаа. Ядахдаа хүү нь зогсоно шүү гэдэг энэ зохицуулалт байхгүй. Энэ мэтчилнээр гадаадын зээл, тусламжтай холбоотой асуудлууд дээр бид нар бас зарчмын хатуу байр суурийг илэрхийлж явах ёстой болов уу гэж бодож байгаа.

Гуравдугаарт нь төр, хувийн энэ төр өмчүүдээсээ хувьчлах замаар салмаар байгаа юм. Хамгийн сонгодог жишээ энэ. Сумьяабазар гээд Монгол Ардын намын нэмэлт минутаа авчих уу даргаа, Монгол Ардын намын энэ сайд хүртэл хийж байсан хүнтэй холбоотой Үндэсний хөрөнгө оруулалтын банк.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Цогтбаатар гишүүнд 1 минут сунгая.

Да.Цогтбаатар: Сангийн сайдтай холбогдуулаад яригдаад байдаг Чингис, Хаан банктай энэ 2 банктай өрсөлдөхгүй л юм бол төр банкаар Төрийн банкаар юугаа хийх гэж байгаа юм. Яагаад хувьчлахгүй өнөөдрийг болтол дараад байгаа юм? Төрийн банкаар дүүрэн Монгол Ардын намын дарга нарын шахаас нар байгаа даргаасаа өгсүүлээд. Энийг хэзээ цэгцэлж эхлэх юм? Уг нь өнгөрсөн 2024 оны хаврын чуулган хаах гэж байхад Бямбацогт сайд хувьчлалынхаа асуудлыг оруулж ирнэ гэсэн. Нэг ч асуудал оруулж ирсэнгүй сая гэх мэтчилэнгээр энэ бид нар энэ асуудлуудаасаа салмаар байна.

Дараагийн асуудал энэ мал, малчин 2 бодлогогүй хаягдчихсан. 20, 30 жил Хөдөө аж ахуйн яаман дээр вакцины мафи нь бий болчихсон. Өнөөдрийг болтол мал эрүүлжиж чаддаггүй, мах экспортод гарч чаддаггүй хүссэн хэмжээгээрээ гэх мэтчилний эдгээр асуудлууд дээр таны зарчмын байр суурийг болон холбогдох сайд нараас нь тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Даваагийн Цогтбаатар гишүүн ээ би энэ 72 хүний нэрс уншсан юм байгаа шүү. 72 хүний нэрс надад өгсөн. Энийг Засгийн газар өөрсдөө өгч байгаа ийм хүмүүс оролцож байгаа гээд. Түүнээс биш 72-уулаа энд байна гэж би бас хэлээгүй байх нэгдүгээрт.

Хоёрдугаарт ер нь цаашдаа Ерөнхий сайдад би санал тавьсан шүү дээ. Орж ирэхдээ, тодорхой асуудлуудад орж ирэхдээ сайд нараа байлцуул нэг. Хоёрдугаарт, яг ажил хариуцсан хүмүүсээ байлцуул битгий энэ олон хүмүүс энэ 70, 80-аар нь битгий авчраад ингээд ажилгүй болгоод, ажил хийлгэхгүй суулгаад бай гэсэн шүү дээ. Тэгээд энэ дээр Ерөнхий сайд анхаарна биз. Ерөнхий сайд хариулах уу? Ерөнхий сайд Занданшатар.

Г.Занданшатар: Тэгээд жоохон дэг журамтай баймаар байна. Ам, ажил зөрүүгүй баймаар байна. Зарим гишүүд нь болохоор сайд нар хариулахгүй явж ажлаа хий 70 наядараа суух хэрэггүй явж ажлаа хийгээд, тэгээд эрүүл мэнд, олон асуудлууд байна сайд нарыг явж ажлаа хий гэхээр нөгөө хэсэг нь болохоор бас нэхээд. Тэгээд алийг нь дагах юм энэ чинь. Энэ сайд нар явж ажлаа хийлгэ гээд байх юм. Нөгөө хэсэг нь болохоор хаачив гээд байх юм. Энэ чинь төр засгийн ажил тасралтгүй явах ёстой шүү дээ. Тэгээд хэрэв би андуураагүй бол манай

Цогтбаатар гишүүн Хөгжлийн банканд ажиллаж байсан, банкны салбарт ажиллаж байсан тэгээд энэ ба банкны салбарын зовлон, жаргалыг сайн мэдэж байх ёстой. Тийм учраас Төрийн банкиг жишээлбэл бид энэ Үндсэн чиглэл баталсны дараа өргөн мэдүүлэх гээд энэ төрийн өмчийн компаниудын үр ашгийг сайжруулах хүрээнд IPO сая 5 хувь нь гарсан олон нийтийн олон нийтэд хувьцааг нь арилжаалах хувийг 34-60 хувь хүртэлх МИАТ-аас авхуулаад тодорхой жагсаалтууд орж ирнэ. Тэр хүрээнд үр ашгийг сайжруулна нэгд.

Хоёрт ер нь энэ хууль зөрчдөг, худлаа ярьдаг юмнуудаасаа салах хэрэгтэй ... цаанаа. Тийм учраас бид нар энэ авлигатай тэмцэхгүй болоод л улс орон сүйрэх гээд байна. Аль нам байх нь хамаа байхгүй. Одоо бүгдээрээ хаа хаанаа хариуцлагатай байя. Хуулиа дээдэлдэг байя, ёс журамтай байя. Тэгж байж энэ улс орон чинь хуультай, эзэнтэй, энэ геополитик гадаад, дотоод нөхцөл байдал хүнд үед тусгаар тогтнол, аюулгүй байдлаа хамгаалж оршин тогтнож чадна. Тийм учраас энэ зүгээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын 6 чиглэл болох оршин тогтнохуйн, эдийн засгийн, төр засгийн энэ аюулгүй байдал бүгд холбогдоно. Ийм учраас хөгшин, залуугүй гишүүд аль нам, хүйс, жендер үл хамааран ёс журамтай байж, энэ авлигал, албан тушаалын хэн томилгоо аливаа асуудлаас ангид байж байж энэ асуудлууд явна шүү.

Тийм учраас хэлсэн үгэндээ эзэн байж бид нар хариуцлагатай байх асуудал дээр хаана анхаарах ёстой. Тэгж байж энэ улс орон цэгцэрнэ. Цэгцрэх хөдөлгөөн явагдаж байж хуулиа дээдэлдэг төртэй, засагтай тэгээд тэр нь ард олныхоо орлогыг нэмэгдүүлэхийн төлөө эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулахын төлөө, энэ Монгол хүний мөрөөдөлтэй болохын төлөө, нэгдмэл үнэт зүйлтэй нэг улс байхын төлөө энэ хүчээ бид нэгтгэж ажиллах ёстой. Энэ тэмцэл бол энэ таван жилийн үндсэн чиглэлд бас тодорхой хэмжээгээр суусан. Одоо бид үг яриа, үйл хэрэг зөрдөггүй байх ёстой ийм зарчмыг хаа хаанаа баримталж ажиллая.

Ж.Бат-Эрдэнэ: 13 цагаас завсарлах ёстой. Цаашаа үргэлжлүүлээд явчих уу? Завсарлага авах уу, цаашаа үргэлжлүүлэх үү? Үргэлжлээд явъя.

Сархадын Зулпхар гишүүн. Хэн хариулах юм? Бямбацогт гишүүн хариулъя.

С.Бямбацогт: Өмч хувьчлалтай холбоотой 26-28 онд хувьчлах аж ахуйн нэгжийн жагсаалт төрийн бодлогыг энэ намрын чуулгандаа багтааж Улсын Их Хурал оруулж ирнэ ээ ойрын үед оруулж ирнэ. Өмч хувьчлал гэхээр хуучин ерөөсөө л хувьчлал нэрээр хулгай хийдэг гэсэн ард түмэнд бас тогтсон ойлголт байдаг. Энэ бас ойлголтыг бас засах ийм алдаа бас гаргахгүй байх талдаа илүү анхаарч байгаа. Үр ашиггүй хөрөнгө үр өгөөжөө өгдөг байх ёстой. Үр ашиггүй компаниудыг хувьчлах, дээрээс нь хувийн хэвшилтэй өрсөлддөг энэ компаниудыг бас хувьчлах иймэрхүү бас бодлого барина гэж байгаа. Энэ хүрээндээ Монголын цахилгаан холбоо, Хөдөө аж ахуйн бирж, Үндэсний давхар даатгал, Монголын хөрөнгийн бирж, “Эрдэнэс Тавантолгой”, Дулааны III дугаар цахилгаан станц, Эрдэнэтийн ДЦС, МИАТ төрийн өмчит, Төрийн банк зэрэг компаниудын асуудал эхний ээлжид орж ирнэ ээ гэдгийг танд хэлье. 34.../минут дуусав.

Ж.Бат-Эрдэнэ: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууна.

С.Зулпхар: Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын эрхэм гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Их тодорхой асуултууд асууя. Таван жилийн чиглэл гарах гэж байгаатай холбоотой бас хүний хөгжлийг бид тэргүүлэх чиглэлээ болгоно гээд хэлж байна. Угаасаа бид хэлсээр ирсэн. Өнөөдөр ч хэлнэ. Цаашдаа ч гэсэн энийгээ зорилго болгоно гэдэгт эргэлзэхгүй байна. Наранбаяр сайдаас энэ Инчоны тунхаглалыг түрүүн Мөнхтуяа гишүүн ч гэсэн асууж байна лээ манай боловсролын салбарын зардлыг төсвийн 20 хувь, 6 хувь руу бид хүргэе гэдэг ийм чиглэл барих ёстой гэж байгаа юм. Тэгэхлээр энэ зүгээр бид энэ рүү тэмүүлэх нь тодорхой байх. Энэ 5 жил дотор энэнтэй холбоотой ямар тооцоолол байгаа вэ хэдэн хувьд нь хүргэх вэ гэдэг ийм тодорхой асуулт байна.

Хоёр дахь зүйл бас боловсролтой холбоотой. Бид энэ гадаад хэлгүй бол гадагшаа гарч чадахгүй гэдгийг сайн мэдэж байгаа. Гэхдээ манайхны гадаад хэлний боловсрол их тааруухан шүү дээ. Тэгээд Англи хэлийг чинь бид шинэ хөтөлбөрт оруулсан. Тэгэхлээр энэ Англи хэлний түвшнийг хэр түвшинд хүрэх юм, ямар үр дүн гарах юм гэдэг ийм зорилтыг 5 жил дээр яаж та бүхэнд тусгасан бэ? Тодорхой шалгуурууд нь тодорхой байгаа учраас. Нөгөөтээгүүр бид хүссэн, хүсээгүй хиймэл оюун ухааныг их өгөгдлийг ашигладаг ийм цаг үе рүү шилжиж байна. ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт хиймэл оюун ухааны хичээлийг оруулах уу, хөтөлбөрт нь оруулах уу? Хятад аль хэдийн оруулчихсан. Эхнээс нь энийг хэрэглээд явж байна.

Дөрөв дэх асуудал Наранбаяр сайд их, дээд сургууль суралцагчдын жишээ нь хувийг харьцангуй бид бууруулах зорилт тавьж байсан. Мэргэжлийн болон техникийн боловсролын хувийг нэмэгдүүлэх ийм зорилт тавьж байгаа энэ дээр ямар жишээ нь тооцоолол байна вэ? 5 жилийн дараа манай нийт суралцагчдын ЕБС-ийн дараах сургалтын гэсэн үг шүү дээ сурагчдын хэдэн хувь нь мэргэжлийн боловсролын сургалт дээр суралцах юм бэ гэдэг ийм асуулт байна. Боловсролтой холбоотой. Энэ Ерөнхий сайд л хариулах байх шинжлэх ухаантай холбоотой асуудлыг бас их чухалчилж байна гэж хэлж байна. Тэгэхлээр шинжлэх ухаантай холбоотой өнөөдрийн зардал Занданшатар Ерөнхий сайд аа манай нийт ДНБ-ий 0.07 хувь байгаа юм. Бид ингэж тооцсон.

Гэтэл зүгээр бидний мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт 0.5 хувь байхгүй юу. Тэгэхээр яах вэ энэ удаа бид төсөв дээрээ цалингуудыг нь нэмлээ, ШУА-ийн тодорхой лабораториудын тоног төхөөрөмжийг орууллаа. Барилгыг нь жишээ нь барих юм байна. Ер нь цаашдаа бид энэнтэй холбоотой шинжлэх ухаан, технологи, инновацын зардлыг ДНБ-ий хэдэн хувьд хүргэх ийм зорилт барих вэ энэ дээр бас та бүхэн ямар тооцоо хийж байна гэсэн ийм асуулт байна.

Үүний дараагийн асуулт бол ахиад Ерөнхий сайдаас асууя. Уг нь цалин хөлс хариуцсан салбарын сайд байх ёстой юм байгаа юм. Бид энэ цалин хөлсний бодлого дээр нэгдмэл байх ёстой. Тэрнээс гадна цалин хөлсний энэ бодлого дээр ДНБ-ий тодорхой хувьтай ер нь ойртуулах ёстой юм байгаа юм. Бид ижил жишгийн улсуудаас 8.7-гоос 13.3 функтээр доогуур байдаг юм. Манай ДНБ дэх цалингийн жишээ нь эзлэх хувь шүү дээ. Тэгэхээр энийг бид уг нь ДНБ-ий 45-50 хувь руу ойртуулчих юм бол энэ үндсэндээ саяын хэлээд байгаа ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллыг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээний боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах энэ зорилт угаасаа биелэх юм. Энэ чинь

харилцан хамааралтай учраас. Тэгэхлээр энэ дээр ажлын хэсэг ямар тооцоолол хийж байна аа? Бид ингээд яг тодорхой жишээ нь шалгууруудыг тодорхой үндсэн параметртэйгээ харьцуулж энэ тооцооллуудыг дараа нь хэмжээд явахгүй бол хоосон зорилт байх юм бол тэгээд л дараа нь ахиад л таван жилийн дараа яриад сууж байх ийм нөхцөл байдал үүсэх байх гэж бодож байна. Тэгээд энэ дээр хариулт авчихвал би дараа нь бас саналаа хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Танхимд 6 сайд, 1 пиджак байна шүү Сайд нараа дуудаарай. Цагаа дараа нь өгчихье. Энэний хариултыг нь дараа өгчихье. Занданшатар сайд хариулах уу.

Г.Занданшатар: Монгол Улсын ДНБ-д цалин хөлсний эзлэх хувь, хэмжээ аль төстэй улсуудаас 8.3-аас 13.3 хувиар доогуур байна. Үүнийг нэмэгдүүлж 45.9-өөс 50.5 хувьд хүрэх зорилтыг үндсэн чиглэлд тусгасан. Ингэхдээ технологийн шинэчлэл, инновац, хөрөнгө оруулалтыг дэмжиж болон ажлын ажилтны үр чадварыг сургаж, дахин дадлагажуулах, үндэсний бүтээмжийг нэмэгдүүлэх замаар бодит цалинг өсгөхөөр төлөвлөж байна. Төрийн албан хаагчдын цалин хөлсний реформыг хийж, цалин хөлсний бүтцийг оновчтой болгож, бүтээмж, гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоог бий болгохоор төлөвлөсөн. Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөөг Засгийн газраас хэрэгжүүлнэ. Судалгаа хийгдсэн. Ерөөсөө бүтээмж, цалин 2 уялдах ёстой. Зөвхөн цалинг биш.

Жишээлбэл, бусад тодорхой салбаруудад ажилтныг нь тоо хэт өндөр тэгсэн мөртөө бүтээмж багатай, цалин хөлс багатай байгаа энэ харилцаа бүтээмжийн алдагдлыг зөв оновчтой болгох асуудал цалин хөлсийг нэмэгдүүлэх суурь хүчин зүйл болох ёстой юм байна лээ. Боловсролын салбарт ч гэсэн тэр. Одоо энэ технологи, инновацыг ашиглах замаар суралцахуйн хувьсгал хийнэ гээд байна шүү дээ. Тийм ээ шинжлэх ухаанаа мэдлэгийн эдийн засаг руу шилжүүлж тэгэхэд суралцахуйн хувьсгал хийхэд бас бид нар цаг, үдийн хоол маш олон зардлыг хэмнэх, үр ашигтай болох боломжуудыг нээнэ. Одоо бие даан суралцах боломжийг олгосноороо жишээлбэл, medlee.mn байдаг юм уу цахим платформыг ашигласнаараа хүүхдүүдийн сурлагын чанар эрс сайжирсныг судалгаагаар тогтоосон. Энэ олимпиадад ЭЕШ-д өндөр оноо авч байгаа хүүхдүүд голцуу цахим платформ өөрөө суралцахуйг илүү дэмжсэн сурагчид илүү үр дүнтэй суралцаж байгаа нь батлагдсан.

Тийм учраас энэ технологийн дэвшлийг ашиглаж суралцахуйн реформ хийнэ гэдэг бол бүтээмжийг сайжруулах, гүйцэтгэл үр дүнд чиглэсэн сургалтыг системд шилжих тэр хэмжээгээр үр ашгийг нэмэгдүүлэх, оновчтой болгох бусад салбар руу ажлын байруудыг шилжүүлэх оновчтой болгох ийм цахим цогц өөрчлөлтүүдийг хийсэн. Төрийн албаны реформ, гүйцэтгэл, бүтээмжийн суурилсан цалин хөлсний тогтолцооны реформыг хийхээр төлөвлөж байна. Энэ дотроо мэдээж шинжлэх ухаанд шинжлэх ухааныг дэмжсэн инновацыг дэмжсэн ажлыг бодит жишиг болгох шаардлагатай юм байна лээ. Тийм учраас ШУА-ийн хуулиас авхуулаад хууль, эрх зүйн тодорхой өөрчлөлтүүд шаардлагатай. Энэ чиглэлээр бас манай Рэгдэл гишүүн, манай Зулпхар гишүүн нар бас санаачилж саяын төсөвт бас тодорхой асуудлуудыг шийдсэн. Энэ чиглэл өргөжөөд явах ёстой. Тэгэхдээ 1 зүйлийг онцолж хэлэхэд манай бүтэц алдагдсан учраас ДНБ-д тооцох нь бас алдаатай болчихсон байгаа шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Доржзовдын Энхтуяа. Уучлаарай Цогтбаатар гишүүн түрүүн асуулт асуусан. Хэн хариулах билээ? Хөдөө аж ахуйн сайд. Чи тодруулчихсан уучлаарай. Хариултыг чинь авчихъя.

Ж.Энхбаяр: Вакцины асуудал шахаа гээд энэ асуудал яаман дээр бүрэн цэгцэрсэн. Та бүхэн санаж байгаа бол энэ вакцин тойрсон хэрүүл болдог, янз янзын өвчин дэгддэг, зохиомлоор үүсгэдэг гээд нэлээн асуудал сүүлийн 3 жил сонсогдохгүй байгаа биз. Энийг цэгцэлчихсэн. Шууд үйлдвэрээс нийлүүлэлтийг хийдэг болсон. Гэхдээ шинжлэх ухаан, нотолгоо, үр дүнд суурилсан энэ сонгон шалгаруулалт хийгдээд. Нөгөө талаас Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага өөрөө энэ бүсийн энэ зонхилон гардаг энэ вирустэй холбоотой ингээд зөвлөгөө нь омгуудын зөвлөгөөг гаргаад ингээд шинжлэх ухаанаар нь залаад явчихдаг. Тэгэхээр тэр олон шалгуураа дагаад ингээд хийгээд, хийдэг болсонтой холбоотой. Тэр мал, амьтны тэр шахаа гэдэг зүйл дууссан. Энэтэй холбоотойгоор үйлчлэлүүд сайн байгаагийн илрэл, экспорт эрс нэмэгдэж байгаатай л уяж харагдах, бодох ёстой юм.

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээе Хөдөө аж ахуйн сайд.

Ж.Энхбаяр: Мал эмнэлгийн чанар, үйлчилгээ дээр ахиц дэвшил гарсантай холбоотойгоор мал, махны экспорт, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт эрс нэмэгдээд байгаа. Өнөөдөр гэхэд бид нар 230 гаруй сая долларын 60 орчим мянган тонн мах экспортолчихсон байна. 24, 23-нд бид нар 300 сая доллар жил тус бүр хүргэж экспортолсон. Энэний цаана чинь нөгөө мал эмнэлгийн чанар, аюулгүй байдлын үйлчилгээний үр дүн харагдаад байгаа юм. Нөгөө вакцины чинь асуудал шийдэгдсэн үр дүн. Тэрнээс өмнө чаддаггүй байсан байхгүй юу их багаар. 10, 20 мянган тонн хүрээд л 10, 20 сая долларын мах экспортлоод л хэл ам гаргаад л хаачихдаг, өвчин нь дэгдээд л хаачихдаг байсан. Тэгээд ийм асуудлууд тогтвортой яваад байна. Зөвхөн бас хөдөө аж ахуйн түүхий эд ноолуур гэхэд л ноднингийн мөн үеэс самнасан ноолуурын экспорт үндсэндээ 5 дахин нэмэгдчихлээ шүү дээ 5 дахин. Энэ болгоны цаана чинь л мал эмнэлгийн чанар, үйлчилгээ, мал эмнэлгийн бодлого яваад байгаа. Мэдээж дутуу зүйл их.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Доржзовдын Энхтуяа гишүүн асуулт асууя. Айн Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Инчоны тунхаглалыг бид бас биелүүлэх ёстой. Энэ рүү зорьж явах ёстой. Энэ жил гэхэд бас энэ дотоодын нийт техникүүд эзлэх боловсролын салбарт зориулж байгаа санхүүжилт 5.2 хувьд тэгээд төсвийнхөө 16.4 хувьд хүрсэн байгаа юм. Энийг төсвийн хувьд 20 хувь руу хүргэх энэ үед боловсролын салбарт хуримтлагдсан олон асуудлуудыг шийдэх боломжоор шууд хангагдах ийм юм байна лээ санхүүгийн хувьд.

Хоёрдугаарт нь Англи хэлний сургалтыг бид нэмэлт хөтөлбөр 3 дугаар ангиас зааж эхэлсэн. Person хөтөлбөрөөр 12 дугаар анги төгсөх үедээ хүүхдүүд дунджаас дээш түвшний ийм Англи хэлтэй болох ийм боломжтой гэж харж байгаа. Энэ хөтөлбөрийг бас үндэсний хөтөлбөр болгож бид нар бас хөгжүүлэлтийг хийж байгаа гэдгийг хэлье.

Мэргэжлийн боловсролын тухайд өнөөдөр их, дээд сургуульд шууд хүүхдийг авах гэхээсээ илүүтэйгээр төгсөөд мэргэжлийн боловсролоор дамжиж өөрөө шууд хөтөлбөрийн зах зээл дээр гардаг байх нь маш.../минут дуусав.

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэлт 1 минут өгье.

П.Наранбаяр: Мэргэжлийн боловсрол дээр ингээд суралцах нь өөрөө бас хөдөлмөрийн зах зээлийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах туйлын чухал ийм арга хэмжээ гэж харж байгаа. Тэгэхээр бид бас энэ дээр элсэлтийг нэмэгдүүлэх бодлогыг тууштай барьж бид энэ жил 26 онд 26673 хүүхдээр нэмэхээр, урьд нь элсэлт 40 мянгатай байсан ингэж нэмэхээр ийм бодлого бариад явж байгаа.

Тэгээд хиймэл оюун ухааны тухайд бид өнөөдөр бага сургуулийн хөтөлбөрийг шинэчилж байна. Энэ дээрээ компьютерын ухаан гэж орж ирж байгаа. Үүний салшгүй нэг хэсэг нь хиймэл оюун ухаантай ажиллах, хиймэл оюун ухааныг зөв ашиглах, хиймэл оюун ухааныг ойлгох ийм хөтөлбөрүүд орж ирж байгаа ийм байдлаар хэрэгжүүлж байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Баярлалаа. Их тодорхой хариултууд өгч байна бас их тийм эерэг бас хариултууд ч гэсэн өгч байна. Би сая мэргэжлийн боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролтой холбогдуулаад бас нэг зүйлийг тодруулъя. Энэ нөгөө төр, хувийн хэвшлийн түншлэл чинь хөтөлбөрийн агуулгыг жишээ нь ажил олгогч нь өөрөө тодорхойлоход оролцдог. Тэрнээс гадна шаардлагатай үед ажил олгогч өөрөө тэтгэлэг өгөөд ажиллах хүчнээ бэлддэг ийм зүйлийг нээсэн шүү дээ хуулиараа бид нар. Үүний үр дүнгүүд зарим газар гарч байгаа юм шиг байгаа юм. Тэр энэний сайн туршлагыг улсын мэргэжлийн боловсролын байгууллагууд техникийн боловсролын сургуулиудад нэвтрүүлэх чиглэлээр та бүхэнд бас болж байгаа юм байна уу? Их сайн туршлагууд яваад байгаа юм байна лээ шүү дээ. Бид сая бас очиж ажилласан. 10 дугаар хороолол дахь Политехникийн коллеж дээр очсон чинь суралцагчдын 30 хувийн тэтгэлгийг нь ажил олгогч нар өгч байгаа байхгүй юу. Ажил олгогч өөрсдөө хэрэгтэй хүнээ тэгээд бэлдээд авч байгаа юм. Тэгэхээр энэ зүйлийг та бүхэн бас яаж хийх чиглэл барьж байна? Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Энэ чухал асуудлыг, маш чухал асуудлыг хөндөж байна. Энэ хосмог сургалтын тогтолцоо. Энэ бол бид бас Германы Жи Ай Зэт-тэй хамтраад ноднин жилээс нэвтрүүлж эхэлсэн. Ойролцоогоор бас энэ бид цөөхөн эхэлсэн 400 гаруй хүүхэд л байсан. Энэ жилд 1600 болгож нэмэгдүүлж байгаа. Ингэснээр ихэвчлэн цахилгааны инженер мэргэжлээр ч юм уу бэлтгэгдчихье 3 жилийн хугацаанд бэлтгэгдэж байхад эхний жилдээ 30 хувь нь компани дээр ажиллаад 70 хувь нь яг танхимаар хичээллэж байгаа. Тэгээд энэ харьцаа 3 жилийн дараа 30:70 болж эсрэг болно. Өөрөөр хэлбэл, 70 хувь тэр компани дээр ажиллана. Компанийн хувьд шууд хүнээ бэлтгээд авчаж байгаа ийм сайн талтай.

Тийм учраас өнөөдөр 60 гаруй аж ахуйн нэгжүүдтэй хамтраад 21 политехникийн коллеж мэргэжлийн боловсролын сургуульд 1601 суралцагчийг ингээд хамрагдаж эхэлж байна. Энэ аж ахуйн нэгжийн хувьд маш их таатай ийм боломжийг бий болгож байгаа. Хөтөлбөрийг тодруулахад хүртэл тэд оролцоод ингээд хамтраад явж байгаа их сайн жишээ гэж харж байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтбаатар гишүүн нэмэлт авах юм уу? Нэмэлт 1 минут.

Да.Цогтбаатар: Пүрэвдорж дарга хурал удирдаж байхдаа бүгдээс нь тодруулах уу? Асуулт байна уу гэж байгаад микрофоныг нь хаадаг юм. Та болохоор туршлагагүй байгаа юм уу, эсвэл ийм коммунист юм уу, ийм бүдүүлэг юм уу? Дахиж битгий ийм алдаа гаргаарай. Би асуултынхаа тодруулга хэсгийг ч аваагүй, хариултыг нь ч гүйцээгээгүй байхад та шууд дараагийнх нь гишүүн рүү явуулаад битгий ингэж бүдүүлэг загнаад бай л даа та. Та Улсын Их Хурлын дэд дарга болохоос биш коммунист намын дэд дарга биш шүү дээ.

Ерөнхий сайдаа Төрийн банкиг би бас өмнө нь Хөгжлийн банканд ажиллаж байхаасаа өмнө 2 ч том арилжааны банканд ажиллаж байсан нэр төртэйгөөр. Яг тэнд байдаг засаглал Төрийн банканд байхгүй, хамаг юм нь нууцлагдмал, хаалттай байгаа учраас энийг нээгээд Төрийн банк яг юу нуух гээд тэнд суугаад байгаа юм. Би гайхаад байгаа юм. Харилцагчийн мэдээлэл нууц, бусад нь нууц биш тэгээд эдгээрийг яагаад шууд 100 хувь хувьчилж болохгүйгээр заавал шахаа томилгоо хийх гээд 20, 30 хувь нэр төдий байлгаад байдаг юм уу л гэдгийг тодруулах гээд. Тийм учраас энэ ба.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах юм та хэнээр хариулуулах гэж байна Ерөнхий сайдаас уу? Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Төрийн банк бас хөдөө орон нутагт салбартай, төрийн байгууллагуудын хадгаламж, данс хадгалдаг бас нэлээн тийм стратегийн банк. Мэдээж хувьчлал хамгийн сайн шийдэл. Тэгэхдээ өнгөрсөн гашуун туршлагаудаас харахад банк хувьчлаад банк идчихлээ л гэдэг нэр Ардын банкнаас авхуулаад л ард түмний сэтгэлд хар толбо үлдээчихсэн. Тийм учраас бидний барьж байгаа чиглэл бол Банкны тухай хуульд нийцүүлж аль болохоор IPO гаргаж, олон нийтийн хяналтын банк болохоор ийм зарчим баримталж байна. Тийм учраас Банкны тухай хуульд бид өөрчлөлт оруулж банкнуудыг public буюу олон нийтийн банк байх тийм зарчим руу нь нийцүүлсэн. Тэгэхгүй бол банкнууд бүх бизнес рүү орж байна, зээл хуу санхүүгийн давуу байдлаа ашиглаж энэ нөгөө бизнесийн давуу бай.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар гишүүнд нэмэлт 1 минут.

Г.Занданшатар: Тийм учраас банк санхүүгийн салбар өөрөө их эмзэг салбар л даа. Энэ бие организмтай зүйрлэвэл хүний биеийн цусан хангамжтай адилтгадаг мөнгөний зах зээл, мөнгөний эдийн засгийн асуудал. Тийм учраас хамгийн гол нь энэ дээр олон нийтийн хяналттай үр ашигтай болгох нь л хамгийн гол зорилго нь ... буюу банкны засаглалыг сайжруулах ёстой. Үүний тулд бид нар олон нийтийн байлгах ийм хуулийг Их Хурлаас баталчихсан. Одоо банкнууд бас IPO гаргаад эхэлчихсэн. Нийт банкнууд дээр бас тодорхой хэмжээний олон нийтийн хяналт тогтож эхэлж байгаа. Цаашдаа тэр хэмжээгээрээ өргөжих ёстой.

Тэгэхээр энэ банк тойрсон дуулианыг олон нийтийн санал сэтгэл, онол, практик туршлага дээр үндэслэж оновчтой шийдвэрлэх ёстой. Тэгэхдээ ямар ч байсан бид нар олон нийтийн болгох ийм чиглэл баримталж байгаа. Ер нь гишүүд санаачлаад хувьчлаад стратегийн хөрөнгө оруулагч оруулж ирээд гадаадын банк оруу хөрөнгө оруулагч орж ирээд ийм сайн хувилбар байхыг бас үгүйсгэхгүй.

Б.Пүрэвдорж: Доржзовдын Энхтуяа гишүүн асуулт асууя.

Д.Энхтуяа: Үндсэн чиглэл. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг кнопдоо хүрэхгүйгээр дэмжээд явуулах юм шиг байна. Тэгээд мэдээжийн хэрэг дэмжигдэнэ. Ер нь миний бодлоор ер нь энэ төрийн бодлогын залгамж халаа гэж ер нь байхгүй болчихсон юм шиг санагддаг л даа. Тэгэхээр урьд нь байсан энэ Засгийн газрууд маш гоё гоё нэртэй, уриатай гарч ирдэг. Иргэн бүрд хөгжлийг шинэчлэлийн Засгийн газар, итгэлцэл, хамтын ажиллагааны өсөлт, хариуцлагын дээд ёс зүйтэй засаглал, төвлөрсөн хүчээр бүтээн байгуулъя, хүн төвтэй хөгжил гээд дөнгөж жил гаруйхны өмнө бид нар “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гээд энэ Засгийн газрын бодлого чиглэлийг дэмжээд ингээд явсан. Тэгэхээр энэ өнгөрсөн Засгийн газар 14 мега төслийг хэрэгжүүлнэ ээ гээд. Энэ бас Монгол Ардын намын сонгуульд ялалт байгуулсан гол хөтөлбөрүүд орсон гэж ойлгосон. Тэгээд энэ 14 мега төслийг маш их дэмжиж байсан. Энэ хурдтай хөгжилд мэдээж хувь нэмрээ оруулна гээд. Тэгэхээр одоо та итгэл, одоогийн итгэл, эрс шинэчлэл гэсэн ийм уриатай орж ирж байгаа юм байна.

Тэгэхээр зүгээр хувь хүн миний хувьд жишээлбэл 14 мега төсөлд итгэж байсан. Тэгэхээр энэ шинэ итгэлийг бий болгохын тулд яаж шинэ итгэлтэй болох юм бэ? Танай Засгийн газар хүн бол манай Засгийн газрын мега төсөл юм гэж та бас хэлж байсан. Өнөөдөр нөгөө дундаж давхаргыг ядуурлыг бууруулъя, дундаж давхаргыг бас нэмэгдүүлье гээд ингээд ярьж байгаа боловч өнөөдөр дундаж давхаргыг бүрдүүлж байгаа 50 хувь чинь гадаа жагсаж байна шүү дээ. Эмч, багш, ахмад гээд. Энэ 14 мега төслийн оронд миний ойлгож байгаагаар түрүүний хэлсэн энэ төрийн залгамж халаа юм шиг байгаа юм таны энэ засаглалын. Тэгэхээр энэ хүн төвтэй Засгийн газар гэдгээ та яаж, ямар зүйлээр хэрэгжүүлэх юм бэ? Зүгээр ганцхан жишээ хэлье л дээ. Алтанхуяг Ерөнхий сайдын Засгийн газрын үед маш тодорхой зүйлүүдийг хийж чадсан байдаг юм. E-Mongolia-г анх бий болгосон, дэд бүтцийн 80 төсөл хэрэгжүүлж, 3000 км зам харгуй барьж байсан, ипотекийн зээлийг 8 хувь болгож байсан. Ил тод байдлын тухай хуулийг баталснаараа энэ төрийн худалдан авалтыг цахимжуулсан гэх мэт өөрийн нэрээр нэрлэгдэх ийм ажлыг хийсэн байдаг юм.

Тэгэхээр таны хувьд дэмжлэг бас байна. Энэ хүн төвтэй мега төслийгөө хүн төвтэй болгож байгаагаа яаж хэрэгжүүлэх юм бэ? Өнөөдөр энэ ахмадуудын асуудал дээр энэ аргачлал гээд түрүүн Ариунзаяа гишүүн хөндөж байна лээ. Тэтгэврийн хуулийн 27.1.2-т зааснаар аргачлал дээрээ жоохон танай Засгийн газар ажиллаад өгөөч ээ. Өнөөдөр энэ тэтгэвэр авч байгаа ахмадуудын 50 хувь нь 689 мянган төгрөгийн тэтгэвэртэй. 93 хувь нь 1.5-аас доош тэтгэвэртэй байгаа байхгүй юу. Тэгэхээр ингээд өндөр тэтгэвэртэй ахмадуудын тэтгэвэр нь маш өндрөөр нэмэгдэх гээд байна. Эд нарыг бас буруутгаж байгаа юм алга байна.

Гэхдээ 50 хувь бас ядуурлын шугамаас доогуур амьдраад байна шүү дээ энэ ахмадууд чинь. Тэгэхээр энэ дээр энэ аргачлал дээрээ танай Засгийн газар

бодитойгоор бас аргачлал дээр хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна. Та энэ дээр бас бас дахиад амлалтаа өгчихгүй юу. Тэгээд тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар Ерөнхий сайдад хариулъя.

Г.Занданшатар: Нэгдүгээрт, тэтгэврийн хувьд түрүүн бас би тодорхой хэлсэн дахин хэлье. Ер нь 689 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа 50 хувь, 1.5 сая төгрөг авч хүртэл авч байгаа тэтгэвэр авагчдын цалин 10-аас дээш хувиар нэмэгдэнэ. Тэгж байж бид суурь тэтгэврийнхээ дийлэнх олонхынхоо тэтгэврийг 10-аас дээш хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Өөрөөр хэлбэл, мөнгөн дүнгээр нэмэгдүүлье ээ гээд би түрүүн хэлчихсэн. Тэгэхгүй хувьчилж нэмэгдэхээр их тэтгэвэр авч байгаа нь 4.5 сая төгрөгийн тэтгэвэр авдаг хүн байна жишээлбэл. Тэр хүн 8.6 хувиар нэмлээ гэж бодоход бараг. 400-гаад мянган төгрөгөөр нэмэгдэнэ. 689 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа хүн 8.6 хувиар нэмэгдэхээр 50, 60-аад мянган төгрөг ч юм уу ингээд бага нэмэгдэнэ. Тийм учраас энийг бид нар бага тэтгэвэр авч байгаа иргэдийнхээ тэтгэврийг илүү нэмэгдүүлэх тийм чиглэл баримталж байгаа. Тийм аргачлал ашиглана гэж сайдтай бид нар ярилцаж тохирсон.

Багш нарын цалинг бид 26 оны эхнээс эхлээд 742 мянган төгрөгөөр суурь цалинг нэмэгдүүлж бас яг энэнтэй адилхан зарчмаар хувьчилж биш бас өндөр цалин авдаг багш нартайгаа хааж, хувь, хэмжээг орхигдуулахгүйгээр нийтэд нь 11 сараас 2.8 сая төгрөг нэмэгдүүлж байгаа юм. Ингээд нийт мөнгөний хэмжээ энийгээ дагаад цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнтэй шалтгаалаад инфляц өсөөд талхны үнэ чинь double-даж өсөөд байх юм бол энэ цалин нэмсний хэрэггүй болно оо. Тийм учраас эдийн засгийнхаа энэ рам төсвийнхөө рамд байх ёстой. Бидний бодит ажил бол иргэдийнхээ дундаж давхарга эмч, багш нарынхаа нийт орлогыг тэлэхэд оршиж байгаа юм. Энийг өгөөжтэй эдийн засгийн өөрчлөлт гэж байгаа юм.

Тэгээд 4 жил яриагүй мөртөө 5 жил ерөөсөө тэнцээгүй мөртөө нэг улс төрийн шалтгаантай юм шиг нэгэн зэрэг дарамт шахалт үзүүлээд байж болохгүй. Харилцан учраа ойлголцоод төсөв доторх шинэчлэлээ хийгээд, цалин хөлсөө нэмэгдүүлээд явах ийм шинэчлэлийг ойлголцоод явж байгаа юм. Энийг манай багш, эмч нарын төлөөлөл бас хүндэтгэлтэй хандаж ойлголцоод явж байгаа. Зарим ганц хүмүүс бидний шалгаж тогтоосноор улс төрийн шалтгаанаар өдөөн турхирч байгаа асуудлууд бий. Харин тийм үзэгдэлтэй бид хатуу тэмцэх ёстой. Тэрийг ч гэсэн тогтоох ёстой төр гэж байгаа бол. Тэгэхгүй үүний чинь үр дүнд нь юмны үнэ тэнгэрт хадвал нийт иргэдийн эрх ашиг хохирно шүү дээ. Энэ 50 хувь жагсаж байгаа гэхээсээ илүү жинхэнэ 50 хувь, 100 хувь байгаа ард иргэдийн чинь энэ юмны үнэ талхны үнэ, мах, гурилын үнэ дагаад тэнгэрт тулчих юм бол энэнээс хэн хожих юм. Ийм учраас энэ эдийн засгийн бодлого мөнгөний бодлоготойгоо уялдаж төсвийн бодлого чинь явах ёстой. Түүнээс .../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Түүнээс биш байгаа мөнгийг Занданшатар харамлаад л дараад байгаа юм байхгүй шүү дээ. Харин ч энэ дэлхийн эдийн засаг нүүрсний үнийн уналтаас шалтгаалаад төсөв чинь 2.2 их наядоор тодотгол хийж таналаа. Үргүй зардлыг хэмнэлээ, ахиад 1.1 их наядоор танаж байна. Маш хүнд үед бид энэ зорилтыг хэрэгжүүлж байна. Тэгтэл нүүрсний үнэ одоогоос 3 дахин үнэтэй байх

үед, 2 дахин үнэтэй байх үед энэ шаардлага тавьж жагсаж байхгүй, ажил хаяж байхгүй яасан юм гэдэг асуудлыг зүй ёсоор бас иргэд тавьж байна. Өмнө нь энэ зорилтуудаа хэрэгжүүлж байхгүй яасан юм? Яагаад яг ийм улс төрийн эгзэгтэй үед энэ зэрэг зэрэг дарамт шахалт үзүүлж байгаа юм шиг ийм тал талаас нь бензин шатахууны асуудал дээр ч гэсэн тэр зориуд хөөргөдөөд паник үүсгээд саяын өнгөрсөн сар өдөр болгон биднийг ийм сорилт шантаажаар шахаж байгаа юм шиг жилүүд болж бид дор бүрд нь асуудлаа харин шийдэж.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Энхтуяа гишүүн тодруулъя.

Д.Энхтуяа: Та хэллээ та нар улс төрийн турхиралт хийгээд ингээд энэ манай намын хэлээд байгаа юм уу, эс үгүй бол намайг хэлээд байгаа юм уу? Би ахмадын асуудлаар бас дуу хоолойгоо илэрхийлдэг. Тэгээд ахмадын тэтгэвэр, тэтгэмжийн энэ аргачлалыг яаж бодох юм бэ гэдэг асуулт асуусан байгаа. Та тэр төрийн бодлогын залгамж халаа гэдэг дээр бас хариулт өгөөч ээ. Тэр 14 мега төсөл Монгол Улсад хэрэгтэй байсан юм уу хэрэггүй байсан юм уу? Танай Засгийн газрын энэ 14 мега төслөөс хэдийг нь авч хэрэгжүүлэх гэж байгаа юм, хүн бол мега төсөл юм гээд ингээд энэ үгээрээ цааш нь залгамж халаагаа хийж явах гэж байгаа юм уу?

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар сайд хариулъя.

Г.Занданшатар: Би үнэнийг хэлнэ гэсэн учраас бодит байдлыг хэлж байна. Энэ дотор ер нь энэ залгамж чанар алдагдсан учраас Дэлхийн банкны засаглалын индексээр Монгол Улсын улс төрийн тогтворгүй байдал, бодлогын тогтворгүй байдал эдийн засагт нөлөөлдөг учраас 2019 онд би энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг санаачилж хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх зарчмыг суулгасан юм. Тийм учраас энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулж энэ тогтвортой байх, засаглал тогтвортой байхын тулд парламентыг өргөтгөх энэ санаачилгууд гарч хэрэгжсэн юм. Энэ цогц өөрчлөлтүүд болж хэрэгжсэн юм. Харамсалтай нь хууль батлаад гүйцэтгэх шатандаа хэрэгжүүлэхгүй буруу ойлгоод яваад байсныг өнөөдөр засаж залруулж байгаа юм.

Тухайлах юм бол энэ 14 мега төсөл дотроос бид нар ТЭЗҮ-тэй, санхүүгийн эх үүсвэртэй асуудлуудыг бодитой шийдвэрлэнэ. Эхний ээлжид эрчим хүчний асуудлууд Тавантолгойн 445мвт-ын цахилгаан станцын асуудал. Эгийн голын.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулах уу?

Г.Занданшатар: Тэгье. 14 мега төслүүдээс техник, эдийн засгийн эрсдэлтэй бодитой төслүүд хэрэгжүүлж байна. Улс орны хөгжлийн хувьд нэгдүгээрт, эрэмбэлэгдэх зүйл гангийн үйлдвэр, зэсийн үйлдвэр байдаг. Ингэж байж Япон, Солонгос ч байдаг юм уу Азийн бүх улсууд босож байдаг. Ингэж байж барилга, үйлдвэрлэл, техник тоног төхөөрөмж өсөж байдаг. Ийм учраас ингэж эрэмбэ дэс дараатайгаар, өгөөжтэй bankable төслүүдээ эхэлж хэрэгжүүлэх чиглэлийг барьж, зэс хайлуулах үйлдвэрийг бид эхний ээлжид тавьсан. Зэсийн үнэ өнөөдөр 11 мянган доллар хүрч байж байна. Зэсийн үнэ өнөөдөр 11 мянган доллар хүрч байна.

Ийм учраас зэсийн үйлдвэрийг бид шахаж байгаад ТЭЗҮ-ийг нь сая батлаад, техникийн даалгаврыг нь гаргаад тендерийг нь зарлаж байна. Ингэж бодитой ажлууд хийж болохоос биш бид 14 байна уу, 10 байна уу тоо зарлахдаа гол биш бодитой ажил хэргийг хэрэгжүүлэхийг зорьж байгаа юм. Энэ дээр яах вэ таныг хэлж байгаа юм биш шүү бодит байдлыг бид хэлж байгаа юм. Эдийн засагт тулгарч байгаа сорилт, бэрхшээлүүдээ ярьж байгаа юм. Төслүүд ингээд тууштай хэрэгжинэ. Орон сууцжуулалтын банк байгуулах ажил.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ганбатын Очирбат гишүүн.

Г.Очирбат: Өдрийн мэнд хүргэе. Таван жилийн үндсэн чиглэл Эдийн засгийн байнгын хороон дээр дэмжигдээгүй. Дэмжигдээгүй үндсэн 4 шалтгаан байгаа. Хамгийн 1 дүгээр шалтгаан бол хууль зөрчиж байгаа. Монгол Улс бол урт хугацааны бодлоготой “Алсын хараа 2050”-ийг баталсан байгаа 30 жилийн хугацаатай. Үүнтэй уялдуулаад Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6.5 дээр байгаа үндсэн 8 зорилт хөтөлбөрийг батлах ёстой байсан. Одоо хүртэл батлаагүй. Энэ батлагдаагүй байхад таван жилийн хөтөлбөрүүд орж ирж байгаа. Тэгээд хуулиа зөрчөөд яваад байдаг. Энэ хэзээ батлагдах вэ нэгдүгээрт Ерөнхий сайд байгаа болохоор.

Хоёрдугаарт, өнгөрсөн таван жилийн тайлан хангалтгүй. Нийт 95 үзүүлэлтээр үнэлээд бүх төсөл, хөтөлбөр арга хэмжээнүүд нь 50 хувь. 50 хувь ажлаа хийсэн байна. Сүүлийн 10 жилд засаг бариад 50 хувь ажлаа хийх юм бол цаашаа яах юм бэ Ерөнхий сайд аа? Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах юм уу Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах юм уу? Ажлаа хийж чадахгүй байгаа эрх баригч ялсан нам ер нь цаашдаа сонгуульд орох шаардлага байгаа юм уу. Энэ дээр та юу гэж бодож байгаа юм ийм.

Гурав дахь шалтгаан Монгол Улс Улсын Их Хурлын тогтоол шийдвэр, Байнгын хорооны ажлын хэсгүүд гараад тогтоол, шийдвэрүүд гардаг аа, 2020 оны 5 сарын 13-ны өдөр “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг ингээд тогтоол хэлбэрээр баталсан. Занданшатар Ерөнхий сайд өөрөө Их Хурлын дарга байхдаа баталсан. Энэний хавсралт 3 гэж байгаа. Хавсралт 3 дээр Монгол Улсын хүний хөгжил гэж байгаа. Өнөөдөр 21-ээс, 26-аас 30 оны үндсэн чиглэл ярьж байгаа. Хүний хөгжлийг энэ дээр юу гэж тавьсан бэ гэхээр үндсэн энэ 10 ажлынхаа 1 болгоод хүний хөгжлийн индексийг 0.81-ээс дээш түвшинд хүргэнэ ээ гэж тавьсан байгаа. 2020 онд энэ хавсралтыг батлахдаа яг шалгуур үзүүлэлттэй нь тавиад хүний хөгжлийн үзүүлэлт индекс гээд 2025 онд 0.77, 2030 онд 0.85-д хүргэнэ ээ гээд ингээд бүүр ингээд тоотой нь, шалгуур үзүүлэлттэй нь тавьчихсан байгаа хувьтай нь. Тэгэхэд энийгээ 0.81 болгоно оо гээд бууруулаад ороод ирсэн энэ шалтгаан.

Хоёрдугаарт нь дундаж давхаргын эзлэх хувийг 40 орчим хувь байгаагаас 60 хувь болгож, 20 хувиар нэмэгдүүлнэ ээ гэж байгаа юм. Энэ хавсралтын бас шалгуур үзүүлэлт яг ингээд тоотойгоо байгаа шүү. Дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувийг 2025 онд 80 хувьтай болгоно гэж, 2030 онд 85 болгоно оо гэж байгаа юм. Тэр юу гэсэн үг вэ гэхээр дундаж давхарга 85 хувь руу очно оо гэж байна. Тэгэхэд та өнөөдөр 20 хувь гээд оруулаад ирчихсэн байдаг. Тэгээд ийм ийм шалтгаанууд байна.

Хамгийн сүүлийн том шалтгаан бол энэ Засгийн газрын дэвшүүлж байгаа энэ мөрийн хөтөлбөрүүд нь хоорондоо зөрдөг, будилдаг. Ялангуяа энэ 2024-28 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр үндсэн ийм 3 том ажил орж ирсэн. 26-30 оных дээр орж ирээгүй. Нэгдүгээрт Оюу толгойтой дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ ээ гэсэн. Энэ орж ирээгүй. Энэ таван жилийн төлөвлөгөө дээр. Эгийн голын УЦС-ыг барих гэсэн энэ орж ирээгүй байна. Энэ ямар учиртай юм? Дараа нь алт цэвэршүүлэх үйлдвэрийг барих ажлыг эхлүүлнэ ээ гэсэн. Орж ирээгүй байна. Түрүүн Занданшатар Ерөнхий сайд өөрөө энэ аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх ёстой, гангийн үйлдвэр, зэсийн үйлдвэр гээд энэ аж үйлдвэрийн салбар руу нэлээн анхаарч яриад байгаа юм. Орж ирээгүй байна. Үндэсний хиймэл дагуулын хөрөнгө оруулалт хөөргөнө өө гэсэн энэ бас орж ирээгүй. Тэгэхээр одоо ер нь цаашдаа яах ёстой юм бэ? Мэдээж Монгол Улс хөгжлийн хөтөлбөртэй байх ёстой. Стратеги төлөвлөгөө, дунд хугацааны төлөвлөгөө, богино хугацааны төлөвлөгөө байх ёстой. Байлаа гээд энийгээ хийж хэрэгжүүлэхгүй, хийж байгаа ажил нь 50 хувьтай байгаад байвал хойшдоо бид яах ёстой юм Ерөнхий сайд энэ асуултад хариулт аваад тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя. Занданшатар сайд.

Г.Занданшатар: Очирбат гишүүн сайн байна. Тэгэхдээ энэ асуултыг өөрсдөдөө бас тавих хэрэгтэй. Өнгөрсөн жил яагаад та нар энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн та 6.5-ыг ярьж байна. Тэгвэл өнгөрсөн жил жил болгон таван жилийн төлөвлөгөөг үнэлж төлөвлөгөөг нь хэлэлцэх ёстой. Тэр үед ярьж байхгүй яасан юм. Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий тоон болон тооны чанар, шалгуур үзүүлэлттэй хэмжигдэх хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд байна гээд тэр 8 хөтөлбөр байгаа. Энэ 8 хөтөлбөрийг чинь бид нар энэ саяын энэ үндсэн чиглэлд оруулаад хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр байна. Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр байна. Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр байна. Яг энэ байгаль орчны засаглалын зорилт, хөтөлбөр гээд энэ 8 чиглэлээр чинь бид энэ 5 үндсэн чиглэлд агуулгыг нь боловсруулаад ороод ирчихсэн байгаа биз дээ?

Тийм учраас ерөөсөө бид бас ардчилал зах зээлд шилжихдээ хий хоосон хөөрөлд автаж яг энэ бодлогын баримт бичиггүй явж 174 баримт бичиг аль аль засаглалын үед батлаад хоорондоо уялдаа холбоогүй байсныг эмхэтгэх гэж энэ асуудлыг оруулсан юм. Үндэсний хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Эгийн голын УЦС-ын ТЭЗҮ-г тодотгож, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх төсөл гэдгээр оруулчихсан байгаа. Энийг бид хэрэгжүүлнэ гэж бодож байгаа. Бид энэ хоосон амлалт өгөхгүйн тулд дандаа ТЭЗҮ-тэй эцэслэн батлагдсан санхүүжилтийн эх үүсвэртэй төслүүдийг хөтөлбөрт оруулсан. Алт цэвэршүүлэх үйлдвэрийн ТЗҮГ-г боловсруулна гээд заачихсан байгаа юм. ТЭЗҮ нь байхгүй ахиж шинэчлэх шаардлагатай юм байна лээ.

Тийм учраас бид хоосон амлалт биш бодитой ажлын чиглэлүүдийг оруулах гэж энэ хөтөлбөрт тусгасан. Тийм учраас хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэсэн энэ Үндсэн хуулийн зарчимд нийцүүлж “Алсын хараа-2050”-ийг тухайн үеийн манай эрдэмтэн судлаач, Засгийн газар маань оруулж ирээд батлагдсан. КОВИД, дайн байлдаан, олон улсын нөхцөл байдлаас шалтгаалаад төлөвлөгөөнд

өөрчлөлт орж саатал учирсан асуудлууд олон бий. Дахин шинэчлээд энэ явж байна. Ийм учраас энийгээ бид үнэлдэг, шалгадаг байх ёстой. Би дахин хэлье 9 дүгээр сарын 11-нд өмнөх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ, тайланг Улсын Их Хуралд ирүүлсэн. Тэрэнтэй та бүхэн уншиж танилцаад яг наад заалтууд чинь орсон байгаа гэдгийг тодруулж хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Очирбат гишүүн 1 минут сунгая.

Г.Очирбат: Хуулиар 10 жилээр батална гээд заачихсан байгаа, нэг. Хоёрт гэх юм бол энэ би түрүүн танд хэлсэн 2024-28 он энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр дандаа Оюу толгойн дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ ээ гэж оруулж ирсэн. ТЭЗҮ боловсруулна гэж байхгүй. Эгийн голын УЦС-ыг барина гэж оруулж ирсэн, алт цэвэршүүлэх үйлдвэрийг барих ажлыг эхлүүлнэ ээ гэж байсан дандаа. Тэгэхээр бид нар энэ таван жилийн хугацаанд ТЭЗҮ боловсруулсаар байгаад дуусах юм байна л даа. Үгүй ээ ажил хиймээр байна шүү дээ. Харин бодитой үр дүн гаргамаар байна нэгд.

Хоёрт гэх юм бол хуулиа сахъя л гэж байгаа юм. Бид нар төлөвлөгөөтэй байх ёстой. Тэрнийхээ дагуу тоотой цаг хугацаатай ажлаа төлөвлөсөн юм бол төлөвлөсөн шиг гүйцэтгэе, гүйцдэг юм. Гүйцэтгэсэн юм бол үр дүнгээ улс эх орноороо хөгжиж, хөгжүүлж харуулъя л даа. Тэгээд та энэ төрийн бодлогод 20 хэдэн жил тасралтгүй ажиллаж байгаа хуулиа сайн мөрдөөд явуулчхаарай.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Сүхбаатарын айн. Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Энэ 2005-ийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 10 жилийн үндсэн чиглэл бол энэ 21-25 онтойгоо уялдаж орж ирэх ёстой байсан. Энийг жилийн төлөвлөгөөг оруулж ирэх хугацааг нь, энэ үндсэн чиглэлийг оруулж ирэх хугацааг нь хуульчилж заасан боловч 10 жилийн төлөвлөгөөг оруулж ирж заагаагүй юм байна лээ. Тэгэхдээ энэ бол зүйтэй. Таны саналыг дэмжиж байна. 10 жилийн хөтөлбөрөө боловсруулах ёстой. Харин нэг зүйлийг онцолж хэлэхэд энэ их бодитой хэмжиж болохуйц тодорхой зүйлүүд заахгүй бол дандаа эхлүүлнэ гээд заачихдаг юмнууд бол олон учир, шалтгааны урдаас ТЭЗҮ өсөж байгаа, төсөвт өртөг өсөж байгаа бас олон улсын нөхцөл байдлаас шалтгаалаад гацаж байгаа яриа хэлэлцээр шаардлагатай тийм төсөл, хөтөлбөрүүд бас бий. Ийм учраас бүс нутгийн интегралчлалд бас бусад улсын бодлоготой бас уялдуулах шаардлага гарна. Энийг ингээд төлөвлөгөөнд үндсэн чиглэлд бид бас.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Очирбат гишүүн.

Г.Очирбат: Хариултаа бас бүтэн авчихмаар байгаа юм. Салбарынх нь яамнууд бас байгаад байгаа дээр, сайд нар байгаад байгаа дээр. Тэгээд түрүүн би танд хэлсэн шүү дээ хүний хөгжлийн индексийг 0.81-ээс дээш болгоно оо гэсэн. Та Их Хурлын дарга байхдаа Их Хурлын тогтоол гаргаад тогтоолын хавсралт 3 дээр 85 болгоно гэсэн байсан. Энийг яагаад тоог нь багасгасан юм?

Хоёрдугаарт, дундаж давхаргыг та 20 хувиар нэмэгдүүлнэ гэсэн 30 он гэхэд 85 хувь Монгол Улсын нийт иргэдийн 85 хувь нь дундаж давхаргатай байна гээд тогтоолын төсөл бас ингээд батлагдчихсан. Тэгээд энийгээ хийж хэрэгжүүлэхгүй яагаад энэ 2 тоо зөрчхөв өө? Мэдээж ажил хийх хэцүү. Таныг ойлгож байгаа. Улс

төрийн нөхцөл байдал үнэхээр хүнд юман дундуур явсныг ойлгож байгаа. Тэгэхдээ та бол Монголын төрд 20 хэдэн жил тасралтгүй энэ төрийн бодлогыг боловсруулж байсан хүн. Загасны ой санамжтай байж байж болохгүй шүү дээ. Өөрийнхөө Их Хурлын удирдаж байхдаа гаргасан тогтоолоо одоо Ерөнхий сайд болчхоод оруулж ирж байгаа Үндсэн чиглэлтэйгээ зөрчилдүүлж оруулж ирж байгаа нь ямар учир шалтгаантай юм бэ?

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд Занданшатар сайд хариульъя.

Г.Занданшатар: Дахин давтан хэлээд байгаа учраас би тодорхой хэлье. Би 20 жил тасралтгүй ажиллаагүй ээ. Би Улсын Их Хурлын даргаар ажиллаж байхдаа энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж, энэ улс орон Үндсэн хууль, засаглалын хуваарилалт бас асуудалтай байна гэж үзэж энэ ардчилсан шилжилт, 30 жилийн алдаа, оноог засах гэж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг манлайлж ажилласан. Харамсалтай нь энэ хэрэгжилт дээрээ ийм алдаатай байдаг юм байна. Энийг гүйцэтгэх засаглалд ажиллаад үзэж байна. Би 12-16 онд энэ талаар судалгаа хийж, төрд ажиллаагүй би судалгаа хийж байж энэ бүх бүтцийг боловсруулж ажилласны хувьд энэ сүүлийн 8 жилд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийх ажлаа хийсэн. Одоо гүйцэтгэх засаглалын төсөвт энийгээ амьдруулах гэж ажил хэрэг болгох гэж ажиллаж байна. Улсын Их Хурлын баталсан баримт бичгийг 1 хүн баталдаггүй, нийт гишүүдийн олонхоор баталдаг Засгийн газраас өргөн мэдүүлснээр хэлэлцдэг журамтай. Энийг 1 хүнээс 5 сар ажиллаж байгаа биднээс таван жилийн ажил.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Таван жилийн ажлын Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл дээр тогтвортой хөгжил, хүртээмжтэй өсөлт, зохистой хөдөлмөр эрхлэлт гээд олон улсын бас хэрэглэгддэг нэр томъёо бидэнд бас НҮБ-ын бүрэн эрхт гишүүний хувьд хүлээсэн үүргийн дагуу бас нэлээн хэдэн үг, үсэг, санал, хэмжих нэгжүүдийг оруулж ирсэн нь сайшаалтай байна. Нэлээн олон хэмжих нэгжүүдийг харж үзсэн бас тодруулах ийм зүйлүүд байна.

Цаашдаа ер нь тийм зарчмын санал гаргахад Их Хурлын гишүүд маань ингээд энэ том хэмжээний бичиг баримтуудыг заавал чуулганыхаа танхимд сууж байгаад л бүгдээрээ асуугаад л ингээд л цаг яахаас илүү тухайн тухайн үед нь холбогдох яам, мэргэжилтнүүдээс нь тэр цахимаар байдаг юм уу, юугаар асуугаад, энд харин тэр хэмжих нэгжүүдийнх нь хувьд гэдэг юм уу бодлогын тодорхой асуудал дээр нь мэтгэлцэж байвал бас илүү зүгээр юм болов уу гэж бас бодогдож байна. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор бас цаашид бид нар анхаарах хэрэгтэй байна гэж хэлмээр байна.

Ирэх таван жил хүнд ноогдох ДНБ 10 мянган доллар гээд бид нар энэ хэмжиж байгаа үзүүлэлтээ ч гэсэн бас бодож үзмээр байгаа юм байгаа юм. Нийт эдийн засгийн хувьтай холбоотойгоор л өсдөг. 1 иргэн дунджаар нийгмийн бүлгүүдэд хуваарилагдаж байгаа орлогууд нь яаж өсөх вэ гэдэг жин индекс гэдэг юм уу тийм үзүүлэлтүүдийг нь авч үзвэл илүү оновчтой байдаг. Тэгэхээр энэ дээр дахиж нарийвчилсан үзүүлэлтүүд буюу хүртээмжтэй эдийн засгийн өсөлт гэдэг дээр ямар үзүүлэлтүүдийг авч үзэхээр байгаа вэ гэдгийг хэлмээр байна. Орон

сууцын асуудал дээр бас орж орлогод нийцсэн орон сууцыг 68 мянгад хүргэнэ ээ гэж байна. Жилд 12 орчим мянга орон сууцад орох юм байна.

Тэгэхээр энэ тал дээр түлхүү ямар бүлгүүдийг авч үзэх вэ гэдэг дээр асуумаар байна. Орон сууцын корпорац банк байгуулна гэдэг, гэдгийг бас дэмжиж байна. Бид нар ингэж явахгүй бол зүгээр зах зээл дээрээс жирийн иргэд, орлого багатай багш, эмч нар гэдэг юм уу жирийн ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс зах зээлийн үнээр орон сууц худалдаж авна гэхээр үндсэндээ болохгүй байгаад байгаа юм. Саяхан 1 залуу надад хэлж байна лээ багш би 10 жил орон сууцад орох гээд мөнгө цуглуулаад 20 гаруй сая төгрөг болсон чинь энэ хугацаанд дахиад байр авах гэсэн чинь нөгөө байрны маань үнэ бас ингээд өсчихлөө гээд. Тийм учраас яах аргагүй энэ орлогод нийцсэн орон сууцын бодлогыг бид нар давхар авч явж тусгайлан авч үзэхгүй бас болохгүй ээ гэдгийг бас төрөлжүүлж хэлмээр байна.

1 ажлын байрыг бий болгоход ойролцоогоор 10 мянга орчим доллар гэдэг ийм судалгаа байгаа тогтвортой ажлын байр. Тэгэхээр бид нар яг яг ийм ажлын байруудыг бид нар бий болгох хэрэгтэй. Ингэхийн тулд зүгээр нэмэлт саналууд байгаа. Сум болгонд бид нар үйлдвэр барьж чадахгүй. Ядаж төрөлжүүлээд 3 сумын дунд төрөлжүүлсэн жижиг үйлдвэрүүдийг бий болгоод мөн 3 сумын дунд хийж байгаа бүтээн байгуулалтууд гэдэг юм уу ядаж барилгын бригадыг бий болгоод тэнд нь тогтвортой ажлын байруудыг бий болгодог мэргэшсэн ийм зүйлүүдийг бий болгох гэдэг юм уу ийм детальчилсан төлөвлөгөөнүүд бас бид нарт их чухал байгаа юм гэдгийг бас хэлмээр байна. Тэгэхээр энэ тал дээр манай саяхан төсөв батлагдсан олон гишүүд маань тойрогтоо бас янз бүрийн төслүүд тавигддаг. Энийг тухайн нутгийн орон нутгийн иргэд нь хэчнээн ажлын байр бий болгож оролцох вэ гэдэг ийм зүйлүүдийг энэ төлөвлөгөө дээрээ бас нарийн оруулж өгүүлбэл их сайн болно оо гэдгийг хэлмээр байна.

Дотоодын аялал жуулчлалтай холбоотой хэлэхэд бид нар ингээд өвөл болонгуут хүүхдүүдээ аваад бид нар чинь маш их гадагшаа явдаг болсон байна лээ. Маш их хэмжээний валют гадагшил. Тэгэхээр энэ өвлийн аялал жуулчлалыг бий болгож энэ хүүхдийн амралтуудтай зэрэгцүүлээд дотоодынхоо аялал жуулчлалыг нэмээд, доллар валютаа авч үлдээд, дээрээс нь аялал жуулчлалынхаа салбаруудыг дэмжээд ингээд ингээд явах бодлогыг авах бодлогыг бид нар хийх ийм чухал. Энэ дээр яг ямар төлөвлөгөө байна вэ гэдэг зүйлийг асуумаар байна. Тэгээд тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд Занданшатар.

Г.Занданшатар: Ер нь дэлхий даяар НҮБ-ын гишүүн улсууд бараг бүгдээрээ нэгдсэн Тогтвортой хөгжлийн зорилт хөтөлбөрийг 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр баталсан. Энэ бас дэлхий нийт НҮБ-ын өмнө хүлээсэн Монгол Улсын үүрэг учраас энэ 17 зорилтын хүрээнд түүний шалгуур үзүүлэлт хүрэх үр дүн, түвшинтэй уялдуулж энэ хөтөлбөрийг боловсруулсан. Тийм учраас Тогтвортой хөгжлийн зорилтууд тогтвортой ажлын байр, тогтвортой хөгжлийн үндсэн үзэл санаанууд энд дэлхий нийтийн чиг хандлагатай уялдаж суусан. Магадгүй 2030 оноос үнэлээд сая бас Очирбат гишүүн ч асууж байна дэлхий нийтээрээ 2030 онд хүрэх зорилтдоо хүрэхгүй болсон. Тэр 17 зорилт биелэгдэхгүй байна гэдэг нь тодорхой болж, НҮБ сая Ерөнхий чуулган дээрээ ч гэсэн эрчимжүүлэхгүй бол 2030 онд хүрэхгүй нь. Энэ дайн байлдаан, КОВИД, олон улсын нөхцөл байдал, үнэ ханш,

энэ бүх нөхцөл байдлаас шалтгаалаад дэлхий нийтээрээ энэ 2030 он хүртэл Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх нийтлэг зорилтдоо хүрч чадахгүй болж байна. Нэн ялангуяа хүний хөгжлийн түвшин, ядуурлын түвшин гэх мэтчилэн үзүүлэлтүүдээр дэлхий нийт том сорилт, бэрхшээлтэй тулгарч байгаа.

Монгол Улсын хувьд бас энэ байгалийн баялгаас хэт хараат байдалтай болсон эдийн засгаа төрөлжүүлж байж томоохон реформ урт хугацааны бодлого хэрэгжүүлж байж бид энэ байдлаасаа гарч ажлын байр бий болгодог, ажлын байрыг дэмжсэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох шаардлагатай. Энэ inclusive economy гэдэг юм. Тэгэхээр уул уурхай илүү хүртээмжтэй эдийн засгийн салбар биш. Яагаад гэвэл тэрний үр өгөөжийг төр татвараар уул уурхайн бизнес илүү төвлөрч байдаг. Тэгээд энийг төр дахин хуваарилах болохоороо энэ авлигал, хээл хахууль олон асуудалтай тулгараад байдаг.

Харин хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбар ажлын байр бий болгодог илүү inclusive буюу тэр хүртээмжтэй эдийн засгийн салбар байх. Ийм учраас энэ таван жилийн үндсэн чиглэлийн гол зорилт бол тогтвортой ажлын байрыг бий болгодог, тэр салбаруудаа дэмжсэн, ажлын байр бий болгосон, түр биш тогтвортой ажлын байрыг бий болгосон энэ салбараа дэмжихэд чиглэгдэж байгаа юм. Энэ 1 өдөр хийчих асуудал биш. Татварын, эдийн засгийн, өрсөлдөх чадварын олон өөрчлөлтийг хийж байж бид бид энд хүрнэ. Ингэж байж үйлдвэрчний эвлэл жинхэнэ утгаараа хөгжинө. Одоо манай үйлдвэрчний эвлэл ч гэсэн шинэчлэгдэх ёстой юм байна лээ. Аль 1994 оны хуулиар яваад байдаг ажилчин анги байхгүй үйлдвэрчний эвлэл болчихоод байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ бодлого ч гэсэн үйлдвэрчний эвлэл дэмжиж, бид хөдөлмөрийг дэмжсэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн ёстой дундаж давхарга бий болсон ажиллах хүчин, ажилчдаа дэмждэг ийм өөрчлөлт хийх явдал бол энэ таван жилийн үндсэн чиглэлийн гол зорилт байх ёстой. Ингэж байж бид нөгөө халамжаас хөдөлмөрт гэдэг уриаг.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбат гишүүн 1 минут сунгая тодруулъя.

С.Эрдэнэбат: Тэр ажилчин ангийн хувьд хэлэхэд би одоо бас санал хэлэх гээд байгаа юм Ерөнхий сайдаа энэ манай ажилчдын тогтвор суурьшлын асуудал их чухал байгаа юм. Бид нар маш олон хүнийг бэлдэж байгаад гадагшаа алдаж байна. Өөр салбар хооронд алдаж байна. Банк санхүү, уул уурхайн сороод аваад явчхаж байна. Тэгэхээр тэрийг дагаад өөр салбарууд нь чадавхгүй унаад байдаг. Тийм учраас энэ хувь, төр гэлгүй ялангуяа энэ төрийн өмчийн компаниудыг хувьчлах дээр гадаадын зарим улс орнууд ажилчдаа болон энэ баялгийг шударга хуваарилах, ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг дэмжихэд тодорхой хэмжээний давуу хувьцаануудыг ажилчдад нь өгдөг. Үйлдвэрээсээ гараад явах юм бол тэрийг нь буцаагаад авчихдаг ийм бодлогуудыг бас бид нар ингэж хийж нөгөө баялгийг шударга хүртээхэд бас ийм аргуудыг хэрэглэх тал дээр бас хэрэглэвэл тун зүгээр байгаа юм.

Тэр ахмадын тэтгэврийн хувь дээр хэлэхэд тэр тэнцвэржүүлж нэмэх гэдэг нь би таны саналтай бас санал хүргүүлсэн. Эдийн засаг, Өргөдлийн байнгын хороон дээр бас тийм санал гаргасан. Тэрийг дэмжиж байгаа гэдгийг бас хэлмээр байна. Аялал жуулчлалтай холбоотой саналыг нэмж хариулбал бас сайн байна.

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Гүйцээж хариулъя түрүүн цаг амжаагүй учраас. Дундаж давхаргыг 20 хувиар нэмэгдүүлнэ гэж хөтөлбөрт орсон. Энэ үндсэндээ үйлдвэрчнээ дэмжинэ гэсэн үг. Үйлдвэрчний эвлэл шүү дээ. G1 коэффициентийг 0.29 байгааг 0.25 болгож орсон байгаа. G1 коэффициент буюу орлогын ялгааны коэффициентийг. Үндсэн чиглэлийн хавсралтын 3.3 дугаар хавсралтын 4.4.13-д орон сууцжуулалтыг дэмжиж, бид орон сууцжуулалтын банк байгуулахаар төлөвлөж байна. Багш, эмч нарыг түлхүү хамааруулсан 2024 онд 12150 ажлын хөтөлбөрт хамрагдсан тоо орон сууцын хөтөлбөрт хамрагдсан, орлогод нийцсэн хөтөлбөрт хамрагдсан тоо 12150 байгааг 68650-д хүргэхэд хүрч орлогод нийцсэн орон сууц. Түүнээс нийт орон сууцын хэмжээ олон байна. Орлогод нийцсэн хямд өртөгтэй орон сууцжуулалтын бодлогыг хэрэгжүүлж багш ажилчдыг хамруулахаар төлөвлөж байгаа гэдгийг онцолъё. Мөн аялал жуулчлал болон аялал жуулчлалын салбар болон нийт үйлдвэрчний эвлэл маань шинэчлэгдэх ёстой гэдэг нь

Ж.Бат-Эрдэнэ: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Нэлээн олон ярианд төрийг цомхон болгоно эдийн засагт төрийн оролцоог багасгана гээд ярьж байгаа. Уул нь энэ асуудал дээр хэлэлцэж байгаа асуудал дээр би зарчмын хувьд эсрэг өөр бодолтой байгаа. Тэгээд яг энэ мэт хэрэггүй ажлуудаасаа бид нар хасаж байж төрийг цомхон болгоно. Яг энэ таван жилийн бид нар гүйцэтгэлээ ч ярихгүй, тэгээд 10 жилийн асуудлуудаа ч ярихгүй ийм асуудлуудыг ингэж энэ 70, 80 хүнийг цуглуулчхаад тэгээд хэрэгжүүлэхгүй, хэрэг болохгүй ийм ажлуудад ингэж цаг үрдэг. Эд нар өөр ажилд цаг зарвал бид нар илүү үр дүнтэй ажиллаж болохоор. Тэгэхээр энэ дээр би энэ дунд хугацааны хөтөлбөр дээр хөгжлийн бодлого төлөвлөлт дээр 10 жилийн, 5 жилийн, 4 жилийн ингээд 3 хөтөлбөр байгаа. Энэ 5 жилийнхийг би хэрэггүй энийг болих ёстой гэж бодож байна.

Тэгэхээр энийг эхлээд 1 дүгээр 5 жилийнхээ тэр асуудлаа ярьчихаад энэ асуудлуудыг яах вэ ийх вэ гэж ярих нь зөв болов уу гэсэн ийм бодолтой байгаа юм. Тэгэхээр энэ 5 жилийн төлөвлөгөө гэдгийг ер нь социалист голдуу орнууд 1 юутай 1 хүн юм уу, 1 гэр бүл илүү удаан хугацаанд оршин тогтнож засаглах бололцоотой улсуудад яг ийм төлөвлөгөөнүүд хэрэгжүүлдэг. Хэрэгжүүлээд таван жилийн төлөвлөгөөнүүдийг хараад үзвэл та нар анзаарвал Хятад, Орос, Казакстан, Узбекстан энэ тэр гэх мэтчилнээр хуучин социалист орнууд голдуу байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ улсууд төвлөрсөн төлөвлөгөөтэй зах зээлийн бус байдал давамгайлсан ийм газруудад яг энэ таван жилийн төлөвлөгөөнүүд байдаг. Тэгэхээр энэ төлөвлөгөөнөөс харахаар ихэнх нь бас яг энэ зүүн төвийн үзэл баримтлалтай 1 нам эрх барьж байгаа үед Засгийн газар жишээлбэл нийт таван жилийн асуудлыг ярих нь бас нийцэхгүй гэж бодож байна. Жишээлбэл, энэ дотор орсон хөтөлбөрүүдийн ихэнх нь буцаад л яг л хүний асуудлуудыг шийдэж өгнө, тэр яам ийм асуудлуудыг шийднэ гэдэг байдлаар хүний өмнүүр орж асуудал шийддэг иймэрхүү чиг баримжаатай байгаа.

Тэгэхээр өөр жишээлбэл улс төрийн чиг баримжаатай нам гараад ирвэл энэ чинь угаасаа ямар ч хэрэглэх боломжгүй. Өнгөрсөн 33 жилийн хугацаанд бид нар бас өөр чиглэл рүү явъя гээд зорьсон. Бид нар бас ингээд өнөөдрийн түвшнээс харахад хангалттай үр дүнд бид нар хүрээгүй байна. Улс төрийн хувьд жишээлбэл бид нар намыг, төрийн дээр нам байдаг гэдэг энийг өөрчилье гэсэн өнгөрсөн хугацаанд үйл явдал нам бол төрийн дээр байдаг юм гэдгийг бас маш тодоор харууллаа. Бид нар зах зээлийн эдийн засгийн хувийн хэвшлийг дэмжинэ гэсэн өнөөдөр Монгол Улсын хамгийн том компани ТӨК, топ 100 аж ахуйн нэгж гээд байгаа энэний ихэнх нь бараг 90 орчим нь төрөөс өгдөг зөвшөөрөл, лиценз дээр хамааралтай, улс төрөөс хамааралтай ийм бизнесүүд байгаа юм.

Бид нар яг энэ 5 жилийн үндсэн чиглэлийг харахаар бид нар буцаад л урагшаа явдаг биш буцаад ухардаг иймэрхүү байдалтай л байна. Тэгэхээр бид нар зогсож харахгүй бол өмнөх асуудлаа Улсын Их Хурал дээр ярилцахгүйгээр дахиад жишээлбэл энийг ингээд үргэлжлүүлээд ярина гэдэг бол зарчмын хувьд санал нийлэхгүй байгаа. Тэгээд Ерөнхий сайдаас энэ чиглэлээр ямаршуу бодолтой байгаа юм гэдгийг нь асуумаар байгаа. Түрүүчийн энэ төр давамгайлах хандлага жишээлбэл энд байгаад байхгүй. Төр өмнөөс нь шийддэг.

Тэгэхээр энэний хамгийн гол асуудал нь болохоор хэзээ ч буурахгүй байгаа шалтгаан тэр нь бид нар өнгөрсөн хугацаанд улс төрийг асар үнэтэй болгосон. Улсын Их Хурлын гишүүн болохын, тулд улс төрч болохын тулд асар өндөр үнэтэй болгосон. Энэ нь буцаад ТӨК-удыг бууруулахгүй байх хөшүүрэг байгаа. Тэгэхээр энэ улс төрд Улсын Их Хурлын гишүүн болоход энэ төрийн асуудлыг шийдэхэд ороход энэ зардлыг бууруулахгүй бол бид нар хэзээ ч энэ ТӨК-удаа буулгаж чадахгүй. Энэ авлигын асуудал дээр хэргүүдийн тоо нь л нэмэгдээд байдаг болохоос биш улам нэмэгдээд болсон асуудал ерөөсөө шийддэггүй. Тэгэхээр энэ үүр уурхайгаа цэгцлэхгүй бол бид нар ингээд гоё гоё юм яриад энэ бүтэхгүй харагдаад байгаа юм нэгдүгээрт. Хоёрдугаарт, Ерөнхий сайдад тэр тэр асуулт байна.

Хоёрдугаарт, энэ бусад улс төрийн намуудаас ялангуяа баруун төвийн ч юм уу үзэл баримтлалтай улс төрийн намуудаас энэ чиглэлээр ямаршуу санаа бодлууд ирсэн бэ гэдэг талаар бас асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Энэ асуудлаар 3 үндэслэлээр хариу өгье гэж бодож байна. Нэгдүгээрт, Засгийн газар хууль биелүүлэх үүрэгтэй. Энэ Улсын Их Хурлаас баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн дагуу 11 дүгээр сарын 1-ний дотор таван жилийн үндсэн чиглэлийг нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд 12 сарын 1-ний дотор батлах ёстой гэсэн ийм хуулийн хугацаатай. Энэ бол хууль, эрх зүйн орчин.

Хоёрдугаарт, яах вэ олон улсын түвшинд аль аль намуудаас ч энэ саналыг гаргаж байгаад ингээд орсон хуулийн төслийг 2015 онд Ардчилсан намын үед энэ хууль батлагдсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль энэ таван жилийн үндсэн чиглэл боловсруулах, жилийн төслөө боловсруулах энэ. Тийм учраас тэндээс та хууль дээрээс тодорхой уншиж болох байх гэж бодож байна.

Гуравдугаарт, олон улсын жишиг Азийн хөгжлийн загвар буюу энэ таван жилийн үндсэн чиглэл, төлөвлөгөө боловсруулж ирсэн жишиг Японы 62 оны үйлдвэр хөгжлийн таван жилийн төлөвлөгөө, Солонгосын, Сингапурын ийм жишээнүүд байгаа. Дээр нь яг ийм vision буюу улсынхаа хөгжлийн ерөнхий чиг хандлагыг үндсэн чиглэлийг тогтоосон Энэтхэгийн энэ азийн бараг бүх улсуудад энэ жишиг форматыг ашиглаж хөгжлийн бодлогоо төлөвлөж явж байгаа. Орчин үеийн эдийн засгийн хөгжлийн загвар бол бас цэвэр төгс өрсөлдөөнт зах зээлээс манайх төгс өрсөлдөөнтэй зах зээл биш учраас ийм бодлого төлөвлөлтийн арга механизмуудыг ашигладаг чиг хандлага дэлхий даяар давамгайлж байгаа. Энэ бол эдийн засгийн онолын болон хөгжлийн бодлогын тусдаа асуудал.

Харин энийг илүү үр дүнтэй, үр ашигтай болгож, улс орныхоо хөгжлийг зөв чиглэлд хандуулж ингэж явах нь чухал. Тийм учраас өмнөх таван жилийн үндсэн чиглэлээс сайжруулаад хэмжигдэхүйц тодорхой энэ зарчимд нийцүүлээд энэ хөгжлийн бодлого төлөвлөлтөө чиглэлээ гаргаж яваад ямар энэ 14 мега төслөө гэхэд стратеги гэдэг бол эрэмбэ дараа, 14 мега төсөл гэхэд бүгд туссан байгаа. Тэгэхдээ аль нь түрүүлж хэрэгжих юм, бүх зүйлийг нэгэн зэрэг хийх бололцоогүй. Тийм учраас улсын хөгжлийн бодлого чиглэл байх нь гарцаагүй. Монгол Улсын Үндсэн хуульд ч гэсэн тийм тодорхой заалт бий. Аж ахуй, эдийн засгийн үйл ажиллагааг өөрийн улс орны онцлогт нийцүүлэн төрөөс удирдан чигжүүл, чиглүүлнэ ээ гэсэн. Ингээд Кейнсийн ч байна уу Фрейдийн ч байна уу ингээд онолын маргаан эдийн засгийн онолын маргаан болоод явчихна. Төлөвлөх ёстой юу үгүй юу гэдэг өөр асуудал. Харин практик шаардлага байна сайжруулах.

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Ерөнхий сайдыг яг хууль биелүүлэх гэж байгаа учраас оруулж ирээд тэрийг ойлгож байна. Зүгээр би хувь улс төрчийнх нь хувьд саналыг нь сонссон юм. Ер нь дунд хугацааны төлөвлөлт 10 жил, 5 жил, 4 жил буюу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гэж ийм байгаа. Тэгэхээр 4 жилийн цикл чинь 5 жилтэйгээ сонгуулийн цикл чинь таван жилийн төлөвлөгөөтэй ойрхон байгаа учраас энэ бараг хэрэггүй шат яваад байгаа юм биш үү гэдгийг Улсын Их Хурал дээрээ энийг ярилцаад эхнийхээ 5 жилийнхээ тэр төлөвлөгөөг бид нарт үнэхээр хэрэгтэй байгаа юм уу, хэрэггүй байгаа юм уу, энэ олон хүмүүсийн цаг, хүчийг барах хэрэгтэй байгаа юм уу гэдгийгээ ярьчихаад тэгээд дараа нь хэлэлцэх ёстой юм уу гэж. Энэ Их Хурлын л асуудал байх л даа. Бат-Эрдэнэ даргад ийм саналтай байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд тодруулъя.

Г.Занданшатар: Тэгэхээр энэ бодлого, төлөвлөлтийн бас улс төрийн ач холбогдол нь Энхтүвшин гишүүнээ улс төрийн намууд сонгуульд оролцохдоо дааж давшгүй халамж, тэтгэмж амладаг. Жишээлбэл хүүхдийн мөнгөнөөс авхуулаад л эх орны хишиг гээд ингээд улс орныхоо эдийн засгийг даахгүй хэмжээнд оруулчихдаг учраас энэ таван жилийн үндсэн чиглэл тэрнээс хараат бус, илүү шинжлэх ухаанч, олон түмний хүсэл эрмэлзэлд тулгуурласан байх зорилгоор таван жилийн үндсэн чиглэл гэж хуульчилсан гэж ойлгож байгаа юм.

Тийм учраас энэ 5 чиглэлдээ нийцүүлж намын мөрийн хөтөлбөр, хөтөлбөрүүд, сонгуулийн мөрийн хөтөлбөрүүд боловсрогдоод тэр дээрээс болж

Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр бас боловсрогдож байх ёстой. Тэгээд ингэж хашиж авсан нь зүйтэй болсон. Нөгөө хэт популист хандлага, бас нөгөө халамжит дулдуйдсан эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийг дэмждэггүй өнөөдрийн бидний 30 жилийн асуудлуудыг чинь голлох ёстой хязгаарлахын тулд ийм үндсэн чиглэл, бодлого төлөвлөлт рүү бас шилжсэн нэг шалтгаан юм байна лээ гэдгийг.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн дахиад тодруулах уу.

Д.Энхтүвшин: Улс төрийн, Улсын Их Хурлын тухай Сонгуулийн тухай хууль дээр урт хугацааны хөгжлийн бодлого хөтөлбөр л нийцүүлнэ гэгчхсэн байгаа. Саяын хэлсэн жишээлбэл тэр төсөв дааж давахгүй гэдэг заалтуудад чинь хязгаарласан, хязгаарлалттай заалтууд орчихсон байгаа учраас яг энэнтэй таван жилийн төлөвлөгөөтэй шууд уялдахгүй намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр бол урт хугацааны буюу 30 жилийн алсын хараатай уялдана гэсэн яг Улсын бүртгэлийн тухай, Сонгуулийн тухай хууль дээрээ ийм заалттай юм байна лээ. Тэр яах вэ зүгээр миний хувьд Бат-Эрдэнэ даргад яг энэ асуудлаа эхний асуудлуудаа хэлэлцэж байж энэ 2026-30 оныхоо асуудлаа хэлэлцвэл яасан юм бэ гэсэн ийм санал байгаад байна. Тэрийг хэлэх гэсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Мөнгөнцогийн Ганхүлэг.

М.Ганхүлэг: Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе ээ. Бат-Эрдэнэ даргад бас ажлын амжилт хүсье. Монгол Улс 2030 онд ямар байх вэ тухай бид бүхэн бас ярилцаж байна. 2 сайн зүйл бас байна. 2019 оны Үндсэн хуулийн бас нэмэлт, өөрчлөлтөөр 25.1.7-д заасан Монгол Улсын бодлого, төлөвлөлт тогтвортой байх гэсэн энэхүү заалтыг зарчмыг бас баримтлахыг эрмэлзсэн байна.

Хоёр дахь нь шалгуур үзүүлэлтүүдийг илүү сайжруулах алхмуудыг бас хийсэн байна. Тодорхой индексүүдээр бас гаргаж ирээд хэмжигдэхүйц байх, тодорхой байх иймэрхүү бас шаардлагуудыг бас сайжруулсан байна. Анхаармаар, тодруулмаар бас хэд хэдэн зүйлүүд бас байна. Ерөнхий сайдаас эхлээд асууя. Таныг бас анх сонгогдож байхад ер нь залуучуудын асуудал дээр, залуучуудын оролцоо болон яг энэ төрийн гаргаж байгаа энэ бодлого, шийдвэр хоорондын уялдаа холбоо л ийм зааг ялгаатай үндсэндээ төр улсдаа тодорхой байгаа ирээдүйдээ итгэх итгэл бас нэлээн муу байгаа тухай үнийг хэрхэн сэргээх тухай бас би танаас бас асууж байсан. Таны өргөн барьсан 2026 оны төсөв дээр Залуучуудын яамтай Засгийн газар гэж хэлэхээргүй төсөв орж ирсэн. 200 орчим сая төгрөгийг 21 аймаг 9 дүүрэгт байгаа. Таны саяын хэлсэн хүүхэд, залуучуудын 1 сая орчмыг нь бүрдүүлж байгаа дийлэнх энэ хэсэгтээ зарцуулна гэдэг ийм байдалтай төсөв орж ирсэн. Зарчмын зөрүүтэй саналууд гаргаад энийг бас жоохон өөрчилье өө анхаарал хандуулъя, 12 төрлийн төсөл, арга хэмжээг залуучууд руу чиглэж хэрэгжүүлье ээ гэдэг санал гаргасан. Нөгөө улаан, ногоон лаазаа өргөөд 3 удаа санал хурааж байж дэмжигдсэн саналыг унагаасан. Сая Пүрэвдорж дарга байхгүй хүн орж ирээд техник ажилласангүй ээ гэдэг нэрийдлээр үндсэндээ Ухаа худгийн энэ Хянан шалгах түр хороо байгуулах асуудлыг үндсэндээ дэмжигдээгүй ээ гэдэг ийм томъёоллыг гаргаж байх шиг байна. Яг зарчмаа барих, үндсэндээ барих юм бол энэ саналыг 3 удаа санал хураахад Энхнасан гишүүн, Х.Болормаа гишүүн танхимд байгаагүй. Эргэж орж ирж үндсэндээ бас хураалгасан гээд ингээд ийм яг зарчмаа барих гээд ч байгаа юм шиг, барихгүй ч юм шиг хүн болгонд өөр

өөр байдалтай үйлчилдэг ийм нөхцөл байдлууд сүүлийн сард маш их харагдаж байна. Та нарыг бас би маш сайн ажиглаад л байгаа.

4.2.5 дээр залуучуудын асуудлыг тусгахдаа залуучуудын хөгжлийн индексээр хэмжинэ ээ 61 байгааг хэд болгох нь тодорхойгүй ийм зураас татаад ингээд тавьчихсан байж байна. Тэгээд ер нь бид яг энэ залуучуудын асуудал дээр ямар байр суурь цаашдаа илэрхийлэх вэ? Ам, ажлын зөрүүгүй байна гэж та бас хэлж байна.

Гэхдээ яг бодит байдал дээр төсөв дээр оруулж байгаа юм байхгүй, төлөвлөгөө дээрээ зааж байгаа байдал нь нэр төдий хэмжигдэх ийм байдал нь хоосон. Тэгээд энэ залуучуудын хөгжлийн индекс чинь өөрөө 5 асуудалтай. 5 асуудлаас 2-ыг нь оруулаад ирчихсэн гээд ингээд нарийвчлаад ярих зүйлүүд нэлээн байна. Ундрам сайд хариулах уу Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиа хэзээ ярих вэ? Түрээсийн орон сууц гэдэг хөтөлбөр эхлүүлье гэдэг саналыг бас Байнгын хорооноос гаргаад өгсөн. Боловсролын зээлийн санг Хөгжлийн сан болгоод гадагшаа явдаг биш дотооддоо сурдаг ийм тогтолцоог бий болгоё гээд ингээд ярьсан. Залуу малчдын хөтөлбөр хэрэгжүүлье гэсэн энэ бүх саналууд ерөөсөө хаданд хэлж байгаа юм шиг болоод байна. Залуучуудын дэд хороог миний бие бас ахалж байгаагийн хувьд энэ асуудлыг дараа дараагийн хэлэлцүүлгүүд дээр тодорхой бас ярихгүй бол болохгүй байна гэдэг ийм саналтай байгаагаа бас хэлье. Бүсчилсэн хөгжлийн асуудал дээр би нэмэлт хариултаа авчхаад асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Залуучууд залуучуудынхаа бас санал бодлыг сонсож тэн дээр үндэслэж энэ бодлого шийдвэр, хууль, төсөл санаачилж байх ёстой. Би зунжин энэ үндсэн чиглэлийг хэлэлцүүлж “Шинэ итгэл, эрс шинэтгэл” гэдэг энэ санаа залуучуудаас гарч ирсэн санаа. Монголын залуу үе ямар хүчирхэг оюун санаатай орчин үеийн болчихсон юм бэ гэж. Энийг шинэ итгэл гэж нэрлэж байгаа юм. Залуучууддаа сая та бүхэн тэр Netflix-ийн шоунд орж байгаа. Монголын залуучуудыг хар, сагсныхаа, шатрынхаа энэ залуучуудыг хар. Та харин үеэсээ хоцроод ийм коммунист сэтгэлгээтэй байж болохгүй. Залуучуудад боломж өгөх ёстой болохоос биш мөнгө, халамжид дулдуулж болохгүй. Залуучуудад төсөв тавих ёстой, тэгэх ёстой ийм коммунист сэтгэлгээнээсээ салмаар байгаа юм. Харин залуучууд чинь бидэнд боломж өгөөч гэж байна, бидэнд шийдэл өгөөч гэж байна. Энэ эдийн засгийн аюулгүй байдалд санаа зовж байна.

Бид 4 бүсийн чуулга уулзалтад залуучууддаа татварын реформгүй шинэчлэл хийхэд залуучууд мөнгө төсөв биш. Энэ татвар дээр НӨАТ-ыг бууруулж өгөөч энэ боломжийг бидэнд олгож өгөөч гэж ярьж байна шүү дээ. Залуучуудын хөгжлийг дэмжих асуудал чинь тоогоор биш энэ чанараар хэмжигдэж байна. Тэр уулзалтууд дээр та ганц дээр ч оролцоогүй бас залуу гишүүний хувьд оролцоод явах болов уу гэж бодсон чинь. Залуучуудаа сонсох хэрэгтэй байна. Тэднийхээ энэ хүсэл эрмэлзэл, тэмүүлэл, хүчирхэг оюун санааг дэмжсэн, боломж олгосон ийм санал санаачилга гаргаж залуучуудаа соён гэгээрүүлэх, ажлын боломж олгох, инновац, энэ инновац, цахим шилжилт, цахим эдийн засаг гээд яриад байгаа орчин үеийн чиг хандлагуудыг дэмжсэн, энэ мэдлэгийн эдийн засгийг дэмжсэн мэдлэгтэй, боловсролтой байх, эрүүл Монгол хүн байх, спортлог байх ийм

чадваруудыг эзэмшсэн залуу үеэ төлөвшүүлэх чинь бидний хамгийн чухал зорилт. Энийг зөвхөн төсөвт мөнгө тавьж залуучуудад халамж, мөнгө хувааж иддэг юм шиг тийм ойлголтоор хэмжиж болохгүй. Тийм учраас энэ сэтгэлгээндээ бас өөрчлөлт гаргамаар байна. Залуу мөртөө хөгшин сэтгэлгээтэй хүмүүс байж болохгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Ундрам сайд хариулъя.

Ч.Ундрам: Залуучуудын асуудал залуучууд маань нийгмийн 1 бүлэг учраас бүх яамд энэ залуучуудтай холбоотой асуудлыг хариуцах ёстой. Энэ төлөвлөгөөнд байгаа энэ залуучуудын хөгжлийн индекс нь өөрөө 3 жилд 1 удаа гардаг юм. Тэгээд хамгийн сүүлд 2023 онд гарсан байгаа. Тэгэхээр тэрний дараагийнх нь 2026 онд гарна гэсэн үг. Энэ индекс дотор боловсрол, эрүүл мэнд, улс төрийн оролцоо гэх мэтчилэн хэд хэдэн зүйлээр оноо тавьж байгаад тэгээд улс орнуудыг эрэмбэлдэг. 23 онд бид нар 61 байсан бол одоо 26 онд 59-д орно оо гэж ер нь зорьж байгаа. Залуучуудын хөгжлийн хуулийг бид нар сая бас орон нутгууд, яам дээр, яамнууд дээр бас нэлээн хэлэлцүүлгүүд хийгээд Төрийн ордонд нэгтгээд тэгээд асуудлуудыг нь бүгдийг нь нэгтгээд Ерөнхий сайдад өгсөн байгаа. Хуулийн төслийг тун удахгүй ор.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулъя.

М.Ганхүлэг: Ерөнхий сайд аа уулзалтуудад ганц нэгд нь оролцсон та бас анзаараагүй байж магадгүй. Татвартай холбогдолтой, бас “Рио” парк дээр болсон уулзалт дээр би бас оролцсон. Татварын асуудал дээр тодорхой үр дүнг бас залуучууд хүсэж байгаа. Тэр ажлыг бас үндсэндээ 2026 онд ямар үр дүн гаргах вэ гэдгийг харж байгаа. Тодорхой үр дүнгийн тухай л яриад байгаа юм. Таныг бас яг энэ залуучуудынхаа оролцож байгаа тэмцээн, уралдаануудыг хараад дэмжиж байгааг ойлгож байгаа.

Гэхдээ яг энэ ажлын байр нэмэгдүүлэх, байр, орон сууцтай болох, энэ малчдын асуудал энэ тэр дээр ингээд бид нар жагсаалтыг нь нэлээн хойгуур оруулаад ингээд яваад байж болохгүй байна тодорхой юу байна вэ гэдэг ийм л асуултыг би танаас асууж байгаа. Тэгээд энэ орж ирж байгаа саналууд нь ч гэсэндээ маш ерөнхий, шалгуур үзүүлэлтүүд нь хоосон байна гэдэг энэ шүүмжлэлүүдийг та бүхэн маань аваарай.

Зүүн бүсийн хувьд түүхэн аялал жуулчлалын бүс нутаг байгаа. Ундрам сайд энэ дээр бас тодорхой ямар зорилтууд байгаа вэ гэдгийг бас нэмж хариулаач ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Ундрам сайд.

Ч.Ундрам: Зүүн бүсэд тэр дундаа Хэнтий аймагт тогтвортой аялал жуулчлалын төсөл хэрэгжээд явж байгаа Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр тэгээд энэ төсөл маань намайг ажил авахад нэлээн гацчихсан байсан. Энийг урагшлуулаад бүх бүтээн байгуулалтуудыг нь ирэх жил дуусгахаар бид нар төлөвлөж байна. Үүн дээр нэмээд бид нар бас энэ аялал жуулчлалын бүсүүдийг тодорхойлоод Засгийн газраар оруулах гэж байна. Мөн энэ 2026 оны төсөвт бид нар аялал жуулчлалын компаниудаа дэмжих зорилгоор 6 хувийн хүүтэй нэн хөнгөлөлттэй зээлийг 150 тэрбум төгрөгийн зээлийг орон нутагт ялангуяа үйл

ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд арилжааны банкнуудаар дамжуулж олгох юм.

Тэгээд ер нь цаашид аялал жуулчлалын компаниудын ажилтнуудыг сургалтад хамруулж илүү үйлчилгээ, чанар дээр нь анхаарна гэж төлөвлө.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Таван жилийн үндсэн чиглэлд хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлнэ ээ. Дотоодын болон гадаадын жуулчдын тоог 173 мянгаас 186 мянгаар нэмэгдүүлнэ ээ гэсэн ийм зорилт орсон байна. 5 жилд бид 13 мянган жуулчнаар нэмэх ийм зорилтыг ямар тооцоо судалгаанд үндэслэж гаргасан юм бол оо? Тэгээд энэ бас хангалттай юу гэдэг энэ асуултыг асууя. Хөдөө аж ахуйн сайдаас бас бид нарт тавиад байгаа зүүн бүсийн 7 боомт эдийн засгийн эргэлтэд орохтой холбогдолтой ямар заалтууд байна вэ? Дорнод аймгийн Халхгол сумын тариаланчид наашаа 1000 км биш 20, 30км Баянхошуу боомт руугаа нэвтрэх боломж байх уу? Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын малчин наашаа 7, 800км газар явалгүйгээр тэндээсээ Бичигтийн боомт руугаа 50, 60км яваад хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн экспортлох боломжийг бид ирэх 5 жилийн хугацаанд олгож чадах уу, энэ дээр тодорхой ямар заалтууд байна вэ гэдэг дээр?

Ж.Бат-Эрдэнэ: Ж.Энхбаяр Хөдөө аж ахуйн сайд. Хэн хариулах юм? Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Бид жил болгон урд хөрштэйгөө боомтын асуудлаар уулзалт хийдэг. Одоо ингээд удахгүй он гараад уулзалт хийнэ. Тэгээд мөн энэ 17, 18-нд Шанхайн хамтын ажиллагааны орнуудын Ерөнхий сайд нарын уулзалтаар Москвад бас уулзахдаа энэ боомтын асуудлаа бид нар ярихаар төлөвлөчихсөн байгаа. Тэгээд таны хэлж байгаа саналыг хүлээж авч байгаа. Ер нь хил орчмын иргэд ихэнхдээ зөвхөн нөгөө уул уурхайн бүтээгдэхүүн гарахаар зохицуулчихсан ийм гарцаар бас гарах их хүсэлтийг тавьдаг. Тэгээд энэ болгонд бас нөгөө урд хөрш маань бас тодорхой шийдэл гаргадаггүй учраас ийм хүлээлт их байдаг юм. Тэгэхдээ бид нар аль болохоор энийг хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор энэ дээр бас.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Нэмж хариулъя Дэлгэрсайхан.

Б.Дэлгэрсайхан: Энэ дээр тодорхой бодлого гаргаад ямар ч байсан шийдэл гаргана гэдгийг бас би Ганхүлэг гишүүндээ хэлье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ундррам сайд.

Ч.Ундррам: Хил орчмын аялал жуулчлалыг жуулчлалтай холбоотой БНХАУ-ын Засгийн газар манай Засгийн газар хоёр хоорондоо тохиролцсон асуудлууд байгаа. Тэгээд үүнтэй холбоотой яг энэ хил орчмоор гарах процедурын асуудлыг журам боловсруулаад манай яамнаас Хууль зүйн яаманд хүргүүлсэн байгаа. Тэгээд хэрвээ Хууль зүйн яам сайд нь батлах юм бол үүний дагуу хил орчмын аялал жуулчлал нэлээн хөгжихөөр төлөвтэй байгаа. Үндэсний статистикийн

хорооноос гаргасан тоогоор бид нар өнгөрсөн жил 727 мянган жуулчин авсан. Энэ жил 800 гаруй жуулчин болохоор ийм төлөвтэй байгаа. Тэгээд бид нар ер нь цаашид тооноос илүү чанарт ирээд жуулчид маань Монгол Улсад тодорхой хэмжээний валют зарцуулдаг ийм чанартай жуулчин руу анхаарах нь зүйтэй юм байна гэж бодож байгаа. Тийм учраас тооны өсөлтийг арай багаар тооцоолсон байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвжавын Ганзориг гишүүн алга байна. Жуковын Алдаржавхлан гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Та бүхэндээ өдрийн мэндийг дэвшүүлье. Ямар ч байсан хэмжих хэмжүүртэй бичиг баримт нэг бодлогын бичиг баримт орж ирж байна гэж ойлгож байгаа. Тэгэхдээ бид нар 30 жил олон Засгийн газар олон сайхан төлөвлөлтийг хийгээд хэрэгжихгүй байгаа үндсэн шалтгаан юу юм бэ гэдгээ Монгол Улс оношлох хэрэгтэй байгаа юм. Алдаагаа засдаггүй хүслийн жагсаалт дахин битгий орж ирээсэй гэж бодож байна.

Хоёрдугаарт, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Засгийн газрын 4 жил хөгжүүлэх мөрийн хөтөлбөр 2-ын гол ялгаа юу юм бэ гэдгийг илүү сайн ойлгох хэрэгтэй болов уу. Үнэхээр энэ Засгийн газрыг хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөртэй адилхан юм бол энийг заавал батлах шаардлага байна уу үгүй юу гэдэг асуудал. Үнэхээр Монгол Улсыг хөгжүүлэх тэр төслүүдийг эрэмбээр нь жагсааж байгаа бол энийг батлах шаардлагатай гэж бодож байна. Тэгээд энд нэг зүйлийг би асууж тодруулъя гэж бодож байна. Үнэхээр эрэмбэлж байгаа юм уу? Салбар болгоныг сайхан болгох, хүрэх үр дүн хэрхэн хэмжих вэ гэдэг жагсаалттай бодлогын бичиг баримт орж ирсэн байна аа.

Тухайлах юм бол хүний хөгжил хамгийн чухал гэж байна. Дээд боловсролыг Монгол Улс хөгжүүлэхийн тулд ямар үндсэн чиглэл, ямар эрэмбэ, ямар ажил нь чухал юм бэ гэдэг дээр тодорхой асуулт асуумаар байна. Жил болгон 100-150 орчим тэрбум төгрөгөөр гадаадын их сургуульд Монгол залуучуудыг явуулдаг. 50 орчим хувь нь эргэж ирдэг ээ Чойжилсүрэн сайдаа 50 орчим хувь нь эргэж ирдэг. Энэ гадаадын нэр хүндтэй сайн сургуульд явуулах нь чухал. Гэхдээ дэлхийн хэмжээний багш нарыг Монголдоо урьж Монгол Улсын Үндэсний их сургууль, ШУТИС, ХААИС, энэ Эрүүл мэндийн шинжлэх ухааны сургуулиа дэлхийн хэмжээний сургууль болгох ийм реформ, тогтолцооны өөрчлөлт хийж болдоггүй юм уу? Сайн багш нарыг авчрах юм бол Монгол окутан болгон дэлхийн хэмжээний боловсролыг Монголдоо, эх орондоо авах бас боломж бүрдэнэ ээ гэж бодож байна. Энэ тал дээр ямар байр суурьтай байгаа юм бэ?

Өнөөдөр Монголын бизнесүүд, тэр дундаа жижиг, дунд бизнес эрхлэгчид банкны зээлээс өөр санхүүгийн эх үүсвэр байхгүй байна. Зээлийн хүү хэт өндөр, зээлийн олдоц нь бага. Хөрөнгийн зах зээлийг хэрхэн хөгжүүлэх юм бэ? Хөрөнгө оруулалтын сан байгуулах тухай тийм үндсэн чиглэл энд алга байна. Өнөөдөр дижитал эдийн засгийг хөгжүүлж гээд ярьж байна. Сайн санаа, санаачилга тэр бизнес цэцэглэн хөгжих, ургах тэр хөрс, суурь нь Монголд байхгүй байна. Бидний жишээ авдаг Казахстан, Узбекистанд яаж байна вэ гэхээр хөрөнгө оруулалтын сангууд нь хөрөнгө оруулаад явдаг тэр тогтолцоо руу орсон байна. Тэгэхээр Монгол Улс бизнест хөрөнгө оруулдаг бизнес хийхийн тулд заавал зээл авдаг биш,

банкны хаалга, очер дугаар хүлээдэг биш хөрөнгө оруулалт авдаг шинэ орчин, шинэ сувгийг бий болгох энэ чиглэл байна уу гэдгийг хэлье.

Гуравдугаарт нь санхүүгийн зах зээл дээр банк давамгайлж байна. Гаднын банкиг Монгол Улс оруулж ирэх юм уу, оруулж ирэхгүй юм уу, зээлийн хүүг хэрхэн бууруулах юм бэ, банкны дотоодын банкны засаглалыг сайжруулах нээлттэй болгох энэ бодлогоо үргэлжлүүлэх юм уу, хувьцааг нь нээлттэй болгох юм уу энэ чиглэлд хариулт өгөөч ээ гэдгийг хэлье.

Гурав дахь асуулт, би 1 минутаа нэмээд авчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Баатархүү гишүүнд 1 минут.

Ц.Баатархүү: Тээвэр ложистикийн салбарыг хөгжүүлэх үндсэн чиглэлүүд байна. Монгол Улсад зайлшгүй энийг ярих хэрэгтэй гарц гаргалгааг нэмэх хэрэгтэй гэж бодож байна. Сум хоорондын авто замаар холбоход 1000 орчим километр зам барих юм байна энэ 5 жил. Яг одоо сумдаа авто замаар холбох нь чухал юм уу? Алтанбулагийг Улаанбаатартай холбох экспресс зам чухал уу? Замын-Үүдээс Улаанбаатар руу холбох экспресс зам чухал уу гэдэг дээрээ эрэмбэ дарааллын судалгаа хийсэн юм уу? Эдийн засагт аль нь өгөөж өгөх юм бэ? 2.5 их наядар Туулын хурдны замыг барих нь чухал юм уу, үнэхээр Азийг Европтой холбосон экспресс зам барих нь чухал юм уу гэдэг ийм эдийн засгийн судалгаа байгаа юм уу? Надад энэ харагдахгүй байна. Юу гэж хэлмээр байна вэ гэхээр зүгээр Засгийн газрынхаа хийх ажлыг та бүхэн маань хэмжих нэгждээ оруулаад ирсэн юм биш биз дээ гэдэг ийм.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулах уу? Занданшатар Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Баатархүү гишүүний асуулт, саналтай бас санал үндсэндээ нэг байна. Жишээлбэл боловсролын салбарт бид суралцахуйн хувьсгал хийх ёстой. Суралцахуйн хувьсгал гэдэг илүү үр дүнтэй суралцах боломжийг нээх явдал юм. Тийм учраас дэлхий дээр дипломат deflation буюу дипломын үнэгүйдэл явагдаж байгаа. Гадаадын нэр хүндтэй өндөр зардалтай сургуульд суралцахаас илүү Монголоосоо ч гэсэн дэлхийн түвшний боловсролыг эзэмших ийм цахим платформ суралцахуйн хувьсгал дэлхий даяар хийгдэж байна. Үүнд дасан зохицож саяын ЮНЕСКО-гийн гаргасан тэр суралцахуйн хувьсгалын идеологи үзэл санаанд нийцүүлж энэ боловсролын салбарын зардлын үр ашгийг сайжруулах тэр хэмжээгээр зөвхөн гадаадын нэр хүндтэй багш нарыг авчрахаас илүү цахимаар болон энэ олон платформоор энэ суралцахуйн хувьсгалыг хийж 1 талаас зардал ч хэмнэгдэх, нөгөө талаас үр ашгийг сайжруулах, дэлхийн түвшний өндөр боловсролтой залуучууд бэлдэх ийм боломжийг эрэлхийлсэн ийм боловсролын салбарын цогц шинэчлэлийг бид Наранбаяр сайд үүрэг өгөөд хэрэгжүүлж байгаа. Энэ зөвхөн цалин нэмэгдүүлэх төдийгүй боловсрол эцсийн дүндээ Монгол хүүхэд уламжлал, ёс заншлаа мэддэг, бас дэлхийн түвшинд боловсрол эзэмших боломжийг нээсэн ийм боломжийг нээнэ.

Жишээлбэл, ганцхан жишээ дурдахад Стэнфордын их сургуульд сурч байгаа Урангоо гэж 2 дугаар курсийн охин байна. Тэр КОВИД-ын үед морьтойгоо интернэт барьдаг газар, уулын оройд гарч хичээлээ бэлтгэж хийж байгаад дэлхийн өндөр түвшинд тэтгэлэгтэй өнөөдөр суралцаж байгаа ганцхан жишээ. Тэгээд тэр

охинтой холбогдоод бид нар энэ дээр яаж ажиллаж болох вэ, энэ яаж хүүхэд суралцахуйг эрхэм болгож байна, яаж энэ эрдмийн их далайгаас өөрөө шууд өөрөө очоод оюуны мэдлэг сангаа арвижуулж болж байна. Ийм цогц өөрчлөлт шинэчлэлтийг хийхээр бид бас ажиллаж байгаа. Олон улсын байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтарч ажиллаж байна.

Тийм учраас таны тэр Боловсролын зээлийн санг өөрчлөх тэр санаачилгыг бид бас Боловсролын сайдад үүрэг өгсөн байгаа. Одоо боловсрол хавтгай болж байна шүү дээ. Энэ бол технологийн дэвшил. Аж үйлдвэрийн технологийн IV дүгээр хувьсгалын энэ ололтыг технологийн дэвшлийг суралцахуйн хувьсгал болгож байгаа энэ байдлыг ашиглах ёстой. Тийм учраас залуу техникчдийн инновацын шинэ төвүүдийг бий болгох ёстой. Тэр таны санаачилга төсөв энэ тэр дээр зөв гэж бодож байна. Энэ хөтөлбөртэй санал агаар зарчмын хувьд нэг байгаа. Энийг хэрэгжүүлэх ажил дээр харин бас Боловсролын яамтай таныг бас хамтарч ажиллахыг урьж байна. Та инновацын сайд хийж байсан хүний хувьд технологийн дэвшил, инновац энэ уялдах ёстой. Энэ талаар Наранбаяр сайд дэлгэрүүлж хариулна.

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр Баатархүү гишүүний асуултад хариулъя. Энэ Боловсролын зээлийн сантай холбоотойгоор асууж байна. Тэгэхээр Боловсролын зээлийн санг Хөгжлийн сан болгож цаашдаа ер нь ийшийгээ авьяастныг цуглуулж авчрах ийм бодлого, чиглэл рүү оруулахыг дэмжиж байгаа. Ялангуяа бас дотооддоо суралцах суралцаад “2+2” хөтөлбөр гадагшаагаа суралцах ийм боломжийг нээсэн ийм журм журмын шинэчлэлийг хийсэн. Түүний зэрэгцээ бид бас энэ дотоодынхоо их, дээд сургуулиудыг олон улсын эрэмбэ, чансааны энэ үзүүлэлтүүд рүү оруулж шалгуулж ингэж эрэмбийг нь тогтоож байгаа. Өнөөдөр МУИС жишээлбэл дэлхийн шилдэг 1500 дотор ороод ирчихсэн. Ангаах ухааны их сургууль 1237-д ингээд жагсаж байх жишээтэй ийм шинэчлэлтүүд хийгдэж аль болохоор дотооддоо бас боловсрол эзэмших боломжийг илүү түлхүү болгох ийм бодлого явж байгаа. Цаашдаа ер нь бид ШУТИС болоод МУИС мөн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр сайдын микрофоныг сунгая.

П.Наранбаяр: Мөн Анагаахын их сургуулиуд дээр төсвөөс дэмжлэг үзүүлж шинэ байрыг барих энэ ажлыг хийж байна. Сувилахуйн ухааны чиглэлээр 2 ч том байр бариулж энэ дээр сувилахуйн ухааны чиглэлээр хүнээ бэлдэх ийм боломжийг бий болгож байна. Ер нь 158 тэрбумын ийм төсөвтэйгөөр ажиллаж байгаа энэ Боловсролын зээлийн сан. Эндээс ихэнх хөтөлбөр юунууд Ерөнхийлөгчийн тэтгэлгээр суралцаж байгаа оюутнууд одоо 1000 гарч байна. Тэгэхээр энэ жилийг оруулаад. Тэгэхээр эдгээр хүүхдүүдтэй ямар гэрээ байгуулж байна гэхээр ерөөсөө буцаж ирэх, ирээд ажиллах ийм гэрээтэй 5 жил заавал өөрийнхөө төрсөн нутаг болоод Улаанбаатар хотод ажиллах ийм боломжтойгоор ажиллах ёстой. Тэгж байж энэ ийм тэтгэлэг болох ёстой. Ер нь Боловсролын зээлийн сан тэтгэлэг, хөнгөлөлт, зээл эд нар гэсэн ийм 4 төрлийн 31 бүтээгдэхүүнийг үзүүлдэг. Тэгээд энэ хооронд бид бас таны хэлсэнчлэн аль болохоор энэ Боловсролын зээлийн санг Монгол Улсын ирээдүйг авч явах шилдэг боловсон хүчнийг бүрдүүлж тэр нь эх орондоо хүчээ өгч байдаг ийм л боломжтой.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Хөрөнгийн зах зээлтэй холбоотой Дэлгэрсайхан сайд. Хэн бэ? Бямбацогт сайд хариулах уу?

С.Бямбацогт: Банкны, арилжааны банкнууд харьцангуй сүүлийн үед бас өөрсдөө эрсдэлээ даагаад эрсдэлгүй ажиллах энэ ажил дээрээ бас нэлээн анхаарал тавьж харьцангуй тогтвортой болж байгаа. Төрийн банкны тухайд бас тодорхой хувийг нь хувьчлах олон нийтэд нээлттэй арилжих ийм замаар бас гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах ийм бодлого бас оруулж ирж байгаа. Үндсэн чиглэл дотор гадаадын хөрөнгө оруулалттай бас гаднаас банк оруулах асуудлыг бас дэмжих ийм заалт орсон байгаа. Тийм болохоор бас өрсөлдөөн нэмэгдэнэ, илүү бас гаднаас хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэр татагдаж нэмж бий болох, эх үүсвэр бий болох, үүгээр бас зээлийн хүү бас дагаад энэ арилжааны банкнуудын өгч байгаа хувийн хэвшилд ялангуяа хөрөнгө оруулалт үйлдвэрлэл томоохон төслүүд хэрэгжүүлэх зээлийн хүү бас буурах, эдийн засаг тэлэх тийм бололцоо бүрдүүлэх зорилгоор гадаадын бас хөрөнгө оруулалттай банкийг Монголд бас оруулж ирэх энэ асуудлыг бас үндсэн чиглэлд тусгасан байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Би Баатархүү гишүүнтэй санал нэг байна. Ер нь бид энэ 2 улсыг холбосон транзит ялангуяа босоо тэнхлэгийн замаа шинэчлэх тусгай зориулалтын ийм хүнд даацын зам тавихгүй бол ер нь болохгүй байгаа юм. Манайхаар хамгийн дөт гээд ОХУ-аас ч тээвэр их явж байна. Хятадаас ч их тээвэр явж байна. Тэгээд бид бас тусгай зөвшөөрлийг нь өгөөд ингээд энэ манай Монгол дээгүүр зорчиж байгаа замаасаа 1 машинаас ингээд дамжаад өнгөрөхөд 300 мянган төгрөгийн ийм төлбөр авдаг юм.

Тэгэхлээр зэрэг эхний замыг бид нар Замын-Үүд, Говьсүмбэр гэж тусгай зориулалтын замын сонгон шалгаруулалт зарласан. Энэ ямар учиртай юм гэхлээр ийм том замыг бид нар төсвийн мөнгөөр хийх ямар ч боломжгүй учраас ингээд төр, хувийн хэвшлийн түншлэлээр энийг хийлгэ.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Төр, хувийн хэвшлийн түншлэлээр энийг барих ийм сонгон шалгаруулалт хийсэн байгаа. Тэгээд 11 компани санал ирүүлснээс одоогоор 3 компани шалгараад эцсийн сүүлийнх нь дүнг манай үнэлгээний комисс гаргана. Энэ тусгай зориулалтын хүнд даацын ийм замыг тавьж байгаа. Тэгээд шат дараатайгаар ингээд ер нь замуудыг бид нар аль болохоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр ингээд хувийн зам болгож өгч бариулахгүй бол бид нар ингээд өөрсдөө санхүүгийн боломж байхгүй учраас цаашдаа төлбөртэй замыг л бий болгоё гэж байгаа юм. Тэгэхлээр аль болохоор төлбөртэй замын эхлэлийг сая энэ өнгөрдөг 9 сарын 13-ны Засгийн газрын хуралдаанаар 77 дугаар тогтоолоор уул уурхайн бүтээгдэхүүн ачсан энэ машин, ачаатай машин даацаа замынхаа даацаар явахдаа 150 мянган төгрөгийн төлбөр төлж байгаа. Энэ мэтчилэн ингээд аажим аажмаар бид нар бас ингээд сайн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Жанчивын Галбадрах гишүүн асуултаа асууя.

Ж.Галбадрах: Гишүүдийнхээ өдрийн мэндийг хүргэе ээ. Тогтоолын төлөлттэй танилцсан. Тийм юм чинь бид нарын яриад байдаг нөгөө хүслийн жагсаалт биш бодлогын баримт бичиг болсон байна гэж үзэж байгаа учраас дэмжиж байгаа. Тэгээд энэ дээр ажилласан хүмүүст бас баяр хүргэхийг хүсэж байна. Эдийн засаг, хөгжлийн яамны залуучуудтай маш ойрхон ажиллаж бас санал солилцсон. Гэхдээ олон санал хэлсэн байгаа. Сайжруулаад явна гэдэгт найдаж байгаа бас засвар орох байх гэж бодож байна.

Тэгээд хөгжлийн таван жилийн үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралтыг оруулж ирснээр өөрөөр хэлбэл үнэлгээний шалгуур үзүүлэлт зорилтот түвшнийг оруулсан нь түүнийгээ тоогоор, хуваарь илэрхийлэхийг нь оролдсон нь их сайшаалтай ийм зүйл байгаа. Энийг л их бид нар бодитой болгох хэрэгтэй. Мөн үндсэн 8 чиглэлээ тогтоож, тэргүүлэх чиглэлээ эрэмбэлсэн нь сайн хэрэг. Хүний хөгжил. Боловсрол, эрүүл мэндийг нэгдүгээрт тавьсан нь манай Ерөнхий сайдын яриад байдаг хүний хөгжил манай Засгийн газрын мега төсөл байна гэсэн энийгээ баталж байна гэж талархан хүлээж авч байгаа.

Таван жилийн үндсэн чиглэлийн хамгийн амин чухал зүйл нь тэр суурь түвшин, зорилтот түвшнээ тодорхойлоод тэгээд хэмжиж болохуйц шалгуур үзүүлэлтүүд оруулахыг ингээд зорьсон. Энэ л бодитой байх ёстой. Үүнтэй холбогдуулаад би 4 асуулт асууя гэж бодож байна. Боловсролын салбараа 5 жилийн турш эрэмбэлсэн учраас тэргүүлэх чиглэл болгосон, тэргүүлэх салбар болгосон. Үүнийгээ байнга мөрдөөд явж чадна биз дээ? Үүний тулд зүгээр олон гишүүд давхардуулж ярьж байна. Төсвийн нийт зардлын 20 хувьд нь боловсролын зардлыг хүргэж чадах уу гэдэг асуултыг асуумаар байна. Энэ дээр бас санхүүжилтийн 2 эх үүсвэр байна. Улсын төсөв байна, гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж байна гэдэг дотор гадаадын зээлд 468 тэрбум төгрөгийг тавьсан байгаа юм. Тэгэхдээ энэ Азийн хөгжлийн банкны эх үүсвэр мөн үү гэдгийг 130 сая долларын зээл мөн үү? Тэгээд 2026 онд огт ямар ч дүн тавигдаагүй байна. Энэ ямар учиртай юм бэ гэдгийг асууя.

Хоёрдугаарт, Баялгийн сангийн хуримтлалыг 2024 онд 4.48 гэсэн ийм суурь түвшин байгааг 2030 онд зорилтот түвшинд 21.56 бараг 5 дахин нэмэх нь. Энэ бололцоотой, бодитой юу? Баялгийн сан дээр ер нь ямар бодлого баримталж байгаа вэ гэдгийг Ерөнхий сайдаас асуумаар байна.

Гуравдугаарт нь суурь түвшнийг бодитой тавих шаардлагатай. Зарим зөрүүтэй зүйл байгаад байгаа юм. Тэр 3 дугаар хавсралтын 1.1.2.1 гэсэн стандартын шаардлага хангасан бүлгийн тоо ЕБС-д байгаа бүлгийн тийм тоо нь нийслэлд 76.5 хувь аймагт 97 хувь байна гэж байна. Энэ хэр бодитой вэ? Би өөрөө энд талын судалгаа хийсэн хүн байгаа. Тэгээд 704 төрийн өмчийн сургууль дээр 23748 бүлэг байгаагийн 30-аас дээш бүлэгт, дээш хүүхэдтэй бүлэг нь 9500 тэнд 362 мянга гаруй хүүхэд сурч байгаа. Энэ нь 50 гаруй хувьд давчхаад байгаа. Тэгээд ийм зөрүүтэй байхад энэ яг бодитой тоо мөн үү? Тийм учраас бид нар суурь түвшнээ маш сайн нарийн нягталж байж тавиад тэрнээсээ цаашаа явна.

Нөгөө талаас зорилтот түвшнийг бас бодитой тавих ёстой. Энд сэтгэлийн хөөрлөөр бас тавиад байх шиг байгаа юм. Одоо мэргэжлийн багшаар хангагдсан цэцэрлэг одоо 23.6 хувьтай, ЕБС бас 23.8 хувь гэж байж байгааг 2030 онд

цэцэрлэгийг 95 хувьд хүргэнэ. ЕБС-ийг 96 хувьд хүргэнэ. Мэргэжлийн багшаар хангагдсан багшийг ердөө 5 жилийн дотор. Энэ бол их сайхан сонсогдож байгаа. Тэгэхдээ энэ үнэхээр бодитой биелэх зорилт тоо мөн үү? Ийм шаардлагуудыг хөндлөнгийн байгууллагаараа хянуулаад энийг сайн хийлгэж байх нь бид нарт энэ үндсэн чиглэлүүдээ үндсэн төлөвлөгөөгөө биелүүлэх.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Жанчивын Галбадрах гишүүнтэй бас санал нэг байна. Энэ боловсрол тэргүүлэх салбар. Боловсролд оруулж байгаа хөрөнгө оруулалт ирээдүйн хөгжлийн суурийг тавина. Тэгэхдээ төсвийн зарлагын 20 хувьд хүрэхийн тулд манай энэ төсвийн цогц реформ хийх шаардлагатай байгаа. Манай ийм сонирхолтой түвшин байгаа нь алтан гахайгаас хойш нэмэгдсэн хүүхдийн төрөлт, өсөлт, нэмэгдэл бол боловсролын салбар бас 1 сая 145 мянган хүүхэд, суралцагч нартай болоод ирэхээр сургуулийн тоог нэмэх шаардлагатай болсон. Ачааллууд нэмэгдсэн, багш нарын тоогоо нэмэгдүүлэх шаардлагатай болсон. Тэр хэмжээгээр зардал өсгөж байгаа юм.

Нөгөө талдаа Монгол хүний дундаж наслалт уртсаж 71.7 болсноороо бас тэтгэврийн ачаалал маань нэмэгдэж байгаа юм. Ингээд дагаад бас халамж, хэдийгээр хүүхдийн мөнгийг боловсролд ч оруулдаггүй, халамжид ч тооцдоггүй боловч энэ маань 1.5 их наядын үндсэндээ зардал, төсвийн зардлын маш том хувийг эзэлж байгаа юм. Энийг бас боловсролтой уях ийм санаачилгууд бас яригдаж байгаа. Тэгэхээр энийг ингэж цогцоороо төсвийн зарлагын хүрээндээ энэ авч үзэхгүй бол болохгүй байгаа юм. Тэгээд энэ ачааллын хувьд тантай санал нэг байна. Жишээлбэл нийт багш нарын 3-ны 1 нь сумд ажиллаж байна юу багш нарын 3-ны 1 нь сумд ажиллаж байна. 3-ны 1 нь аймагт ажиллаж байна. 3-ны 1 нь Улаанбаатарт ажиллаж байна.

Тэгтэл Улаанбаатар хотод нийт энэ суралцагч 1 сая 145 мянган хүүхдийн 60 хувь нь суралцаж байдаг. Тэгэхээр нийт сурагчдын 60 хувьд нийт багш нарын 3-ны 1 хичээл заахаар ачаалал нь эрс ялгаатай, 2 дахин ялгаатай, 2-оос 3 дахин их ялгаатай болоод тэр хэмжээгээрээ улсын дунджаар энэ багшид хамрагдах хүүхдийн тоо, анги дүүргэлт энэ тэрийнх бага юм шиг харагддаг ч Улаанбаатарынх эрс өөр. Энэнээсээ шалтгаалсан багшийн ачаалал, дарамт 60, 70 хүүхэдтэй сурч байгаа гээд залуу багш нарын ачаалал, дарамт тэгээд нөгөө залуу багш нарт анги олон хүүхдийн ангиа хуваарилчихдаг энэ тэр гэсэн ийм олон асуудлууд бий. Ийм учраас энэ бас цахимжилт саяын хэлээд байгаа олон санаачилгууд энэнтэй уялдаж гармаар байгаа юм. Таны энэ саяын сэтгэлийн хөөрлөөр тавигдсан тоонууд байж магадгүй.

Гэхдээ явж байгаа цаашдын хандлага 2030 он хүртэл төрөлт буурч байгаа юм. Өөрөөр хэлбэл сургуулийн ачаалал буурна. Дэлхий нийтийн чиг хандлага Япон, Солонгост гэхэд сургуулиуд эзгүй болж байна шүү дээ. Хүүхдүүд төрөлт багассанаас шалтгаалаад. Тэгээд энэ бас сайн үзүүлэлт биш ч гэсэн тодорхой хэмжээгээр өсөж байсан цикл ямар ч байсан шинэ сургууль барих шаардлага, багш нарын тоог нэмэх шаардлагууд харьцангуй буурах хандлагатай болно. Энэ хэмжээгээр нэгж оногдох зардал.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Цэндийн Сандаг-Очир гишүүн. Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр 20 хувьд хүргэх эсэх тэгээд тэр энэ зорилт болж явж байх ёстой. Ингэж байж л бид олон асуудлыг шийднэ. Нөгөө талдаа энэ 468 тэрбум гэж хэллээ энэ Азийн хөгжлийн банканд энэ удаагийн энэ дагалдах энэ хуулийн төсөл, мөн олон улсын гэрээ хэлэлцээгээр 150 сая долларын хэмжээтэй Азийн хөгжлийн банкны зээлийг хөнгөлөлттэй зээлийг авахаар байгаа. Үүний 130 сая нь 41 байршил дээр сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор барилга байшин барихад чиглэж байгаа. Тэгэхээр энэ мөнгөн тоон дүн нь бараг мөргөж байх шиг байна. Тэгэхээр хэрвээ яавал Сангийн яамнаас бас тодруулаарай. Бид бас энэ яах вэ энэ та түрүүнд хэллээ 96 руу шууд хүргэнэ гээд ингээд бичсэн байна гэдэг нь энэ Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдсаны дараа тоонуудаа бас дахиж магадалж харъя. Ингэх бас шаардлага байх байх гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Галбадрах гишүүн тодруулъя.

Ж.Галбадрах: Ерөнхий сайд төрөлт багасаж байгаатай холбоотой юм ярьж байна. Тэгээд бид нар бас энийг тооцож үзсэн. Бүүр наад тал нь л 2060 он хүрч байж л энэ төрөлтийн тоо чинь сургуульд нөлөөлж орж ирэх тийм тооцоолол бас байгаа. Тийм учраас бид нар өнөөдөр нөгөө 50, 60 хүрээд байгаагаа ердийн 30 гэдэгтээ оруулъя. Тэрнээс хойш 2 ээлж байгаагаа 1 ээлжид оруулъя гэж ингэж явсаар байтал энэ ийм тоо гарч байгаа.

Наранбаяр сайдаас ахиад тодруулахад тэгвэл 468 тэрбум төгрөг гэдэг маань тэр Азийн хөгжлийн банкных байх нь байна. Тэгвэл ирэх жил ямар ч тоо тавигдаагүй байна гэдэг ирэх жил шинээр сургууль, цэцэрлэг баригдахгүй байх нь. Бид нар чинь энд маш их хүлээлттэйгээр шинэ төсөл, шинэ сургууль, шинэ цэцэрлэгийг Азийн хөгжлийн банкны зээл бэлэн байгаа, зээл авахад ер нь бүх нөхцөл нь бүрдчихсэн байгаа учраас бид нар шууд л 26 оноос хэрэгжүүлээд явна гэсэн зүйл ярьж байсан учраас бид нар энд их хүлээцтэй байсан л даа. Тэгтэл өнөөдөр тийм биш болох нь уу гэдгийг тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ Азийн хөгжлийн банкны энэ зээлийн асуудал явж байгаа. Тэгээд 12 дугаар сарын эхээр бас энэ Азийн хөгжлийн банктэй Боловсролын яамны зүгээс уулзалтуудыг зохион байгуулна. Филиппинд ч зохион байгуулна. Ингээд тэгээд энэ ажлууд явагдана.

Тэгэхээр энэ жилдээ огт тавигдахгүй 26 оноос эхлэхгүй гэсэн үг ерөөсөө биш. 26 онд эд нар оруулах энэ төслийн нийт арга хэмжээ гэхэд 200-гаад сургууль, цэцэрлэг, дотуур байрны ийм барилгууд байх жишээтэй. Он дамначихсан төслүүдээ дуусгана. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бас шинээр сургууль, цэцэрлэгүүдийг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ. Тэгэхээр “0” байна гэсэн ийм ойлголт байхгүй. Зээлийн хувьд 12 сарын эхээр ярилцаад ингээд 2026 оны эхний улиралд гэхэд ингээд зээлээ аваад эхлэх ийм боломжтой гэсэн ийм ойлголттой байгаа. Энэ Сангийн яамны зүгээс энийг нь бас тодруулаад хэлээд өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын индэр.

Ж.Дэлгэржаргал: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. Азийн хөгжлийн банкны зээлийн хувьд Улсын Их Хурлаар соёрхон батлах процесс явж байгаа. Энэ төслийн хүрээнд нийтдээ 32 сургууль, 9 цэцэрлэгийн төлөвлөлт шинээр барихаар орсон байгаа. Тэгэхээр гадаад зээлийн ашиглалтын хувьд Сангийн сайдын багц дээр 1.2 их наяд байхаар сая төсөв дээр батлагдсан. Энэ хүрээндээ бид нар Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан төслүүдийг гүйцэтгэлд нь үндэслээд олгох боломжтой. Тэгэхээр саяын дүнгийн хувьд 26 ондоо гүйцэтгэл нь гарах юм бол ашиглалт нь гараад явах боломжтой.

Ж.Бат-Эрдэнэ: Хөдөө аж ахуйн яамныхнаас Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Би Хөдөө аж ахуйн сайдаас Хөдөө аж ахуйн яамныхнаас асууя. Энэ өнөөдөр Төрийн ордонд 21 аймаг 9 дүүргийн малчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөн болж байгаа юм байна. Тэгээд сая тойргоос ирсэн төлөөлөгч нартай уулзлаа асууж өгөөч гээд ямар асуулт гэхээр энэ сүүлийн 1, 2 жилийн хугацаанд хөдөө аж ахуйн ноос, ноолуур, арьс шир, сүүний урамшууллууд олгогдохгүй байгаа гэдэг юмыг ярьж байна. Би өмнөөс нь олгогдож байгаа гэж ярьсан. Харамсалтай нь яг малчид эмэгтэйчүүд маань олгогдохгүй байгаа гэдэг юм ярьж байна. Бид нар жил жилийн төсөв дээр тодорхой хэмжээний урамшууллуудын мөнгийг баталж байгаа шүү дээ. Тэгээд энэ хаанаа яаж гацаад байдаг юм, ямар шалтгаантай байгаа юм гэдгийг Хөдөө аж ахуйн яамныхан хариулж өгөөч.

Хоёр дахь асуудал 26-30 оны таван жилийн хөгжлийн ярилцаж байна. Энэ тал дээр би Ерөнхий сайдаас засаглалын асуудал дээр ер нь цаашдаа энэ төрийн албан хаагчдын тоог цөөрүүлэх, цомхон, чадварлаг байлгах гээд төрийн албан хаагчдын энэ 246 мянган төрийн албан хаагчдыг цөөлөх асуудал гээд яриад байгаа. Би төрийн албан хаагчдын анхан, дунд шатад байгаа төрийн албан хаагчдыг цөөрүүлэх асуудлыг хөндмөөргүй байгаа юм. Гагцхүү энэ дээрээ байгаа яам, тамгын газар, агентлагуудаасаа энэ төрийн албан хаагчдыг төрийн албыг цомхотгох асуудлыг хэрхэн яаж энэ хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан юм бэ? Бүүр цаашдаа энэ ирэх таван жилийн хугацаанд энд 16 яамыг цөөрүүлэх, нэгтгэх ийм бодлого байна уу, үгүй юү? Хуучин бид нар бас Дэд бүтцийн хөгжлийн яам гээд энэ Эрчим хүч, Уул уурхай, Эрдэс баялгийн яамнуудыг нэгтгэчихсэн яам байсан шүү дээ. Зам, тээрийн яам, Барилга, хот байгуулалтын яамнуудыг нэгтгэчихсэн яваад байж болсон, болж байсан. Тийм учраас энэ ирэх жил таван жилийн хөгжлийн төлөвлөгөөнд энэ төрийн албаны данхар бүтцийг гээд яриад байгаа энэ бүтцийг бууруулах, цөөрүүлэх энэ бололцоо боломжийг ер нь энэ Засгийн газар яаж эрэлхийлж ажиллаж байгаа вэ? Бодлогодоо яаж тусгасан бэ?

Нөгөө талаар бас энэ засаг захиргааны нэгжийн хувиар энэ олон байгаа, байхгүй нь мэдэгдэхгүй 1000 доош хүн амтай энэ сум, суурин газруудыг нэгтгэх асуудлыг ер нь энэ Засгийн газар ер нь цаашдаа яаж олж харж байгаа вэ? Энэ нь эргээд цаанаа нөгөө энэ төсвийн энэ 300 гаруй сумуудын асуудал байна. Энэ дээр төсвийн хэмнэлтийн хүрээнд энэ хөгжлийн төлөвлөгөөнд яаж туссан бэ гэдгийг.

Гуравд төрийн албан хаагчдын цалин, урамшууллын тогтолцоог энэ хөгжлийн төлөвлөгөөнд яаж тусгаж байгаа вэ? Одоо бид нар ингээд жишиг

тогтоолоо. Хэн ажил хаяж, жагсаж, цуглаж, суулт хийсэн нь цалингаа нэмүүлдэг ийм байдал руу орлоо. Тэгвэл энэ хөгжлийн төлөвлөгөөнд ер нь цаашдаа энэ цалин, урамшууллын тогтолцоог нэгдсэн байдлаар хэрхэн яаж нэмэгдүүлдэг байх юм? Тэрнээс хэн ажил хаяснаар нь нэмдэг байж болохгүй биз дээ. Тийм учраас энэ хөгжлийн төлөвлөгөөнд цалин урамшууллын асуудлыг, нийгмийн асуудлыг, орон сууцын асуудлыг төрийн албан хаагчдын хөгжлийн төлөвлөгөөнд хэрхэн яаж тусгасан бэ? Ийм 3 асуултыг асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя. Занданшатар Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Сүүлийнх нь асуултаас эхлээд хариулна. Ер нь энэ төрийн албан хаагчдын цалин хөлс, урамшууллыг энэ гүйцэтгэлд тулгуурласан, бүтээмжид суурилсан цалин хөлсний тогтолцоонд шилжүүлэхээр энэ таван жилийн үндсэн чиглэлд суусан байгаа. Энэ жагсаж цугласанд нь цалин нэмээд байгаа юм байхгүй ээ. Энэний ард харин иймэрхүү улс төрийн турхиралт хатгалга байсан нь тогтоогдож байгаа. Яагаад багш нарын цалинг нэмсэн бэ гэхээр нэгдүгээрт боловсролын жил болгож зарлаад амлачихсан юм байна лээ өмнөх Засгийн газар. Энийг чинь өмнөх Засгийн газрын амлалт гэж би үзэхгүй шүү дээ. 3 талт хэлэлцээр байгуулаад 3.5 сая төгрөгт 3 жилийн дотор хүргэнэ гээд 3 жилийн өмнө амлаад 3 талт хэлэлцээр байгуулчихсан юм байна лээ 22 онд, 23 он дараалаад.

Тэгээд энийгээ жил болгон нэхэж шаардаад тодорхой 10, 10 хувиар нэмж байгаад 30 хувьд яагаад хүргээгүй юм бэ гээд тэгэхээр сая гэнэт ухаарлаа гэж байгаа. Энэний ний нуугүй ярьсан. Тэгэхдээ Засгийн газар үүрэг хүлээгээд 30 хувь нэмэгдүүлнэ багш нарын цалин гээд энэ 3 талт хэлэлцээр үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан. Энэ нөгөө 3 талт хэлэлцээрийг 3 жил тутам баталж авдаг ийм хуультай, журамтай олон улсын жишиг ч гэсэн ийм. Тэгээд энийгээ биелүүлэх Засгийн газрын үүргээ биелүүлээгүй учраас л энэ хүмүүс ажлаа хийж байгаа юм.

Тэгэхээр энэ бас хууль зүйн үндэслэлтэй учраас, гэрээ байгуулаад гарын үсэг зурчихсан учраас энийг хэрэгжүүлэх чиглэлээр багш нарын хувьд багш нарын цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлаар ийм чиглэлтэй юм байна лээ. Тэгэхдээ бас буруу зөрүү ойлголт байгаад байна. Нэлэнхүүд нь 50 хувь нэмчихсэн юм биш. Яг саяын Галбадрах гишүүний асуусан шиг сая 484 мянган төгрөгийн цалинтай ингээд 1 сая 200 мянган төгрөг гар дээр авдаг хүн Улаанбаатар хотын багш нарын олонх өндөр ачаалалтай 60, 70 хүүхэдтэй ачаалалтай бид нар яаж амьдрах вэ гэдэг асуудал. Тэр суурь цалин дээр нь бид нар илүү нэмэх бодлого баримталж үйлдвэрчний эвлэлтэй ойлголцож ийм шийдлүүд гараад явсан. Энэ сая хүүхдийн боловсролтой холбоотой асуудал учраас тийм учраас нэгдүгээрт энэ ажил хаяад л жагсаж цугласанд нь цалин нэмээд байгаа асуудал байхгүй. Тохирсон тэр тохиролцоогоо Засгийн газар хэрэгжүүлээгүй л юутай холбоотойгоор энэ асуудал шийдэгдэж явж байгаа юм шүү гэдгийг бусад салбар ч гэсэн мэдээлж байгаа юм.

Тэгэхдээ бид энэ төрийн албан хаагчдын цалин, урамшуулал, орон тоо, төсөв, хий үргүй зардал энэ бүхнийг нэгтгэн цэгцлэх зарчмаар өмнө нь би олон удаа хариулсан сая бүтээмж, гүйцэтгэлд тулгуурласан цалин хөлсний тогтолцоонд шинэчлэл хийх ийм асуудлыг энэ таван жилийн үндсэн чиглэлд тусгасан. Эмч нарынхаа ч гэсэн эмч нар ч гэсэн гүйцэтгэлийн цалин хөлсөнд шилжсэн. Цаашдаа төрийн тусгай албан хаагчдын асуудал байна. Цалин хөлс.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэлт цаг өгье.

Г.Занданшатар: Яамдын тоог өөрчилснөөрөө улс хөгжвөл хөгжихөөр болсон. Нэмээд л хасаад л зөндөө янз янзаар үзсэн. Яг энэ яамдын тооны асуудлыг 4 жилдээ л 1 удаа шийдэж байх ёстой гэж би үздэг. Энэ 24 онд та бүхэн ингээд л батлаад өгчихсөн Их Хурал тэрүүгээрээ л явах ёстой гэж өөрчлөлт хийгээгүй. Яагаад гэхээр яам солигдохоор тэрнээсээ илүү зардал гардаг юм. Тамга, тэмдгийг нь солино, албан бланкнууд өөрчлөгдөнө, далимдуулаад баахан халаа сэлгээ явна, бүтцийн өөрчлөлт явна, төрийн албан хаагчид ч хохирдог, ажил үүрэг нь ч тодорхойгүй болдог, ахиад ажил нь жигдрэх гэж ахиад хэдэн жил болдог. Тэгтэл хугацаа үнэтэй байдаг, ажлуудаа амжуулмаар байдаг ийм учраас ер нь яаманд төрийн бодлого илүү тогтвортой ажиллаж байж хөдөө аж ахуйн салбарт ч гэсэн хэрэгжиж байгаа бодлого нь илүү тогтвортой байж байж л энэ улс орны эдийн засаг ч тэр, бас ард иргэд, бизнес эрхлэгч ч гэсэн ийм тогтвортой үйлчилгээ үзүүлж байж л энэ төрийн бодлого хэрэгжих юм байна лээ. Тийм.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Хүнс, хөдөө аж ахуйн салбарт олгож байгаа урамшуулалтай холбоотой асуултууд асуусан байна. Нэг онцлог байгаа салбарын урамшуулал жилийн эцсээр дүнгээ гаргаж байж дараа ондоо олгогддог дийлэнх нь. Жишээлбэл энэ жилийн ургацын тоо баланс дуусаад 25 оны олгох урамшуулал 26 оны төсөв дээр сууж олгогдоно оо гэсэн үг. Ийм маягаар жоохон хоцрогдлууд бий, он дамждаг ийм зүйл байгаа. Сүүтэй холбоотой 11 сарын 1-нээс дараа оны 4 сар хүртэл тэр сүүний урамшууллыг литр тутамд 1000 төгрөг болгож үйлдвэрт тушаасан үйлдвэрүүдэд нийт 30. Улсын хэмжээний 36 үйлдвэр энэ зохион байгуулалтад оролцож байгаа. Тийм болохоор урамшуулалд ямар нэгэн алдаа оноогүй явж байгаа нийт 10 мянга орчим фермер малчид энэ сүүний кластерт холбогдож ажиллаж байгаа, хамрагдаж байгаа. Сүүтэй холбоотой энэ асуудлууд ондоо багтаад үндсэндээ бүх урамшуулалтай холбоотой.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ж.Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Урамшууллын асуудал энэ 24 ондоо, 25 оны жилийн эцэс гэхэд бид нар 24 оныхоо гүйцэтгэлийг шахаад нэгтгээд ингээд 24 оны урамшууллууд 25 оны эцэс гэхэд олгогдоно. 25 оны урамшууллууд 26 ондоо олгогдоно буюу он дамжиж ингэж явна. Урамшуулалд ямар нэгэн өөрчлөлт ороогүй учир нь энэ бүгд өөрөө хуульчлагдсан ийм урамшуулал Их Хурлын тогтоолтой явж байгаа тул энэ олгох зүйлүүд олгогдоно.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Би Барилга, хот байгуулалтын сайдаас асууя. Ирэх таван жилийн хөгжлийн төлөвлөгөөнд энэ орон сууцны бодлогын асуудал, тэр дундаа энэ Улаанбаатар хотын алслагдсан дүүргүүд, сум суурин газрууд дээр энэ ипотекийн орон сууцны зүгээр Улаанбаатар хотдоо л шаваад байдаг зогсоол ч байхгүй, хүүхдийн тоглоомын талбай ч байхгүй, зам талбай ч байхгүй ийм газартай л орон сууц барих тэр бололцоо боломжийг нь олгоод байдаг. Энэ дэд бүтэц

хөгжсөн энэ Налайх, Багахангай, Багануур энэ дүүргүүд дээр орон сууцын бодлогыг ер нь Барилга, хот байгуулалтын яам, Засгийн газар цаашдаа ер нь яаж хэрэгжүүлэх юм бэ? Энэ банкнуудаар дамжуулж ипотекийн зээлийг нь олгох асуудал байж болж байна. Тэр газрууд чинь эрчим хүчний дэд бүтцийн хүрэлцээ, хангамж нь байна, газрынх нь асуудал бололцоотой байна. Ингээд Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах асуудал бас байна. Энэ тал дээр танай яам Засгийн газар ер нь яаж анхаарал хандуулж энэ хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан юм бэ гэдгийг бас хариулж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Хот байгуулалтын сайд Бат-Амгалан сайд.

Э.Бат-Амгалан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулья 2025 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар энэ орон сууцжуулалтын банк байгуулахаар ажлын хэсгүүд гарсан ажиллаж байна. Манай яаман дээр энэ үүнтэй холбоотой орон сууцжуулалтын анхдагч хууль гаргахаар ажлын хэсэг ажлын дэд хэсгүүд гараад ажиллаад явж байна. Ер нь нийслэл Улаанбаатар хот дотор Багануур, Налайх, Багахангай гэсэн алслагдсан 3 дүүрэг маань орж байгаа. Энэ 3 дүүрэгтээ 2040 он хүртэл хөгжүүлэх хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн асуудлуудыг бүгд бас зураглалтайгаа, ерөнхий төлөвлөгөө дээр бид нар бас ажиллаад явж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Үргэлжлүүлж хариулах уу? Бат-Амгалан гишүүн.

Э.Бат-Амгалан: Тэгээд энэ орон сууцжуулалтын анхдагч хуулийг Улсын Их Хурал дээр Улсын Их Хурлын эрхэм гишүүд маань бас дэмжиж баталж өгснөөр энэ алслагдсан дүүргүүд, алслагдсан хороод, мөн нэн шаардлагатай байгаа инженерийн шугам сүлжээний эх үүсвэрүүдийн асуудлыг Улаанбаатар хотыг хөгжүүлэх 2040 оныг хүртэл хөгжүүлэх энэ хөгжлийн бүсчилсэн бөгөөд ерөнхий төлөвлөгөөнүүдтэй уялдуулж ажиллуулна. Энэ хүрээнд бас дотор яг бидний хувьд, нийслэлчүүдийн хувьд, мөн Монголчуудын хувьд нэн тэргүүний эгнээнд байгаа энэ ипотекийн зээлийн асуудал, энэ ипотекийн зээлийн эх үүсвэрийн асуудлуудыг энэ ажлын дэд хэсгүүд дээр, ажлын хэсгүүд дээр судалгаанд ороод явж байгаа Засгийн газарт танилцуулах чиг үүрэгтэй. Барилга, орон сууцжуулалтын яаман дээр орон сууцжуулалтын хуулийг өргөн барихаар, энэ намрын чуулганд өргөн барихаар ажиллаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ таван жилийн төлөвлөгөө 26-30 он гээд сонсож байна. Гишүүдийн ярьж байгаагаар энэ 14 мега төслөөс 11 нь хэрэгжих юм шиг ярьж байна л даа энэ таван жилийн хугацаанд. Гэтэл энэ санхүүгийн боломж маш муу болоод сая бид нар эмч, багш нарын цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэхэд бараг мөнгө байхгүй гээд өр, зээл таазандаа тулчихсан ийм хүнд байдалтай болчихлоо шүү дээ. Тэгэхээр энийг санхүү мөнгийг хаанаас босгох вэ? Ер нь бонд босгох юм уу? Нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал энэ эрүүл мэндийн салбарын асуудал байна л даа. Эмч, багш нар, эмч нар сая ажил хаялтаа зогсоох шиг байна. Тэгээд яг он гараад яг тодорхой хэдэн хувиар нэмэгдэх юм? Мөн эрүүл мэндийн салбарын ачаалал

хотын эмнэлгүүдийг хараарай бүүр маш их ачаалалтай байна. Бүсчилж хөгжүүлнэ гээд л юм ярьж байгаа манайх. Ер нь аймгуудын нэгдсэн эмнэлгийг түшиглээд тэрэндээ шаардлагатай тоног, MRI юм уу, ангиогийн аппаратын чухал аппарат, тоног төхөөрөмжийг нь тавьж өгчихвөл энэ хот руу ирэх эмч нараа чадавхжуулчихвал энэ ачаалал нь буурах юм биш үү. Энэ талаар барьж байгаа бодлого байна уу? Ер нь эрүүл мэндийн салбарын бодлого ер нь буруу тийшээ явж байна л даа. Төслийн санхүүжилт доор буруу тийшээ яваад санхүү мөнгө нь босохоо байсан. Аймгуудын нэгдсэн эмнэлэг, хотын дүүргийн эмнэлгүүд, том том клиникийн эмнэлгүүдийн ер зээлийг ерөөсөө авлага, өгдгийг нь ингээд нуугаад байх юм. Энийг ил болгож байж энэ бүх юмыг нь санхүүжилтээ ЭМД-ын шинэчлэл дээр ямар шинэчлэл хийх гэж байна? Ер нь миний бодлоор энэ буруу тийшээ бодлого нь явж байна. Энэ талаар барьж байгаа бодлого ер нь цаашдаа яах вэ энийг?

Гурав дахь асуудал энэ аялал жуулчлалын чиглэлээр Засгийн газрын мөрийн хөтөлбөртэйгөө Таванбогд, Хотон нуурын үзэсгэлэнт байгаль үзэсгэлэнт газар руу аялал жуулчлалын тийм цогцолбор байгуулна гээд яасан одоог хүртэл байхгүй. Энэ талаар энэ таны төлөвлөгөөнд байна уу? Дараа нь чөлөөт бүс гээд асуудал байж байна. Цагааннуурын чөлөөт бүс гээд 19 дэх жилдээ байна уу 25 хүн ажилладаг хоосон хашаа. Энэ тал дээр ямар бодлого барьж байна? Аль эсвэл цомхотгох юм юм уу зүгээр цалин өгөөд байж байх юм уу. Энэ талаар төлөвлөгөөнд тодорхой тусгасан юм байна уу? Ер нь соц нийгмийн үед Цагаан нуурыг чинь баруун бүсийн худалдаа үйлчилгээний төв болгоод дундад Азийн орнууд руу Станийн орнууд руу бүх төв малын түүхүүдээ гаргадаг байсан. Энэ бодлого алдагдчихлаа. Цаашдаа ч энэ талын асуудлыг шийдэхгүй бол ер нь хэцүү байдалтай болох юм шиг байна. Энэ талаар яг төлөвлөгөөндөө тодорхой тусгаж байна уу?

Хүнс, эмийн аюулгүй байдал дээр Хөдөө аж ахуйн яаманд ЖДҮ-гийн төсөв хасаад байх юм. Дотооддоо ер нь эх орны хөрсөнд ургасан эрүүл хүнсний ногоогоор хангах боломж байгаа. Энэ тал дээр та энэ таван жилийн хугацаанд ер нь анхаарлаа хандуулах уу? Ер нь дотоодын эх орны эрүүл хөрсөнд ургасан хүнсээр хангах боломж бодлогын талаар ер нь ямар бодлого барьж байна?

Дараагийн асуудал энэ эмийн аюулгүй байдал дээр 100 жил болоход эмийн үйлдвэр байхгүй. Баталгаат лаборатори нь тоног төхөөрөмжгүй. Энэ талаар бодлого барих энэ эмийн үйлдвэрийг хөгжүүлэх тал дээр та ямар бодлого барьж байна? Дараа тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Сүүлээсээ Хөдөө аж ахуйн сайд хариулах уу? Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Хүнс, эм хүний хоолойгоор давж байгаа асуудал ходоодонд орж байгаа. Үүний тогтолцооны асуудлыг бид ер нь хүнс эмийн аюулгүй байдал гэдгээрээ цул цөм болгож авч үзвэл их зүйтэй. Одоо бол тус тусдаа байгаа, зохицуулалтууд өөр өөр байгаа. Энэ ер нь цаашид нэгдэх ёстой гэсэн ийм байр суурьтай байдаг.

Оруулж ирж байгаа энэ бодлогын асуудал дээр Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрлэлийн боловсруулалтын хүчин чадлыг 50 хувиар нэмэгдүүлнэ ээ гэж энэ

5 жилийн хугацаанд. Энэний цаана чинь энэ хүнсний аюулгүй байдлын асуудал, чанарын асуудал, хүнсний хангамжийн асуудал, хүртээмжийн асуудал гээд иж бүрэн цогцоор нь хийх олон хөтөлбөрүүд энд суусан байгаа. Та хөтөлбөрийн үзвэл манайхаар 4 том зорилтын хүрээнд 14 томоохон хөтөлбөр хэрэгжүүлэхээр энэ хөгжлийн бодлогод Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас санал өгөөд дэмжигдээд явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Өөр Бямбацогт сайд хариулах юм уу хэн хариулах юм? Чөлөөт бүс их олон жил боллоо гэж байна. Цагааннуурын чөлөөт бүс үү? Ганхуяг сайд.

Х.Ганхуяг: Ер нь чөлөөт бүс тухайн байршил онцлогоосоо хамааруулж байгаад ер нь хөгжлийг төлөвлөлтийг хийдэг. Цагааннуурын чөлөөт бүсийн хувьд яг хил орчим, хил залгаа ийм бүс нутаг байгаа. Хамгийн түрүүнд ер нь эхний ажлын томилолтоо бид нар Баян-Өлгий аймгаас эхлэх бодолтой байна. Өвөлжилтийн нөхцөл байдал ч бас тийм амаргүй байгаа гэж дуулдаж байна. Тийм учраас Цагааннуурын тэр чөлөөт бүстэй холбоотой асуудлуудаар тэр хүртэл бид нар юмнуудыг нь судалъя. Болж өгвөл чөлөөт бүсийг, хил орчмын чөлөөт бүсийг худалдаа, чөлөөт худалдаа талдаа илүү байр суурийг илэрхийлсэн байдлаар бид нар бас хөгжүүлэх ёстой гэж хардаг. Одоо үндсэндээ бид нар Цагаан нуур, Замы-Үүд, Алтанбулаг гээд 3 чөлөөт бүс дээр хөрөнгө оруулалтууд хийгдээд явж байна. Замын-Үүд дээр нэлээн эрчтэй явж байна. Тэнд шугам сүлжээ, инженерийн шугам сүлжээ рүү орчихсон явж байна. Дэд бүтцийн ажлууд хийгдэж байна. Цагааннуур хоцрогдож яваа тэр үнэн ажил дээр нь газар дээр нь танилцаад би тэр зохих арга хэмжээнийх нь дагуу танд эргээд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Энд сайдууд байхгүй бас зарим асуух асуултад хариулахгүй байна л даа. Одоо энэ улсын хэмжээнд бензиний үнэ их нэмээгүй мөртөө Өлгийд 130 төгрөгөөр нэмэгдсэн. Цаанаасаа 2 газраас орж ирдэг байдал хүнд байна. Энийг бууруулах тал дээр ер нь ямар бодлого барьж байна? Энэ хүнд байна.

Нөгөө талаар Ерөнхий сайдаас асуухад Багшийн хөгжлийн ордон гэж байна. Эмчийн хөгжлийн ордон гэж байхгүй байна. Тийм учраас сая эрүүл мэндийн хөгжлийн 2 дугаар байр хуучин анагаахын дундын байрыг энэ эмч нарын хөгжлийн ордон гээд барьж өгөөч гээд 16 давхар барилгын зураг, төсвийг нь гаргачихсан байна. 6 давхар хүртлээ оффис, тэгээд дээд тал нь эмч нар байрладаг тийм. Та энэ 5 жилд энийг хэрэгжүүлэх үү? Энэ бүх зураг төсөв хийлгэчихсэн юм байна. Энэ дээр анхаарах боломж байна уу танд ер нь?

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах юм? Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: ОХУ-ын дотоод зах зээлийн хүндрэлтэй нөхцөл байдал нефтийн үйлдвэрүүдэд Орос Украин дайнаас шалтгаалсан халдлагуудын улмаас дотоодын зах зээлийн бас дутагдал үүссэн хямралтай нөхцөл байдал бий болсон хэдий ч Монгол Улсыг бидний тавьсан хүсэлтийг хүлээж авч шатахууны нийлүүлэлтийг эрс нэмэгдүүлж байдал төвийн бүсэд тогтворжсон. Нөгөө трэйдер компаниудаар дамжуулж баруун бүсээр Цагааннуурын боомтоор нефть шатахуун хуучин орж ирдэг байсан тэр үед тасалдчихаж байгаа юм. Үндсэндээ шууд бирж

буюу үндсэн үйлдвэрлэгч нараар дамжиж трэйдерүүд дунд нь аваад баруун бүсээр нэвтрүүлдэг байсан. Тэр юм зогссоноос шалтгаалаад баруун бүсийн нефтийн хангамж шууд хилийн боомтоор тасалдсан. Улаанбаатар хотоос зөөж байгаа учраас энэ тээврийн зардал чинь ингээд .../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Тэгэхдээ бид нар баруун бүсийг тогтворжуулах талаар бас ажиллаж байна. Манай Жангабыл гишүүн бас санаачилгатай ажиллаж байгаа. Хоёрдугаарх юм нь тэр эмчийн хөгжлийн төвийн талаар. Багшийн хөгжлийн төв өөрөө мэргэжлийн онцлогтой. АУДС та дахин АУИС-ийн дэргэдэх энэ сургалт энэ тэр чинь өөрөө нэг ёсондоо Эмчийн хөгжлийн төв гэсэн үг шүү дээ тийм ээ. Тэгээд энэ таны ярьж байгаа асуудлыг судалъя, учрыг магадалъя, Төсөвт суух асуудал болохоос биш энэ үндсэн чиглэлийн асуудал биш байна.

Ж.Бат-Эрдэнэ: Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Нөгөө 11 мега төсөл гэж л ойлгоод байгаа л даа. Тэр нь санхүү мөнгийг хаанаас босгох вэ, бонд босгох уу гээд асуусан. 2 дахь нь энэ эрүүл мэндийн салбарын төсөв, аймгуудын нэгдсэн эмнэлэг халгаад барьж байна. Сангийн яамныхнаас асуухад энэ дансыг нь хаачихсан юм уу ямар учиртай юм? Энэ талаар тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Би асуулт танилцуулахдаа хэлсэн үгэндээ их тодорхой заасан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэд нь баригдах вэ, зээл, тусламжаар хэд нь баригдах вэ. 48 хувь нь улсын төсвийн санхүүжилт дэмжлэгээр, 16 хувь нь гадаадын зээл, тусламжаар гэж хэлсэн санаж байна. Би тоонуудыг нарийвчилж танд хэлье. Энэ 39 төсөл буюу 44.8 хувийг улсын төсвөөр, 25 төсөл буюу 28.7 хувийг гадаадын зээл, тусламжаар, 14 төсөл буюу 16.1 хувийг шууд хөрөнгө оруулалтаар, 8 төслийг төр, хувийн хэвшлийн түншлэл, үнэт цаас, холимог эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тооцлоо гэж хэлсэн.

Ж.Бат-Эрдэнэ: Мөнхчулууны Энхцэцэг.

М.Энхцэцэг: Гишүүн та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсыг ирэх таван жилд хөгжүүлэх үндсэн чиглэлийг чуулганаар хэлэлцэж байна. Тэгээд үүнтэй холбоотой эрчим хүчний ялангуяа эрчим хүчний салбарыг ирэх 5 жилд хэрхэн яаж хөгжүүлэхтэй холбоотой хэдэн асуулт асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт бид сүүлийн үед цахилгаан эрчим хүчний зах зээлийг либералчлах талаар маш их ярьж байгаа. Одоо бид худалдан авагчийн загвартай буюу цахилгаан станцуудаас түр худалдаж аваад хэрэглэгч рүү зардаг ийм бүтэцтэй явж байгаа. Энэ шилжилтийн үед ашиглагддаг ийм загвар. Энэ загвараар бид нар 24 жил явж байгаа. Бусад бүх л бараг ихэнх улс орон бол өрсөлдөөнтэй, чөлөөтэй ийм зах зээл рүү шилжчихсэн. Тэгэхээр ирэх 5 жилд энэ цахилгаан эрчим хүчний зах зээлээ либералчлах, чөлөөтэй, өрсөлдөөнтэй болгох, хэдэн хувиар зах зээлээ нээх тийм зорилго байгаа юу гэсэн эхний асуулт.

Хоёр дахь асуулт болохоор мэдээж хувийн хэвшлийн оролцоо маш чухал байгаа. Тэгэхээр өнөөдөр эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоо хэдэн хувьтай байгаа, цаашид энэ ирэх 5 жилд хувийн хэвшлийн оролцоог хэдэн хувиар нэмэгдүүлнэ гэсэн тийм зорилго байгаа юу?

Гуравдугаарт, нь та бүхэн мэдэж байгаа эрчим хүчний салбарын шугам тоноглолууд маш өндөр насжилттай болсон. Эхнээсээ 50, 60 жилийн насжилттай тоног төхөөрөмжүүд нь дэлбэрч гэмтэж эхлээд байгаа. Тэгэхээр энэ ирэх 5 жилийн хугацаанд энэ дундаж наслалтын хэмжээг хэдэн хувиар бууруулна тэгнэ гэсэн ингэнэ гэсэн тийм зорилт байгаа юу гэсэн ийм 3 асуултыг асууя. Тэгээд тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Чойжилсүрэн гишүүн.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний салбарыг либералчлах асуудлыг эхлүүлэх талаар бид нар бэлтгэл ажил хийгээд явж байгаа. Эхний ээлжид ТӨК-удын засаглалыг сайжруулъя гэдэг энэ зорилтыг тавиад ТӨК-удыг энэ 25 оноос эхлээд өнгөрсөн жил өртөгт нь ойртуулах арга хэмжээ авсны хүчинд зорилт тавьсан боловчиг харамсалтай нь дулааны нэмэлтийг хойшлуулснаас шалтгаалаад дандаа алдагдалтай байна. Уул нь энэ төрийн эрчим хүчний салбарын ТӨК-удын хувийн компаниудын хувийн салбарын оролцоог оролцуулчих юм бол төр бүх юмыг шийдэж байна, ил тод бус байна, авлига байна гэдэг энэ шүүмжлэлээс салах юм болов уу гэсэн ийм зорилт бий .

Хоёрдугаарт, эрчим хүчний салбарын либералчлалыг 1 өдөр бүрэн хийчихгүй байх. Танаар ахлуулсан ажлын хэсэг сүүлийн 15, 6 сар бид нар бас та нарыг хүлээгээд байгаа. Та нарыг хүндэлж байгаа. Дандаа та нарт нөгөө бүрэн цагаар төрийн албан хаагч эрчим хүчний салбарын ажилтнуудыг таны удирдлага дор ажиллуулж байгаа. Улсын Их Хурал дээр Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Энийг Засгийн газар хүндэтгэлтэй хандаад танаас бас ямар бодлого гардаг юм болов уу гэдэг энийг бас харж байгаа гэдгийг манай эрчим хүчний салбарынхан иймэрхүү байр суурьтай байгаа гэдгийг бас танд хэлье.

Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр ийм арга хэмжээ авах эх үүсвэр талдаа буюу цахилгаан станцыг барих тал дээр хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж байгаа. Одоо яг төвийн бүсийн эрчим хүчний систем дээр гэхэд Бөөрөлжүүтийн 600мвт-ын хүчин чадалтай цахилгаан станцууд эхний 1, 2 дугаар блок ашиглалтад ороод явж байна. 27, 28 ондоо 3, 4 дүгээр блок нь ашиглалтад орно. Баян сум дээр 660мвт-ын цахилгаан станц 27, 28 онд 1, 2 дугаар блокоо ашиглалтад оруулахаар явж байгаа.

Гуравдугаарт, Сэлэнгэ аймгийн төв дээр 70мвт-ын цахилгаан станц 1, 2 дугаар блокийг энэ 2026 оны 1 дүгээр улиралд багтаагаад ашиглалтад оруулна гэсэн ийм төлөвлөгөө явж байна.

Дөрөвдүгээрт, энэ Тосонцэнгэл сум дээр 30мвт-ын цахилгаан станцын 22мвт-ын хүчин чадалтай блок ашиглалтад орсон байна.

Тавдугаарт, энэ Шивээ-Овоо дээр 660мвт-ын хүчин чадалтай цахилгаан станц ажлаа эхлээд 2028, 2029 онд ашиглалтад оруулахаар явж байгаа гэх мэтээр

эрчим хүчний салбарын эх үүсвэрийг бид нар төр, хувийн хэвшлийн түншлэл буюу хувийн хэвшлийнхний хөрөнгийг татаж оролцуулаад барья. Дамжуулах шугамыг төрд хадгалъя гэдэг ийм зорилт тавиад явж байгаа.

Дамжуулах шугамын тухайд хэд хэдэн төслийн арга хэмжээ энэ 5 жилийн төлөвлөгөөнд суусан. Эхнийх нь Багануураас Чойр хүртэлх цахилгаан дамжуулах 220 киловольтын агаарын шугам дэд станцын өргөтгөл байна. Чойр Сайншанд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Чойжилсүрэн сайдын микрофоныг сунгая.

Б.Чойжилсүрэн: Мандалговь, Арвайхээрийн шугам явж байна. Баруун бүс дээр жишээлбэл Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн 220 киловольтын шугамууд гэх мэт энэ өргөтгөлийн ажлууд, цахилгаан дамжуулах сүлжээний өргөтгөлийн ажлууд идэвхтэй хийгдэж байгаа. Улаанбаатар хот руу 2 гегаваттыг хотын 2 талд 1 гегаваттыг оруулж ирэхийн тулд цахилгаан дамжуулах сүлжээний өргөтгөл, цахилгаан түгээх сүлжээний өргөтгөлийг хийхэд 2 тэрбум доллар хэрэгтэй гэсэн ийм судалгаа гарч байна. Бусад төслийн бэлтгэл ажлууд дөхөж явна. Эх үүсвэр шийдэгдсэн гэх мэт ийм ажлууд хийгдэж байгаа гэдгийг бас хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Энхцэцэг гишүүн тодруулъя.

М.Энхцэцэг: Тэгэхээр Монгол Улсын эрчим хүчний салбарыг ирэх таван жилд хөгжүүлэх энэ үндсэн чиглэл дээр цахилгаан эрчим хүчнийхээ зах зээлийг либералчлах 1 ч үг, үсэг байхгүй байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл салбар нь, Эрчим хүчний яам нь, Засгийн газар нь зах зээлээ либералчлах ийм хүсэл сонирхолгүй байгаа энэ нөхцөлд энэ бодлогыг хэрэгжүүлэх бодлого нь байхгүй байгаа энэ нөхцөлд зах зээлийг либералчлах хууль, эрх зүйн орчин бичигдэнэ гэсэн ойлголт байхгүй. Өнгөрсөн хугацаанд та бүхэн мэдэж байгаа Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдсан. Миний бие өөрийнхөө гишүүнийхээ төсвөөр тасралтгүй 4 зөвлөхийг ажиллуулж дулаан хангамжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулчихаад явж байгаа. Цахилгаан хангамжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах гэхээр өөрөөр хэлбэл Эрчим хүчний яамнаас нь либералчлах ямар ч хүсэл сонирхол байхгүй. Яг одоо төр монопол одоо байгаа системээрээ явах ийм хүсэл сонирхолтой байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Дахин тодруулъя.

М.Энхцэцэг: Ямар ч боломжгүй байгаа. Дээрээс нь ерөөсөө энэ салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулаад явах үндсэн үүрэг бол Эрчим хүчний яамны үүрэг. 2001 онд батлагдсан хоцрогдсон хуулиа өнөөдөр шинэчлээгүй 24 жил явчихсан. Тэгээд энэ шинэ 126 гишүүнтэй Улсын Их Хурал анх удаа ажлын хэсэг байгуулагдаад байгуулаад ингээд Дулаан хангамжийн тухай хуулийг боловсруулсан. Одоо тэгээд цаашаа цахилгаан хангамжийн тухай хууль гэхээр энэ салбар нь энэ Засгийн газар нь үнэхээр либералчлах сонирхол байхгүй тохиолдолд энэ хууль бичигдэнэ гэсэн ойлголт байхгүй. Эхлээд салбар нь бодлоготой үнэхээр ийшээ явна ядаж зах зээлийнхээ бид нар 5 хувийг энэ 5 жилийн хугацаанд либералчилъя гэдэг бодол нь гарч байж тэр бодлогыг хэрэгжүүлэх хууль нь бичигдэнэ. Ер нь бид нар энэ 12 сарын 1-нээс эхлээд энэ бид нар өнөөдрийг хүртэл хийсэн бүх ажлаа Эрчим хүчний яаманд хүлээлгэж өгье

гэж бодож байгаа. Яагаад гэвэл өнөөдөр энэ салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах үндсэн үүрэг нь

Ж.Бат-Эрдэнэ: Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүндээ баярлалаа. Би одоо энийг, энэ хуулийг цаашаа бичих үү, өөрчлөх үү гэдэг асуудлыг та санаачилга гаргаад Их Хурал дээр бариад байсан учраас бид нар харамсалтай нь бичээгүй байсан. Та хэрвээ бичихгүй гэвэл бид энэ хуулийн төслийг боловсруулж Их Хуралд өргөн барихад бэлэн байна. Дахин хэлье танд байнгын бүр ажлын бүрэн цагаар ажиллуулдаг 10 гаруй төрийн албан хаагчийг танай ажлын хэсгийн бүрэлдэхүүн дэд ажлын хэсгээр бид нар бүтэн жил шахам ажиллуулсан. Тэгэхээр тахиа өндөгний үлгэр яриад хоорондоо маргаад байх хэрэггүйгээр нэг талдаа гаргаад шийдсэн нь дээр гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууна.

Д.Пүрэвдаваа: Хуралдаан даргалагч аа би уул нь Ерөнхий сайдаас асуулт асуухаар зэхсэн байсан юм. Энэ дуудах боломж байдаг юм болов уу? Өө тэгвэл минутаа шинээр эхлүүлчихье тэгэх үү дарга аа? Нэлээн уртхан л асуумаар байна.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдаваа гишүүний минутыг шинээр эхлүүлье.

Д.Пүрэвдаваа: Нэгэнтээ Монгол Улсын 2026-30 онд хэрэгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл гэдэг бодлогын бичиг баримт батлах гэж байгаа учраас энэ танхимд бас нэг зүйлийг сануулаад унших гэсэн юм. Ялангуяа сайд нар анхааралтай сонсооч ээ гэж хүсэх байна. Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ гэдэг мөрийн хөтөлбөрийг 2024 онд та бүхэн маань дэвшүүлсэн. Тэгж байж иргэдийнхээ саналыг авч өнөөдөр та бүхэн маань 68-уулаа сууж байгаа. Нийт 48 сар засаглахын 2.5 жилийн аль хэдийн ингээд төсвөө баталчихсан. Тэгээд би та бүхэнд сануулах үүднээс энэ хэд хэдэн юмыг уншиж өгье. Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй эхний 3 жилд 3 хувийн зээлийн хүүтэй, ипотекийн зээлийн 6 хувийн хүүтэй хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлнэ ээ гэсэн. 3 хувийн хүүтэй зээл хэдэн хүн авсан бэ? Хэдэн хүн авахаар төлөвлөж байна вэ? Дараагийн дугаарт 3 мянган эмч, 10 мянган сувилагч, 500 мэргэшсэн асрахуйн ажилтныг гадаад, дотоодод бэлтгэх бодлого баримтална. Хэдэн мянган сувилагч эд нар гадагшаа явчхав? Асуумаар байна.

Дараагийн дугаарт багшлах хүний нөөцийг чадавхжуулж, цэцэрлэгийн багш 10 мянга, бага ангийн багш 2 мянга, ерөнхий боловсролын багш 11 мянга, Англи хэлний 2 мянга, МСҮТ-ийн 2 мянган багшийг гадаад, дотоодод бэлтгэх бодлого баримтална. ХҮН нам ч гэсэн ялгаагүй энэ хөтөлбөрийг нь хэрэгжүүлэх ёстой шүү дээ. Залилан мэхэлж болохгүй.

Дараагийн дугаарт төмөр замын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлж, хил дамнасан холболтыг гүйцээн нүүрсний экспортыг 100 мянган тоннд хүргэнэ. Хэзээ 100 мянга болох вэ? Go-Mongolia арга хэмжээг үргэлжлүүлж гадаадын жуулчдын тоог жилд 2 саяд хүргэнэ ээ. 2 сая шүү. Өөрсдөө 3 саяулаа байж байж яаж ийм мөрийн хөтөлбөр дэвшүүлж ард түмнээ хуурсан байна гэдгээ тайлбарлаадах. 3 Ди, 4 Си онгоцны буудлуудыг орон нутагт байгуулна. Хэд байгуулагдав аа? Та

бүхэн энэ 5 жилдээ хэдийг барих нь вэ? ААНОАТ-ыг 50 хувь болгон бууруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Хуулиа санаачилчихсан уу? Хэзээ 5 хувь болох вэ? Шинэ хоршоо хөдөлгөөнийг үндэсний хэмжээнд өрнүүлж аравтын системийн бүтцээр хоршооллыг дэмжинэ. Аравтын систем чинь ямар шатдаа явж байгаа вэ? Тэгээд ДНБ-д эзлэх Засгийн газрын гадаад өрийг 40-өөс доош хувьд тогтмол хадгалж, хувийн хэвшилд олон улсын зах зээлээс хямд өртөгтэй эх үүсвэр татах боломжийг олгоно. Сүүлийн 2 жил дандаа 60-д барьж байгаа шүү дээ. Тэгээд хэзээ 40 болох вэ? Энэ зөвхөн зах зухаас нь шүү. Ази тивийн хүний эрхийн төвийг Монгол Улсад байгуулна гэсэн байна. Энэ ажил 5 жилд чинь орсон уу тэгээд эдгээрийг та бүхэн маань энэнээс өшөө зөндөө дурдаад байвал маш олон зүйл заалт бий. Тэгэхээр энэ Монгол Ардын намын 2024 онд Улсын Их Хурлын сонгуулиар ялахдаа амлаж байсан зүйлүүдийн мөрийн хөтөлбөр дээр тавьсан энэ үзүүлэлтүүдийг би та бүхнээс асууж байна. Одоо яг 1, 1-ээр нь хариултаа авъя. Тэгээд тодруулна.

Ж.Бат-Эрдэнэ: Бямбацогт. Учрал сайд.

Н.Учрал: Засгийн газрын өр 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 35.7 их наяд төгрөг буюу GDP-гийн 39 орчим хувьтай тэнцэж байна. Тэгэхээр оны төгсгөлд энэ дүн 40 их наяд, 44 хувь руу GDP-гийн 44 хувь руу хүрнэ. Тэгэхээр бид нар Төсвийн тогтвортой байдлын хуулиар ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй гэж заасан байдаг. Тэгэхээр 2026 онд бид төсвийн төсөөлөл дээр ДНБ-ий 27 оноос 45 руу буулгаад ингээд шат шаттай бууруулах арга хэмжээнүүдийг авч байгаа гэдгийг бас хэлье.

Тэр Татварын багц хуулийн шинэчлэлийг Их Хуралд өргөн мэдүүлэх гэж байна. Legal info дээр бараг сар гаруй хэлэлцүүлгүүдийг өрнүүлсэн, саналуудыг авсан. Ингээд энийг бэлтгэхийн тулд сая төсвийн хүрээний мэдэгдэл дээр нэрлэсэн ДНБ тэнцвэржүүлсэн орлогын харьцааг бууруулсан. 37 байсны 30 руу буулгасан. Ингээд энэ орон зайд татварын шинэчлэлийг хийх тэр орон зайг бий болгож байна гэдгийг бас хэлье. Тэгэхээр энэ татварын шинэчлэл хийгдэнэ. Бараг төсөвт 4 их наяд гарсан хэмжээний ачаалал үүсгэнэ.

Тийм учраас эхлээд энэ орон зайг бий болгох хэрэгтэй. Ер нь энэ замбараагүй төлөвлөлтүүд бидэнд ийм саад тотгор учруулж байгаа мөрөөдлийн олон жагсаалтуудыг энэ жилийн төлөвлөгөө, хөгжил хөтөлбөрт тусгаснаас болж хэмжиж болохоо больсон. Тийм учраас энэ удаа таван жилийн чиглэлийг тоон аргыг илүүтэй тавьж, индикатор шалгуур үзүүлэлтүүдийг тусгаснаар энийг эргээд хэмжих бололцоо бүрдэж байгаа юм. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр бол зөвхөн 1 намын мөрийн хөтөлбөр биш 24 онд парламентын сонгуулийн дараа 3 намын мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг нэгтгээд Их Хурлаар баталсан бодлогын баримт бичиг гэж бас ойлгож болно.

Тэр аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр 30 онд бид нар гадаад жуулчдын тоог 2 саяд хүргэнэ ээ гэдэг зорилтыг энэ таван жилийн чиглэл дээр бичсэн байгаа. Тэгэхдээ энэ зөвхөн 2 саяд хүргэнэ гээд зогсох биш энэ тоог ахиулахын тулд аль аль салбар ямар ажил ямар нэгж хувиар хувь нэмрээ оруулах вэ гэдгийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын үр дүн дээр тухайлан бичсэн. Тийм учраас жил болгон энэ тоон үзүүлэлтээр нь хянаад явна.

Аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр хөрөнгө оруулалтын хөтөлбөрт энэ таван жилийн чиглэлийг дагалдуулаад нөгөө нисэх буудлуудыг шинэчлэх төслүүд буюу Хэнтий аймаг, Чингис хаан нисэх буудал, Ховд, Хөвсгөл, Дорнод, Өмнөговь гэдэг гээд энэ аймгууд дээр энэ нисэх буудлуудыг барьж байгуулах асуудлуудыг тусгаж өгсөн гэдгийг бас хэлье. Мөн тэр 4 түвшний үр дүн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Нэмж хариулах уу? Пүрэвдагва гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Ер нь өмнөх нөгөө Засгийн газар маань Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд байхдаа, энэ намын дарга байхдаа Улсын Их Хуралд ялахын төлөө л та бүхэн энэ тоонуудыг авч орж ирсэн шүү дээ. Тэгээд энэний чинь ард түмэн итгээд сонголтоо хийсэн гэж ойлгож байгаа. Одоо тийм учраас жоохон хариуцлагатай баймаар байна. Тэгээд жишээгээр энэ хэдэн эмч 3 мянган эмч, 10 мянган сувилагч, 500 мэргэшсэн асрагч эд нар гээд ингээд аягүй тоогоор ингээд тавьчихсан байж байдаг мөрийн хөтөлбөртөө тусгачхаад тэгээд энэ 5 жилийнхээ энэ чиглэл дээр тусгахгүй байсан юм уу? Тэрийгээ хууль зүйн хувьд тайлбарлаад өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тэгээд 2021 онд батлагдсан таван жилийн чиглэл хуулийнхаа дагуу сонгуулийн циклийн биш үед энэ таван жилийн чиглэл батлагдсанаараа үүнд суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр жилийн төлөвлөгөө боловсруулагддаг. Тэгэхээр бид энэ таван жилийн чиглэлийг илүү удирдамж гэж ойлгох хэрэгтэй. Төсөл, арга хэмжээнүүдийг тухайлан суулгадаггүй. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж явах ёстой. Харин 30 тэрбумаас дээш төслүүд санхүүжилт нь шийдэгдсэн ТЭЗҮ нь боловсруулагдсан мөртөө санхүүжилт нь шийдэгдээгүй бэлэн байгаа гэдэг 3 ангилалд хуваагаад хөрөнгө оруулалтын хөтөлбөр дээр 188 төслүүдийг бичээд явж байгаа. Тэгэхээр саяын таны хэлсэн төслүүд үйл ажиллагааны хөтөлбөрт туссан учраас хэрэгжүүлэх үүргийг Засгийн газар хүлээж байна. Тэгэхээр Их Хурал хяналтаа тавиад явна. Бодлогын чиглэл аль зүг рүү явах вэ гэдгийг чиглүүлж байгаа direction буюу энэ удирдамж гэж хэлж болно оо.

Ж.Бат-Эрдэнэ: 1 тодруулчихсан байх аа. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууна. Дараагийнх нь Мандхай гишүүн. Ренчинбямбын Сэддорж гишүүн алга байна. Энхбатын Болормаа гишүүн алга байна. Даваасамбуугийн Ганмаа. Уучлаарай Болормаа гишүүн. Энхбатын Болормаа гишүүн уучлаарай.

Э.Болормаа: Өдрийн мэнд хүргэе ээ. Өнөөдөр ингээд Төрийн ордонд “Уур амьсгалын өөрчлөлт ба малчин эмэгтэйчүүд” гэсэн чуулган болж байна. Ингээд бас энэ чуулганд оролцохоор хөдөө орон нутгаас зорин ирсэн эмэгтэйчүүдтэй санал, бодол солилцсоны үндэс дээр өнөөдрийн бидний хэлэлцсэн асуудалтай холбоотой 3 зүйлийг тодруулан асууя гэж бодож байна. Энэ таван жилийн үндсэн чиглэл дотор хамгийн чухалчилж байгаа хүний хөгжил гэж байгаа. Тэгээд үүнийг дэмжиж байгаа. Мэдээж эдийн засаг үүднээсээ улс орны хөгжлийн ерөөсөө цөм суурь бол хүний хөгжил. Энэ асуудалтай холбоотой хамгийн том зүйл бол нийгмийн даатгал болон тэтгэвэр тогтоох асуудал байгаа. Энэ бол бид нарын нийгмийн 1 төрлийн гэрээ гэсэн үг.

Тэгэхээр эхлээд асуусан зүйлс юу вэ гэхээр хөдөө, орон нутагт тэтгэвэрт гарч байгаа ингээд хүмүүс их шударга бус байна. Энийг бид олон жил ярьж эхэлсэн. Жилээс жилд төсөв дээр ингээд тэтгэвэр нэмэгдэх асуудал ярьдаг. Ирэх жил 8.6 хувь гэж байгаа нь бага тогтоолгосон хүмүүстээ илүү шударга бус байна. Энийг зөвхөн өнөөдрөөр ярьж байгаа биш ер нь энэ бид нар сүүлийн энэ шилжилтийн үеийн хөдөлмөрийг үнэлж байгаа байдал, түүнээс орж ирсэн НДШ, зарим хэсэг бүлэг хүмүүс нөхөн төлөх энэ гэх гэх мэтчилэн асуудлууд дээр шударга бус нөхцөл үүссэн байна гэдгийг уламжилж энэ дээр таван жилийн үндсэн чиглэл дотроо нийгмийн даатгалын шинэчлэл, тэтгэвэртэй холбоотой ямар зүйлс орсон бэ гэдгийг нэгд асууя.

Үүнтэй уялдуулан 2 дахь асуулт Малчин эмэгтэйчүүд малчны тухай хууль энэ жилийн 1 сарын 1-нээс хэрэгжиж байгаа. Түүнийг даган мөрдөх журмыг Засгийн газар батлах ёстой байтал батлаагүй байгаа тал дээр асуулт асууж байна. Энэ яг боловсруулалт нь ямар шатан дээр явж байна, хэзээ батлахаар бэлтгэгдэж байгаа вэ гэсэн энэ 2 дахь асуулт нь.

Гурав дахь нь мөн хүний хөгжилтэй холбоотой өрх толгойлсон эмэгтэйчүүд дээр онцгойлсон ямар бодлогуудыг энэ таван жилийн үндсэн чиглэлдээ тусгасан бэ гэсэн энэ 3 асуултыг асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Нийгмийн даатгалын шинэчлэлтэй холбогдуулаад бодлогын чиглэл дээр өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээг ажиллагсдын дундаж цалингийн 35 хувьд хүргэнэ ээ гэдэг ийм шалгуур үзүүлэлтийг тусгасан. Тэгэхээр энд хүрэх ёстой. Тэгээд жил жилээр ахиц үзүүлэхийг тухайлан төсвийн ерөнхийлөгч нарын үр дүн дээр бичээд, ерөнхийлөн захирагч нарын үр дүн дээр бичээд хэмжээд явна гэсэн үг. 95 онд манай улс шимтгэлд суурилсан тэтгэврийн тогтолцоонд шилжсэн. Ингээд хагас хуримтлал руу шилжих гээд нэлээдгүй их цаг хугацааг зарлаа.

Гэхдээ бас нийгэм нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хагас хуримтлал руу бас алхсан тодорхой хуримтлалууд явж байна. Одоо бол Засгийн газар хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ингээд олон тулгуурт олон давхаргад төрийн тэтгэврийн тогтолцоо руу шилжиж, энэ хувийн тэтгэврийн сангуудыг байгуулж санхүүгийн захаа дэмжих чиглэл рүү илүүтэй бодлогоо чиглүүлж байна. Тэгэхээр энэ бодлогын чиглэл дээр ч тэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ч тэр тусгачихсан.

Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилт бодлогын чиглэлийн 2.2 дээр суусан. Нийт ажиллах хүчин даатгуулагчийн эзлэх хувь 79 байгааг 5 жилийн дараа гэхэд 86.2-т хүргэнэ. Ер нь энэ таван жилийн бодлогын чиглэл ерөөсөө тийм мөрөөдлийн жагсаалт биш хэт их өөдрөгөөр төсөөлөөгүй, илүү хэмжиж болохуйц байдлаар хандсан гэсэн үг. Тэр өрх толгойлсон эмэгтэйчүүдийн асуудлууд дээр үндсэн чиглэлийн төслийн 3 дугаар хавсралт дээр 7 хоногт 48 цагаас дээш цагаар ажиллагсдын эзлэх хувийг 32.3 хувиас 15 хувьд хүргэнэ. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг гээд ингээд тухайлан энэ өрх толгойлсон эмэгтэйчүүд болоод энэ халамжтай холбоотой асуудлуудыг тусгаад явсан. 24 оны байдлаар нийт 997 мянган өрх байгаагаас 54683 өрх толгойлсон эх,

өрх толгойлсон эцэг 11950 байгаа юм байна лээ. Нийт өрхийн 6.7 хувийг эзэлж байгаа. Үүнийг бууруулах арга хэмжээнүүдийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр тухайлан үүргүүдээ өгөөд явсан. Яг төсөв төлөвлөдөгтэй адилхан эдийн засгийн өсөлт тэр салбарт хэдэн нэгж хувиар хувь нэмрээ оруулах вэ гэдэг шиг салбар болгонд нь эдгээр асуудлуудыг тусгаад явсан.

Малчдыг дэмжих тухай хуулийн энэ журмууд хэрэгжээгүй. Парламентын сонгуулийн өмнө энэ Тэмүүлэн гишүүний тэр Малчны хууль батлагдаад түүнээс хойш журам гарахгүй байна гэдгийг Их Хурал дээр байнга яригдаж байгаа асуудал. Тэгэхээр бид нар энийг бас Засгийн газар дээр ярилцсан. Одоо энэ журмуудыг яаралтай гаргана. Тэгээд ер нь энэ хууль гараад гаргүй, хөлгүй, энэ дүрэм, журам нь байхгүй бол хэрэгждэггүй энэ байдал ер нь Их Хурал дээр ч гэсэн хуулиуд дээр нэг шүүрдэж янзлахгүй бол маш олон хуулиуд ингээд орхигдоод байгаа талтай. Үүнд анхаарч ажиллана.

Ж.Бат-Эрдэнэ: Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: Эхний асуулт дээр тэтгэврийг өмнөх цалингийнх нь 35 орчим хувь байлгах гэдэг ийм зорилтыг хэлж байна л даа. Олон улсын судалгаануудыг харах юм бол ер нь 40-өөс бага хувь руу орно гэдэг бол ахмад настнууд ядуурлын түвшинд аваачиж байх ийм том эрсдэлтэй гэж байгаа юм. Олон улсын сайн жишгүүд ер нь 50-70 хувь руу очих ёстой гэж байгаа юм. Тэгэхээр энэ өнөөдрийн бодит нөхцөл байдал дээр хэцүү байгааг ойлгож байна л даа. Гэхдээ бид нар энэний төлөө гарц шийдлийг хайж эхэлмээр байгаа юм л даа.

Тэгэхээр өнөөдөр НДШ өндөр байна гэж өнөөдөр нийгмийн даатгал төлж байгаа залуучууд хэлж байгаа бол нөгөө талдаа хөдөлмөрөө эрхлээд тэтгэвэртээ гарсан ахмадууд маань энэ түвшин нь амьдралд нь хүрэлцэхээргүй наад захын эмчилгээний төлбөрт нь хүрэлцэхээргүй ийм түвшинд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ завсрыг төсвөөс санхүүжүүлэх ч юм уу өөр гарцуудыг бид нар эрэлхийлэх ёстой. Энэ түвшин үнэхээр хангалтгүй түв.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дахиад тодруулъя Болормаа гишүүн.

Э.Болормаа: Тэгэхээр бид нар энэ дээрээ нэмэлт гарц гаргалгаанууд буюу энэ тэтгэврийн шинэчлэлийг бүүр номер 1-д тавимаар байна. Тэгэхгүй өнөөдөр бид энэ зун, намар ингээд ахмадууд жагсаж байгаа асуудал байна. Энэ дээрээ бид нар ингээд энэ жагсаал намжих биш яаж энэ асуудал шийдэгдэх вэ, яаж энийг шийдэх вэ гэдэг талаас нь хармаар байна. Тэгээд энэ Их Хурал ер нь энэ шинэчлэлийн төсөв дээр оруулж ирэхийг дэмжих байх гэж бодож байна.

Хоёр дахь тодруулах асуудал энэ дагаж мөрдөх журам буюу энэ Малчны тухай хууль дээр яг тодорхой он, сар хугацаатай хэлмээр байна. Улсын Их Хурлаар баталчихсан 1 сарын 1-нээс эхлээд мөрдөгдөх байтал ингээд дагалдсан журмууд нь Засгийн газар дээр гацаад байгаа асуудал одоо бид нар энэ жилийн эцсийг үзэх гэж байна шүү дээ. Тэгэхээр яг он, сар хугацаатай хэзээ дагалдах журам гарах вэ гэдгийг асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: 1 хууль батлагдахаар ер нь багадаа 10-аас дээшгүй журам батлагдах ийм үүргийг хүлээлгээд байдаг. Тэгээд яг Малчдын хууль дээр бараг бүтэн жил яригдаж байна шүү дээ. Тийм учраас бид нар бас Засгийн газар дээр энийг анхаараад энэ оны өмнө энэ журмуудыг гаргаж дуусга гэдэг байдлаар шахна, шаардана гэдгийг бас хэлье. НДШ дээр яг би таны саналтай санал нэг байна. Тэгээд ер нь тэтгэврийн шинэчлэл 1 дүгээр асуудал. Тийм учраас ямар ч байсан одоо энэ хагас хуримтлал руу шилжсэнээ илүү амилуулах хуримтлал дээр хуримтлал үүсгээд байгаа хөрөнгийн менежментийг хийх, түүний хуримтлалаасаа өгөөжийг нь иргэд хүртдэг болохгүй бол одоо тэтгэвэр яг шимтгэл өөрөө НДШ татвар шиг дарамт үүсгэж байна. Тийм учраас хагас хуримтлалыг илүү амилуулахад анхаарна.

Ж.Бат-Эрдэнэ: Даваасамбуугийн Ганбаа гишүүн.

Д.Ганмаа: Үдээс хойшийн мэнд ээ. Энд манай энэ таван жилийн төлөвлөгөө боловсруулж оруулж ирсэнд баяртай байна. Мэдээж энэтэй холбоотой жилийн, 4 жилийн гэх мэтчилэн бодлогууд гарч ирэх бас суурьтай, тийм төсөөлөлтэй болж байна гэж бодож байна. Зүгээр эрүүл мэндийн салбараас яг энэ таван жилийн төлөвлөгөө боловсруулахад яамнаас буюу салбараас ямар төлөөлөл, ямар хүмүүс, ямар мэргэжлийн баг энд оролцсон бол оо гэдэг нэгдүгээрт асуулт байна. Энэ асуулттай холбоотой Эрүүл мэндийн яамнаас ер нь хүн байгаа юм уу, хэн хариулах юм доо? Энэ жишээлбэл манайх эцсийн зорилгоо яг юугаар тодорхойлсон юм, эрүүл мэндийн салбарын чинь эцсийн зорилго нь юу юм? Тэрэндээ хүрэх завсрын зорилго чинь юу юм? Энэ 2-той уялддаг нөгөө блокуудын чинь хоорондын харилцаа хамаарал, санхүүжилт, нөөц, эм гэх мэтчилэн энэ бодлогууд нь огт харагдахгүй байгаад байгаа байхгүй юу.

Энэ эрүүл мэндийн салбар маань бусад салбаруудыг бодвол их онцгой, тусдаа шинжлэх ухаан гэж би сүүлийн жил бараг ярьж байгаа. Бусад зүйлүүдтэйгээ яг адилхан байдлаар оруулж ирэхээр зэрэг дандаа энэ бодлого нь орхигдоод, хаягдаад, тэгээд асуудал гарахаар зэрэг л тэр гал унтраах байдлаар араас нь яваад байгаад их сэтгэл зовж байгаа юм. Тэгэхлээр саяын тэр эцсийн зорилго, завсрын зорилго, тэгээд эрүүл мэндийн гүйцэтгэлийн яг үнэлгээний хүрээ гэдэг юмныхаа системийг бий болгож байж тэрний дагуу энэ төлөвлөгөөгөө боловсруулах ёстой байдаг юм. Health system performance framework гэж бүүр нэрлэдэг, бүх улс оронд л энэ байдаг. Манай улс оронд энийг гаргаж ирсэн юмнууд нь яг яаж явж байна? Тэр нь хөрсөн дээрээ хэр зэрэг бууж байгаа юм? Яаж тусгасан юм?

Хоёрдугаарт, нарийвчлаад асуух юм бол жишээлбэл эрүүл мэндийн хэрэгцээний үнэлгээ гэсэн юм хийдэг. Тэр эрүүл мэндийн хэрэгцээний үнэлгээг манайх хийгдсэн юм байна уу? Байхгүй бол өнгөрсөн, огцорсон Засгийн газарт би Эдийн засгийн яаманд нь энэ судалгааны төсвийг боловсруулаад ингэж хийдэг юм гээд өгсөн байгаа. Энэ ажил дараа дараагийнхаа Засагт ороод явж байгаа юу? Хэр зэрэг явцтай байж байна аа? Тэрийг эхлээд асуучихъя даа.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Учрал сайд.

Н.Учрал: Энэ таван жилийн бодлогын чиглэлийг боловсруулахад Эрүүл мэндийн яам оролцсон. Мөн Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв,

Эмийн агентлаг, Эрүүл мэндийн даатгалын газар, мөн ШУА, Анагаах ухааны хүрээлэн гээд олон талын оролцоог хангаж боловсруулсан. Анагаах ухааны үндэсний их сургууль бас мөн оролцсон байгаа. Эрүүл мэндийн салбарт халдварт өвчний тоог бууруулна гээд илүү хэмжиж болохуйцаар тавиад ингээд явж байгаа зорилгууд дээр нь яг тухайлсан зорилтуудыг тавиад явж байгаа. Тэрнээс биш төсөл, арга хэмжээнүүд мэдээж нөгөө жилийн төлөвлөгөө дээрээ тусгагдаад явна.

Жишээ нь, хорт хавдраар нас барсан хүний тоо гээд 13.2 дээр байгаа. Энийг яг ингээд жил жилээр хэд хэдэд хүргэх вэ гэдгээр хэмжээд явсан гэсэн үг. Эрүүл мэндийн салбараас үндсэн чиглэлийн төслийн хавсралт 3.1.2 дээр та харж байгаа байх 30 онд хорт хавдрын нас баралт 10 мянган хүн ам тутамд 13.2 байгааг бид нар таван жилийн дараа л 8 болгож бууруулна. Үүнийг хийхийн тулд салбар ямар ажлуудыг хийх вэ гээд тухайлсан ажлуудыг нь тавьж өгөөд, дээрээс нь хөрөнгө оруулалтын хөтөлбөр дотроо 7 төслийг тавьсан. Ингээд тэр өвчний тоог бууруулахын тулд Зүрх судасны үндэсний төв, Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах төв, ХӨСҮТ 2, ХСҮТ 2, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, аймгууд буюу 17 аймгийн нэгдсэн эмнэлгийг сайжруулах, нөгөө яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийг өргөтгөнө гэдэг байдлаар.

Тэгэхээр ер нь бодлогын чиглэлийн гол онцлог бол яг үндэсний үр дүнгийн 10 үр дүн байгаа юм. Үндэсний үр дүн гээд. Энэ үндэсний үр дүнд салбарын үр дүнгүүд хэрхэн нөлөөлөх вэ, салбарын үр дүнг хэрэгжүүлэхийн тулд төсвийн ерөнхийлөн захирагч нар ямар үр дүнд хүрэх вэ? Үүнийг хэрэгжүүлэхийн тулд ямар ямар төслүүдийг хэрэгжүүлэх вэ гэдгийг нь хөрөнгө оруулалтын хөтөлбөр дотроо тусгагдаад явсан.

Мөн энэ таван жилийн чиглэл дээр анхан шатын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх 2 тухайлсан зорилтууд байгаа. Тэгээд үүн дээр яг хийх ажлууд нь ингээд жил жилээрээ та бас хавсралтаар харах юм бол тусгагдаад явсан учраас бид нар ирэх жил төсөл, арга хэмжээний процессыг үнэлэхгүйгээр үнэхээр тэр өвчний нас баралтын тоог хэдээр бууруулсан бэ гэдэг тэр хувийг нь үнэлээд ингээд төсвийн ерөнхийлөн захирагчид ажлаа хангалттай хийсэн гэдгийг нь үнэлээд явах ийм шинэ жишиг рүү бид нар явж байгаа. Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж, үйлчилгээний хамралт бол 65 хувь байгаа. Энийг бас 68 хувьд хүргэх бас зорилт мөн давхар туссан.

Ж.Бат-Эрдэнэ: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Харин Ки Пи Ай-уудыг яах вэ би харж л байна л даа. Сая таны авсан жишээ, эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж, үйлчилгээний хамралтын хувь, одоогийн түвшинд 65, 30 онд 68 болгоно гээд. Тэгвэл ДЭМБ-ын дата мэдээлэл ил байдаг. Тэрийг харахаар Монгол Улсын үзүүлэлт уул нь 2019 онд энэ чинь 67 байсан байхгүй юу. Тэгсэн чинь 21 онд 65 болоод буурчихсан. Ингэхээр бид нар хөгжөөд байна уу ухраад байна уу? Тэгээд энэ Ки Пи Ай-уудаа нөгөө дордуулж суурь түвшнээсээ дордуулж орж ирээд байгаад асуудал байгаа. Энэ тэгэхдээ харьцангуй майнер буюу жижиг асуудлууд. Миний гол хэлэх гээд байгаа юм нь Ки Пи Ай тавихаасаа өмнө энэ эрүүл мэндийнхээ тогтолцоог нь нийт хүрээнийх нь хувьд нь үнэлж байж тэгээд тус бүрд нь оруулж ирэхгүй бол бид нар дандаа ингээд асуудлыг хайсан, тусдаа ар араас нь ингэж хөөсөн л юм болчихоод

байна л даа. Тэгэхийн тулд л би энэ салбарынхан орж ирсэн юм болов уу. Түрүүн би асуусан шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн энэ дээр хариулаадах даа.

Н.Учрал: Бид нар нөгөө хянаад, үнэлээд, мониторинг хийж байгаа эрх бол сая Эдийн засаг, хөгжлийн яаманд ирсэн. Тэгэхээр бид нар таван жилийн бодлогын чиглэлээр боловсруулсан учраас эргээд үнэлэх учраас Ки Пи Ай-уудыг илүү тэр хэмжиж болохуйц, тодорхой цаг хугацаатай, бодитой байлгах дээр анхаарсан. Салбарын яам өөрсдөө нөхцөл байдлынхаа шинжилгээг хийгээд саналаа бид нарт боловсруулж оруулж ирсэн. Тэгээд яг би тантай санал нэг байгаа. Тогтолцооны хувьд өөрчлөлт хийхгүй бол бидний энэ тавьсан Ки Пи Ай-уудыг эргээд үнэлэхэд үнэлгээ бид нар процесс үнэлэхээ больж байгаа учраас үнэлгээ хангалттай сайн гарахгүй. Тэгэхээр ирэх жил эргээд үнэлэгдэхэд бэрхшээлтэй. Эрүүл мэндийн салбарт бид нар нийт 11 дүнг тодорхойлчихсон. 11 үр дүн хүрсэн үү, хүрээгүй юү гэдгээр ирэх жил хэмжээд эхэлнэ. Тэгэхээр салбар энэ үр дүнд хүрэхийн тулд тэр тогтолцооныхоо шинэчлэлийг хийх үүрэгтэй. Чадахгүй бол хангалтгүй гээд л үнэлэгдэнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Энэ өдрийн мэндийг хүргэе. Би юу яах гэсэн юм. Эдийн засаг, хөгжлийн яамны сайдаас энэ сүүлийн 2021-2025 оныг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, тайлан дээр болохоор 67.7 хувь гээд гарчихсан. Гэхдээ үүнийх нь 20 хувь нь яг одоо хэрэгжээд дуусаагүй байгаа ажлууд байгаа юм байна. Тэгэхээр түрүүн та хэлсэн яг манай яамны судалгаагаар бараг 50 хувьтай хэрэгжсэн. Тэгэхлээр энэ хэрэгжээгүй төлөвлөгөөгөө яах вэ? Үргэлжлүүлэх юм уу, эсвэл шинээр төлөвлөөд хэрэгжээгүйг нь орхиод явах юм уу? Энэ дээр яг ямар бодлого баримталж энэ таван жилийн төлөвлөгөөндөө баримталж байгаа вэ гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, би Эдийн засаг, хөгжлийн яамны сайдад бас захимаар байна. Шинжлэх ухаан манай хөдөө аж ахуйн гол шинжлэх ухааны хүрээлэнгүүд Эдийн засаг, хөгжлийн яаман дээр байдаг. Гэвч ирэх 5 жилийг тодорхойлохдоо ахиад ийм системтэй, зүгээр ийм гоё, лоозонтой, ийм өргөн хүрээтэй, нарийвчлагдаагүй, ерөнхийлсөн ийм ажлуудыг төлөвлөмөөргүй байгаа юм. Хөдөө аж ахуйн салбарыг эдийн засгийн тулгуур салбар болгож хөгжүүлэе ээ гэх юм бол тогтолцоогоор нь өөрчилж харахгүй бол болохгүй байгаад байгаа юм. Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний экспорт сүүлийн 5 жилийн хугацаанд 2020-24 онд жишээлбэл -0.6 хувьтай, 2023 онд 3.4 хувьтай, 2024 онд 2.8 хувьтай байгаа юм. Бодит дүнгээрээ ер нь бүтээгдэхүүний экспорт буурч байгаа.

Нөгөө талдаа хөдөө аж ахуйн төсөв сүүлийн 5 жилийн хугацаанд 1 дахин өссөн буюу 2 их наяд төгрөг бид нар зарцуулчихсан байгаа. Хөдөө аж ахуйн салбарын бүтцийг хараад үзэх юм бол, төсвийн бүтцийг харах юм бол төсвийн 60 хувь нь нөгөө бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хөнгөлөлт, татаас, урамшуулал бүгд орж байгаа. Тэгэхээр 1 талдаа бид нар ингээд төсвөө нэмээд байгаа, дэмжлэг үзүүлээд зээлээр хөрөнгө оруулалтад зарцуулаад байгаа юм шиг боловчиг нөгөө талдаа ерөөсөө энд хүнсний нийлүүлэлт нэмэгдэхгүй байна. Тэгэхээр энэ бүтээгдэхүүн чинь олшрохгүй байна. Бид нар

ерөөсөө импортоос хараат улс болж байгаа гэдгийг би онцолж хэлмээр байгаа юм. 49 хувь нь импортоор бид нар эрэлтээ хангаж байна хүнснийхээ.

Тэгэхээр энэ хүнсний бүтээгдэхүүний индекс одоо яагаад хэрэв нийлүүлэлт нэмэгдсэн бол үнэ буурах ёстой. Гэтэл 86 функтээр нэмэгдсэн байгаад байгаа хүнсний бүтээгдэхүүний индекс. Тэгэхээр энэ дотоодоосоо нийлүүлэлтийг хангах, чанарт суурилсан нөгөө үнийн тогтолцоо, өртгийн сүлжээ өсгөх, бүтээмж гэдэг асуудлууд ер нь орхигдчихсон байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хөдөө аж ахуйн салбарыг бүүр углуургаар нь дахиж бүүр реформ хийж ингэж тогтолцоогоор нь өөрчлөхгүй бол бид нар маш их хэмжээний мөнгө. Улсын төсвөөс татвар төлөгчдийн мөнгийг үргүй зараад л байдаг зараад л байдаг хүнсний дотоодын үйлдвэрлэл нэмэгдэхгүй нийлүүлэлт хангагдахгүй яваад байгаа. Тэгэхээр энэ дээр ирэх 5 жил Эдийн засаг, хөгжлийн яам шинжлэх ухаанд суурилсан шинжлэх ухааны хүрээлэнгүүд нь байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам илүү эдийн засгийн ийм тулгуур салбар болгож хөгжүүлэхийн тулд юуг тусгасан юм бэ гэдгийг би асуумаар байгаа юм. Ингээд 2 асуулт.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн.

Н.Учрал: Энэ 24 оны сонгуулийн дараа байгуулагдсан Засгийн газар бүтэц, бүрэлдэхүүний хуульдаа өөрчлөлт оруулаад шинжлэх ухааны салбарыг Эдийн засаг, хөгжлийн яаманд харьяалуулсан. Хөгжлийн бодлогын баримт, бичгүүдийг боловсруулдаг яам нь шинжлэх ухааныхаа салбарыг удирдах нь өөрөө ач холбогдолтой юм гэдгийг сая энэ таван жилийн чиглэл боловсруулахад би бас өөрөө олж харлаа. Яагаад вэ гэхээр энэ таван жилийн чиглэл ШУА-ийн оролцоотойгоор бичигдсэн. Бага чуулганы салбаруудаар манай төрийн захиргааны төв байгууллагынхан очоод нөхцөл байдлаа, дүн шинжилгээгээ танилцуулаад ингээд шинжлэх ухааны салбар оролцсон. 6 бага чуулганаар хэлэлцээд ШУА-ийн Их чуулганаар хэлэлцэж баталсан. Тэгэхээр анх удаа бид нар таван жилийн чиглэл, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр ч бай, бодлогын баримт бичгүүдийг боловсруулахад шинжлэх ухааны салбараа дайчилж ажиллаж чадсан.

Тийм учраас энэ олон хүрээлэнгүүд олон олон салбарын хүрээлэнгүүд хэдий ч энэ шинжлэх ухааны салбар хэрэглээний судалгаа хийх үүргийг хүлээж байгаа учраас нэг газраа төвлөрөх нь ач холбогдолтой. Хэрвээ хүрээлэнгүүд салбар салбар руу шилжвэл бас 1 улс бол хэрэглээний судалгаагаа хийх ч нөхцөл байдалгүй болоод ингээд салбар болгоны өдөр тутмын асуудалд туслалцаа үзүүлдэг ийм байгууллага болчих эрсдэлтэй юм байна гэж ер нь том агуулгаараа харж байгаа юм.

21-25 оны таван жилийн чиглэл байгаа. Энэ таван жилийн чиглэл дээр нийцлийг нь харж бид нар шинэ төслөө боловсруулсан. Аудитын дүгнэлт гарсан хэдий ч хэрэгжиж дууссаны дараа үр дүнг нарийвчлан дүн шинжилгээ хийх ёстой. Зарим нь нөгөө хугацаа нь бас болоогүй учраас хэрэгжээгүй гэдэг ийм үр дүн гарчихсан байгаа юм. Тэгэхдээ хэрэгжиж дуусах хугацаа нь дууссаны дараа үнэлгээ өгнө.

21-25 оны таван жилийн чиглэлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хавсралтад нийтдээ 73 төслийг бид нар энэ таван жилийн чиглэл рүү татаж авч

оруулсан. Энэ дээр юу вэ гэхээр санхүүжилт шийдвэрлэгдээгүй мөртөө хэрэгцээ шаардлагын хувьд өндөр, сошиал тэр импакт өндөртэй төслүүдийг ангилаад хэрэгжиж байгаа төслүүдээс нь 20, санхүүжих эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай төслүүдээс 20, ТЭЗҮ, зураг төсөл хийх шаардлагатай төслүүдээс 13 төслийг татаж авсан. Хэдийгээр санхүүжилт, ТЭЗҮ аль аль нь хийгдээгүй ч гэсэн 13 төслийг авч явахгүй бол салбарын үр дүнд нөлөөлөх, заавал тэрийг явуулж байж тэр салбарын үр дүн буюу дээрээс нь үндэсний үр дүнд нөгөө индикатор дээр нь ахиц үзүүлэх шаардлагатай учраас заавал татаад явсан гэдгийг бас хэлье. Тэгээд хөдөө аж ахуйн бодлогын асуудал дээр Энхбаяр сайд хариулна.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд. Энхбаяр сайдын микрофон.

Ж.Энхбаяр: Хариулъя аа. Мандхай сайд ер нь үг хэлэх болгондоо хөдөө аж ахуй сүүлийн 5 жил уруудаад байна гэж яриад байх юм. Хаанаас ямар тоо авч юу гараад байгааг нь ерөөсөө ойлгохгүй юм. Монгол Улсын Статистикийн ерөнхий газрын мэдээ өөр л заагаад байх юм. 2020 онд хөдөө аж ахуйн салбарын ажиллах хүчний тоо 525 байсан. 24 жилээр тэр 652 мянга болж өссөн. Энэ 120 мянган хүн хаанаас гараад ирэв? Хөдөө аж ахуйн экспорт 2020 онд 421 байсан. Одоо 977 сая 1 дахин нэмэгдчихээд байна шүү дээ. Зөвхөн энэ онд гэхэд ажиллахгүй биш 48 мянгаар нэмэгдчихээд байна. Сая ноолуурын, боловсруулсан ноолуурын экспорт өнгөрсөн оны мөн үеэс 5 дахин нэмэгдчихээд сая өнөөдрийн тоо гарч байна. Энэ чинь 100, 100 сая доллароор өсөж байна шүү дээ. Тэгээд энэ өсөлтөө баталгаажуулахын тулд энэ бодлого.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Цаг нэмж өгье, минут нэмж өгье.

Ж.Энхбаяр: Энэ амжилтаа бататгахын тулд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийнхэн, боловсруулалтын хүчин чадлыг 50 хувиар нэмнэ ирэх таван жилийн дотор гэсэн л зорилт тавилаа. Энэ дотроо энэ маань өөрөө маш олон гүнзгий агуулгатай. Мал аж ахуй, газар тариалан, бэлчээр ашиглалт, усжуулалт, үр сорт, хөрс хамгаалал, ашиг шимт мал сүрэг, үржил селекц ингээд хүнс, хөнгөн үйлдвэрийн боловсруулалтын түвшин, экспорт гэсэн бүтэн хүрээг хамарсан энэ чинь 10 гаруй том бодлогын асуудлыг оруулж ирж байгаа зүйл шүү дээ. Энэ 3 минутад багтааж хариулах бололцоо алга. Өөдрөг байгаа. Танд арга ухаан, мэргэн санаа байвал тэрийгээ санаа гаргаач. Ерөнхий л хоосон ингээд дайраад байх юм. Ингэж өөрчилмөөр байна энийг нь, ингэж бодлого гаргамаар байна гээд ажил хэрэгч санал ярь л даа. Тэр чинь л хэрэгтэй байна шүү дээ. Тэрийг чинь хүлээгээд байна шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Мандхай гишүүн нэмэлт цаг.

М.Мандхай: Тоо худлаа ярьдаггүй тэгээд тийм учраас би Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуугаад байгаа юм. Арай эдийн засаг суурьтай салбарын хөгжлийг бүтцээр нь өөр түвшинд харах учраас би мэргэжлийн яамнаас нь асуугаад байгаа юм. Шинжлэх ухаанч яг Шинжлэх ухааны хүрээлэн нь өөрөө дэргэдээ байгаа учраас. Хэрэв өнөөдөр нийлүүлэлт нэмэгдсэн бол яагаад хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөөд байгаа юм бэ гэдгийг энгийн би зүгээр зүгээр л supply demand-аас би зүгээр эдийн засгийн энгийн би ойлголт асуугаад байх юм. Нийлүүлэлт өнөөдөр нэмэгдээд сүүлийн 5 жилийн хугацаанд улсын төсөв 1 дахин нэмэгдсэн. Экспортын чинь дундаж нэгжийн үнэ унаад байгаа -0.06 хувь уначихсан

байна. Яагаад өнөөдөр тэгвэл импорт, хүнсний импорт жил ирэх тусам нэмэгдээд тэгсэн мөртөө хэрэглээний үнийн хэрэглээний индекс өөрөө 61 функтээр нэмэгдчихсэн хүнсний үнийн бүтээгдэхүүний индекс чинь 86.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс хэн хариулах юм? Ж.Энхбаяр. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Эдийн засаг чинь сүүлийн хэдэн жил бараг 3 дахин тэлчихлээ шүү дээ. Орлого нэмэгдчихлээ, хэрэглээ өсөж байна. Хэрэглээгээ дагаад импортын тоо чинь хэрэглээний импорт өндөр гараад байна шүү дээ. Нөгөө талаас дотоодын үйлдвэр, нийлүүлэлт тасралтгүй нэмэгдэж байна. Газар тариалан өсөхгүй байна гэдэг, өссөнгүй, мөнгөнийхөө хэмжээнд өссөнгүй гэж яриад байх юм. Хүний иддэг гурил хэрэглээний хэмжээ тэр тогтсон түвшиндээ л байгаа шүү дээ. Амьдрал сайжирсан гээд 3 дахин илүү гурил идэхгүй шүү дээ. Тэр орлого нь бусад хэрэглээ рүүгээ гараад байгаа байхгүй юу даа. Бусад өөр сонголт руу яваад байна шүү дээ. Зөвхөн Хүнсний хувьсгалын үр дүнд гэхэд сая бид нар статистик гаргаж байлаа. 53 шинэ үйлдвэр шинээр, цоо шинээр бий болоод 1000 гаруй бүтээгдэхүүн шинээр худалдаанд нийлүүлэлтэд оччихсон байна шүү дээ. Тэгэхээр энэ ажлын хэсгийн манай хөдөө аж ахуйн энэ академийн улсууд хариулаач энэ салбар унаад байгаа юм уу. Энэ хүний яриад байгаа үндэслэлийг нь тайлбарлаад өг.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд.

Н.Учрал: Өмнөх 2 жилд зуд гээд бас унаснаа бодох юм бол хөдөө аж ахуйн салбар 36 хувиар өссөн. Тэгээд энэ өнгөрсөн 2 жилд энэ чинь бас уналттай байсан. Тэр өссөн гэвэл тоон дээрээ яривал өссөн. Тэгэхдээ мэдээж бид нар хөдөө аж ахуйн салбарт цаашдаа олон татааснуудыг өгдөг. Энэ татаас болгон дээр эксит стратегийг бас гаргах хэрэгтэй. Тэгээд олон тулгуурт болгох хэрэгтэй. Энэ гадаад худалдааны хийж байгаа олон хэлэлцээрүүд байна. Энэ Евро Азийн хэлэлцээрийг ч гэсэн Их Хуралд оруулж ирнэ. Хөдөө аж ахуйн бараа экспортод гаргах, стандартыг хангуулах ажлууд байна. Тэгээд олон асуудлууд байгаа юм. Ингээд шат шатдаа шинэчлээд явна. Тооны хувьд өмнөх 2 жилд байснаас өсөлттэй байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Банзрагчийн Түвшин. Түвшин гишүүн.

Б.Түвшин: Та бүхэндээ оройн мэндийг хүргэе. Тэгэхлээр 26-30 оны хөгжлийн үндсэн чиглэлд тулгуурласан төлөвлөгөө ярилцаж байна. Тэгэхлээр энэ төлөвлөгөө яах вэ ерөнхий загвар, модель аягүй харьцангуй бас гайгүй байна гэж ингэж үзэж байна. Тэгээд эндээс бас хэдхэн асуулт асууя. Ер нь 26-30 оны хөгжлийн үндсэн чиглэлд орлогын урт хугацааны стратегийг тухайлбал, татварын суурь орлогын төрөлжилт, мэдрэмжийн үнэлгээ ер нь энэ тусгагдаагүй харагдаад байгаа юм. Тэгэхлээр ер нь энэ орлогын, төсвийн орлогын стратегийг юу гэж харж байна? Энийг ямар бичиг баримттай уялдуулж хэрэгжүүлэх вэ гэдэг нэгдүгээр асуулт ийм байна.

Хоёрдугаарт, энэ орлогын хэлбэлзлүүд байгаа. Бид нар сая өнгөрсөн 2,3-хан жил гэхэд л төсвийн орлогыг маш их хэлбэлзэлтэйгээр баталж байгаа. Тэгэхлээр энэ хэлбэлзлийг бууруулах ямар зорилго байна? Ямар санхүүгийн нөөц хүрээ байна? Ямар тоон зорилгууд тавьсан бэ гэдэг хоёрдугаар асуулт.

Гуравдугаарт, ер нь манай улсад НӨАТ, онцгой гааль гэх мэтийн ийм шууд бус татварууд нь орлогын 60 гаруй хувийг эзэлж байгаа. Ер нь олон улсын жишгээр шууд татварууд, шууд бус татварууд 50, 50 хувьтай байдаг. Тэгэхлээр энэ шууд татварыг нэмэгдүүлэх ямар бодлого байна? Шууд бус татварыг бууруулах ямар бодлого байна? Энэ хоёрыг ер нь тэнцвэржүүлэх тийм зорилтоо юу гэж тодорхойлж байгаа вэ гэдэг ийм асуудал байна.

Дараагийн асуулт болохлоор энэ орон нутгийн татварын бие даасан байдлаар. Тэгэхлээр ер нь бид нар олон олон газрууд руу татаас, татварыг өгч байна. Орон нутгуудын татварыг бий болгох өөрсдийн татвар хуваарилалтыг бодитойгоор өргөтгөх ямар бодлогуудыг явуулж байна вэ? Цаашдаа энэ орон нутгууд ер нь эдийн засгийн хувьд бие даах бодлого явуулж байгаа юу, энэ дандаа татаастай хэлбэрээрээ явах юм уу гэдэг ийм асуудал байна.

Макро бодлогын хувьд Сангийн яам Монголбанкны мөнгөний бодлого төсвийн бодлого 2-ыг хэрхэн уялдуулж хангаж ажиллах вэ? Энэ олон улсад ийм платформ гаргачихсан хоёулаа дандаа хослуулаад явдаг ийм аргууд хэрэглэж байгаа юм байна. Манай дээр ер нь энэ төсвийн бодлого, мөнгөний бодлогын уялдаа, хамтын хяналт, хариуцлагын тогтолцоог ер нь боловсруулж байгаа юу гэдэг ийм асуулт байна.

Санхүүгийн тогтвортой байдлын хувьд бас асуултыг тодруулчихъя гэж бодож байна. Ер нь ОУВС, Швейцарын Засгийн газрын зэрэг улсууд төсвийн эдийн засгийн бодлогын эрсдэлийг бүртгэдэг. Тэгээд ийм бодит цагийн хяналтын системтэй байгаад байгаа юм. Бид нарт ер нь энэ төсвийн эрсдэлийг бүртгэх тийм хяналтын систем, тогтолцоо боловсруулж байгаа юу гэдэг нэг ийм асуудал асуултыг хариулья.

Техникийн шинжтэй 2 санал байгаа. Ер нь энэ 26-30 онд иргэдээ орлоготой байлгах, ер нь эдийн засгийн чухал чухал асуудлуудыг тусгасан. Тухайлбал, Завхан аймгийн Арцсуурийн боомтын зам бол энэ орно оо гээд ингээд тусчихсан байгаа. Тэгэхдээ тэр боомтынх нь энэ ажил нь төсөв, төлөвлөгөө нь гарчихсан, батлагдчихсан байгаа учраас тэр боомтын ажлыг нь нэмээд тусгаарай гэдгийг сануулж хэлье. Ингээд саяынхаа асууж байгаа 7 асуултдаа хариулт тавья.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд хариулья.

Н.Учрал: Мэдээж эдийн засгийнхаа бүтцийг харахад цөөхөн хэдэн бүтээгдэхүүнээс, уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай эдийн засаг бол энэ орлого дээрээ зөв стратеги боловсруулахгүй бол байнга ингээд хэлбэлзэж байна л даа. Тийм 5 сард баталсан төсвийн хүрээ гэхэд л сарын дараа зайлшгүй өөрчлөгдөх шаардлага үүсдэг. Экспортолж байгаа бүтээгдэхүүн, тэр дундаа тэр нүүрснийх нь үнэ нь өдөр бүр бараг хэлбэлзэж байгаа тэр цаг үеүүд таарчихаар зайлшгүй өөрчлөөд явахаас өөр сонголтгүй болж таардаг. Тэгэхдээ ирэх жил бид нар экспортод нүүрсийг 80 сая тоннд хүргэнэ гэж бас зорьж байгаа мэдээж.

Тэгэхээр энэ бас төсөөлөл, өөдрөг төсөөлөл. Энэ удаа төсөв дээр ч гэсэн мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэе ээ гээд зорьсон юм. Би ер нь эргээд харахад энэ орлого дээр тэнцвэржүүлсэн орлого ДНБ-ий харьцааг л буулгасан нь л одоо их

том алхам боллоо гэж харж байгаа юм. Одоо 30 хувь руу орсон. Тэгээд ирэх 28 онд энэ 28 руу ороод ирэхэд орон зай бий болно. Тэгэхдээ энийг зүгээр орхиж болохгүй. Энэ татварын багц хуулийг батлах ёстой.

Дээрээс нь энэ тохиолдолд нөгөө хувийн хэвшил дээр үүсээд байгаа ачааг багасгах ёстой байгаад байгаа юм. Тийм учраас энэ Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Хөрөнгө оруулалтын хууль, энэ Зөвшөөрөл, мэдэгдлийн хууль, энэ 120 хууль чинь ерөөсөө л энэ чиглэл рүү илүүтэй хандаж байгаа. Тийм учраас бид нар эдийн засгийнхаа сууриа өргөтгөх чиглэл рүү анхаарах ёстой, тэлэх хэрэгтэй. Хувийн хэвслээ дэмжих тодорхой үр дүн гаргах салбаруудыг анхааръя, уул уурхайн бүтээгдэхүүнээр нь төрөлжүүлэх хэрэгтэй. Ер нь алт, зэсийн агуулга нэмэгдэж байгаа учраас л бид нар эдийн засгийн өсөлтийг бас харьцангуй өндөр төсөөлөөд байгаа болохоос биш энэ ажил хийгдэхгүй бол угаасаа явахгүй. Тийм учраас алт ч бай, зэс ч бай дээрээс нь нөгөө “Орано”-тай хийсэн хөрөнгө оруулалтын гэрээ, сая Солонгост бид нар хөрөнгө оруулалтын том форум хийсэн. Энэ үеэр нэлээн олон хөрөнгө оруулагч нараа бас тохиролцоонд хүрч байгаа газрын ховрыг ашиглах чиглэлээр.

Тэгэхээр ер нь энэ уул уурхайн эдийн засагтай орон бол бүтээгдэхүүнээр нь төрөлжүүлэх бодлогоо барьж ажиллах ёстой гэж ингэж бид нар зорьж байгаа. Тийм учраас хөрөнгө оруулалтын энэ хөтөлбөр дээр ч гэсэн энэ боловсруулах үйлдвэрүүдийг дэмжье гэдэг чиглэлээр боловсруулах үйлдвэрийн төслүүдийг илүүтэй тусгаж өгсөн. Ер нь нэмүү өртөг шингээх бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэл рүү анхаарах ёстой. Хувийн хэвшил ч гэсэн яг энэ зах зээлд чөлөөтэй өрсөлдөөд ингээд төрөлжүүлж орж ирж байж үр дүн гарна. Тийм ч учраас зарим зөвшөөрлүүдийг мэргэжлийн холбоонд нь шилжүүлэх, зарим жишээ нь зөвшөөрлийн хугацааг нь уртасгаж өгөх, зөвшөөрлийг заавал дахиж материал бүрдүүлэхгүйгээр сунгах гээд хүнд суртлыг бууруулах ажлуудыг.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Н.Учрал: Ер нь тэгээд эрэлтийн гаралтай бид нар инфляцтай тэмцэх ёстой. Тэгэхээр цаашдаа мэдээж Төв банк хараат бусаар мөнгөний бодлогоо бариад ажиллаж байна. Тэгээд Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам Засгийн газраас ийм мөчлөг сөрсөн бодлого гээд ингээд төсөв баталчихсан, төрийн оролцоо бууруулна гэхихсэн. Ер нь эргээд үлдэх нь зөвхөн тэр орлого GPD-гийн харьцаан дээр л байгаад байгаа юм. Тэгээд тэр орон зайн дээр бид яах вэ гээд. Түүн шиг Засгийн газар гүйцэтгэх засаглал өөрөө тэр гааль дээр үүсээд байгаа, хил боомтууд дээр үүсээд байгаа хүнд суртлуудыг буулгаад эхлэхэд гэхэд л яг Ганцмод-Гашуунсухайт дээр нөгөө хэдэн километр очерлодог машин тэрэг байхгүй болоод л, 6, 7 буудаг нь байхгүй болоод л, 2 тал мэдээллийн солилцоо ч гэдэг юм уу ер нь орлого нэмэгдүүлэх ажлууд ингээд үе шаттайгаар ингээд хийгдээд явж байна. Бид нар энэ зорилтдоо хүрэхийн тулд бас ажиллана.

Ж.Бат-Эрдэнэ: Түвшин гишүүн тодруулъя.

Б.Түвшин: Ер нь энэ төсвийн орлогыг, хэлбэлзлийг тогтворжуулах, асуудлыг тоогоор, зорилтын хувиа гаргаад, тэгээд тогтворжуулалтын механизмыг хариуцах институтийг нь ингээд энэ төлөвлөгөө дээрээ тодорхой болгоорой гэдэг энэ чиглэлийг бас өгөх нь зүйтэй байх. Төсвийн орлогын яг тодорхой стратегигүй

байгаад байгаа. Төсвийн орлогын тодорхой өсөлтийг хангадаг институтын үндэс суурийг бас энэ төлөвлөгөө дээр бас зайлшгүй тавих шаардлагатай байгаад байгаа.

Гуравдугаарт, тэр орон нутгийн бие даасан байдал дээр ер нь орон нутгийн эх үүсвэр татварын хуваарилалтын бодитойгоор ийм өргөтгөх бодлогыг эхлэх Ки Пи Ай-уудыг бид нар энэ төлөвлөгөө дээрээ тусгаж өгч байж цааш цаашдаа явахгүй бол ерөнхийдөө энэ талаар туссан зүйл байхгүй байгаад байна.

Ялангуяа энэ төсвийн болон мөнгөний бодлогын асуудал дээр макро эдийн засгийн хувьд Их Британийн жишээ байгаад байдаг юм байна. Тэгэхлээр энэ чинь нөгөө бид нар инфляц ярихаараа Монголбанктайгаа ярьчихаад байдаг, төсөв санхүү ярихаараа, зарлагын асуудлаа ярихаараа Сангийн яамтайгаа ярьчихдаг. Энэ 2-ыг холбосон.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэлэв үү? Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Учрал сайдад баярлалаа. Өмнөх таван жилийн үндсэн чиглэлээс хамаагүй сайжирсан. 2 дугаар хавсралт дээр 330 хүрэх үр дүнтэй энэ өрх бүрдээ ямар арга замаар хүрэх гэж байгаа, энийг хэн үндсэн хариуцагч нь юм, хэн хамтран хариуцагч нь юм гэдгийг төсвийн ерөнхийлөн захирагч нар тус бүрээр нь гаргаж өгсөн байна. Маш зөв. Хавсралт 3-ыг бас анхаарах ёстой 426 шалгуур үзүүлэлт байна.

Суурь түвшин гээд тавьж байгаа жил жилээр нь зорилтот түвшин гээд тодорхой гаргаад тавьсан байна. Сайшаалтай байна. Чуулганыг үзэж байгаа хувийн хэвшлийнхэн, мөн салбаруудад ажилладаг мэргэжлийн хүмүүс, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд энэ таван жилийн үндсэн чиглэлийг уншиж үзэхийг хүсэж байна. Өмнөх таван жилийн чиглэлүүдээс хамаагүй ахицтай гарч байна. Төлөвлөж сурч эхэлж байна. Хийж чаддаг байсан юм байна шүү дээ. Жил хагас шахуу ярилаа. Тэгээд сайн ажиллаад гаргаад ирж байна. Учрал сайдад дахиад баярлалаа.

Бодитой зүйлүүдийг дурдъя. 7.3.3.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт болон төсөвлөлтийн уялдааг сайжруулна. Арга зам нь бодлого төлөвлөлт, төсөвлөлтийн нэгдсэн удирдлага бий болгоно гэж.

6.2.1.1.Хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулна гээд үүндээ PM2.5, 10 азот, хүхэр бүгдийг нь тусгаж өгсөн байна. Ажил хийж чаддаг юм байна шүү дээ. Өмнө нь яагаад хийдэггүй байсан юм бол гэдэг эргэлзээ бас ингээд хэвээрээ үлдэж байна гэхдээ.

4.4.1 дээр инженерийн дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна. Нэгдсэн төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлнэ гэж байна. Бат-Амгалан сайдад баярлалаа. Хот байгуулалтын салбарт ялт ч үгүй энэ дутуу байгаа газраа тусад нь төлөвлөдөг, барилгаа тусад нь төлөвлөдөг, замаа тусад нь төлөвлөдөг эд нарыг бүгдийг нь нэгтгээд явна гэж байгаа бол маш зөв зорилго, зорилт тавьсан байна.

Ерөнхий сайдаас асуулт байгаа юм уг нь. Байхгүй болохлоороо өөр хүн хариулах болов уу даа тээ? Бид нар энэ таван жилийн үндсэн чиглэлээ баталлаа.

Хэрвээ таны хариуцаж байгаа яамнуудын сайд нар энэ зорилтот түвшиндээ жил бүр хүрч чадахгүй сайд нартайгаа хариуцлага тооцох уу? Бид нар ийм зорилго, зорилт тавьж байгаа бол хүрч чадаагүй үр дүнг эргээд хариуцлага тооцдог тийм тогтолцоо нь бас байх ёстой. Тэгж байж гүйцэтгэх засаглал сайн ажиллана.

Нөгөө талдаа Улсын Их Хурал бас адилхан. Улсын Их Хурлын харьяа байгууллагуудын зорилго, зорилтууд байна. Үүн дээр ч гэсэн бид нар ахиц гарахгүй байх юм бол хариуцлагыг нь тооцдог тийм тогтолцоонд шилжих ёстой. Үүн дээр Их Хурлын дарга болон Байнгын хороодын дарга нар бас анхаарч ажиллах ёстой болов уу гэж бодож байна.

Хоёрдугаарт, Сангийн сайдаас 2 асуулт. Ирэх жилээс эхлээд төсвийн гүйцэтгэлийг энэ таван жилийн чиглэлийн 3 дугаар хавсралтаар гаргах хэрэгтэй байна. Яг энэ бид нарын тавьж байгаа Кэй Пи Ай-ууд ахисан юм уу ахиагүй юм уу? Тэрийг бид нар Их Хурал дээр хэлэлцэх ёстой.

Хоёрдугаарт нь 27 оны төсвийг боловсруулахдаа энэ 3 дугаар хавсралтын Кэй Пи Ай-д ямар ч үр нөлөө үзүүлэхгүй төсөл, арга хэмжээн дээр төсөв тавьж болохгүй. Тэгэхлээр энэнтэйгээ нийцүүлээд явах ёстой гэсэн үг. Таван жилийн чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө, жилийн төсөв энэ 3-ын хавсралтууд бүгд яг адилхан байх ёстой. Тэгж байж бид нар үнэлгээ, хариуцлага, үр дүнгээ тодорхойлох боломжтой. Энэ ажлуудыг хийх үү?

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн, Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Таван жилийн чиглэлийг боловсруулахад манай Лувсанжамц гишүүний манлайлал их өндөр байлаа. Тэгээд Их Хурал дээр бас ажлын хэсэг байгуулсан. Нийгэм, олон нийтэд энэ таван жилийн чиглэл, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн ач холбогдол, үнэ цэнийг бас их ойлгуулж өгсөн. Тэгээд бид нар бодлогын баримт бичиг бараг 500 гаруйг баталчихсан байсан л даа. Тэгээд 19 онд тэгээд энэ Хөгжлийн бодлогын хууль гарснаас хойш бас цэгцрэх аяндаа орж байгаа.

Гэхдээ процесс үнэлэгдсээр байгаад өнөөдрийг хүрчихсэн учраас ийм үнэлгээ ийм хэтэрхий субъектив байдлаар хандаж ирсэн. Хэн хэндээ их бэрхшээлтэй. Тэгээд үнэлэх гэхээр хийгээгүй гэх хэцүү, хийсэн гэх хэцүү. Нэг юм хийсэн юм шиг хэдэн зураг эвлүүлээд ингээд байдаг. Тэгэхээр би энэ хөгжлийн бодлогын баримт бичиг өөрөө тоон арга руу ингээд шилжчихэж байгаа учраас дараа нь ямар нэгэн тайлбар байхгүй шүү дээ. Хүрсэн үү, хүрээгүй юү тэгээд л бол оо.

Тийм учраас хэрвээ тэр зорилтыг салбарын үр дүнд хүргэж чадаагүй бол тухайн төсвийн ерөнхийлөн захирагч өөрөө хариуцлага хүлээх ёстой. Тийм учраас Ерөнхий сайдад бас олгогдсон Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх учраас ер нь бүгдээрээ энэ салбарын сайд нарын ажлыг маш хялбар дүгнэж суръя. Энэ Лувсанжамц гишүүний хэлж байгаагаар. Ерөөсөө л наад үр дүнд хүрээгүй. Хүрсэн, хүрээгүй. Тэгээд л ингээд хүрээгүй л бол хариуцлагаа хүлээх ёстой гэдэг зарчмаар хандаад явах нь би бас зөв гэж бодож байгаа.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын хууль дээр энэ урт болон дунд богино хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хэлэлцээд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг Ерөнхий сайд шууд хүргүүлдэг. Тэгээд Ерөнхий сайд өөрөө шийдвэрлээд явдаг. Тэгэхээр яг энэ хариуцлагын тогтолцоо, механизмаа маш ойлгомжтой болгох ёстой. Хаана ч double стандарт үйлчилж болохгүй. Тэгээд хаана, хэн, ямар ажлыг хийж хэрэгжүүлэв ээ гэдгийг маш ойлгомжтой болно. Салбарын үр дүн гэхээрээ нөгөө салбар болгон үр дүнгээ тавьж байгаа. Төсвийн ерөнхийлөн захирагч гэхээр Их Хурлын дэргэдэх байгууллагууд хүртэл энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус ороод явж байгаа учраас тэр төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн хэрвээ ахиц үзүүлээгүй байвал энэ чинь том агуулгаараа үндэсний үр дүн дээшлэхгүй л гэсэн үг шүү дээ. Үндэсний үр дүн.

Тэгэхээр бид нар олон улсын индексүүдтэй, дээрээс нь Тогтвортой хөгжлийн зорилтуудын 72 хувьтай уялдуулсан. Тэгэхээр бид нар тухайн төсвийн ерөнхийлөн захирагч үр дүндээ хүрч байвал салбарын үр дүн дээшилнэ. Салбарын үр дүн дээшилж байвал үндэсний үр дүн дээшилнэ. Ингээд олон улсын индексүүд дээр урагшлаад эхлэхээр нөгөө зээлжих зэрэглэл, бусад энэ олон улсын индексүүд маш эерэг эффекууд өгөөд явна. Ингэж байж өөрөө эдийн засаг бас углуургаараа хөрөнгө оруулалтын орчин ч гэсэн сайжрах, сууриа тэлэх ийм бололцоонууд бүрдэнэ ээ гэж ингэж би харж байгаа юм.

Манай ажлын хэсгээс нэмж.

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын индэр.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Бид таны хэлсэн дагуу тэр хүрэх үр дүн, зорилтыг ер нь ганцхан Сангийн яамны ажлын хэсэг бид нар Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Засгийн газраас шийдвэр гаргуулна. Энэ дээр бүх яамнууд энэ дүндээ зорилтоо тавьдаг, үүний биелэлтээ гаргаж өгдөг энэ талд онцгой анхаарна. Бид яах вэ өмнөх энэ жилийн хувьд бас эхлэлийг нь тавьсан. Гол асуудал салбарын яамнууд дээр энэ зорилтуудаа маш зөв тодорхойлдог байх, үүний биелэлтээ бас үнэн, зөв бодитойтой гаргадаг. Тэгээд энийгээ бас сар болгон, улирал болгон тайлагнаад энэ явцаа бас Засгийн газарт танилцуулаад явдаг ийм тогтолцоо руу бид шилжинэ ээ гэдэг ийм байдлаар Сангийн яам ажлаа зохион байгуулаад ажиллаж байгаа. Тэгээд энэ талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулаад бас шийдвэрийг нь гаргуулаад ингэж ажиллах болно.

Ж.Бат-Эрдэнэ: Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Зөв голдиролдоо л ороод л яваад байна. Та хэдийн маань сүүлийн 4, 5 жил хийсэн ажлуудын үр дүн ингээд гараад эхэлж байна тээ? Хуулийн хэрэгжилт нь ингээд суурь нь тавигдаад явдаг. Цаг хугацаа ордог гэдгийг маш сайн ойлгож байгаа. Хэдүүлээ гэхдээ хамтраад эд нарыгаа сайхан засаад явах юм бол татвар төлөгчдийнхөө мөнгийг төгрөг бүрийг бид нар үр ашигтай зарцуулах боломж нь бүрддэг. Улс төрчдийн, төрийн албан хаагчдын хариуцлагатай ажиллагаа, төсвийг хариуцлагатай зарцуулдаг ийм тогтолцоонд бий болно гэдэг дээр 100 хувийн итгэлтэй байна.

126 гишүүндээ санал тавимаар байна. Улсын Их Хурал дээр хэлэлцэх таван жилийн үндсэн чиглэлийн ажлын хэсэг би ахалмаар байна. Бүтэц, агуулгын хувьд зөв байгаа. Нарийн засах зүйлүүд бас байна. Нэгэнт бид нар салбарын төлөөллүүд маш олон байгаа энэ 126 гишүүнтэй парламент таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг нь зөв болгох ажил дээр гар бие оролцоод дэмжиж ажилламаар байна. Ажлын хэсгийг ахлуулж өгөхийг хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Цэвэгдорж овогтой Туваан гишүүн үг хэлнэ.

Ц.Туваан: Монгол Улсыг 2026-30 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах асуудал яригдаж байгаа. Тэгээд маш олон бичиг баримтууд байгаад байна. Энэ дээр Алсын хараа 2050-аас өгсүүлээд өнөөдөр Ерөнхий сайдын амнаас 170 гаруй гэж ярьж байсан, сая Учрал сайдын амнаас 500-гаад гэж ярьж байна. Ингээд маш олон бодлогын бичиг баримттай. Бид нарт цаас ерөөсөө багадахгүй байгаад байгаа. Зөндөө л цаас байна. Тэгээд яаж яг бодитой тэрийг ажил болгох вэ гэдэг асуудал л байгаа юм.

Өмнөх нийгмийн үед бид нар 5 жилээр төлөвлөдөг гээд л ер нь шүүмжилдэг л байсан л даа. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг энэ тэр гээд. Энэ чинь ер нь зөв байсан юм биш үү? 5 жилээр ажлаа төлөвлөөд тэгээд төлөвлөгөө боловсруулаад дүгнээд явдаг энэ төлөвлөгөөг нь Төлөвлөгөөний комисс гэдэг байгууллага ингээд хийгээд явдаг эдийн засгийн бүх тооцооллыг нь. Тэгээд ерөөсөө энэ эрэлтэд суурилсан нийлүүлэлтийн бодлого гэдэг юмаа гаргаад тэгээд яг эрэлт, нийлүүлэлт 2 нь балансалж очдог ийм л зүйл байсан байна. Тэгээд одоо энэ асуудал байхгүй болсноос хойш ерөөсөө эрэлт, нийлүүлэлт хоорондоо зөрөөд ингээд явчихдаг. Тодорхой хэлбэл зүгээр хүнсний ногоон дээр ярья л даа. Манай бүс нутагт байж байна. 1 жил манжин гайгүй үнэд орохоор хүмүүс шуураад дараа жил нь бүгдээрээ манжин тарьдаг.

Тэгээд илүү үйлдвэрлэл яваад тэр манжингийнхаа үнийг унагаачихдаг. Энэ жил манжин бүтэхгүй юм байна гээд лууван тарьдаг. Иймэрхүү тийм бодлогогүй, захиалгагүй ийм эрэлтэд суурилаагүй нийлүүлэлт хийгээд ингээд зах зээл дээрээ илүү үйлдвэрлэл бий болгоод явчхаад байна. Тэгэхээр энийг тийм байгууллагатай больё. Одоо Эдийн засаг, хөгжлийн яам энэ асуудлыг хариуцаж байгаа гэж байгаа. Тэгээд яам юм чинь бас асуу энийг асуудал хариуцаад явна гэх нь хаашаа юм. Ер нь тийм яг мэргэшсэн тийм агентлагтай, мэргэжлийн эдийн засагчдаас бүрдсэн агентлагтай болбол яасан юм бэ? Энэ дээрээ улсынхаа шилдэг боловсон хүчнүүдээ авъя. Улс төржилгүй авъя. Монгол Ардын намаас ч тэр, Ардчилсан намд ч гэсэн зөндөө сайн эдийн засагч нар байна. Эд нарыгаа авч байгаад ийм агентлаг шиг бүтэц байгуулаад хэдүүлээ тэрүүгээрээ л бүх захиалга, тооцоолол, хангамж энэ тэрээ шийдээд явдаг байя гэсэн ийм ажил хэрэгч санал тавимаар байна.

Дараагийн асуудал нь энэ Дамдинням сайдаас асууя. Энэ бензиний асуудал сая нэг юм болоод одоо ч их айхтар бүрэн илаарьшаагүй л байна л даа. Хөдөө орон нутгууд яг намрын ид ажлын цаг дээр хангамж дутагдалтай газрууд байна. Тэгэхээр энэ дээр 2 асуудал байгаа. Нэг нь дотооддоо үйлдвэрлэх. Дотооддоо үйлдвэрлэх асуудал чинь газрын тос боловсруулах үйлдвэр орно оо. Тэр ингээд явна. Мөнгө төгрөг нь шийдэгдчихсэн учраас орно. Энийг харин яаж ажиллуулах вэ гэдэг дээр одоогоос санаа зовж эхэлмээр байгаа юм. Тэгэхгүй бол яг цаг нь

болдог. Нөгөө газрын тосных нь, түүхий тосных нь асуудал хүндэрнэ шүү. Тэгэхээр энийг одоогоос бодож яримаар байгаа юм.

Нөгөө талд нь энэ савны асуудал. Энэ жил багахан мөнгө тавих шиг л боллоо. Тэгээд тэр юу ч болохгүй л дээ. Бид нар тооцоолол хийж үзэхэд 3 сарын хэрэглээ хангах нөөцийн савтай болоход 900 тэрбум төгрөг шаардах юм байна лээ. Тэгэхээр энэ нэлээн их төсөв шаардана. Тэгэхээр хувийнхантай хамтарч хийх хэрэг гарах байх. Дарга 1 минутаа нэмээд авчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Туваан гишүүнд 1 минут нэмж өгье.

Ц.Туваан: Тэгэхээр энэ дээр ямар бодлого явж байгаа вэ? 50 хувиа хангах дээр тэр түүхий тосныхоо хэрэглээ 1.5 сая тонны тосоо яаж хангах гэдэг дээр одоогоос анхаарч явахгүй бол гэдэг дээр 1 асуулт асуучихъя. Энэ мега төслүүд дээр уг нь ороод явж байсан юм. Тэгээд одоо мэдэхгүй ээ ер нь надад жоохон бүдгэрээд л байх шиг байна. Энэ кокос хими, нүүрс хими гээд. Энэ нүүрс хими чинь манайд байгаа энэ маш их нөөцтэй нүүрснээсээ бид хэд ядаж эхний ээлжид дизель түлшнийхээ хэрэгцээг хангах, нүүрснээс түлш гаргаж авах энэ зүйл чинь дэлхийд ер нь ердийн зүйл боллоо шүү дээ. Тэгэхээр бас давхар ийм юмаа бодоод явбал яадаг юм бэ. 50 хувиа энэ шинэ газрын тос боловсруулах үйлдвэрээсээ хангаад 50 хувь дээрээ алсын жоохон бодлого гаргаад энэ рүүгээ чиглээд, судалгаагаа хийгээд ингээд явж байвал яадаг юм бэ гэсэн ийм бодол байдаг юм. Тэгэхээр энэ дээр бас салбарын сайдын хувьд ямар бодлого байгаа вэ гэдэг ийм асуулт асуучихъя. Тэр мэргэжлийн байгууллага дээр Учрал сайд.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Миний яг хувьд зүгээр өөрийн итгэл үнэмшил би төр цомхон байх, зохицуулалт нь энгийн байхад өөрсдөө учраа олно л гэж ийм л бодолтой хүн л дээ. Тийм учраас агентлаг байсандаа, байгаагүйдээ бас энэ төлөвлөлт буруу байна гэж хэлэх нь өрөөсгөл. Зүгээр төлөвлөлт өөрөө зөв байх ёстой. Төлөвлөлтийн чадавхаа сайжруулах ёстой. Ядаж энэ бодлогын чиглэлийг боловсруулах аргачлалаа хөгжлийн бодлого хариуцаж байгаа мэргэжилтнүүддээ, холбогдох албан тушаалтнууддаа зааж зааварлаад өгчихдөг л байх ёстой Монголын төр.

Тийм учраас сая тушаалаар энэ таван жилийн чиглэлийг боловсруулах аргачлалыг батлаад энэ чиглэлээрээ хөгжлийн бодлого хариуцсан нөгөө аймгуудын мэргэжилтэн, газар, хэлтсийнхэнд сургалтуудыг зохион байгуулсан. Энэ дээр НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр тусалсан. Ингээд бид нарт ямар боломж байсан бэ гэхээр ШУА-ийг дайчилсан. Манай ажлын хэсэгт ажиллаж байгаа манай эрдэмтэн, судлаачид, академич нар тусалсан. Ингээд Бага чуулганаараа ороод Их чуулганаараа ороод ингээд явахаар шинжлэх ухаанч төлөвлөлт болж болох юм байна.

Хоёрт яг энэ бас анх удаагаа гэж бараг хэлнэ шүү энэ бодлогын баримт бичиг дээр Ки Пи Ай тавилаа л даа. Тэрнээс биш тэр 550, 60 бодлогын баримт бичгүүд чинь үнэхээр эмх замбараагүй төлөвлөлт байсан. Тэгэхээр ер нь ингээд нөгөө Эдийн засаг, хөгжлийн сайдаар томилогдсон учраас дээрээс нь Ерөнхий сайдын барьж байгаа энэ зарчмыг нь бариад энэ 14 төслийг ч тэр яам болгон дээр

байсан төслүүдийг ч тэр нөгөө эрэмбэлэх ажлыг нь 4 бүлэг, 15 зүйл аргачлалаар үнэлчихсэн. Тэргүүн ээлжид төслүүдээ тавиад хойшлуулахыг нь хойшлуулаад ингээд эхлүүлсэн.

Тэгээд таны хэлж байгаа нүүрс химийн нөгөө цогцолбор бол 14 төсөл байдаг. Энэ ухраагүй. Энэ ажил бол урагшилж байгаа. Тэгээд яах вэ удаашралтай байна. Эрдэнэс Монгол дээр ТЭЗҮ боловсруулаад тэгээд ямар ч байсан ажлын даалгаврыг нь зарлаад ингээд явсан. Ер нь ингээд хот нэг юм хийдэг, яам нь нэг юм хийдэг, компани нэг юм хийдэг ийм байж болохгүй. Тийм учраас бид нар бодлогын чиглэл дээр ч тэр, 4 жилийн хөтөлбөр дээр ч тэр нүүрс химийн цогцолборыг барьж байгуулна гэдгийг явсан. Тэгээд эхний шат ямар ч байсан ажлын гараанаас гараад ингээд явж байгаа.

Тэгэхээр зүгээр санхүүжилтийг нь шийдвэрлэх шаардлагатай төслийн жагсаалтад байгаа. Гэхдээ нийгмийн хэрэгцээ, шаардлага өндөртэй учраас тэргүүн ээлжид хэрэгжүүлэх гээд зорилтыг нь тусгасан байгаа гэдгийг бас хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Дамдинням сайд хариулах уу?

Г.Дамдинням: Туваан сайд маань бас ажил хариуцаж байсан хүн. Яг санаа зовж байгаа юман дээр маань л ижил л дуугарч байна. Нэгдүгээрт бид нар дотооддоо үйлдвэрлэхэд эх үүсвэр, түүхий тосны хэрэглээ импорт хийхээс болон дотооддоо олборлох 2 хувилбараар зэрэгцүүлж зохион байгуулалт хийж явахаас өөр аргагүй байгаа. Одоогийн манай хүчин чадал үндсэндээ 360 мянган тонн руу буусан байна. Та өөрөө бас мэдэж байгаа байх. Ер нь “Петро Чайна”-тай холбоотой энэ сум, аймаг, мөн бас Засгийн газрын агентлаг, Сангийн яамны зүгээс, бас шүүх эсэх нь шийдэгдсэн энэ татвартай холбоотой асуудлыг ер нь энэ Улсын Их Хурлаар оруулж ирснийг шийдэх ёстой юм байна лээ. Тэгэхгүй бол бид нар энэ дотоодоосоо хангах хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх ямар ч боломжгүй байгаа.

Хоёрдугаарт энэ савны холбоотой асуудал байна. Савтай холбоотой асуудал дээр бид улсынхаа хэмжээнд 440000-ын савтай хүмүүс. Энэ маань үндсэндээ манай 1 сарын хэрэглээг л арай гэж хангадаг.

Ж.Бат-Эрдэнэ: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Тийм. Ер нь сүүлийн үед энэ төлөвлөлт дээр бас ахиц гарч байгааг үгүйсгэхгүй. Тэгэхдээ хэдүүлээ тийм яам, сайд, Засгийн газар солигдохоор ингээд манайд, бид нарт байгаа юу чинь л ийм л бүтэц чинь ингээд л байна л даа. Тэгээд л ирээд л нөгөө хуучин ажиллаж байсан хүмүүсээ сольдог. Тэгэхээр энэ төлөвлөлт хариуцсан агентлаг юм уу юу гэдэг юм газар нь ингээд тогтвортой ажилладаг л болмоор байгаа юм. Бүх юмаа мэддэг, салбар салбарын яг тооцооллоо хийчихдэг хүмүүсээ авчраад нэг тийм байгууллагатай больё оо л гэсэн ийм санал хэлээд байгаа юм. Энэ дээр бас нэлээн дараа нь тодорхой бас ярилцъя. Энийг бас 1 удаа яриад хаячих сэдэв биш байх. Ажлын хэсэг энэ тэр гараад явах байх. Дамдинням сайд дээр тэр юугаа гүйцээгээд тодруулаад хэлчихье. Тэр бид нар энэ улс төржилтөөс болоод бас энэ орон нутаг аймгийн байгууллагуудаас болоод бас хохироод байгаа асуудал ч.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дамдинням сайд.

Г.Дамдинням: Тийм энэ бид нар газрын тостой орон шүү дээ. 41 сая тонны эдийн засгийн үр өгөөжтэй, нөөцтэй. Үүнийхээ 10 сая тонныг нь олборлочихсон байж байгаа. Цаана нь 30 сая байгаа. Энэнийхээ хүчин чадлыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэх зайлшгүй шаардлагатай энэ нөхцөлд 92, 93 онд байгуулагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээнээсээ хойш гарсан хуулиар торгууль ноогдууллаа, татвар тавилаа гэдэг бас ийм л маргаан үүсэж байгаа юм. Дамжуулан татварын асуудал. Энэ асуудлыг бид нар ажлын хэсэг дээрээ ярилцаад удахгүй Их Хурлаар оруулж ирнэ гэсэн ийм төлөвлөлттэй байна.

Хоёрдугаарт, энэ савны асуудал. Сав нөөц бүрдүүлэхтэй холбоотой стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний нөөц, хангамжийг сайжруулах тухай нэн яаралтай горимоор барих хуулийг өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар бид баталж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас оруулсан. Удахгүй засаг Их Хуралд нэн яаралтай горимоор оруулж ирнэ. Энэ бол эх үүсвэрийн асуудал тавигдах юм байгаа юм. Бас Их Хурлын гишүүд маань дэмжиж өгөөрэй гэж хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Би санал хэлье дээ. Тэгэхээр энэ таван жилийн төлөвлөгөө бол энэ Засгийн газрын хугацаа, сонгуулийн циклтэйгээ давхацдаггүй юм. Би эхнээс нь шүүмжилж байсан юм. Үлдсэн 1 жилийг нь дараагийн Засгийн газар хийнэ гэж байхгүй шүү дээ. Тэгээд ч энэ таван жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнд хариуцлага ирж байгаа ч юм байхгүй. Тэгээд нэг хий хоосон ийм баримт бичиг байдаг.

Тэгээд зүгээр энэ дунд хугацааны баримт бичиг хэдхэн зүйл дээр л төвлөрмөөр байгаа юм. Эхлээд бид нар ингээд хөгжлийн загвараа тодорхой болгомоор байна. Бид бүгдийг хийж чадахгүй. Магадгүй бид нар аж үйлдвэрийг юм уу, аль эсвэл хөдөө аж ахуй, эсвэл хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх юм уу гэдгээ тодорхой болгоод л ингээд л явах хэрэгтэй. Бидний чадах юм уул уурхайн түүхий эдүүдээ дахин боловсруулж чадна. Ингэвэл орлого нэлээн нэмэгдэх боломж байна. Өнөөдөр Индонез, Чили бол тэгж байна шүү дээ манай түүхий эдийг ав. Тэгэхдээ манай улсад үйлдвэрээ хий гэххэж байна шүү дээ. Бид нар түүхий эд дээрээ тэгээд ажлын байр бий болгоод явж болно.

Хоёрдугаарт, бидний чадах юм хөдөө аж ахуй, органик хүнс ээ. Хятадад 9 сая орчим долларын саятан байна. Эд нар органик хүнсний хэрэглээнд чухалчилж байна шүү дээ. Тийм учраас бид нар энэ органик хүнс чиглэл рүү явах юм бол орлого олох боломж байна мал аж ахуй дээр. Аялал жуулчлал бидний чадах юм байгаа юм. Энэ 3 салбараа тэргүүлэх болгоод тэгээд эрчим хүч, зам, дэд бүтцээ хөгжүүлээд явчих юм болно.

Дээр нь бид нар салбарыг мэргэжлийн хүмүүсээр удирдуулах хэрэгтэй. Тэр мэдэхгүй, туршлагагүй хүн чинь бүх юмыг чадах юм шиг бодоод байдаг байхгүй юу. Хамгийн аюултай нь яаж хохироож байгаагаа мэддэггүй мэргэжлийн бус хүн чинь. Тийм учраас ингээд салбаруудын ажил унаад, тэгээд салбаруудын ажил явахгүй байгаа учраас энэ хөгжил чинь урагшлахгүй байгаа юм.

Гуравдугаарт энд том зорилт тавьсан байна лээ. Дундаж давхаргыг 40-60 хувь болгоно гэж. Энэ аймаар том зорилт шүү дээ. Ингэхийн тулд орлогын тэгш, зөв хуваарилалтыг бий болгох хэрэгтэй. Одоо энэ хэрэгжүүлсэн гээд байгаа таван жилийн төлөвлөгөө дээр хэрэгжсэн юм бий. Жишээлбэл 1 хүнд ноогдох ДНБ-ийг 4200-аас 6000 болгоно гэсэн. Болсон. Тэгэхдээ иргэдийн амьдрал ийм болсон уу гэвэл болоогүй. Нөгөө хүн амын 3 хувь руу л энэ чинь шингэчхээд байна шүү дээ. Тэгэхээр энийг цэгцэлж байж, энэ татварын тогтолцоогоо өөрчилж байж бид нар тэр 40-60 хувь руу хүрнэ.

Дараа нь бидний нэг хийх ёстой юм энэ үнэн, худал, зөв, бурууг ялгадаг, ойлгодог ийм нийгэмтэй болох хэрэгтэй. Өнөөдөр бид нар ерөөсөө үнэн, зөв, бурууг ойлгож ялгах аа больсон. Энэ гүтгэлэг гэдэг юм ямар ч ял байхгүй, доромжлол ял байхгүй. Дэлхийн бүх улс оронд гүтгэлэг ялтай. Манайд байхгүй. Бүгдийг харлуулна. Ард түмэнд төрийн итгэлцэл байхгүй. Ард түмэн, иргэд төрдөө итгэхгүй яах вэ? Непалдана. Непалдвал яах вэ Казахстан шиг харийн цэрэг орж ирнэ. Тусгаар тогтнол чинь, үндэсний аюулгүй байдал чинь ганхана. Тэгэхээр бид нар ийм хэд хэдэн зүйлийг л хийчих хэрэгтэй суурь. Тэрнээс биш олон гоё ганган юм яриад, попрод ерөөсөө хэрэг байхгүй. Энэ попрор чинь нийгмийг залхааж байна шүү дээ.

Тийм учраас асуудалд бодитой хандаад хэдхэн зүйл дээр төвлөрөөд ингээд явчих юм бол энэ 3 сая хүнийг тэжээх баялаг бидэнд байна уу байна. Зөвхөн юу дутаж байна? Бид нар буруу удирдаж байна. Хоёрдугаарт иргэдээ бид нар бүтээлч, халамжийн бус Монгол хүн байх чиглэл рүү нь хүмүүжүүлж сургаж чадахгүй байна шүү дээ. Миний нэмэлт 1 минутыг өгчхөөрэй.

Ж.Бат-Эрдэнэ: Даваасүрэн гишүүн 1 минут сунгая.

Ц.Даваасүрэн: Бид ядуурлыг бууруулъя, хөгжье гэх юм бол иргэдээ бүтээлч хүн болгох ёстой. Одоо манай иргэд яаж байна вэ? Халамж, хов живээр амьдарч байна. Тэгэх юм бол бид нар тийм биш ажлын байр нэхдэг эх оронч сэтгэлгээтэй ийм иргэнийг бий болгох ёстой. Хаанаас эхлэх ёстой юм Боловсролын сайд энд байна сурах бичгээс тэр унших бичгийг, тэр түүхийн сурах бичгийг өөрчил. Тэгж байж бүтээлч Монгол хүн бий болгоно. Тэгэх юм бол энэ чинь ард иргэд нь өөрөө бүтээлч байж байж улс орон хөгжиж хэдэн даргаа зүтгээд хөгжүүлж чадахгүй.

Тийм учраас бид нар энэ иргэдийнхээ зөв чиглүүлж удирдах үүргээ төр биелүүлж чадахгүй байгаа байхгүй юу. Тэгээд ард түмэн нь яаж байна нөгөө хулгайч нараа сонгоцхож байна шүү дээ. Өөрсдөө ёс суртахуунгүй, боловсрол муу байгаа учраас. Тэгээд 4 жил хэрэлдээд суучхаж байна. Энэ байдлаараа үргэлжилбэл хэзээ ч бид нар энэ таван жилийн төлөвлөгөө биелэхгүй. Гэх мэтийн өөрчлөлтүүдийг хийх юм.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ренчинбямбын Сэддорж гишүүн асуултаа асууя.

Р.Сэддорж: Таван жилийн үндсэн чиглэл хэлэлцэж байгаа энэ хэлэлцүүлэг маш чухал хэлэлцүүлгүүдээ. Сонгуулийн 4 жилтэй давхцахгүй байх нь ч гэсэн энэ зөв байх бараг. Монгол төрийн залгамж халаа үүгээр сонгуулийн жилээр солигддог

байж болохгүй. Ийм учраас залгамж чанартай байх үүднээс ингээд явах ёстой байх.

Энэ дээр энэ усны асуудлаа хэдүүлээ шийдэхгүй бол нэг хэсэг нь усгүй цангаад тэгээд тэндээсээ хамаг нөгөө төсвийн орлогоо бүрдүүлээд тэгээд Монгол даяараа тэр төсвийн орлогоороо амь зууж тэгэнгүүтээ усны асуудлыг зөвхөн говийн асуудлууд, говийн бүсийн 7 гишүүдийн ярьдаг асуудал мэтээр ингэж ойлгож байгаа зарим хүмүүс байх шиг байна. Тэгэхээр тэр уул уурхайг нээснээрээ тэр говийн ард түмэн хохирох ёсгүй. Амьдралын үнэн гэж байдаг.

Тэгэхээр тэр Монгол Улсын маань орлогыг, төсвийн орлогыг бүрдүүлж байгаа тэр нутаг усны ард түмэн, уугуул иргэдийг малчид, ард түмэн хайрлаж энэ усны төслөө эрэмбийг нь маш дээш нь явуулах хэрэгтэй байна. Тэгээд энэ ТЭЗҮ нь ямар их үнэтэй байдаг юм? Жишээ нь Хэрлэн-Тоонот-ын ТЭЗҮ 10 тэрбум гэж байгаа юм. Орхон-Онгийн тэр дэд төсөл 13 тэрбум гэж байгаа юм. Энэ Эдийн засаг, хөгжлийн яам Учрал сайд, Жавхлан сайд нар энэ ТЭЗҮ дээр ер нь бодитой юм уу? Энэ усны 2 төслийн ТЭЗҮ? Сая ерөөсөө зөвхөн ТЭЗҮ-ийн мөнгийг л суулгасан шүү дээ. Бүгдийг нь суулгаж чадаагүй. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань ямархуу бодолтой байна вэ гэдгийг асууя.

Өмч хувьчлал дээр “Эрдэнэс Тавантолгой” жишээ нь яагаад ингээд хардлагын гол бай болоод байна вэ. Яахаараа энэ компанийн нэр хүнд ийм одоо хамгийн доод түвшинд байна вэ гэхээр энэ “Эрдэнэс Тавантолгой”-г л яаралтай зохих хэмжээнд нь хувьчлах хэрэгтэй. Энэ хувьчлалыг яаралтай зохион байгуулах хэрэгтэй. Бэлээхэн жишээ байгаа шүү дээ 34 хувийг нь төрдөө авч үлдээд 33 хувийг нь Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалаад, 33 хувийг нь Монголынхоо нийт ард түмэнд хувьцааг нь өгөх хэрэгтэй. Одоо хэдэн хувийг нь өгчхөөд байгаа билээ. Тэн дээрээ нэмээд 33 хүртэлх хувийг нь нийт ард түмэндээ өгөх хэрэгтэй. Ингэх юм бол өөрийнхөө өмчөөс хулгай хийдэг тийм хүн гэж байхгүй шүү дээ.

Жишээ нь тэр 33 хувийг Монголын нэртэй компаниуд авчих юм бол энэ компанийг маш сайн хянаад ямар ч алдаа гаргахгүй авч явуулах ийм бүрэн боломжтой ийм Монголынхоо аж ахуйн нэгжүүдийг дэмжих хэрэгтэй. Монголын аж ахуйн нэгжүүд сайн ажиллаж байж Монголын эдийн засаг сайжирна. Өөр ямар ч гарц гаргалгаа байхгүй. 33 хувийг нь Монголын хөрөнгийн биржээр ингээд арилжаалах юм бол Монголын хөрөнгийн бирж үнэхээр өөдөө дээшээ гарна. Тэгээд энэ өмч хувьчлал дээр “Эрдэнэс Тавантолгой” ялангуяа өмч хувьчлал дээр энд байгаа хүмүүс бас өөрийн зүгээс бас хариулт хэлээрэй. Байгаль орчны яам. Байгаль орчны яам бол энэ усан дээр үнэхээр анхаарч чадахгүй байгаа. Нэрэндээ ч болохгүй байгаа юм уу.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тийм говийн гишүүд бас усны энэ төслийн асуудлаар бид хэд уулзаад уулзсан. Тэгэхээр усны төслүүдээ явуулах хэрэгтэй. Тэгж байж л энэ уул уурхайн салбарын төслүүд урагшилна шүү дээ. Тийм учраас энэ зөвхөн говийн хэдэн гишүүний, эсвэл говийн бүс нутгийн асуудал огт биш. Тэгээд ер нь орон нутагт нь тэр нөлөөллийн бүсүүд дээр АМНАТ-ын орлого ч гэсэн илүү төвлөрдөг. Тэгээд энэ ус, нөхөн сэргээх чиглэлийн төслүүдийг бодлогоор дэмждэг болж байж

тэр орон нутаг нутгийн иргэд өөрсдөө тэр үр шимийг нь хүртэж байж л энэ уул уурхайг дэмжинэ шүү дээ. Тэрнээс биш ингээд үр шимийг нь хүртэхгүй тохиолдолд дэмжихгүй.

Энэ үндсэн чиглэлийн чиглэл дээр бид нар энэ хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хавсралт дотор Орхон-Онги төслийг бас тусгасан байдаг. Хэрлэн-Тоонотыг ч гэсэн тусгасан. Хэрлэн-Тоонотын ТЭЗҮ бол Оюу толгойн санхүүжилтээр 3 сая доллароор хийгдэж байгаа. Сая би өөрөө усны төсөл дээр төсөв дээр дэмжигдсэн гэж ойлгож байгаа шүү дээ. ТЭЗҮ-гийн санхүүжилт нь шийдвэрлэгдсэн. ТЭЗҮ хийх бол нэг асуудал. Гол нь энийг зөв зохион байгуулахгүй бол дахиад үр ашиггүй зарлага гарна. Тэгээд яам болгон дээр байгаа ТЭЗҮ, зураг төслүүдийг сая татаж авч байна л даа. Уг нь ингээд зураг байна.

Тэгэхдээ магадлалыг нь шинээр хийлгэчихдэг ч юм уу ингээд сэргээгээд аваад явж болно шүү дээ бид нар. Яам болгон дээр үр ашиггүй зардал гаргаад өнгөрсөн хугацаанд хийгдсэн хэрэгтэй, хэрэггүй ТЭЗҮ, зураг төсвүүд үлдчихсэн. Түүн шиг зөвхөн ТЭЗҮ хийлгээд дуусах биш санхүүжилтийн эх үүсвэрийг нь шийдвэрлэх механизмтайгаа ингээд хамтад нь шийдвэрлээд явахгүй бол бас ийм зүгээр л ТЭЗҮ боловсруулаад өнгөрч болохгүй. Мэдээж ТЭЗҮ боловсруулаад жийж бид нар нөгөө санхүүжилтийн механизм өөрөө тодорхой болно. Тийм ч учраас энэ Тендерийн хууль ер нь нөгөө ТЭЗҮ-тэй зураг төсөвтэй ингээд хамтад нь зарлаж болдог нөхцөл рүү оруулах гээд бид нар боловсруулсан шүү дээ.

Тэгэхээр бид нар ТЭЗҮ-гийнхээ хийлгэх явцдаа санхүүжилтийн шийдвэрлэхэд анхаарна. Таван жилийн чиглэл дээр санхүүжилтийн шийдвэрлэгдээгүй мөртөө нийгмийн хэрэгцээ, шаардлага өндөртэй төслүүдийн жагсаалтад энэ усны бүх төслүүд бичигдсэн. Тэгээд санхүүжилтийг олох, эрэл хайгуул хийх холбогдох санаачилгуудыг гаргах ажлыг Засгийн газрын зүгээс эхнээс нь ТЭЗҮ боловсруулагдаж байх үе, цаг мөчөөс авхуулаад хамтраад ажиллах хэрэгтэй. Тэгж байж хэдүүлээ үр дүнд хүрнэ Тэгээд эхнээс нь. ТЭЗҮ зарлах, даалгавар боловсруулах энэ үеэс нь авхуулаад хамтдаа санхүүжилтийн асуудлаа зэрэгцээд ажил хэрэг болгоод явъя гэж хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сангийн сайд. Сая ч ТЭЗҮ-гийн талаар ярьчихсан уу? Жавхлан сайд.

Б.Жавхлан: Цаашдаа бид төсөв өөрөө төлөвлөлтийнхөө шатанд, батлах шатандаа ч тэр зөв алдаагүй явъя гэвэл энэ зураг төсөв, ТЭЗҮ дээрээ бид нар маш сайн анхаарах ёстой. Энэ жил уг нь 9 сарын 1-нд Засгийн газраас өргөн барьсан төсөв дээр бид 40 тэрбум төгрөгийн энэ ТЭЗҮ, зураг төсөвтөө зориулж төсөвлөсөн. Харамсалтай нь бараг хасах болчихсон уу 20 байгаа 20 үлдсэн байна. Бид Төсвийн хууль дээрээ сүүлийн 2 жилийн дотор хийсэн зураг, төсөвтэй ийм л төслүүдийг батална гээд хуульчилчихсан.

Гэтэл сүүлийн 2 жилийн хийгдсэн зураг төсөв маань бүүр улам л цөөрөөд байгаа. 3 жилийн өмнө хийгдсэн зураг, төсөвтэй ямар ч төсөл хуульчлагдаж батлагдах ёсгүй Төсвийн хуулиар. Тийм учраас цаашдаа бид энэ зураг төсөв, ТЭЗҮ дээр маш сайн анхаарал тавьж, ач холбогдол өгч.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэлт хариулт Жавхлан сайд.

Б.Жавхлан: Харин тийм. Тэгэхээр бид Сэдээ дарга яг тэр талаас нь би хэлж байгаа болов уу гэж бодож байна. Энэ зураг төсөв дээрээ илүү их анхааръя. Энэ дээрээ ач холбогдол өгье. Хэрвээ бид хөрөнгө оруулалт хэрэгтэй л гэж байгаа зураг төсөв маань яг норм журам стандартынхаа дагуу сүүлийн 2 жил хийгдсэн ийм л төсөл цаашаагаа бодит хөрөнгө оруулалт болж, эдийн засгийн өсөлтийг авчрах ёстой юм байгаа юм. Тийм энэ дээр Эдийн засгийн байнгын хорооны даргын хувьд таны хэлж байгаатай санал нийлж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сэддорж гишүүн тодруулъя.

Р.Сэддорж: Өмч хувьчлал дээр хэн ярих вэ? Учрал сайд ярих уу? Учрал сайдыг хариулахыг хүсэж байна. Тэгээд хэдэн санал хэлье. Сэргээгдэх эрчим хүчний төслөө эргэж харахгүй бол одоогийн энэ Эрчим хүчний хуулиар, одоогийн энэ Эрчим хүчний яаманд өгч байгаа ачааллаар энэ явахгүй ээ. Энэ сэргээгдэх эрчим хүч гэдгээ ер нь ярихаа болих хэрэгтэй. Одоо хийж чадахгүй юм чинь. Тэгэхээр говьд өч төчнөөн нар, салхины эрчим хүчний төслүүд хэрэгжүүлэх бүрэн боломж байхад одоо болтол чадахгүй байгаа учраас энийгээ болих хэрэгтэй.

Энэ кокс химийн үйлдвэрээ яаралтай ашиглалтад оруулах хэрэгтэй байна. Үдийн цайгаа 26 оноос өгөөд эхэлчих хэрэгтэй байна. Энэ Хууль зүй, дотоод хэргийн яаманд энэ замын хөдөлгөөний дүрэмд өөрчлөлт оруулах хүсэлт өгсөн байгаа. Тэгээд энэ дэд бүтэц хөгжиж байгаа аймгуудаас ийм хүсэлт.

Ж.Бат-Эрдэнэ: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Сэдээ даргын асуултад хариулъя. Өмч хувьчлалыг бид хуучны 90-ээд оны үеийн 2000-гаад оны үеийн өмч хувьчлал гэдэг тэр сэтгэхүйгээсээ бид аль хэдийн салсан байх ёстой. Цүнх барьсан тийм хувьчлал гэдэг зүйл өнгөрсөн зуундаа үлдсэн байх гэж ингэж бодож байна. Одоо бид нээлттэй хөрөнгийн бирж, хөрөнгийн зах зээл дээр олон нийтийн оролцоог олон нийтийн хяналтыг хангасан ийм хэлбэр рүүгээ бид явж байгаа.

Гэхдээ бид энэ төрийн өмчийн компаниудыг стратегийн хувьд ХК болгох, татан буулгах, эсвэл стратегийн хувьд төрд байх ёстой гэдэг энэ ангиллуудаа их зөв хийх ёстой. 2 жилийн өмнө энэ асуудал мөн хөндөгдөөд Улсын Их Хурал дээр орж ирээд энэ жагсаалт батлагдсан байгаа шүү дээ. Цахилгаан станцууд энэ стратегийн хувьд төрд байх ёстой. Төр энийгээ эзэмших ёстой. Энд Төрийн банк, Хөрөнгийн бирж ХК болох ёстой. Олон нийтийн оролцоог хангаж, хяналтад байх ёстой гэдэг энэ чиглэл рүүгээ явсан. Татан буулгах ёстой компаниудынхаа жагсаалтыг ч мөн гаргасан. Ашиггүй байгаа зүгээр алдагдал авчирч байгаа ийм аж ахуйн нэгжүүдийг төрийн мэдэлд байлгах шаардлагагүй ээ гээд.

Тэгэхээр тэр өмч хувьчлал гэдэг асуудал бас арай өөр хэлбэрээр яригдах ёстой ийм цаг хугацаанд ирсэн байгаа гэдгийг хэлье. Тэгээд яг хувьчлал ярих гэж байгаа бол одоо байгаа компаниудыгаа би дахин хэлье. Яг саяын миний хэлснээр ангиллуудыг нь маш зөв тогтоох ёстой. Стратегийн хувьд төрдөө байлгая, энийг нь татан буулгая, энийг нь ХК болгоё, энийг нь бүүр одоо худалдаж борлуулъя ч гэдэг юм уу энэ зүйлүүдээ маш зөв тодорхойлох ёстой л ийм байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сэддорж гишүүн 1 минут сунгая.

Р.Сэддорж: Жавхлан сайд бас нөгөө асуулт байхад яаж байгаа 34 хувийг нь төрдөө, тэгээд 34 аль нэг 33 хувийг нь нийт ард түмэндээ, 33 хувийг нь Монголын хөрөнгийн биржээрээ арилжаалаад тэгээд 34 аль нэг 33-тай нийлэхээрээ дийлэнх олонх болохгүй тийм хуулийн заалт байгаад байна? Тэгэхээр энэ дээр та ямар бодолтой байдаг юм бэ? Энэ дээр бас Сангийн яам, өөр Эдийн засаг, хөгжлийн яам хариулах уу? Түрүүний энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиа хэдүүлээ хэзээ оруулж ирэх вэ? Учрал сайд энэ дээр нэлээн явсан. Энийгээ шийдэхгүйгээр, төсөвт дарамт үзүүлэхгүйгээр бүсүүдээ хөгжүүлэх боломж хэцүү байгаа. Тэгээд энэ дээр байр сууриа сайн хэлээч ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд хариулах уу? Учрал сайд. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм тэр 33, 33, 34 гэдэг бол Компанийн тухай хууль дээр нөгөө хяналтын багц 34 дор хаяж байх ёстой гэдэг эндээс гарч ирсэн ийм тоо. Тэгэхдээ энэ яг аж ахуйн нэгж болгон дээрээ бодлогууд нь бас өөр байх ёстой. Энэ тухайн аж ахуйн нэгжийн эдийн засагт өгөх өгөөжийг нь нэмэгдүүлэх зорилгоор л энэ асуудал яригдахаас биш 1 удаа хувьчлаад орлого олж ирээд төсвийн орлогыг нэмэгдүүлнэ гэдэг тийм зорилгоор байж болохгүй. Тэр 1 дүгээр зорилго биш.

Тийм учраас яг тухайн аж ахуйн нэгж бүр дээрээ энэ бодлогууд нь ялгаатай ингэж гарч ирж байх ёстой тийм. Тэгэхээр яг тухайлан яг аж ахуйн нэгж компани нь яривал яг тэр бүр дээр нь ялгаатайгаар л ярих хэрэгтэй.

Ж.Бат-Эрдэнэ: Очирбатын Амгаланбаатар.

О.Амгаланбаатар: Би та хэдэд бас энэ дандаа л олон жил парламентад суусан энэ нөхдүүд байна. Энэ 2020 онд энэ баталсан 2050, энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай гээд энэ хууль тэгээд тэрний хүрээнд хэдүүлээ ингээд энэ таван жилийн төлөвлөгөө хэлэлцээд явж байна. Тэгээд энэ дээрээс нэг зүйлийг хэлэхэд яг одоо бид нар энэ таван жилийн төлөвлөгөөг хэлэлцэж байгаа маань бид нар ардчилсан улс биш ээ, ардчилсан сонгууль гэж байхгүй ээ, энэ хайрцаг дунд энийг мөрд өө гэсэн тийм л зүйл явж байгаа шүү дээ. Засгийн газрын хөтөлбөр, тэр аймаг, дүүргийн хурлын сонгууль гэж байхгүй ээ, тэр Их Хурлын 4 жилийн сонгуулийн циклээс өөр ийм хөтөлбөр төлөвлөгөө заавал гаргавал ийм балайралыг одоо болих хэрэгтэй. Тэр 2050 чинь ч гэсэн ер нь хүчингүй болгох ёстой юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр би удахгүй өнөө, маргаашгүй хурдлуулаад энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хүчингүй болгох зүйлийг оруулж ирье. Та хэд ч гэсэн үнэхээр энийг буруу гэдгийг мэдэж байгаа, утгагүй гэдгийг мэдэж байгаа мөртөө хөөрхий энэ нэгэнт гарчихсан хууль юм чинь энийг ингэхээс өөр аргагүй гээд л ингээд явж байгаа байх. Одоо ингээд энэ өнгөрсөн цаг хугацаанд болсон энэ балайрлуудыг, энэ өнгөрсөн цаг хугацааны энэ поп шийдвэрүүдийг ингээд агаарт хөөрчихсөн дахиад ерөөсөө энэ ардчилсан сонгууль, ардчилсан улс гэж байхгүй бараг 2050 он хүртэл би удирдана гэдэг энэ балайралд нийцсэн энэ зүйлүүдийг өөрчлөхгүй бол 4 жил тутам нам болгон мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлээд, мөрийн хөтөлбөрөө дэвшүүлээд сонгууль болдог байх чинь энэнээс заавал зөрүүлээд тогтвортой байх ёстой гэдэг энэ социалист

нийгэмд л ийм байдаг. Гэтэл социалист нийгэм Орос, Хятад 2-ыг хуулсан энэ хуучин 35 жилийн өмнөхөө санагалзсан өөртөө зориулсан энэ балайрлыг зогсоохгүй бол болохгүй.

Тийм учраас энийг би ингэж өргөн бариад хүчингүй болгоно. Тийм учраас энийг буцааж аваад тэр хуулийг, энэ балайрлыг зогсоох ёстой гэдгийг хэлье. Энэ бол заавал хийх ёстой ажил шүү. Сайд нар та нар өөрсдөө ч гэсэн бүгд мэдэж байгаа. Одоо ингээд Занданшатар дарга, энэ Бат-Эрдэнээс авхуулаад та нар ч гэсэн энийг өөрсдөө ингээд бодоод тэр саналыг дэмжинэ гэдэгт итгэлтэй байна.

Хоёрт гэх юм бол би энэ Занданшатар даргаас 1 зүйл асууя. Энэ Оюу толгойн нөгөө зээлийн хүүг бууруулах энэ Оюу толгойтой холбоотой асуудал маань юу болж байгаа вэ? Энэ чинь хамгийн тулгамдсан асуудал байна шүү дээ. Одоо ингээд л энэ хэдэн хүү нь буурдаггүй, хүү нь нэмэгдээд байдаг, улам өр нь нэмэгдээд байдаг ийм асуудлуудыг л ярьж байна. Тэгэхээр энэ “Оюутолголгой”-н зээлийн хүүгийн асуудал яг ямархуу шатад байна вэ гэдгийг хэлье. Тэгээд энийг хэлэлцэх шаардлагагүй. Өнөөдрийн энэ асуудлыг хэлэлцэх шаардлагагүй. Би тэгээд харин энийг хүчингүй болгох зүйлийг өргөн барина. Тэгэхээр тэрийг та бүхэн маань бас хурдан дэмжиж өгөөрэй л гэж та хэдэд хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: 1 асуулт асуулаа. Ерөнхий сайд Занданшатар сайд хариулъя.

Г.Занданшатар: Амгаланбаатар гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, Амгаланбаатар гишүүний бас намынхаа либерал үзэл, бодлого баримтлалд үнэнч, тууштай байгаад талархаж байна, баяр хүргэж байна. Тэгэхдээ энэ Алсын хараа бол хуучин Тогтвортой хөгжлийн зорилт 2030 гэж байсан юм. Энийг дэлхийн НҮБ-аас санаачлаад 2013 онд санаачлаад дэлхийн 180 гаруй улсууд хамгийн либерал эдийн засагтай улсуудаас авхуулаад бүх улсууд энэ тогтвортой хөгжлийн 17 зорилтыг баталж, 2030 он хүртэл энэ дэлхий дахин хүлэмжийн хий, уур амьсгалын өөрчлөлт энэ нөхцөлтэй дасан зохицоод засаглалаа шинэчилье, ядуурлаа бууруулъя, ногоон хөгжлөө дэмжье гээд ингээд энэ цогц төлөвлөгөөг дэлхий даяараа батлаад явж байгаа. Тэр нь ямар дэглэмтэй ямар улс байхаас үл хамаараад НҮБ-ын бүх гишүүн орнуудын хүлээсэн үүрэг болоод хэрэгжээд явж байгаа. Тэрийг “Алсын хараа-2050” болгож өөрчлөөд бас нийцүүлээд дахиад шинэчлэн батлагдсан 13 онд батлагдсан бил үү.

Тийм учраас энэ бас хуулийн дагуу Засгийн газар хууль биелүүлэх үүрэгтэй. Одоо буцааж болохгүй. Яагаад гэвэл хуулиараа энэ төлөвлөгөө хэрэгжиж дуусахаас 2 сарын өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ёстой. 11 дүгээр сарын 1-ний дотор гэсэн үг. Өргөн мэдүүлчихсэн. Хөгжлийн бодлого, тогтвортой байдлын тухай хуулиараа бас 1 сарын дотор хэлэлцэж батлах ёстой. Энэ хуулийг 2015 онд Ардчилсан нам эрхэм эрх барьж байх үед бас баталчихсан хууль Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг. Энэ таван жилийн үндсэн чиглэлтэй байна, жилийн төлөвлөгөө баталдаг байна, улсын төсвийг түүнтэй нийцүүлнэ гээд бодох чиглэлийг бас баталчихсан хууль. Энэ дагуу улс төрийн намууд бас саналаа өгдөг. Ийм хуульд заачихсан ийм хууль биелүүлэх үүрэгтэй Засгийн газар.

Хоёрдугаарх гол асуудал нь Амгаланбаатар гишүүн бас чухал асуулт асуулаа. Оюу толгойн төслийг үр ашигтай болгох хамгийн чухал нөхцөл зээлийн

хүү бууруулах асуудал. 2 өдрийн өмнө Кэйти Жексон зэсийн группийн захиралтай бид нар video conference хийж зарчмын хувьд протоколд гарын үсэг зурахаар тохиролцсон.

Нэгдүгээрт зээлийн хүүг энэ ондоо багтааж бууруулахаар. Энэ бас энэ жилийн хамгийн сайн мэдээнүүдийн нэг. Монгол Улсын зээлжих зэрэглэл сайжирсантай агаар луугаа адил нэг мэдээ.

Хоёрдугаарт нь бас менежментийн төлбөрөө буулгая, төлбөр шимтгэлийг бууруулъя гэж заасан. Ингээд менежментийн шимтгэл, төлбөр энэ 2 буухаар улс оронд ашигтай болно. “Онтрэ”-гийн асуудлыг шийдье гэж тохирлоо. Дээр нь бусад зардлуудыг бууруулах, хамтран ажиллах шинэ чиглэлд тохирох ийм асуудлуудыг манай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд бид нар бас хэлэлцээ хийж, зарчмын хувьд тохиролцоод ирэх долоо хоногт протоколд гарын үсэг зурахаар протоколын үг, үсэг дээр тохи.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Гүйцээж үг хэлье.

Г.Занданшатар: Дуусан болохыг бас мэдээ. Ер нь дандаа олон муу сайн мэдээн дунд энэ их сайн мэдээ, сайн чиг хандлага бүх салбарт тогтож байгаагийн шинж юм. Манай энэ зээлжих зэрэглэлүүд сайжирсан нь бас өнгөрсөн хугацаанд бид БНХАУ-ын Ардын банкны 2 тэрбум долларын свопын 1 тэрбум долларыг төлж барагдуулсан Их Хуралд бид нар. Энэ бүхний үр дүнд бас зээлжих зэрэглэл сайнаар нөлөөлж байгаа. Ийм гадаад, дотоод орчны сайн өөрчлөлтүүд гарч байгааг дурдахад баяртай байна. Энэ бүхэн маань энэ үндсэн чиглэл бодлоготойгоо бас уялдаж явах ёстой. Тийм учраас Амгаланбаатар гишүүнийг бас энэ үндсэн чиглэлийг улсын ерөнхий 1 чиглэл гэж үзэж, Энэтхэг, Япон, Солонгос, дэлхийн бүх улсууд ийм үндсэн чиглэл, бодлогын чиг баримжаатай байж хөгжиж байгаа. Тийм учраас энэ азийн хөгжлийн чиг хандлага бас энийг бас дэмжиж, харин улам боловсронгуй.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүдийг чуулганыхаа танхимд урьж байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Нийт 34 гишүүн асуулт асуусан. Тухай бүр асуулт байгаагүй гишүүдийг нөхөж яриулсан. Түрүүн чинь намайг юу гэхчэв дээ. Би чинь уг нь их либерал амьтан юм байгаа шүү дээ. Ямар ч байсан бүгдийг нь нөхөж бүгдийг нь яриуллаа.

Одоо үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Үгтэй. Тэгээд энэний ар дээр санал хураалт явна шүү гишүүдийг урьж байна. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Замира гишүүнээр тасаллаа. Орохгүй байна уу Ганбаатар? Үг тасаллаа. Сонгобайн Замира гишүүн.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ бодлогын чиглэлийн таван жилийн төлөвлөгөөг уг нь дэмжиж байна. Тэгэхдээ энэ бүх 8 төрлийн чиглэл нь харин эдийн засагтай шууд холбоотой. Эдийн засаг нь хөгжиж байж, сайн байж энэ төлөвлөгөө хэрэгжинэ гэсэн үг. Монгол Улс эдийн засгаа яаж сэргээх вэ? Үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон аж ахуйн нэгжүүд яаж үйл ажиллагааг нь жигдрүүлэх вэ, гадаадын хөрөнгө оруулалтыг яаж татах вэ гэсэн

том том асуудал байна. Үүний төлөө хамгийн гол нь төр засаг нь төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх гээд зүтгээд байдаг дунд, доод шатад очихоор бүх юм замхарчихдаг. Энийг яах бэ, яаж цэгцлэх вэ? Тийм учраас бид нар энэ данхайсан төрөө эргэж харах хэрэгтэй. Яам, газрууд болон агентлагуудыг нэгтгэх ёстой. Чадварлаг боловсон хүчнүүдийг нам харгалзахгүйгээр дэвшүүлэн ажиллуулах ёстой.

Банкны системийг бас шинэчлэх хэрэгтэй. Гадаадын хөрөнгө оруулалттай банкиг татаж өрсөлдөөн бий болгох ёстой. Зогсонги байдалд орсон аж ахуйн нэгжүүдийг сэргээх ёстой. Сэргээхийн төлөө яах ёстой гэвэл яам, холбоотой байгууллагууд нь тулж ажиллах ёстой. Яагаад ажил зогсонги байдалд орсон, юунаас болоод ингээд үйл ажиллагаа нь жигдрэхгүй байна гэдгийг бодит дүгнэлт хийх ёстой. Тэгж байж амьтай үйл ажиллагаа явуулахгүй бол оффист сууж байгаад нэг шийдвэр гаргачихдаг. Тэр нь хэрэгжихгүй. Сүүлд тэгээд юу болж байгаа нь мэдэгдэхгүй нэг нь шийдвэр гаргасан болоод нөгөөдөх чинь тэгээд тэрийг биелүүлчихсэн болоод тэгээд дуусаж байна бүх юм. Тэр нь бас тэгээд манай хөгжилд саад, бэрхшээл болж байгаа бас нэг юм байна. Тэр нь юу вэ гэвэл хээл хахууль. Энэ дунд шатад ялангуяа төрийн байгууллагууд маш их хээл хахууль газар авсан. Одоо хээл хахуулийг бид нар өгөөхийн ингээд яриад байдаг. Тэгэхдээ үр дүн байхгүй. Тэрнээс л болоод гадаадын хөрөнгө оруулалт чинь орж ирэхээ байгаад барагтай зогсонги байдалд ороод байна шүү дээ. Бичиг цаас ихтэй, тэрийг хийхийн төлөө маш их юу төлдөг.

Чөлөөт бүс гээд маш удаан ярьсан байх бид нар. Тэр чөлөөт бүс нь цаасан дээр байгаа. Ерөөсөө үр дүн байхгүй. Бид нар яриад байдаг, яриад байдаг, төлөвлөгөө гаргаад байдаг, хэрэгжиж байгаа нэг ч юм байхгүй. Үгүй ээ яах вэ хэрэгжиж байгаа юм байгаа л даа. Тэгэхдээ үр дүн гарахгүй байна шүү дээ. Манай нийслэлийн замын түгжрэлийг арилгана гээд өчнөөн жил ярьсан. Давхар зам яагаад тавьж болохгүй гэж. Замын хажуугийн явган хүний замыг шинэчлээд байгаад байдаг байгаад байдаг тэр дээр жил болгон сольдог, сар болгон сольдог. Тэрэнд гаргаж байгаа мөнгийг зүгээр давхар зам тавих замаар энэ түгжрэлийг арилгаж болно шүү дээ. Тэгээд манай аймгуудад, би 1 минут нэмж авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбатын Очирбат. Байхгүй.

Г.Очирбат: Баярлалаа. 2021 оноос 2025 он хүртэл таван жилийн хугацаанд Монгол Улсын татвар төлөгч нарын 117 их наяд төгрөгийг эрх баригч нарт зарцуулсан. Энэ 5 жил ажил олигтой хийгдээгүй. Тайлан дээрх үр дүн ажлаа 50 хувь хийсэн байна гэж байгаа юм. Бүх төсөл, хөтөлбөрүүдийг дунджаар дүгнээд үзэхээр 50 хувь ажлаа хийсэн. Цаашдаа ийм хариуцлагагүй байдлаа яаж таслан зогсоох ёстой юм. Улс төрийн намын тухай хууль болон Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, бусад холбогдох хууль дээр энэ арга хэмжээ, энэ хөгжлийн хөтөлбөрүүдийг олигтой хийж чадаагүй. Энэ эрх барьж байгаа аль ч нам нь ч байсан хамаагүй дахиж ер нь бараг энэ сонгуульд өрсөлдөөд хэрэг байдаг юм уу, дахиж энэ хөгжил яриад хэрэг байдаг юм уу? Тэгээд энийг ч гэсэн манай Монгол Ардын намынхан сүүлийн 10 жилд тасралтгүй эрх барьж байгаа. Энэ байдал дээр анхаарал хандуулах хэрэгтэй. Ялангуяа энэ удаан жил олон жил ажилласан сайд, дарга нар ард иргэдээсээ ичих хэрэгтэй шүү дээ. Ичдэг бол ичээд нээрээ бараг нүүрээ хаашаа хийх вэ гэдгээ л олж ядаж суумаар байх юм. Тэгэхэд ичихгүй дараагийн таван жил бид нар ийм сайхан болно оо гээд яриад сууж

байдаг. Их Хурлын тогтоол хүртэл гаргаад өгсөн байгаа. Шалгуур үзүүлэлтээ, хэмжих нэгжтэй нь. Тэрийгээ хийж бүтээсэн ажил байхгүй. Тэгээд одоо дахиад биелэлт нь хангагдаагүй байхад л дахиад л ядуурлыг 2 дахин бууруулна, эдийн засгаа тэлнэ гээд яаж ичихгүй хэлж суудаг юм. Энэ байдал бүүр хэрээс хэтэрчжэж байгаа юм.

Тэгэхээр Монголын ард түмэн бас энэ дээр аягүй тийм анхааралтай байх хэрэгтэй. Ялангуяа энэ хөгжлийн хөтөлбөрүүд батлагдаж байгаа үе дээр. Тэгээд жил болохлоор л төсвөө булаацалддаг, бие бие рүүгээ дайрдаг, хөнжилдөө хөлөө жийлцээд хэн эрх мэдэлд ойрхон байгаа, хэн дарга цэрэгтэй, хэн олон жил сайд болсон нь жил болгон л тэр хөгжлийн хөтөлбөр хамаагүйгээр өөрийнхөө тойрог дээр мөнгө тавиулж байдаг. Тэгээд ийм хариуцлагагүй байдлаа зогсоомоор байна шүү дээ. Тайлангаа хэлэлцмээр гэж хэлээд Байнгын хороонуудад оруулаач ээ гээд хэлээд нэмэр байхгүй. Ингээд хуулийн хугацаа тулж байгаа болохоор гэдэг юмаар хүчээр шахдаг. Эдийн засгийн байнгын хороо буюу мэргэжлийн Байнгын хороон дээр энэ саналыг нь унагаачхаад байж байхад одоо ингээд ирчихсэн хар бүгдээрээ нөгөө улаан кнопоо дарах, хэсэг нь дарах байх нөгөө хэсэг нь орж ирэхгүй байж байгаад санал босгох гэж байгаа юм.

Тэгээд ийм л хариуцлагагүй байна шүү дээ. Монгол Улс хөгжлийн хөтөлбөртэй байх ёстой, төлөвлөгөөтэй байх ёстой, тэрийгээ хийх ёстой, гүйцэтгэлийнхээ үр дүнг үнэлүүлэх ёстой ард түмнээрээ. Гүйцэтгэл чинь 50 хувьтай байна шүү дээ. Тэгээд хэн хариуцлага тооцох юм? Хариуцлага тооцох эрх бүхий субъектүүд энэ парламент бол энэ гүйцэтгэх засаглалаа хянаж байх ёстой. Гүйцэтгэх засаглалын нөхдүүд маань их л сайхан ажил хийгээд байгаа юм шиг л байгаад байгаа юм. Мэдэхгүй цаашдаа хойшдоо ер нь энэ нөхцөл байдлыг нэлээн 126 юун тулд Их Хурлын гишүүнтэй болсон байна лээ. Олон талаас нь харж, хөгжлийн хөтөлбөрүүд дээр, гүйцэтгэл дээр, үр дүн дээр, дараагийн төлөвлөгөө, хөтөлбөр дээр алдаа оноо нь юу байсан бол. Уул нь бид нар хуулиараа Их Хурал ингээд Их Хурлын тогтоол гаргаад чиглэл өгөх ёстой Засгийн газар руу яагаад 50 хувь ажлаа хийх ёстой гээд ингээд. Хугацаа байхгүй гээд шахсаар байгаад дуусгадаг. Төсвийг ч гэсэн тийм байдалд оруулдаг. Бүх улс эх орны хөгжилтэй холбоотой асуудлууд дээр дандаа ингэж шантаажлана гэх юм уу шахаж байж асуудлыг шийддэг. Тэгээд ийм байдалтайгаар сүүлийн 10 жил тасралтгүй яваад тэрэндээ бүүр ингээд бяржчихсан, ханачихсан. Тэгээд ийм баймааргүй байна шүү эрх баригч нарт хандаж хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Дашцэрэнгийн Энхтүвшин.

Д.Энхтүвшин: Засгийн газар маань Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийнхаа дагуу 14.1-д заасныхаа дагуу гүйцэтгэлээ ирүүлсэн байна. Дараагийн таван жилийн бас төлөвлөгөө ирүүлсэн байна. Хуулийн дагуу. Улсын Их Хурал маань энэ асуудлаа хэлэлцээгүй байна. Гүйцэтгэлийг 4 сарын өмнө Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хугацаа дуусахаас, дуусгавар болохоос 4 сарын өмнө хэрэгжилтийн үнэлгээг Улсын Их Хуралд танилцуулна гэчихсэн. Тэгэхээр яг энэ танилцуулах үйл ажиллагаа явагдаагүй учраас энэ асуудлуудаа ярьж байгаад, танилцчихаад дараагийн асуудлуудаа ярих нь зөв байх гэж бодож байна. Тэгээд энэ дээр ч гэсэн танилцчихаад Засгийн газарт бас тодорхой чиглэлүүд өгнө өө гээд хууль дээр заачихсан байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурал энэ танилцах үйл ажиллагаагаа хийсний дараа дараачийн таван жилийн энэ асуудлуудыг яаж ярих вэ гэдгийг яримаар байна. Нөгөө талаас түрүүн би бас асуулт асуухдаа хэлсэн. Энэ таван жилийн төлөвлөгөө илүү санагдаад байгаа. Урт хугацааны болон урт хугацаа гэхээрээ 30 жил, дунд хугацааны гэхээр 3 төрлийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн бичиг баримтууд байгаа, 10 жилийнх, 5 жилийнх, 4 жилийнх.

4 жилийнх нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. Тэгэхээр ингээд сеелжихөөр засаг солигдлоо гэж бодоход энэ бодлогууд нь дагаад жишээлбэл өөрийнхөө эрх барьж байх үед, нэг нам эрх барьж байх үед Засгийн газрыг толгойлж байх үед шийдсэн асуудлыг дараагийн Засгийн газар хийгдэхгүй байх магадлалтай. Тэгээд дагаад өөрчлөгдөх магадлалтай учраас энэ таван жилийн гэдэг энэ илүү ажлыг больчихъё оо гэсэн ийм саналтай байгаа.

Тэгэхээр энэ асуудлуудаа үнэхээр яг бид нарт хэрэг болоод байгаа юм уу болохгүй байгаа юм уу гэдгийгээ хуулийн дагуу Улсын Их Хурал дээрээ хэлэлцчихээд дараагийн таван жилийн асуудлаа ярья гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Мөнхчулууны Энхцэцэг.

М.Энхцэцэг: Монгол Улсыг Хөгжүүлэх 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар хэлэлцэж байна. Тэгэхээр энэ чиглэлийг ерөнхийдөө зарчмын хувьд дэмжиж байгаа. Ялангуяа үндсэн чиглэлийг боловсруулахдаа үндсэн чиглэлийнхээ зорилго, зорилтыг хэмжигдэхүйц байдлаар боловсруулсан нь давуу тал харагдаж байгаа.

Гэхдээ эрчим хүч талдаа нэлээн шүүмжлэлтэй хандах асуудлууд их байгаа. Энэ төлөвлөгөөнөөс энэ 5 жилийн хугацаанд эрчим хүчний салбарыг яаж хөгжүүлэх вэ гэдэг ийм бодлого, чиглэл харагдана гэж ингэж бодсон. Гэвч энэ харагдахгүй байна. Нөгөө л улиг болсон тасралтгүй л ярьж байдаг ийм эх үүсвэрүүдээ шугамынхаа жагсаалтыг ерөөсөө л жагсаалт харагдаж байгаа. Дээрээс нь эрчим хүчнийхээ төсөл болгон дээр 1 хуудас зориулсан ийм жагсаалт л ерөнхийдөө харагдаж байна. Тэгээд дээрээс нь хамгийн гол чухал юм нь энэ 5 жилдээ зах зээлээ яаж либералчлах юм, яаж хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх юм гэдэг энэ салбарын зүгээс барих ёстой үндсэн бодлогууд, чиглэлүүд ерөөсөө харагдахгүй байгаа.

Тэгээд хамгийн гол чухал юм нь энэ “Алсын хараа-2050” гээд батлагдаад Хөгжлийн төлөвлөгөө, түүний удирдлагын тухай хууль, Хөгжлийн бодлого, түүний удирдлагын тухай хууль батлагдаад ямар асуудал болсон бэ гээд тэгэхээр ер нь “Алсын хараа-2050” батлагдахаас өмнө эрчим хүчний салбарт харьцангуй олон төлөвлөгөөнүүд байсан юм. Эрчим хүчний салбараас 2015-аас 30 онд баримтлах бодлогын бичиг баримт, Сэргээгдэх эрчим хүчний нэгдсэн хөтөлбөр, Эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөр гээд олон хөтөлбөрүүд байсан юм. Харамсалтай нь энэ нь энэ хууль батлагдаад салбарын бүх өмнөх төлөвлөгөөний бичиг баримтууд байхгүй болчихсон. Тэр төлөвлөгөөнүүд харьцангуй сайн төлөвлөгөөнүүд байсан. Тэгээд одоо эрчим хүчний салбараас бодлогын бичиг баримт чинь хаана байна гэхээр байхгүй “Алсын хараа” дээр байгаа гэдэг юм. “Алсын хараа”-г нь харахаар жагсаалт, одоо дахиад энийг нь харахаар дахиад жагсаалт.

Тэгэхээр бодлогогүй, стратегигүй салбар яаж цаашаа хөгжих юм бэ. Тэгэхээр хамгийн гайхалтай нь энэ асуудлыг цэгцлэх хэрэгтэй юм биш үү. Энэ хуулиараа салбаруудыг бодлого гаргахыг хориглочихсон гэж байгаа хамгийн гайхалтай нь. Тэгэхээр салбаргүй бодлого яаж явах юм бэ? Өнөөдөр магадгүй энэ эрчим хүчний салбарын болохгүй, бүтэхгүй байгаа энэ асуудал чинь өнөөдөр бодлогогүй болсноос болж байгаа байхгүй юу. Уул нь тэр энэ “Алсын хараа-2050” гарахаас өмнөх бодлогын бичиг баримтад харьцангуй сайн бодлогын бичиг баримтууд байсан юм. Яаж зах зээлээ либералчлах юм, яаж хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх юм гээд маш олон бодлогууд, дээрээс нь тэн дээрээ хэмжигдэхүйц байдлаар төлөвлөчихсөн.

Гэтэл “Алсын хараа” дээр тусгахдаа зүгээр жагсаалт хийчихсэн. Одоо дахиад энэ дээр дахиад жагсаалт. Тэгэхээр энэ хууль дээрээ өөрчлөлт оруулаад салбаруудаа бодлого өөрөө хийгээд явах тэр боломжийг хангаач ээ. Магадгүй салбар нь нарийвчилсан бодлогоо хийгээд явдаг. Тэгээд тэр улсынхаа бодлого дээр болохоор ерөнхий бодлогоо хийгээд явдаг байдлаар ингэж өөрчлөлт оруулахгүй бол Эрчим хүчний яамныхантай ярихаар юу гэж хэлж байгаа гэхээр тийм ээ хөгж.../минут дуусав.

Ж.Бат-Эрдэнэ: Гомбын Ганбаатар үгээ хэлье.

Г.Ганбаатар: Оройн мэнд. Бид нар ч өнөөдөржингөө л улсаа хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл гээд л ярилаа л даа. Уг нь энэ чинь намууд сонгуульд оролцохдоо мөрийн хөтөлбөр гээд гаргадаг тэр нь 4 жилээрээ байдаг. Гэтэл бид хуучин социализмын үеийнх шиг нөгөө 5 жилийн төлөвлөгөө, таван жилийн гавшгай ч гэдэг шиг л ингээд 5 жилээр ингээд сонгуулийнх нь мөрийн хөтөлбөр 4 жилээр байхад бид нар таван жилийн үндсэн чиглэл яриад. Дээрээс нь яах вэ. Энэ бид нар юм ер нь бодох хэрэгтэй юм. Энэ мөрийн хөтөлбөр яг хэрэгжиж байна уу? Түүнд анализ хийдэг газар гэж байдаг юм уу? 14 оноос хойш эрх баригч нам үндсэндээ хамтарсан засгаас хойш үндсэндээ 12 жил боллоо шүү дээ. Бүтэн сонгуулийн хугацаа. Бүтэн 12 жил гэххээд бараг нөгөө зарим ухаантай бүсгүйчүүдийн хэлдгээр бараг нэг 60 биз дээ. Үгүй ээ тэгээд энэ хугацаанд чинь ийм 12 жил болчихоод ахиад ингээд ийм яриад, шинэ итгэл, эрс шинэтгэл гээд ингээд ийм гоё гоё юм яриад явж байдаг. Итгэл төрөхгүй шүү дээ хүмүүс.

Ер нь манай улс 3 зүйлийг л хиймээр юм билээ л дээ. Нэгдүгээрт нь энэ авлигал гэдэг бүүр гаарчихлаа шүү дээ бараг ердийн үзэгдэл шиг. Тэгээд үүнтэйгээ үнэхээрийн тэмцэгдэхгүй бол үндсэндээ авлигын золиос нь л ард түмэн болоод байна.

Хоёр дахь нь энэ байгаа жоохон санхүүгийн нөөц энэ төсвийнхөө хөрөнгө мөнгийг зөв зарцуулах тал дээр энэ чиглэлээр ерөөсөө энэ орж байгаа энэ чиглэл дээр ерөөсөө байхгүй. Үндэсний аудитын тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа юм. Аудитынхаа даргыг ядаж цөөнхдөө өгөөд энэ байгаа жоохон төрийнхөө мөнгөнд зөв хяналт тавиулахгүй бол энэ чинь ерөөсөө улс төрийнхөө дарамтыг ч даахгүй байна. Нийтлэг энэ улс орны жишиг Герман, Финлянд, сая хамгийн сүүлд гэхэд Франц улсын Ерөнхийлөгч нь сөрөг хүчнийхээ нэлээн нөлөө бүхий хүнийг үндэснийхээ аудитын газрын даргаар томилж байна шүү дээ. Тэгээд яах вэ энэ

талаар нөгөө хууль өргөн барьчихсан байгаа. Шинэ Хурлын даргыг томилогдсоны дараа өргөн барих бодолтой байна. Биччихсэн байгаа.

Гурав дахь асуудал нь энэ жилийн төсөлд энэ жилийн энэ төсөв батлагдаж байгаа явцыг харахад бид нар ирэх жилээс энэ мөнгөнийхөө ханшийг дээрээс нь ирэх жилээс хөрөнгө оруулалт гэдэг юмнуудаа үндсэндээ хөрөнгө оруулалтын орон зай гэж юм байхгүй боллоо л доо. Тийм учраас яаралтай тэр энэ “Эрдэнэс Тавантолгой” энэ ТӨК-удаа яаралтай тэр олон нийтэд олон нийтийн тэр нээлттэй ХК болгох асуудлаа эртнээс бэлтгэлээ хангаад дээрээс нь энэ “Эрдэнэс Тавантолгой”-г чинь зөвхөн оффисын компани болоод хяналтаа тавьдаг, үйл ажиллагаанд нь хяналтаа тавьдаг гэрээ хийдэг л компани байхгүй бол энэ чинь хулгайч нарын орон боллоо шүү дээ. Сая юу болов? Үндсэндээ 9 сарын 15-наас хойш нүүрсчдийн хулгайчдын тухай өнгөрсөн хугацаанд ямар их ард түмний, ард иргэдийн боломж хулгайлсан тухай л ярилаа шүү дээ. Өнөөдрөөс л бид харин ирээдүйн улс орныхоо хөгжил дэвшлийн талаар эргээд жоохон бодох бодол төрж байх шиг байна. Тэгээд энэ “Эрдэнэс Тавантолгой”-гоо бас яаралтай энэ цэгцлэхгүй бол бид нар ирэх жил ингээд орон нутгийн улс орны төсөв гэж юм байхгүй болох нь.

Ер нь энэ ТӨК-уд ялангуяа тэр “Эрдэнэс Тавантолгой” эд нар танай намын хулгайч нар л дүүрсэн компани боллоо шүү дээ. Та нар өөрсдөө мэдэж л байгаа. Сая Ерөнхий сайд нь, Хууль зүйн сайд нь юу юу яриад байлаа. Үүнтэйгээ хариуцлага тооцох хэрэгтэй. Одоо сүүлдээ энэ “Эрдэнэс Тавантолгой” дээр чинь Авлигатай тэмцэх газрынхан очоод байршчихсан байна лээ шүү дээ. Үгүй ээ Авлигатай тэмцэх газрынхан ажилд ордог газар болсон юм уу яасан юм тэгээд? Иймэрхүү юмнуудаа цэгцлэхгүй бол энд их гоё гоё юм яриад улс орноо 26-30 онд хөгжүүлэх төлөвлөгөө гээд өдөржингөө л ярилаа. Иймэрхүү юмнуудаа ингээд бодож ажиллаач ээ арай бас өөрөөр ажиллахгүй бол энэ чинь, энэ улс орон чинь, ард иргэд чинь сүйрлээ шүү дээ. Аж ахуйн нэгжүүдийн дарамт эд нар гэж. Тэр дансыг нь хаахгүй гээд байсан зөндөө аж ахуйн нэгжүүдийн дансыг хаачихсан байна лээ шүү дээ. Ерөнхий сайд аж ахуйн нэгжүүдийн дансыг хаахгүй л гээд байсан. Тэгээд иймэрхүү юмнуудаа бодоосой л гэж хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Мэндбаярын Мандхай гишүүн үг хэлнэ.

М.Мандхай: Энэ Монгол Улсыг 21-25 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлан гээд 10 сарын 30-ны өдөр өгсөн байгаа. Тэгээд энэхүү тайланд хөдөө аж ахуйн салбар тэн дотроо хүнсний салбарт гол тулгамдсан асуудал нь дотоодын хангамж хангалтгүй, олон улсын стандарт шаардлага хангасан үйлдвэрлэл сул, малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалт доогуур байгаагаас хүнсний аюулгүй байдлын эрсдэл өндөр хэвээр байна. 24 онд нийт өрхийн 65 хувь нь хүнсний баталгаат байдал алдагдсан. Үүнээс 23 хувь нь ноцтой түвшинд хүнсний хомсдолд орсон. Хүнсний хүртээмж, чанарын асуудлыг илтгэж байна. Хүнсний нэмэлт транс тосыг шинжлэх чадамж хүчтэй лаборатори байхгүй. Хяналтын тогтолцоо алдагдсан, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, лабораторийн чадавхыг сайжруулах, технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх шаардлагатай байна гээд. Ингээд энэ ном дээр угаасаа болохгүй байгаа юм гээд хөдөө аж ахуйн салбарыг маш сайн тодорхой дурдсан байгаа.

Гэвч үнэнийг хэлсэн хүнд хүн өшөөтэй гэгчээр сайд маань намайг удаа дараа заналхийлж дарамталлаа. Би энэ салбарыг уул нь хөгжүүлэхийн төлөө салбарыг углуургаар нь, бүтцээр нь дахиж та системээр нь, тогтолцоогоор нь өөрчилж хараач ээ. Тэгэхгүй бол татвар төлөгчдийн мөнгө өөрөө үргүй зардал руу яваад байгаа юм. Нийт төсвийн чинь 60 хувь нь татаас, хөнгөлөлт, урамшуулал руу явсан мөртөө өнөөдөр хүнсний үйлдвэрлэл ерөөсөө нэмэгдэхгүй, нийлүүлэлт нэмэгдэхгүй байгаад байгаа юм гэдгийг би тоо баримттай, судлаачдын гаргасан дүгнэлттэй би ярьж байгаа юм. Өнөөдөр харамсалтай нь ингээд өөрчлөх сонирхол байхгүй. Сайжруулъя гэсэн ийм саналыг хүлээж авахгүй байгаад байгаад маш харамсаж байна. Ерөнхий сайд байсан бол би Ерөнхий сайдад захиж хэлмээр байлаа. Энэ таван жилийн төлөвлөгөөг Эдийн засгийн байнгын хороо буцаасан. Тэгэхээр энэ ажлын хэсэгт миний бие ороод хөдөө аж ахуйн салбар дээр бас энэ ирэх таван жилийн чиглэл дээр өөрийнхөө бас нэлээн саналыг нарийвчилж оруулна гэж бас энд хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд үг хэлж дууслаа. Ингээд “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх санал хураалтыг өнөөдөр ирц бас хангалтгүй байгаа тул маргаашийн буюу 11 сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийхээр хойшлууллаа. Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг өндөрлөө.

17.09 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

